



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-35
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	36-192
<hr/>	
1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	41-44
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	44-55
3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-99
4. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	99-102
5. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	102-105
6. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	105-108
7. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	108-127
8. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	127-139
9. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ үргэлжлэл/	139-171
10. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” (“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт) Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	171-174
11. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	174-175
12. Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны явцын тайлан	175-180
13. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	180-187
14. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	187-188
15. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурва дахь хэлэлцүүлэг/	188-190
16. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	190-192

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
6 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 15 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Н.Наранбаатар, Л.Оюун-Эрдэнэ,
Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;
Тасалсан: Х.Ганхуяг, Х.Нямбаатар;
Хоцорсон: С.Амарсайхан – 09 минут, Ц.Анандбазар – 03 минут, Т.Аубакир -1 цаг 24 минут, С.Батболд – 1 цаг 45 минут, Х.Болорчулуун – 16 минут, Х.Булгантуяа – 14 минут, С.Ганбаатар – 07 минут, Д.Ганбат – 41 минут, Г.Ганболд – 06 минут, Г.Дамдинням – 21 минут, Б.Жаргалмаа – 1 цаг 57 минут, С.Одонтуяа – 35 минут, М.Оюунчимэг – 12 минут, Д.Өнөрболор – 21 минут, Ш.Раднаасэд – 1 цаг 03 минут, Ч.Хүрэлбаатар – 19 минут, Д.Цогтбаатар – 33 минут, О.Цогтгэрэл – 03 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа хэлэлцэх асуудлын дарааллын 12 дахь асуудал буюу Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	36
Бүгд:	45

20.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Энхбат, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Ж.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон

Хамт өргөн мэдүүлсэн:

- 1.Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 2.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 3.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 4.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 5.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 6.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 7.Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 8.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 10.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 11.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 12.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 13.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 14.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 15.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 16.Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 17.Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 18.Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 19.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 20.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

- 21.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 22.Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 23.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 24.Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 25.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 26.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 27.Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 28.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 29.Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 30.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 31.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 32.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 33.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 34.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 35.Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 36.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 37.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 38.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 39.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 40.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 41.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 42.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 43.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 44.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 45.Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 46.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 47.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 48.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 49.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 50.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 51.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 52.Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 53.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 54.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 55.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 56.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 57.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 58.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 59.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 60.Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 61.Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

- 62.Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 63.Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 64.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 65.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 66.Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 67.Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 68.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 69.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 70.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 71.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 72.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 73.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 74.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 75.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 76.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 77.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 78.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 79.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 80.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 81.Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 82.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 83.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 84.Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 85.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 86.Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 87.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 88.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 89.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 90.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 91.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 92.Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 93.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 94.Хог хаягдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 95.Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 96.Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 97.Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 98.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

- 99.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 100.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 101.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 102.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 103.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 104.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 105.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 106.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 107.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 108.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 109.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 110.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 111.Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 112.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 113.Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 114.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 115.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 116.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 117.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 118.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 13

Бүгд: 49

73.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Д.Өнөрболор, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Ганбат, Б.Баттөмөр, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн Төсвийн байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	24
Бүгд:	51

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	39
Татгалзсан:	13
Бүгд:	52

75.0 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, мөн яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 23 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Л.Энх-Амгалан, Д.Сарангэрэл, Д.Ганбат, Б.Батгөмөр, Б.Бат-Эрдэнэ, Б.Энхбаяр, Т.Доржханд, Ж.Батжаргал, Г.Ганболд, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 11 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55

65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55

65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 17
Бүгд: 55

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 18
Бүгд: 55

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 16
Бүгд: 55

70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 47
Бүгд: 55
14.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

7.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 18
Бүгд: 55
67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 16
Бүгд: 55
70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 17
Бүгд: 55
69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлэв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 24 минут үргэлжилж, 13 цаг 39 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 15 минутад эхлэв.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга А.Энхмаа, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, мөн газрын Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сангийн программ хангамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, судлаач, доктор Э.Гэрэлт-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу дэгийн тухай саналаа оруулж ирэх боломжийг хангаж өгөхийг Улсын Их Хурлын даргаас хүсэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороог хуралдуулахаар тогтсон тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулав.

Хуралдаан 15 цаг 21 минутад түр завсарлав.

Хуралдаан 16 цаг 24 минутаас үргэлжлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийн хуулиар зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийн тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 23

Бүгд: 53

56.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, мөн яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх

Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 16 цаг 57 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “энэ хуульд заасан журмаар” гэсний өмнө “энэ хуулийн 9.2-г нийцүүлэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 24
Бүгд: 54
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөлтийн аргуудад шилжиж байгаатай холбогдуулан судалгаа тооцооллыг нарийвчлан судалж, төслийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16 дугаар зүйлийн 16.4, мөн зүйлийн 3 дахь заалтын 57 дугаар зүйлийн 57.18 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.1, 78.3 дахь хэсгүүдийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 19
Бүгд: 52
63.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт тусгагдсан асуудлыг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган зохицуулахаар төслөөс хасаж, мөн заалтын 78.2 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 13
Бүгд: 51
74.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Найруулгын санал:

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “түүний хэмжээ” гэснийг “албан тушаалын цалингийн хэмжээ” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлээс “зүйл,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 19
Бүгд: 51
62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 17.2 дахь хэсгийн “6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй” гэснийг “6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 16
Бүгд: 51
68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “6.2 дахь хэсгийн “сум” гэсний дараа “баг,” гэж” гэснийг “6.2 дахь хэсгийн “Аймаг, нийслэл,” гэсний дараа “сум,” гэж, “сум,” гэсний дараа “баг,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 15

Бүгд: 51
70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг,” хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 20
Бүгд: 51
60.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.6 дахь заалтын “орон нутгийн салбар, нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж ажлын уялдааг сайжруулах,” гэснийг “энэ хуулийн 20.1-д заасан төвийн үйл ажиллагааны салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах,” гэж өөрчлөн “, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 14
Бүгд: 51
72.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.7 дахь заалтын “аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүргийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 18
Бүгд: 51
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.8 дахь заалтын “, олон улсын байгууллагын” гэснийг хасаж, “төрийн бус” гэсний дараа “байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 16
Бүгд: 51
68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.10 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг аймаг, дүүрэг, сум дахь Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүргэх, энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог” гэснийг “аймаг, сум, дүүрэг дэх төвийн хэрэгжүүлэх энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 19

Бүгд: 51

62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.11 дэх заалтын “Энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог” гэснийг “энэ хуулийн 19.1-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 17

Бүгд: 52

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.2 дахь заалтын “гарах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх” гэснийг “гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 16

Бүгд: 52

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 14

Бүгд: 52

73.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлчилгээ болон энэ хуульд заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 18
Бүгд: 52
65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 20.4 дэх хэсгийн “төвийг” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 19
Бүгд: 52
63.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Найруулгын санал:

Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.3 дахь заалтын “сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн” гэснийг “сонирхлын бүлгийн” гэж, 20.2.7 дахь заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 20.3 дахь хэсгийн “, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгуулага, мэргэжлийн холбоогоор” гэснийг “залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 16
Бүгд: 52
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.5 дахь хэсгийн “хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах” гэснийг “хуулийн 23.2-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 18
Бүгд: 52
65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.6 дахь хэсгийн “томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна.” гэсний дараа “Энэ тохиолдолд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг хамаарахгүй.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 19
Бүгд: 52
63.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.7 дахь хэсгийн “заасан байгууллагын” гэснийг “заасны дагуу томилогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 15
Бүгд: 51
70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Тав.ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:**

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Баделхан, Х.Булгантуяа, Л.Мөнхбаатар, Б.Пүрэвдорж нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3.15 дахь хэсгийн “судалгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээхтэй холбоотой” гэснийг “шинжлэх ухааны суурь, хавсарга, технологи, хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновац судалгааны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 14
Бүгд: 51
72.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан өдрөөс” гэснийг “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 15
Бүгд: 51
70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Зургаа. “ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР:**

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус” гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтын “нөхөн олгох,” гэснийг “нөхөн олгосугай.” гэж, 5 дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36

Татгалзсан: 16

Бүгд: 52

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын” гэж өөрчлөн, төсөлд “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчилсүгэй.” гэсэн агуулга бүхий 3 дахь заалт нэмж, төслийн 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 14

Бүгд: 52

73.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Долоо. “ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР:**

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн тогтоох хэсгийн “хэсэгт заасныг” гэснийг “хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 15

Бүгд: 52

71.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

**Нэг. “ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР:**

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “хүүхдэд” гэснийг “хүүхэд бүрд” гэж өөрчлөн, “хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэсэн” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 22
Бүгд: 52
57.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, мөн яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, хуулийн төслийн талаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан санал, дүгнэлтийг Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нар танилцуулав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “6 дугаар зүйл” гэснийг “6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	25
Бүгд:	51

51.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр хавсралтаар” гэснийг “энэ хуулийн хавсралтаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	34
Татгалзсан:	16
Бүгд:	50

68.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага болох Шадар сайдын ажлын албаны урсгал төсвийн гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилал дахь хөрөнгийн эх үүсвэрээс **1,600.0 сая** төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын багаж, техник, хэрэгслийн зардалд **1,000.0 сая** төгрөг, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал **600.0 сая** төгрөгөөр санхүүжүүлэхээр шилжүүлэх гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ч.Хүрэлбаатар, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 29
Бүгд: 51

43.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Х. 1.1.260.Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, Титэм сургууль/, төсөвт өртөг 9, 673.3 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг **340.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Ш.1.24.Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ төсөвт өртөг 3,611.3 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 2,711.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүн **340.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, уг төсөл, арга хэмжээний эдийн засгийн ангилалд “тоног төхөөрөмж” гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 22
Бүгд: 46

52.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Энх-Амгалан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “ХИШ.3.3.Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “Хөвсгөл” гэснийг “Говь-Алтай” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 10
Бүгд: 45

77.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “IX.1.112.Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “өргөн чөлөөний” гэсний дараа “болон төв гудамжнуудын” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45

62.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Х.1.1.65.Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2019-2023, төсөвт өртөг 7,593.9 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,086.3 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөг “7,593.9 сая төгрөг” гэснийг “10,246.9 сая төгрөг” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	35
Татгалзсан:	10
Бүгд:	45

77.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага болох Шадар сайдын ажлын албаны урсгал төсвийн гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилал дахь хөрөнгийн эх үүсвэрээс 1,600.0 сая төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын багаж, техник, хэрэгслийн зардалд 1,000.0 сая төгрөг, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал 600.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр шилжүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг татан авсанд тооцов. /18:03/

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ /үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга А.Энхмаа, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, мөн газрын Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сангийн программ

хангамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, судлаач, доктор Э.Гэрэлт-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Д.Ганбат, Б.Баярсайхан, Б.Баттөмөр, С.Ганбаатар, Ж.Батсуурь, О.Цогтгэрэл, Т.Доржханд, Б.Жаргалмаа, П.Анужин нарын тавьсан асуулгад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнарэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.10 дахь хэсэг болгох:

17/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтын 41.16 дахь хэсгийг хасаж, мөн заалтын 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.16 дахь хэсэг болгох:

“41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 11
Бүгд: 46

76.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 26 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 7

Бүгд: 46

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30.3 дахь хэсэг болгон 1 дүгээр зүйл нэмэх:

“4/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 8

Бүгд: 45

82.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 42 дугаар зүйл болгох:

“5/42 дугаар зүйл

42 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

42.1.Тойрогт нэр дэвшигчдийн зурагтай хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбар тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсгийн “таваас” гэснийг “гурваас” гэж, мөн зүйлийн 11 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсгийн “нягтлах эрхтэй” гэснийг “болно” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсгийн “саналаа тэмдэглэсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 14
Бүгд: 44

68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2 дугаар зүйлийн 2 дахь заалт болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 10
Бүгд: 44

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн “65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийн “бөгөөд” гэсний дараа “энэ хуульд заасны дагуу урьдчилан санал авсан битүүмжилсэн саналын хайрцаг,” гэж гэснийг, 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэж гэснийг, “41.6 дахь хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхийн аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, “61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг,” гэснийг, “30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг,” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг, 7 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн дугаарыг 20.15, 20.17 дахь хэсгийн дугаарыг 20.16 гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	11
Бүгд:	44

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “ухуулах” гэсний дараа “буюу зурагт” гэж, 41.2 дахь хэсгийн “эвслийн” гэсний дараа “тойрогт” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41.3 дахь хэсгийн “Ухуулах хуудас болон зурагт” гэсний “Зурагт” гэж, 41.11 дэх хэсгийн “нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг” гэснийг “зурагт самбарыг” гэж,” гэж, мөн зүйлийн “32.12” гэсний дараа “, 38.12” гэж, 5 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж, мөн зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “, ухуулах хуудас” гэснийг,” гэж, 6 дугаар зүйлийн “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.6.7 дахь заалт,” гэж тус тус нэмж, 6 дугаар зүйлийн “23.3.4” гэснийг “26.3.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	34
Татгалзсан:	10
Бүгд:	44

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 4 дүгээр зүйлийн ““20-оос гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй” гэснийг “нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн “34.1.1 дэх заалт,” гэсний дараа “41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.12 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 8
Бүгд: 45

82.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 30 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийн “дээд хэмжээнээс” гэснийг “хэмжээний дунджаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 7
Бүгд: 45

84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төсөл доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 7
Бүгд: 45

84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Ес. *“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” (“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт) Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баярмаа, Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	13
Бүгд:	41

68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул “Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:50/

Уг асуудлыг 19 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Арав. *“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41

68.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41

68.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Арваннэг.Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны явцын тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Хянан шалгах түр хорооны явцын тайланг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал танилцуулав.

Танилцуулга, тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д заасны дагуу Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хянан шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцов.

Уг асуудлыг 20 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Арванхоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн Хууль зүйн байнгын хорооноос гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40

65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэгт шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Арвангурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, мөн яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Байнгын хорооноос зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаагүй тул Монгол Улсын төсвийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Арвандөрөв.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, мөн яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

***Арвантав. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2, 5 дугаар заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэнтэй холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 15 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Өлзийт сумын сургуулийн 1982 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Монголын Эмэгтэйчүүдийн холбооны Баянзүрх дэх салбар зөвлөлийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн албан хаагчид болон Баянцагаан сумын ахмадуудын төлөөлөл, Увс аймгийн Бөхмөрөн сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 47 минут үргэлжилж, 73 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 78.1 хувийн ирцтэйгээр 20 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 15 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна.

Ингээд Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулья. 14 асуудал хэлэлцэнэ.

1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

4.“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай.

5.“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг соёрхон батална.

6.Монгол Улсын төсвийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

7.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

9.“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

10.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөл.

11.Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хянан шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг

үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгалтын түр хорооны явцын тайлан.

12.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

13.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг.

14.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дэгийн тухай хуулийн хуулийн дагуу 17.00 цагаас өмнө үндэслэлгүй саналаа үг хэлэхээр Гонгорын Дамдинням, Ширнэнбаньдийн Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж нараас тус тус ирүүлсэн байна.

Одоо Гонгорын Дамдинням гишүүн үг хэлнэ. Алга байна. Хаслаа.

Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьшаа: Та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 тоот дүгнэлтийг үндэслэж Шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн төслүүдийг хойшлуулъя гэсэн байр суурьнаас өнөөдөр үг хэлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэдэг энэ байгууллага өнөөдөр ер нь ямар байгууллага болчихоод байна аа.

Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөгүй гэхээд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн холбогдох заалтуудыг түдгэлзүүлсэн. Энд ямар юм нуугдаад байна.

Энэ түдгэлзүүлж байгаад ямар хэрэг маргааныг Дээд шүүх дээр аваад шийдэх ийм хүсэл зориг, лобби яваад байна. Аягүй том хардалттай асуудал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц энэ хуулиудын заалтуудыг түдгэлзүүлэхдээ 2023 оны 12 сарын 23-ны өдрөөс түдгэлзүүлнэ гэсэн.

2023 оны 12 сарын 23-ны өдөр түдгэлзүүлсэн юмыг өнөөдөр яахаараа Улсын Их Хуралд хууль гаргаж хэлэлцдэг юм.

Түдгэлзүүлсний дараа үүнийг чинь хэлэлцэх ёстой шүү дээ. Энэ хооронд ямар юм хийж шийдэх гээд байна. Ямар юм шийдэх гээд байна. Ямар юмыг Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатын шүүхээр шийдүүлэх ийм тохироо явагдаад байна гэж хардаж байна.

Энэ том уул уурхайтай холбоотой олон маргаан байгаа гэсэн.

Монгол Улсын шүүхийн тухай хууль Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн тухай би олон удаа байр суурь илэрхийлж байсан.

Шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах эрхээ хангах энэ асуудал чинь үнэхээр Үндсэн хууль зөрчсөн нь тодорхой шүү дээ. Тэгтэл Монгол Улсын Үндсэн хуулийн тухай хуульд Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэлт гаргачаад өнөөдөр Шүүхийн тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиудын заалтуудыг түдгэлзүүлж байгаа нь өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн асуудлыг өнөөдөр Улсын Их Хуралд авч үзэх шаардлага үүсэж байна гэж ойлгож байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль гэж байгаа.

Энэ хууль дээр Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэлт гаргачаад хэрэг маргааныг түдгэлзүүлдэг ийм ямар шүүхийн практикийг өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэц оруулж ирж байна.

12 сарын 23-нд түдгэлзүүлсэн асуудлыг өнөөдөр яахаараа Улсын Их Хурал авч хэлэлцдэг юм.

Түдгэлзүүлсэн заалтыг чинь л өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцдэг биз дээ. Тэр 12 сарын 23-наас хойш хэлэлцье л дээ. Энэ асуудлыг.

Урьдчилаад энэ хооронд, өнөөдөр чинь 6 сарын 15. Энэ 6 сарын хугацаанд юу хийх гээд байна. Цэцтэй нийлж, Дээд шүүхтэй нийлж Улсын Их Хурал маань

юу хийх гээд байна. Үүнийгээ ард түмэндээ хэлье.

Ийм зарчимгүй, ийм хууль хэрэглээний нэгдсэн хэрэглэгээ, хүний эрх шүүхэд шударга шүүхээр шүүлгэх, шүүх хараат бус байх энэ зарчим чинь алдагдсаар байгаад өнөөдөр шүүхэд итгэх итгэл, төрд итгэх итгэл чинь байхгүй болсон шүү дээ.

Түүний хамгийн тод жишээ өнөөдөр энэ асуудал болж байна. 12 сар хүртэл 6 сарын хугацаанд энэ асуудлыг түдгэлзүүлэлгүй байя. Тэр хооронд хулгай, луйвраа хийж авцгаа гэдэг ийм байдлаар Үндсэн хуулийн цэц хандсан гэж ойлгож байгаа.

Монгол Улсын Дээд шүүх ч гэсэн өнөөдөр энэ бүх хуулийг тайлбарласан Дээд шүүхийн тайлбар гэж байхгүй шүү дээ.

Гурван хуулийг. Гэтэл өнөөдөр аливаа хууль маргааныг хяналтын шатын шүүхээр шийдвэрлэхдээ Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарыг хэрэглэнэ гэж байгаа. Тэгвэл бүх энэ хуулиудаа Монгол Улсын Дээд шүүх тайлбарлах хэрэгтэй. Ингэж бид хууль гурилдаж, хулгай хийж болохгүй.

Энд ямар асуудал явагдаад байна. Энэ дээр Улсын Их Хурал.../минут дуусав/

Г.Занданшатар: Ш.Адъяшаа гишүүн санал хэллээ. Тийм ээ.

Горимын санал гаргаагүй. Үндсэн хуулийн цэцийн 02 тоот билүү, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, тэгээд хүлээн аваад шийдвэрлэчихсэн.

Тэр үед энэ асуудлаар маргаан, мэтгэлцээн өрнөж асуулт хариулт явагдсан. Тэгэхдээ бас яг хуулийг нарийвчлан унших аваас Үндсэн хуулийн 66.2-т байх аа, 66.2-т Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гэж байгаа юм.

Тэгэхээр зөрчсөн гэж 2 бий, нийцээгүй гэж 2 бий. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бус шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх.

Тэгэхээр нийцээгүй байна гээд дүгнэлт гаргаад оруулж ирээд түдгэлзсэн гэж энэ асуудлыг хэлэлцэх үедээ манай хуульчид тайлбарлаад л, тэгээд л энэ хуулийн төсөл орж ирж байгаа л даа.

Үүнийг тайлбарлахгүй бас энэ Үндсэн хуулийн зөрчил болон хуулийн зөрчил үгүй ээ гэж үзэж байгаа.

Тэгэхээр горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай.

Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Ойрын өдрүүдэд хоёр жагсаал хийнэ.

Маргааш Үндсэн хуулийн цэц дээр очиж жагсаал хийнэ.

2021 оны 7 сард хоёр жилийн туршид тэмцэж байж хуурамч шатахууны эсрэг хуулийг Их Хурлаар батлуулсан. Гэтэл энэ хуулийг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэж хүлээж авсан байна.

Энэ хуурамч шатахуунаар нийт зах зээлийн 20 хувийг, 200 мянган тонн хольц оруулж ирж хольж ард иргэдийн дизель машины дизель аппаратурыг жил болгон эвддэг. Бензин машины бензин хөдөлгүүрийг хоёр жил тутамд эвддэг.

Дээрээс нь тэр хүнд металаар нь бидний алаг үрс амьсгалж хорддог. Тэгээд энэ хуурамч шатахуун хийснийхээ үр дүнд 80 тэрбум төгрөгийн ашиг олдог. Монголчуудыг хохироож байгаад.

Тэгээд энэ хуулийн эсрэг тэмцэж байж батлуулсан юм. Гэтэл үүнийг Үндсэн хуулийн цэц маргаан хүлээж авсан байна.

Би энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн цалинг 2016 онд өөрөө санал гаргаж байгаад 1 сая төгрөгийн цалинтай байж байхад нь 3 сая төгрөгийн цалинтай болгосон.

Гэтэл сүүндээ цадаагүй муусайн төлөгнүүд тэр 80 тэрбумын ашиг руу харж тэндээс авлигал авах гэж байгаа юм уу, яах гэж байгаа юм. Энэ хуулийг оруулж ирж байна.

Маргааш өглөө би ганцаараа ч хамаагүй очоод жагсана. Манай машинаа эвдүүлдэг, алаг үрсээ хордуулдаг ард түмэн хамт очоод жагсвал жагсана биз. Үүний эсрэг ясаа цайлтал үзсээр байгаад л дуусна.

Олон санаатай хүмүүс энэ хуулийг оруулж ирэхийн төлөө явдаг. Би мэднэ.

Тийм учраас маргааш өглөө би Үндсэн хуулийн цэц дээр очиж тэр сүүндээ цадаагүй төлөгнүүдтэй үзэлцэнэ.

Хоёр дахь жагсаал. Одоо Их Хурал завсарлахад нэгхэн сарын хугацаа дутуу байна.

Тийм учраас нийгмийн даатгалын багц хуулийг яаралтай хэлэлцэх талаар ажиллах зайлшгүй шаардлага гарч ирж байна. Бидний ахмадууд 7 жилээр тэтгэвэр тогтоодог болсноос хойш 150 мянган төгрөгөөр хохирдог байсан бол 7 сарын 1-нээс энэ тэтгэвэр нэмэгдэхээр 250-аас 300 мянган төгрөгөөр хохирдог болох нь.

Тийм учраас энэ жагсаалыг 2023 оны 6 сарын 19-ний 12.00 цагт хийнэ. Манай ахмадууд хүрч ирж энд оролцоорой.

Өнгөрсөн 11 сард хүйтэн байхад бид хамтдаа хийж байсан зураг нь энд байж байна. Одоо дулаан сайхан болсон. Бүгдээрээ хамтарч 7 жилийг 5 жил болгох энэ асуудлаа шийдвэрлэх.

Дээрээс нь өнгөрсөн 2018 оноос хойш 7 жилээр бодуулсан тэр хүмүүсийг буцааж 5 жил болгож бодуулах. Мөн түүнчлэн нөхөн олговор болгох энэ хоёр хуулийг хамтдаа хэлэлцүүлэх ийм зайлшгүй шаардлага гарчаж байна.

Манай ахмадууд үнэхээр санаачилгатай, соёлтой хүмүүс байдаг.

Тэгээд өдөрт миний утсанд 7 жилийг 5 жил болох чинь яасан бэ гэдэг 40, 50-иараа мессеж ирдэг.

Нэг долоо хоног л үг хэлэхгүй өнгөрөхөөр л ард түмэн энэ хуулийнхаа мартчихав уу гэж санаа зовнидог. Тэр хүмүүс одоо ингээд гэрээсээ сошиалаар над руу захидал бичиж байхын оронд тэр жагсаал дээр бүгдээрээ ирцгээгээрэй.

Энэ эрх баригчдыг бас нэгэнт л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрсдийнхөө тоог нэмж авсан, дээрээс нь жагсаалтад орох тэр боломжоо нээж

авцгаасан. Түүний хариуд яах вэ эрх баригч нар бас нэг сайн зүйл хийлээ. Тэтгэвэр, цалинг нэмлээ, хүүхдийн мөнгийг 100 хувь нэмлээ.

Одоо харин тэтгэвэрээ бага авч байгаа тэр шалтгааныг зөв болгох тэр ажлыг нь одоо энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрсдөө асар их эрх мэдэл авсан тэр хүмүүсээсээ шаардах цаг болж байна.

Тийм учраас энэ дээр манай Их Хурлын гишүүд бүгдээрээ оролцоорой. Манай Ардчилсан намын гишүүд бүгдээрээ оролцох байх.

Манай энэ тэтгэврийн асуудлаар их ярьдаг Н.Учрал гишүүн ойрдоо юм ярихгүй байгаа шүү. Чи очиж үг хэлээрэй. Манай Г.Тэмүүлэн хөдөө орон нутагт намайг сайн сурталчлаад явсан байна лээ. Г.Тэмүүлэн очиж үг хэлээрэй. Та бүхнийг урьж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Ш.Адъяаа гишүүн хаачив. Санал хураалт явуулах шаардлага байна уу? Горимын саналаар санал хураалт явуулах болчихоод байна. Санал хураалт явуулах. Та саналаа татчих юм уу?

Энэ чинь хуультай асуудал байхгүй юу. Тэгээд 14 хоногийн дотор хуулийн хугацаатай учраас завсарлага өгвөл би чинь аягүй бага л завсарлага. Завсарлага биш л дээ. Энэ чинь нээрээ хойшлуулна гэсэн горимын санал бол.

Санал хураалт явуулаад шийдчихье дээ. Энэ асуудал хуулийн хугацаатай шийдэх ёстой асуудал.

Үндсэн хуулийн 66.2-т зааснаар цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд

оруулж ирэх эрх хэмжээтэй, Үндсэн хуулийн эрхтэй. Тэр дагуу Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын байнгын хороо хүлээж авсан бол түүнийг хууль санаачлах эрхтэй. Энэ хэмжээндээ л дэгийн тухай хуулиар л явж байгаа асуудал. Тэгээд үүнийг Байнгын хороон дээрээ л Ш.Адъяаа гишүүн яривал сайн байна.

Ингээд Ш.Адъяаа гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Ш.Адъяаа гишүүний горимын саналаар 12 дугаар асуудал. Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн ийм горимын санал гаргалаа.

Ш.Адъяаа гишүүний саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Үүнийг хуульчид та хэд сайн ярьцгаа.

Ингээд Ш.Адъяаа гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй. Уг хууль хэлэлцэх асуудлын жагсаалтад багтлаа.

Гэхдээ эхлээд төсвийн хуулиа явуулах ёстой.

Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд

/Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Энэ асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкан дахь мөнгөн хадгаламжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дархлаажилтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсыг хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор болгох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалгатай гэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай,

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Хууль баталсантай холбогдуулах арга

хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.5 хувийн саналаар санал дэмжлээ. /алх цохив/

Энэ их олон хуулийн нэр дурдагдаад байгаа боловч үндсэндээ цахим гарын үсэгт шилжүүлэхтэй холбоотойгоор л гол зохицуулалтууд явж байгаа. Нэг заалттай хуулийн төслүүд. Ихэвчлэн, дийлэнх нь.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Хууль зүйн байнгын хороогоор хянуулаарай. Олон хууль дотор заримдаа юм орж, гарчхаад байгаа шүү дээ.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төсвийн тодотголоор нэмэгдэж байгаа орлого, зарлагыг тэнцвэржүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх Засгийн газрын үрийн нийт хэмжээг бууруулах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан

талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн дарсан, орсонгүй гэж байна. Нэмж оруулъя. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа.

Ж.Батсуурь гишүүн больсон. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Энэ хугацаанд төсвийн тодотгол ч орж ирж байна.

Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл гээд нэг ийм зүгээр ямар ч үнэ цэнгүй нэг ийм болчихсон асуудал бас давхар орж ирдэг юм.

Энэ нэг орж ирж л байдаг юм гэсэн янзтай болчихсон. Уг нь бол энэ чинь хуультай. Төсөв маань өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай.

Тэгээд Сангийн яам ч гэсэн мэдээлэл дээр нь энэ нэг өөрчлөх ёстой

юм даа гэсэн тиймэрхүү байдлаар хандаж ирсэн. Тийм. Энэ бол тодорхой болчихсон.

Тэгэхээр ард иргэдтэй уулзаад явахаар Сангийн яамны гаргаж байгаа бодлого, мөнгөний бодлогууд чинь болохгүй байна.

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөлдөө энэ байдал чинь яаж тусаж байгаа юм бэ? Мөнгөний үнэ цэн гэдэг юм чинь, инфляц гэдэг юм чинь яваад байна шүү дээ.

Монголбанк хариуцах ёстой нь үнэн. Засгийг газар бас нэг талдаа хариуцлага хүлээх ёстой. Инфляцыг буруу бодож байна, худлаа бодож байна. Юмны үнэ чинь нэг дахин, хоёр дахин нэмэгдчихээд байхад яасан ийсний 10 хувийн инфляц нэг оронтой тоо руу оруулах инфляц яриад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ямар бодлого явж байгаа юм бэ? Энэ юмны үнэ өсөөд байгаа гэдэг чинь монгол төгрөгийн ханш суларчхаад байгаа шүү дээ. Ер нь бол.

Монгол Улс импортын хамааралтай улс. Валютаар маш их зүйлээ гадаадаас авдаг. Ялангуяа хүнс, бараагаа. Зөрүүлж юм үйлдвэрлэхгүй байна. Үйлдвэржилтийг төсвөөр дэмжих бодлого ерөөсөө байхгүй байна.

Хувийн хэвшлийнхнийг ч төсвөөр дэмжих бодлого алга байна.

Сангийн яам өөрчилж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл дээр ер нь юу оруулж ирж байна аа? Тодорхой хэлээч. Хэлэх юм байна уу?

Хоёрдугаарт, үйлдвэржилт. Бид юм хийдэг болмоор байна шүү дээ.

Дандаа л олсон хэдэн төгрөгөө тараагаад хаячихдаг. Тэгээд нэмүү өртөг шингэдэг үйлдвэрлэлийг дэмжих бодлого явахгүй байна шүү дээ. Тийм.

Дарханы арьс ширний цогцолбор гэдэг бодлого нэлээн явсан. Тэгээд хувийн хэвшлийнхэн дэмжээд нэлээн явсан. Хөдөөгүүр явж байхад малчдын ярьж байгаа бодлогын ихэнх нь энэ арьс шир чинь үнэгүй хаягдал хог болчихлоо. Энэ дээр төр чинь энэ үйлдвэр юм хумаа хурдан оруулаач ээ. Яагаад энэ бодлогоо явуулахгүй байгаа юм бэ гэж асууж байгаа юм.

Энэ тал дээр ямар бодлого, энэ өөрчилж оруулж ирж байгаа төсвийн хүрээний мэдэгдэл энэ юм нь дээр чинь байна? Хоёр дахь асуулт нь энэ.

Инфляц, төгрөгийн ханшийн уналт дээр ямар асуудал байна?

Тэтгэврийн асуудал орж ирж байгаа. Тэр нь тэтгэврийн зөрүү гэдэг хоёр төрлийн зөрүү байдаг. Нэг төрлийн зөрүүг нь оруулж ирж байгаа.

Яах вэ, үүний ар дээр баахан гомдол гарна. Саяын тэр хүүхдийн мөнгөн дээр 91, 9 гээд буруу бодлого явуулаад буцааж байгаа шиг дахиад асуудал гарна.

Тэгэхээр нэг нь ажиллаад, нэг нь нөхөн тооцуулаад адилхан тэтгэвэр авч байгаа иргэдийг бухимдуулж байгаа энэ асуудал дээр ирэх жилийн төсвийн хүрээний мэдэгдэл энэ тэр дээр чинь дахиж бодлого орж явах юм уу? Ингээд нэг хэсэг гомдлыг нь орхиод, шийдэхгүйгээр нүдэн балай, чихэн дүлий орхиод нэгийг нь шийдсэн болоод явах юм уу?

Яг энэ тэтгэврийн зөрүүтэй холбоотой асуудал дээр оруулж ирж байгаа энэ асуудал дээр чинь тодорхой бодлого байна уу гэсэн ийм гурван асуултад хариулт авъя. Тэгээд тодруулья.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ц.Сандаг-Очир дарга хариулах юм уу? Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн хариулна.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Төсвийн байнгын хороо өчигдөр төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулж 2024-2025 оны төсвийн төсөөлөлтэй холбогдуулж анхныхаа хэлэлцүүлгийг хийсэн.

Үндсэндээ таны ярьж байгаа бодлогын хүрээнд төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулж ер нь цаашид бид дунд хугацааныхаа төсвийн хүрээний мэдэгдлийг чанд мөрддөг байх гэдэг зарчмын саналтай зарчмын хувьд хувь хүнийхээ үүднээс нийлж байгаа.

Бидний хувьд яах вэ, цаашдаа ч гэсэн төсвийнхөө тогтвортой байдлыг хангах үүднээс эрх зүйн хувьд томоохон шинэчлэлийг хийж, тодорхой хязгаар, зохицуулалтыг хуулийн хүрээнд хийх ёстой гэж хувь хүнийхээ үүднээс үзэж байгаа.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл дээр үндсэндээ гол 9 төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд байдаг.

Тэгэхээр бидний хувьд энэ асуудлууд дээр онцгой анхаарч, тодорхой хэмжээнд цаашдаа бодлогын хэмжээнд анхаарч ажиллах шаардлага байгаа.

Үндсэндээ үйлдвэрлэгчид болоод хувийн хэвшлийг дэмжих, бодлогоор дэмжих асуудлын хүрээнд мэдээж бид

ирэх оны төсвийн хүрээнд энэ асуудлуудыг ярих ёстой.

Энэ жилийн хувьд бид одоо орж байгаа төсвийн тодотголын асуудал маань 1.8 их наяд төгрөгийн нэмэгдлийн асуудал тус төсөв дээр нэмэгдэж тусгагдаж орж ирж байгаа. Энэ маань үндсэн гол асуудлыг та мэдэж байгаа. Цэвэр тэтгэврийн зөрүүг арилгах. Мөн дээрээс нь үндсэн цалингийн зөрүүг арилгах, цалингийн нэмэгдлийг бий болгох, тодорхой хэмжээнд төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэлийг хийх хүрээнд энэ өөрчлөлтүүд маань орж ирж байгаа. Үүн дээрээсээ нэмэгдээд гурав дахь үндсэн том асуудал бол хүүхдийн мөнгө болоод халамжийн зардалтай холбоотой асуудлууд байгаа юм.

Тэгэхээр эдгээр асуудлууд маань нийлээд 1.8 их наяд төгрөгийн зөрүү орж ирж байгаа. Эдгээр асуудлуудыг бид яах вэ нэг талдаа өмнөх өнгөрсөн жил 2023 оны төсвийг баталж байх хугацаанаас тодорхой хэмжээний орлого давж биелж байгаа. Эхний 4 сард нийт өнгөрсөн оныхоо 9 сарын хэмжээний тодорхой экспортыг хийсэн. Нүүрсийг гаргасан. Тодорхой эдийн засгийн бодит өсөлт тодорхой төсөөлж байснаас өсөлттэй гарах, орлого нэмэгдэх энэ боломж бололцоо бүрдэж байгаатай холбогдуулж хийж байгаа.

Нөгөө талдаа бидний анхаарах ёстой гол энэ нэмэгдлүүдийг бий болгох үндсэн цалин болоод төрийн албан хаагч нар нийгмийн баталгааг хангах, мөн дээрээс нь тэтгэврийн зөрүүг арилгах болоод тэтгэврийг нэмэгдүүлэх энэ бодлого зайлшгүй хийгдэх шаардлагатай болчихоод байгаа.

Нийтдээ Монгол Улсад инфляцын түвшин маань 20 сар дараалаад 10 хувиас

дээш өсөлттэй гарчихсан. Иргэдийн дунд бодит орлого 5.9 хувиар буурчихсан гэдэг үндсэн тоон мэдээллүүд суурилж. Ер нь бид иргэдийн орлогыг дэмжих, инфляцынхаа түвшинтэй уялдуулж тодорхой нийгмийн баталгааг хангах бодлогуудыг гаргах шаардлагатай байна гэсэн үндсэн дээр энэ зүйлүүдийг хийж байна.

Тэгэхээр энэ удаагийн төсвийн тодотголын хүрээнд ямар нэг байдлаар үйлдвэрчид болоод хувийн хэвшлийг дэмжих шууд чиглэсэн бодлогын асуудлууд орж ирээгүй.

Тэгэхдээ бид эргээд 2024 болоод дараа дараагийн оны асуудлууд дээр мэдээж анхаарч байх ёстой гол чухал асуудлын нэг энэ байгаа. 2023 он дээр бид бас нэг талдаа хэдий шинэ хөрөнгө оруулалт, шинэ бүтээн байгуулалтуудыг шинээр тусгаагүй ч гэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж байгаа хүнсний хангамж болоод хүнсний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой төслийн хүрээнд тодорхой 290 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг хүнсний хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхтэй холбоотой бий болгох хүрээнд бий болгож оруулж тусгаж оруулж ирсэн.

Энэ бодлогын ажлууд хэвээрээ үргэлжлээд явж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлэх байна.

Ер нь төсвийн хүрээтэй холбогдуулаад ер нь бид бас яах вэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Туваан: Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллүүд дээр үйлдвэржилтийн бодлого, нэмүү өртөг шингэх үйлдвэрийн бодлого ороогүй гээд сонсчхов уу, яав? Энэ бол дэндүү харамсалтай байна. Яг л нөгөө бахь байдгаараа. Уул уурхайгаас олсон мөнгөө бид буцаад тараадаг энэ бодлого руу л явах гэж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр би зөв сонсчхов уу, үгүй юу гэдгийг хэлээд өгмөөр байна.

Хоёрдугаарт, дэгээрээ Төсвийн байнгын хороо хариулдаг юм бол Улсын Их Хурлын 32 гишүүн санаачлаад төсвийн асуудал дээр чинь реформ хийгээд бид нарт танилцуулаад Ардчилсан намын гишүүд ч дэмжээд, Ардын намын гишүүд ч дэмжээд явсан энэ бодлого, асуудал чинь ер нь хаана явж байгаа юм бэ? Энэ ер нь тэгээд зөв юм уу, буруу юм уу? Ойрд орж ирэх юм уу? Байнгын хороо үүнийг нэг хариулаад өгөөч.

Г.Занданшатар: Г.Тэмүүлэн дарга хариулна. Ганзоригийн Тэмүүлэн. Төсвийн байнгын хороон дарга хариулна.

Г.Тэмүүлэн: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр бид үндсэндээ яг л энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд, төсвийн сайн засаглалыг бий болгох хүрээнд, ер нь цаашаа төсвөө тогтвортой, хариуцлагатай, ил тод байлгах хүрээнд нийт 32, 33 гишүүд төсвийн шинэчлэлийн хуулийн төслүүдийг өргөн барьсан. 14 хуульд өөрчлөлт оруулах.

Тэгэхээр ерөөсөө үндсэндээ энэ төсвийн засаглал болоод тогтвортой байдлын гурван тулгуур зарчим л байгаад байгаа юм. Төсвийн дүрмүүд, төсвийн тусгай шаардлагууд.

Саяын миний түрүүн дурдсан 9 тусгай шаардлага, суурь зарчмын асуудлууд. Дээрээс нь дунд хугацааныхаа энэ төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг заавал дагаж мөрддөг байх гэдэг асуудлууд энэ төсвийн засаглал болоод тогтвортой байдлын маань гурван тулгуур асуудлын нэг байгаад байдаг.

Гурав дахь асуудал нь төсвийн хяналтын байгууллагуудыг бэхжүүлэх асуудлууд байгаа.

Тэгэхээр ерөөсөө яг энэ гурван чиглэл дээр суурилж бид төсвийнхөө төслийг өргөн барьсан. Төсвийн шинэчлэлийнхээ хуулиудыг өргөн барьсан. Ингээд сая нэг сар гаран Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулж саатсан.

Ирэх долоо хоногоос хэлэлцэгдэж эхлэх байх гэж итгэлтэй байгаа. Энэ хүрээндээ.../минут дуусав/

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор:

Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулахаар орж ирж байна.

Тэгээд эдийн засагт ер нь энэ төсвийн бодлого маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ зардлын тэлэлт эдийн засагт олон сөрөг үр дагаврыг дагуулах эрсдэлтэй байгаа. Өнгөрсөн хугацаанд төсвийн оновчгүй бодлогоос болоод боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт маш сөргөөр нөлөөлөх нөхцөлүүд байсан.

Тэгээд 2000 оноос хойш зардлын бүтцэд ерөөсөө өөрчлөлт орж ирээгүй юм билээ. Тэгээд нийт төсвийн 70 гаруй

хувийг энэ урсгал зардал эзэлж байгаа. Хөрөнгийн 20 орчим хувийг хөрөнгийн зардал эзэлж байгаа.

Тэгэхээр төсвийн бодлого дээр ер нь шинэчлэлт өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага, цаг хугацаа ирсэн гэж миний хувьд ойлгож байгаа. Яагаад гэхээр 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг аваад үзэхээр өнгөрсөн цаг хугацааны 10, 20-оод жил явж ирсэн яг энэ зардлын бүтэц бараг тэр чигээрээ орж ирж байгаа. Алдагдалтай төсөв орж ирж байгаа.

Тэгэхээр Г.Тэмүүлэн гишүүн ээ, Улсын Их Хурлын нийт гишүүдийн 50 орчим хувь тийм ээ, өнөөдөр өргөн бариад байсан төсвийн шинэчлэлийн хуулийн төсөл чуулганаар яагаад орж ирэхгүй байгаа вэ? Энэ тал дээр хариулт авмаар байна.

Тэгээд ер нь Сангийн яам өнгөрсөн төсвийн хугацаанд явж ирсэн төсвийн төлөвлөлт дээрээ бас нэг дүгнэлт хийгээд, үнэлэлт өгөөд, дуусаагүй барилга ажил, төсөл, хөтөлбөрүүдээ дүгнээд тэгээд ингээд урагшилна гээд тэгсэн. Энэ дээр ямар нэгэн тайлан гаргасан зүйл байна уу?

Тэгээд нэн ялангуяа төсвийн шинэчлэлийн хууль миний хувьд маш чухал гэж үзэж байгаа.

Ер нь нэлээн реформын шинж чанартай гурав, дөрвөн шинэчлэлийн шинж чанартай зохицуулалтууд орж ирэхээр байгаа шүү дээ. Тухайлах юм бол төсвийн төлөвлөлтийг сайжруулах ёстой байгаа. Олон нийтийн хяналт тавих бүрэн боломжтой болж байгаа. Төсвийн төлөвлөлтийг тал бүрээс нь хэлэлцэж олон нийтийн хяналттайгаар нийтээрээ хяналт тавих зохицуулалтуудыг тусгасан байгаа.

Дараагийн бас нэг чухал зохицуулалт нь энэ төсвийн бодлого тогтвортой байх тухай асуудал байгаа юм. Тэгээд төсөв тогтвортой байх үндэс нь энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бэхжүүлэх асуудал байгаа юм.

Тэгээд энэ зөвлөл хараат бус байх хэрэгтэй байна, улс төрөөс ангид байх хэрэгтэй байна, олон нийтийн дуу хоолой болсон мэргэжлийн том бүтэц энэ дээр ингээд ажилламаар байна.

Ингэснээр мэдээж өр зээл тавигдах шаардлагыг нарийсгах, нарийвчлах шаардлагатай болно. Төсвийн бодлого тогтвортой болно. Төсвийн зохицуулалтууд, зарцуулалтад тавих хяналтуудыг олон нийтийн хяналтад оруулж нэлээн хариуцлагыг сайжруулах ийм олон талын ач холбогдолтой хуулийн төсөл байгаа гэж миний хувьд ойлгож байгаа.

Тэгээд ер нь төсөв бол төсвийн бодлого нийгэм, эдийн засагтаа үр өгөөжөө өгдөг байх хэрэгтэй. Иргэдийн амьдралд бодит үр өгөөжөө өгдөг байх ёстой. Ер нь өр үйлдвэрлэдэггүй байх ёстой гэдгийг олон жил яриад байгаа боловчиг энэ ахихгүй байна.

Тэгэхээр энэ хууль яаралтай орж ирэх ёстой байна гэж харагдаж байна.

Тэгээд ер нь энэ шинэчлэлийг цаг хугацаа яваад л байдаг, тэгээд энэ шинэчлэл өөрчлөлтийг яаралтай санаачлаад шуурхай явуулахад энэ удаашраад байгаа шалтгааныг нь олж хурдан яаралтай чуулган руу оруулж ирэх хэрэгтэй байна. Г.Тэмүүлэн дарга аа.

Г.Занданшатар: Үг хэлчихэв үү. Тийм ээ. Асуулт. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Төсвийн шинэчлэлийг дэмжиж байгаа гишүүддээ баярлалаа.

Тэгэхээр бид бүхний хувьд нэг талдаа сүүлийн 15, 20 жилийн хугацаанд Монгол Улсын төсөвтэй холбоотой, төсөв санхүү, эдийн засагтай холбоотой энэ асуудлууд дээр үнэлэлт дүгнэлт хийж цаашид тодорхой бодлогын өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлагатай байна гэсэн үндсэн дээр гишүүд хамтдаа энэ хуулийн төслүүдийг өргөн барьсан.

2023 оны 01 сарын 17-нд хуулийн төслийг өргөн барьсан. Үүнээс хойш бараг хагас жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Яах вэ, сая сүүлийн сар, хоёр сарын хугацаанд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэгдэж байгаатай холбогдуулаад, төсвийн тодотгол орж ирж байгаатай холбогдуулаад тодорхой хэмжээнд хойшилж байгаа асуудлууд байна.

Тэгэхээр бид төсвийн шинэчлэлтэй тууштай байх ёстой. Бодлогын ухралтыг хийхгүй байх ёстой. Энэ өөрчлөлтийг даруйхан шиг орж ирж нэг сарын өмнө ч гэсэн батлуулж, нэг жилийн төсөв ч гэсэн тогтвортой, хариуцлагатай байх, үр ашиг, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хуулийн босго шаардлагыг өндөрсгөх хүрээнд энэ шинэчлэлийг хийх ёстой л гэдэг хувь хүний итгэл үнэмшил байгаа.

Цаашдаа бид бүхний бодож байгаа хүрээнд ер нь зүгээр макро түвшиндээ нийгэм, эдийн засагт төсвийн үзүүлэх нөлөөллийг бууруулах зайлшгүй шаардлагатай гэж хараад байгаа юм. Нийгэм, эдийн засагт төсвийн үзүүлэх нөлөөллийг бууруулах.

Ингэж байж цаашдаа юу гэдэг юм хувийн хэвшил дээрээ тулгуурласан, хувийнх нь хөрөнгө оруулалт нь давамгайлсан ийм эдийн засгийн эрүүл бүтцийг бид бий болгох зайлшгүй шаардлагатай байна гэж энэ бодитоор харагдаж байгаа.

Нэг талдаа сүүлийн хоёр, гурван жилийн хугацаанд бас энэ КОВИД-ын нөлөөлөл ч асар ихээр нөлөөлсөн. Үүнээс улбаалж дотоодын нийт бүтээгдэхүүн болоод эдийн засагт төсвийн үзүүлэх нөлөөлөл, эзлэх байр суурь нь бараг 10 орчим пунктээр нэмэгдэж, одоо 37.5 хувьтай болсон байгаа.

Тэгэхээр энэ бол бид цаашдаа төсвийнхөө хүрээнд эрүүл өөрчлөлтийг хийж, бодлогын том өөрчлөлтийг хийж, эргээд эрүүл эдийн засгийн бүтцийг бий болгох хүрээнд төсвийн үзүүлэх нөлөөллийг бууруулах зайлшгүй шаардлагатай байна.

Ингэж байж бид цаашдаа чинээлэг дундаж давхаргаа дэмжсэн бодлого төлөвлөлт, төсөвлөлттэй болгох, төсвийнхөө бодлогоор дэмжиж хувийн хэвшлээ бий болгох орон хувьцаа үүснэ гэж үзэж байгаа.

Тэгэхээр ирэх долоо хоногоос Улсын Их Хурал энэ асуудлыг оруулж ирж төсвийн шинэчлэлийн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Тэр дундаа Сангийн яам болоод Сангийн сайд төсвийн шинэчлэлийн асуудлыг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Тэгээд энэ хүрээнд бид хамтдаа шинэчлэлийг хийнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Хоёр дахь асуудал нь, Д.Өнөрболор гишүүн юу билээ?

Г.Занданшатар: Тэгээд ер нь цаг хугацаатай шахчихсан энэ төсвийн тодотгол, сонгуулийн хууль гээд асуудлууд байгаа учраас ингээд үлдээд байгаа. Энэ төсвийн шинэчлэлийн хуулиа энэ цаг хугацаатай асуудлууд дууссаны дараа яаравчлах хэрэгтэй.

Энэ Төрийн цахим үйлчилгээний хуулиуд, боловсролын хууль гээд дандаа л нэн яаралтай хуулиуд хаврын чуулганд шахагдаж байгаа. Наадмаас өмнө 7 сарын 07-нд чуулган хаахаар төлөвлөж байна.

Тэрнээс өмнө энэ хуулиудаа Байнгын хороод нэлээн идэвхтэй шуурхай ажиллах шаардлагатай.

Одоо Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Төсвийн тодотголыг дэмжиж байгаа. Энэ дээр 1.9 их наяд орчим төгрөгийн цалин, тэтгэврийн хэмжээ нэмэх гэж байгаа гэж ойлгож байгаа. Бас жижиг сажиг өөр асуудлууд байгаа.

Энэ цалин, тэтгэврийг дэлхийн жишиг, эдийн засгийн шинжлэх ухаанд эдийн засгаа тэлж, бүтээмж нэмж байж цалин, тэтгэврийг нэмдэг ийм практик байдаг.

Манайд эдийн засаг тэлж байгаа боловч бүтээмж хэр зэрэг нэмэгдэж байгаа нь. Нэмэгдэхгүй л байгаа л даа. Энэ төсвийн тодотголыг харахад би бас эдийн засагч хүний хувьд хэд хэдэн зүйл дээр анхаарах ёстой болов уу гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, төсвийн тодотгол хийснээр үүсэж болох эрсдэл энд тодотголын баримт бичиг дотор алга байна. Ямар эрсдэлүүд үүсэж болох вэ,

ямар арга хэмжээнүүдийг авах вэ гэдэг юм бодож төлөвлөх ёстой гэж бодож байгаа.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн байдал ерөнхийдөө их хүнд байгаа. Тийм. Хүнд байгаа. Манайд ч ялгаа байхгүй. Өнөөдөр манай инфляц 11.3 хувь байгаа.

Магадгүй энэ өөрчлөлтийг хийснээр инфляц 2 хувиар нэмэгдэж болзошгүй. Өнгөрсөн жилүүдэд бид 34 хувийн инфляцтай 14 орчим их наяд төгрөгийг нэмээд иргэдийнхээ хармаанаас алдсан.

Энэ 2 хувийн инфляц хэрвээ гарах юм бол дахиад 600-аас 700 тэрбум төгрөг гарах бодит эрсдэл байгаа. Манай Засгийг газар үүнийг харж ажиллах ёстой гэж бодож байгаа.

Ханш тогтвортой байгаа. Энэ сайн үзүүлэлт. Энэ юу гэхээр нүүрсний мөнгө валютаар орж ирээд сая тогтвортой байснаа дахиад сулраад эхэлчихлээ л дээ. Сүүлийн хэдэн хоногуудад сулраад эхэлчихсэн. Энэ их муу үзүүлэлт байгаа юм. Хөгжлийн банкны 500 сая орчим долларын төлөх төгс шийдэл гараагүй байгаа. Түүхий эдийн мөчлөг таатай биш байна.

Ингээд цааш цаашдаа нэлээн бодит эрсдэлүүд байна. Үүнийг үзэж харах ёстой.

Энэ өндөр инфляц өрхийн худалдан авах чадварт нөлөөлж, ядуурлыг өсгөөд байгаа. Үүнийг үзэх ёстой.

Дэлхийн хэмжээнд аваад үзэх юм бол түлш, эрчим хүчнээс хамаарсан инфляц буурч байгаа боловч үйлчилгээнийх нь буурахгүй байгаа.

Манайд аль аль нь олигтой буурч өгөхгүй ингээд яваад байгаа.

Бодлогын хүү 13 хувь байгаа. Үүнийг дахиж нэмж болзошгүй гэж хүмүүсийн амнаас гарч байгаа. Ингэх юм бол тэр үйлдвэрлэл гэдэг юм байхгүй болно. Инфляцыг тодорхой хэмжээнд барьж болох байх.

Зээлийн хүү өндөр байгаа ч гэсэн зээл аваад байгаа. Авахаас өөр арга байхгүй. Ингээд цалин, тэтгэвэр барьцаалсан зээлийн хэмжээ 1.6 их наяд болж өссөн.

Хадгаламж барьцаалсан зээлийн хэмжээ 1.3 нь их наяд болоод ингээд 15 хувиар эхний энэ 5 сарын хугацаанд өсчхөөд байгаа юм. Гэх мэтээр.

Ингээд төгрөгийн ханш суларч байгаа учраас төгрөгт итгэх итгэл алдарснаас 2022 оны жилийн эцсийн байдлаар валютын харилцах дансны үлдэгдэл 5.1 их наяд төгрөг хүрсэн. 39 хувиар. Валютын хадгаламж 6 их наяд төгрөг болж өссөн. 84 хувиар өссөн.

Тийм учраас мөнгөн тэмдэгтийн уналт гэдэг инфляцыг, энэ эдийн засагт маш их сөрөг нөлөө үзүүлж байна гэж.

Энд бас нэг анхаарах ёстой юм бол дэлхийд ингээд олон тохиолддог цаг уурын гамшигт үзэгдэл энэ жил болж болзошгүй гэж. “Эл Нино” гэж. Энэ нь юу гэхээр “хэт халалт” гэж. Энэ үзэгдэл энэ жил үү үүсэж болж байна гэж дэлхийн эрдэмтэд тооцож байна.

Энэ бол улс орны эдийн засагт, тэгээд ялангуяа хөдөө аж ахуйд асар их хортой. Сая 30 хэдэн градус хүртэл 6 сарын эхэнд халлаа шүү дээ. 6 сарын эхээр цас ордог. Дараа нь 30 хэд хүртэл халж байна. Ийм юмнууд байна.

Энэ орлогын тэгш бус хуваарилалттай холбоотой баян хоосны ялгаа дэлхийн чихийг монголчууд дэлдийлгэж байгаа. Манай эдийн засгийн өсөлт ядуурлыг өсгөж байгаа.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн товч хариулчихъя. Тэгээд та санаагаа хэлчихье. Тэгээд та тодруулаад асуучих. Дэг нь тодруулж асуух. Ганзоригийн Тэмүүлэн дарга.

Г.Тэмүүлэн: Б.Баттөмөр гишүүний саналыг хүлээж авч байна.

Үндсэндээ яах вэ бид энэ төсвийн тодотголыг баталж байна. Үүгээрээ нийтдээ бараг 1.9 их наяд төгрөгийн тодотгол орж ирж байгаа. Энэ бол цэвэр ерөөсөө төрийн албан хаагч нарын цалингийн нэмэгдэл болоод, тэтгэврийн нэмэгдэл, мөн бас хүүхдийн мөнгө, халамжийн бодлоготой холбоотой зохицуулалтууд хийгдэж байгаа.

Эдгээр асуудлууд маань нэг талдаа сүүлийн 20 сарын хугацаанд л өндөр байсан инфляцын түвшинтэйгээ уялдуулж иргэдийн бодит орлого 5.9 хувиар энэ жилийн хугацаанд бууж байгаатай уялдуулж л хийж байгаа төрөөс явуулж байгаа бодлогын зохицуулалт гэж ойлгож болно.

Үүн дээр нэг талдаа бид энэ тодотголыг хийж байхын хажуугаар анхаарах асуудлууд байна. Магадгүй саяын тэр яг өөрийн чинь хэлж байгаа эдийн засагт нэмэлт дотоод эрэлт үүсэх эрсдэл байна.

Тэгэхээр магадгүй эрэлтийн шалтгаантай ч инфляц үүсэх эрсдэлийг бид зохицуулах ёстой. Төрийн зүгээс. Тэр дундаа Монгол Улсын Засгийг газар Монголбанк энэ төлбөрийн тэнцлийг

сайжруулах чиглэлээр онцгой анхаарах ёстой байгаа.

Энэ хүрээнд бид нарын хувьд бас яг энэ төсвийн тодотголыг дагалдуулж ер нь таны саналыг үндэслээд Их Хурлын хууль батлагдсантай холбогдуулж, төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулж Их Хурлын тогтоолын төслийг гаргах нь зүйтэй юм байна гэж үзээд байгаа.

Монголбанк болоод Засгийн газарт тодорхой үнийн өсөлтөөс сэргийлэх, инфляцыг тогтворжуулах, бууруулах чиглэлээр бодлогын ажлуудыг хий гэсэн чиглэл өгсөн энэ тогтоолыг Улсын Их Хурлаас гаргах нь зүйтэй байна.

Тэр дундаа бид төсөв, мөнгөний бодлогын тохиргоогоо тухай бүр авч хийж байхад тодорхой зохицуулах боломж бололцоо бүрдэх байх. Инфляцыг бууруулах болоод төлбөрийн тэнцлийг сайжруулах чиглэлээр.

Саяын валютын ер нь бас нэг анхаарах асуудал яах вэ, экспорт нэмэгдэж байгаа. Нүүрсний экспорт болоод уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа түүхий эдийн экспортууд нэмэгдэж байгаатай холбогдуулаад бид валютын цэвэр дотогшлох урсгалыг нэмэгдүүлэхэд бодитой анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

Тухайн бид бүхний гаргаж байгаа экспортын бүтээгдэхүүн болгон эргээгээд буцаад цэвэр валютаараа орж ирдэг байх энэ зохицуулалтыг хийх ёстой.

Үүнтэй холбогдуулаад ер нь эсрэгээрээ орж ирэх урсгалыг нэмэгдүүлэхээс гадна гадагшаа урсаж байгаа урсгалыг ч гэсэн тодорхой

хэмжээнд зохицуулалтыг хийх шаардлагатай байгаа юм.

Магадгүй нөгөө импортын орц их шаарддаг тодорхой биш гадаадаас бид импортоор бараа, бүтээгдэхүүн авдаг барилгын салбар ч гэдэг юм уу, тодорхой томоохон төсөл, хөтөлбөрүүд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ч гэсэн төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг нь бид харгалзаж байж магадгүй хойшлуулах гэдэг юм уу, эсвэл тодорхой хэмжээнд барих зохицуулалтуудыг хийх бодлогын зохицуулалт бас хийж болно гэж хараад байгаа юм.

Энэ дээр мэдээж Засгийг газар, Монголбанк энэ асуудлууд дээр хамтарч ажиллаж төсөв, мөнгөний бодлогын тохиргоог зохицуулалттайгаар хийх боломж бололцоо бүрдэнэ.

Үүнд чиглэсэн магадгүй тодорхой тухайлсан, тусгайлсан хуулийн заалт бүхий чиглэлийг хугацаатайгаар эргээд Улсын Их Хуралд танилцуулахаар Улсын Их Хурлын тогтоолыг зүйгээр баталж гаргая гэсэн төлөвлөгөөтэй байгааг танд хэлэх байна.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна.

Б.Баттөмөр: Тэр Улсын Их Хурлын тогтоол гарах ёстой. Энэ дээр инфляцыг хязгаарлах, ханшийг тогтвортой барих үүргийг Засгийн газарт өгөх нь зүйтэй.

Гаднын эрдэмтдийн хийсэн судалгаа байна шүү дээ. Монголын нэг хувийн эдийн засгийн өсөлт ядуурлыг 0.6 хувиар өсгөж байна гэсэн. Үүнийг судлах ёстой.

Дефолт гэдэг юм бол их холдчихсон гэж бас ойлгож болохгүй шүү. Зарим төлөх ёстой төлбөрүүд одоо хүртэл төлөгдөж, сунгагдаагүй байгаа.

Тийм учраас Монголын эдийн засаг “дефолт”, “инфляц” гэж хоёр том эрсдэл байгаа. Үүнийг хийх ёстой.

Манай эдийн засагт хариу нэхсэн маш их олон асуудлууд байгаа.

Тийм учраас энэ тодотголтой холбогдож гарах эрсдэлүүдийг маш сайн тооцож, түүнийг удирдаж ажиллах ийм шаардлага байна гэж үзэж байгаа.

Үүнийг тогтоолдоо маш сайн тусгаж, Засгийг газар гарах эрсдэлийг маш сайн удирдаж ажиллах ийм шаардлага.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хороо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн байна. Олонхын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн ирцээ бүрдүүлье. Санал хураалт явуулна.

Үүдэнд байгаа нэлээн хэдэн гишүүд орж ирье. Үүдэнд байсан 6 гишүүний 2 нь орж ирлээ. Бусад 4 нь яагаад орж ирэхгүй байна. Санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналаар санал хураалт явуулж байна.

Танхимд 40 гишүүн байсан боловч 27 гишүүн санал өгч 52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараа нь төсөв хэлэлцэх учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу долоо хоногийн Баасан гаргийн 10.00 цагаас эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар өөр өдөр цагт эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэн гишүүдэд тарааж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Нийт гишүүдийн олонхоор буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т

заасны дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд нийт гишүүдийн олонх дэмжсэн бол эцэслэн батлагдсанд тооцно гэж заасны дагуу 39-өөс дээш гишүүний ирцээр энэ хууль батлагдана.

Санал хураалт явуулна. Д.Тогтохсүрэн дарга эцэслэн батлах санал хураалт явуулна. Танхимд 39 гишүүн байна. Энэ цаг хугацаатай асуудлууд. Жаахан шахуу эрчимтэй хэлэлцэж явмаар байна. Ирцээ.

Бүлгийн дарга, Их Хурлын дэд дарга нар ирц бүрдүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Эцэслэн батлах санал хураалт явуулахад бэлэн болсон байна.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдье. Санал хураалт. /алх цохив/

39 гишүүн дэмжиж, хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа.

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсан учраас дараагийн асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт хуулийн 7 төсөл, Улсын Их Хурлын тогтоолын 2 төслийг 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдъя.

Нэг.Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэг хуулиар зохицуулах, төрийн албан хаагчийн тоог үндэсний ажиллах хүчний тоотой уялдуулан тогтоох, төрийн албан хаагчийн үндсэн цалин ба нэмэгдлийн харьцааг оновчтой болгох зэрэг зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хуульд заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд бууруулан тооцох зориулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгалаа.

Энэхүү өөрчлөлттэй уялдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн агентлагийн даргаар хуульд заасан ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан хүнийг томилж болох. Энэ тохиолдолд агентлагийн дэд даргатай байх зохицуулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгасан болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудаас ирүүлж байгаа санал, хүсэлтийг харгалзан хэмнэлтийн зарим зохицуулалтыг өөрчлөх санал боловсрууллаа.

Тухайлбал, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаа болон төрийн байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах үүднээс эдгээр байгууллагууд автомашинтай байхаар хуулийн төсөлд тусгав.

Мөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж дууссан байвал зохих хугацааг хойшлуулах өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгасан болно.

Засгийн газраас хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлыг онцгой анхаарч, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан агентын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Үүнтэй холбогдуулан залуучуудын хөгжлийг дэмжих төрийн чиг үүргийг цаашид иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр тооцож Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Дөрөв.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн шинэчлэлийг хөрөнгө оруулагч нарт сурталчлан таниулах, түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн судалгаа хийх.

Хүний нөөцийн чадавх бэхжүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай байгааг харгалзан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн үйлчлэлийг хойшлуулах, төрийн өмчийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд бага зардлаар өндөр бүтээмж бүхий технологи, шинэ бүтээл нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглан иргэдэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг газар зүйн байрлалд харгалзахгүй үзүүлэхтэй холбогдуулан Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Тав.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрт олгох.

2023 оны 1-ээс 6 дугаар саруудад хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаагүй хүүхдэд уг хугацаанд ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж байна.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 7 хууль, 2 Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 6 сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах

орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах чиглэлээр багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж холбогдох хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төрийн хэмнэлтийн хуульд оруулах өөрчлөлтөөр ямар боломж, нөхцөлийг тусгасан, тендерийн хууль батлагдах шатдаа орсон үед төсвийн тодотголын төслийн хамт тендерийн хуульд зохицуулаагүй харилцааг тусгахаар оруулж ирсэн талаар, мөн төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбогдуулан төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн акт зөрчлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийг хөндөхгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэх боломжтой эсэх, мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэрэглээний автомашины талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал өргөн мэдүүлсэн Төрийн албаны хуулийн өөрчлөлтөд нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоог 15 хувиас ихгүй байхаар байна гэж тусгасан талаар тооцоо судалгаа хийсэн эсэх, төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байраар хангах, түүнд тавигдах шаардлагын талаар, мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг заавал хүсэлт гаргасан гэж тусгах нь хэр оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд төрийн албаны бүтэц, зохион байгуулалтыг тогтворгүй, хурдан хугацаанд сольж байгаа нь төрийн албаны мэргэшсэн зарчимд хэрхэн нөлөөлөх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төсвийн тодотголын төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлтийг нухацтай судалж, тооцоо үндэслэлтэйгээр дахин оруулж ирэх, төрийн хэмнэлтийн хуульд тусгасан байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөр хамгааллын дүрэмт хувцсыг хассанаар хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл үүсэхээс болгоомжлох, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхэд бүрд олгохоор төлөвлөж тодотголд тусгасан тул хүсэлтээр гэдгийг хасах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор агентлаг нь дэд даргатай байх зохицуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал нь бүрэн шийдэгдэхгүй болохыг анхаарах, Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтөд үндэслэн боловсруулж өргөн мэдүүлэх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төсвийн тодотгол нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа хэдий ч огт хамааралгүй тендерийн хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа нь төрийн байгууллагууд хувийн хэвшлээ дэмжих, хувийн хэвшлийг шахан гаргахгүй гэх зарчимтай зөрчилдөж байгаа тул холбогдох хуулийн төслийг хэлэлцэх боломжгүй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа

холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 64 хувийн саналаар үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Тогмидын Доржханд гишүүнийг нэмье. Гочоогийн Ганболд, Жигжидийн Батжаргал, Цагаанхүүгийн Идэрбат.

Одоо Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжих нь зүйтэй байна.

Тэр дотроо Засгийн газраас чухал заалт оруулж өгсөн. Энэ нь эрдэм шинжилгээний байгууллагууд судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт, зөвлөгөөний ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэх асуудлыг Тендерийн тухай хуулиар зохицуулахгүй байх нь эрдэм шинжилгээний байгууллагуудад маш чухал ач холбогдолтой байгаа юм. Энэ бол Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй үлдчихсэн байгаа.

Тэгэхээр үүнийг яагаад дэмжих ёстой юм гэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан тендерийн баталгаанаас шалтгаалан төрийн өмчит эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд 100 сая төгрөгөөс дээш эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд барьцаа хөрөнгө байхгүй. Төрийн сангаар төрийн, төсвийнхөө мөнгөөр барьцаа тавьж болдоггүй учраас энэ тендерүүдэд оролцох боломж байдаггүй.

Үүний хамгийн тод жишээ бол Эрдэнэт үйлдвэрийн цагаан тоосыг багасгах талаарх судалгааг манай Шинжлэх ухааны академиэс өөр хийх боловсон хүчинтэй газар байхгүй. Тэгтэл энэ судалгааг хийж чадах юм бол Эрдэнэт үйлдвэрээс гарч байгаа цагаан тоосыг хүртэл багасгах энэ судалгааны аргуудыг, аргачлалуудыг судалж үзэж техник, эдийн засгийн үнэлгээг нь хийх боломжууд нь байгаад байдаг.

Үүгээрээ дамжуулаад бид бас стратегийн том дэмжлэгийг эрдэм шинжилгээний төрийн өмчит

байгууллагууддаа өгөх боломж бас байгаад байна.

Тийм учраас би эрхэм гишүүддээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн өөрчлөлт, энэ 3.5 заалтыг Та бүхнийг дэмжиж босгож өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Санал үндсэндээ хэллээ. Тийм ээ.

Тэрнийг тэр 6 дугаар хууль дээр ярьж босгох асуудлыг хэлэлцэнэ. Сайд ч гэсэн яриад яваад байгаа. Тэрийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Би өмнөөс нь хариулчихъя. Одоо Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын Засгийн газраас төсвийн тодотголтой уялдуулж 7 хуулийг дагалдуулж өргөн барьсан байгаа юм.

Тэгээд энэ 7 хуулийн нэг нь энэ тендерийн хуулийн зохицуулалттай холбоотой ийм заалт. Өчигдөр Төсвийн байнгын хороон дээр бас жаахан үл ойлголцол гарсан юм болов уу гэж би ойлгосон. Түүнээс биш манай Улсын Их Хурлын гишүүд шинжлэх ухааныхаа эсрэг дэмжихгүй гэсэн ийм санал гаргах нэг ч гишүүн би энэ танхимд байхгүй гэж ойлгож байгаа. Нэг ч гишүүн.

Тэгэхээр одоо үндсэндээ ингээд энэ сүүлийн шинжлэх ухаан яагаад ингээд ийм улс орныхоо хөгжлийг дэмжиж чадахгүй хэмжээнд хүрчихсэн юм шиг нийгэмд ийм ойлголтууд төрүүлсэн юм бэ гэвэл төр өөрөө бид л төрүүлсэн юм билээ. Бид төрүүлсэн.

Тэгэхээр 1990 онд бид Монгол Улс 6 мянган эрдэм шинжилгээний

ажилтай байсан. 1990 онд. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ нэг хувийг бид шинжлэх ухаан, технологийн салбарт зарцуулдаг байсан улс. 1990 онд.

Гэтэл бид өнөөдөр нийт эрдэмтдийн тоо, эрдэм шинжилгээний ажилтны тоо дөнгөж 1450-хан зуун тавьхан эрдэм шинжилгээний ажилтантай. Төрөөс өнөөдөр шинжлэх ухаанд зарцуулдаг мөнгө дотоодын нийт бүтээгдэхүүний 0.01 хувьд хүрэхгүй хэмжээнд хүрчихсэн байна.

Бид нэг сая хүнд ногддог эрдэмтдийнхээ тоогоор манайтай хөгжлийн ойролцоо улсуудаас даруй 5 дахин, 6 дахин, 10 дахин бага болчихсон байна.

Тэгэхээр яагаад ийм нөхцөл байдал үүсчихсэн юм бэ гэхээр төрийн үйлчилгээний тендерийн хууль яг энэ шинжлэх ухааны хөгжил дэвшилд чөдөр тушаа болсон ийм хууль болж олон жил явлаа.

Өнөөдөр шинжлэх ухааны байгууллагууд, судалгааны байгууллагууд, хүрээлэнгүүд, эрдэм шинжилгээний ажилтнууд олон жил хийсэн өөрийнхөө инновац, патентуудыг улс орныхоо хөгжил дэвшилд оруулах энэ хувь нэмрүүдийг нь боомилсон. Дунд нь цүнхний цавчаа компаниуд гарч ирж ийм тогтолцоо руу бид түлхсэн байна.

Яагаад гэвэл нөгөө төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд одоо яг өөрийнхөө эрдэм шинжилгээний ажилтныг хүний нөөцтэй, лабораторитой, патенттай, инновацтай энэ суурь судалгаануудыг хийдэг хүрээлэнгүүдээр ажил, үйлчилгээ гүйцэтгэх ийм чадваргүй болсон байгаа юм. Ийм чадваргүй болсон.

Тийм учраас бодлогын алдааг засаж залруулж орж ирсэн энэ хуулийг л бид ярьж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бид шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр гэдгийг өнөөдөр эдийн засгийн тоогоор нь, эдийн засгийн үзүүлэлтээр нь, эдийн засгийн өгөөжөөр нь хэмжих цаг болсон гэж бодож байгаа юм.

Би зөвхөн нэгхэн жишээ дурдъя. Одоо сүүлийн 10 жил Шинжлэх ухаан, технологийн сангаас 170 орчим тэрбум төгрөгөөр 4 мянга гаруй судалгааг санхүүжүүлсэн байна.

Гэтэл 4 мянган санхүүжүүлсэн судалгаа, патентууд, ашигтай загварууд, инновацууд өнөөдөр улс орны эдийн засгийн үйл ажиллагаанд нэвтэрч чадахгүй байх санхүүжилтийн тогтолцоог бид хийсэн байна.

Тийм учраас бид нарын өнөөдөр энэ бодлогын хэмжээнд засаж залруулж байгаа, өчигдрийн Төсвийн байнгын хороон дээр гарсан үл ойлголцлыг манай Улсын Их Хурлын гишүүд маань дэмжиж саналаа өгнө гэж ойлгож байгаа.

Та бүгдийг Монголын бүх эрдэм шинжилгээний ажилчид, шинжлэх ухааны салбар хараад сууж байна гэдгийг би хэлье.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд одоо жишээ нь шинжлэх ухааны салбарт тогтвортой суурь судалгаа хийсний үр дүнг би ганцхан жишээ дурдаж хэлье. Дарханы 144 гэдэг сортыг хийх гэж манай шинжлэх ухааны салбарынхан 15 жил зарцуулсан байна. 20 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Гэтэл энэ зарцуулсны үр дүнг өнөөдөр бид жил бүхэн 10 тэрбум

төгрөгийн эдийн засгийн өгөөжийг хүртээд сууж байгаа. Зөвхөн газар тариалангийн салбарт зөвхөн нэг сортоос хүртэж байгаа өгөөж ийм өндөр түвшинд хүрсэн байна.

Өнөөдөр элэг шилжүүлэн суулгах мэс заслыг, тэр судалгаануудыг өнөөдөр Шинжлэх ухаан, технологийн сангаар бид санхүүжүүлсэн. Түүний үр дүнг өнөөдөр Монголчууд хэдэн арван мянган хүмүүс гадаадад явж илгээж шилжүүлдэг байсан улсууд өнөөдөр эх орондоо элгээ шилжүүлэх энэ том боломжуудыг олгосон.

Би зөвхөн сүүлийн үед хийгдсэн хоёрхон судалгаа, шинжилгээний үр дүнг зарлаж байгаа юм.

Энэ мэтчилэнгээр шинжлэх ухаанд хийгдэх гэж байгаа улсын үйлдвэр төрийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Сайн байна. Дагаж өргөн мэдүүлсэн 9 хууль батлахын 6 дахь хууль дээр энэ асуудлыг ярина. Шинжлэх ухаанаа дэмжье гэж байна.

Одоо Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Монголын төрд олон хулгай нүүрлэсэн. Түүнээс хоёр хулгай нь ард иргэдийн ахуй амьдрал, авдаг цалин, тэтгэвэр, тэтгэмжид шууд нөлөөлж байгаа.

Тэгээд Засгийг газар энэ олон хулгайтай тэмцээний үр дүн гарч, өнөөдөр ингээд тодорхой хэмжээнд иргэдийн хүсэн хүлээж байсан зарим асуудлуудыг шат дараатай шийдвэрлэж байна.

Тэр хоёр хулгайн нэг нь нүүрсний хулгай. Тухайлбал, Монгол Улсын эдийн

засгийн 93 хувийг экспорт, уул уурхай эзэлж байгаа.

Хоёрдугаарт, Хөгжлийн банкны өр Монгол Улсын өр болж байгаа. Энэ өрийг төлж төлж байгаа учраас иргэдийнхээ цалин, тэтгэвэр, тэтгэмжийг, халамжийг илүүтэй нэмэх байсан боломжийг хумсалсан гэсэн үг.

Тэгэхдээ Засгийг газар шударга ёсыг тогтоож алдагдсан боломжийг эргүүлж олохын төлөө тэмцээний үр дүнд өнөөдөр тодорхой хэмжээний дэвшлүүд гарч байгаа юм.

Энэ дэвшлүүдийг харин ард иргэдэд очиход ямар нэгэн чирэгдэлгүй, асуудалгүй хүргэх хэрэгтэй. Би хүүхдийн мөнгийг хэлэх гээд байна.

Хүсэлт гаргасан иргэдэд хүүхдийн мөнгө өгнө гэж энэ зүйлээ больчих. Эхнээсээ бид 91 хувьд нь өгнө гэсэн. 91 хувиас нь ямар ч хүсэлт авахгүйгээр шууд өмнө нь авч байсан тэр жишгээр нь хүүхдийнх нь мөнгийг дансанд нь хийх ёстой.

Өнөөдөр тухайлбал хэрвээ та цахим орчинд орох боломжгүй бол хороо хорин дээрээ оч гэж.

Одоо 7 сарын 01-нээс хүүхдийн мөнгө өгнө. Хороон дээр энэ олон иргэдэд үйлчлэх тийм боломж, тийм боловсон хүчний нөөц байхгүй. Маш олуулаа цуглана. Бухимдана. Төрийн энэ авч байгаа шийдвэрүүд иргэдэд харин эсрэгээрээ бухимдал төрүүлэх ийм нөхцөл үүсэх учраас үүнийгээ зөв зүйтэй шийдээрэй гэж.

Хоёрдугаарт, 161 мянган иргэний тэтгэвэр, цалингийн материал алга болсон. Тиймээс 10 хувиас өөр нэмэгдэл авахгүй гэж байна. Жил бүр цаашдаа

инфляцын түвшинтэй уялдуулан иргэдийн тэтгэврийг нэмнэ. Тэгээд энэ хүмүүсийг ямар итгэлцүүрээр ямар байдлаар нэмж байх юм бэ. Энэ хүмүүс насан туршдаа хэлмэгдээд явах юм уу? Энэ асуудлыг шийдвэрлээрэй гэж хэлмээр байна.

Гуравдугаарт хэлэх гэж байгаа зүйл. 2024 оны төсөвт анхаарах хэд хэдэн асуудал байна.

Өнөөдөр бид огт ярихгүй байгаа зүйл бол амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн асуудал. Улаанбаатарт сарын орлого нь 277 мянга, хөдөө орон нутагт 238 мянган төгрөгийн орлоготой иргэдийг амьжиргааны баталгаажих түвшинд байна гэж бид нэрлэж байгаа.

Энэ бол 26 мянган өрх байна. Энэ мөнгөний хэмжээг 2024 онд бид эргэж харах ёстой.

Дөрөвдүгээрт, хүүхэд хамгааллын асуудал дээр 2024 оны төсөвт анхаарах ёстой. Энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бас хамаатай асуудал. Хэдий эмэгтэй гишүүд рүү асуудлыг холбоод байна. Бид өөрсдийнхөө хэмжээнд хууль хяналтын байгууллага болон харьяалагдах байгууллагадаа ажиллаж байгаа.

Засгийг газар хууль хэрэгжүүлэх үүрэгтэй, ийм функцтэй субъектийн хувьд энэ асуудалд илүүтэй анхаарах ёстой гэдгийг хэлэх гэсэн юм.

Дөрөвдүгээрт, ядуурлыг бууруулах чиглэлд юу хийх юм бэ? Өнөөдөр Монгол улс Номхон далайн баруун бүсдээ ядуурал бууруулаагүй орны тоонд орчихсон явж байгаа. Гурван хүн тутмын нэг нь ядуу. Одоо энэ тоо ч нэмэгдэж байгаа байх. 2024 оны төсөвт

энэ чиглэлд дэвшил гаргах, тодорхой санхүүжилт суулгах, тодорхой асуудлыг шийдэх ийм асуудлыг суулгах ёстой гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Зургаадугаарт, төрийн үйл ажиллагаа залгамж чанартай байдаг. Нөгөө халамжаас хөдөлмөрт шилжих бодлого яасан бэ? Яагаад энэ тухай огт ч ярихаа больчхов оо? Ажлын байр бий болгох, нэг ч гэсэн хүнийг ажилтай орлоготой болгох, ашиг орлогыг нь нэмэгдүүлэх чиглэлээр ямар нэгэн зүйл бид хийх ёстой шүү. Энэ тухай бүр ярихаа больчихлоо. Больчихлоо.

Зургаадугаарт, бид **“Цалинтай ээж”** хөтөлбөрийг бид хэдийгээр ярихгүй байгаа боловч иргэд, эмэгтэйчүүд яриад эхэлсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Товч гэсэн хариулчих. Тэгээд хариулт хангалтгүй бол тодруулж асууна. Б.Жавхлан сайд хариулах уу? Товчхон.

Б.Жавхлан: Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхан асуултуудад нь хариулья хариулья.

Хүүхдийн мөнгөн дээр бид өнгөрсөн жилийн түүхийг заавал дурдах хэрэгтэй. Төсөв өргөн барих үед эдийн засгийн нөхцөл байдал, ялангуяа гадаад өрийн нөхцөл байдал Монгол Улс дампуурлаа зарлах, дефолтын тэр ирмэг дээр байсан.

Бидэнд ерөөсөө сонголт маш бага байсан. Олон Улсын Валютын Санд тусламж хүсэж хатуу нөхцөлтэй зээлийн хөтөлбөрт ороод хүүхдийн мөнгө маань бүр 50 хувиас ч доошоо унах ийм эрсдэл байсан.

Харин бид үүнийг сөрж өөрсдийн дотоод нөөц боломж, ялангуяа манай

түүхий эдүүдийнхээ экспортыг. Сая Д.Сарангэрэл гишүүн хэллээ. Их зөв тодорхойллоо.

Бид маш хүнд нөхцөл байдалд зах зээлийг нэлээдгүй ил тод болгож, либералчилж ингэсний үр дүнд энэ боломжууд гарч энэ удаа бид тодотгол хийж цалин, тэтгэвэр, тэтгэмж, энэ хүүхдийн мөнгөө нэмэх эхний боломж гарсан дээр ийм тодотгол хийж байгаа.

Харин хүүхдийн мөнгөн дээр бид нэлээн судалгаа хийсэн байгаа. Энэ дээр хүүхдийн мөнгө авах шаардлага байхгүй. Үүнийгээ **“Хүүхдийн төлөө фонд”** ч юм уу, ер нь хүүхдийн сайн сайхны төлөө зориулья, хандивлая гэсэн ийм сонголт хийх боломжийг нь тэр иргэдэд олгож байгаа гэсэн үг.

Хүсэлт гаргасан хэд нь тийшээгээ зохицуулалт хийж болно.

Одоо богино хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын нэгжүүд дээр, хэлтсүүд дээр очиж биеэр хүсэлт гаргах боломжгүй, эсвэл ухаалаг утсаар санал өгөх боломжгүй ч байдаг юм уу, тэр хэсгүүд дээр хүсэлт ирээгүй тохиолдолд хүүхдийн мөнгө олгогдоод, хүсэлт нь зөвхөн тэр өөр зүйлд, өөр хүүхдийн сайн сайхны төлөө зориулья гэж байгаа тэр сонголтыг нь олгоход л ийм зохицуулалт хийж явуулна.

Тэгэхээр үндсэндээ бүх хүүхдэд олгож байна л гэсэн үг. Энэ дээр нэг хүндрэл гарахгүй болов уу л гэж ингэж бодож байна.

Тэтгэврийн хувьд та итгэлцүүр асуусан. Тийм ээ. Тийм. Итгэлцүүрээр 486 мянган тэтгэвэр авагчдын тоо болох байгаа юм. Энэ оны сүүлээр. Үүнээс 165 мянган тэтгэвэр авагч нар маань цалингийнхаа доод суурийг итгэлцүүрээр

нөгөө зөрүүнүүдийг нь арилгаж байгаа. Зөрүүнүүд арилна гэхээр ингээд бүгд нэг тэгшитгээд л жигдрээд ороод ирнэ гэсэн ойлголт байхгүй.

Энд хүн болгон, ахмад настнууд тэтгэвэр авагч болгон өөр өөрийн кэйстэй, ажилласан жилүүд нь өөр, суурь цалингууд нь тодорхой хэмжээнд жоохон жоохон зөрүүтэй. Ер нь нэлээн дөхөж орж ирнэ.

Өөрөөр хэлбэл 20, 30 жилийн зөрүүтэй ижил мэргэжилтэй, ижил салбарт тэтгэвэрт гарсан ахмадууд маань өндөр цалинтайнууд нь өндөр хэмжээнд тэтгэвэр нь тогтоогдоно, нам авч байснууд нь мөн нам авч байгаатай нь ижил тогтоогдоод л ингээд зөрүүнүүд нь арилах юм.

Тэгэхээр энэ бол нэг удаагийн тодотголоор шийдэгдэж байгаа хэдий ч яг олон жил хүлээсэн, олон жил бас шийдэх боломж гарч ирээгүй энэ тогтолцооны суурь өөрчлөлт хийгдэнэ гэсэн үг.

Мөн өөр нэг шийдэгдэж байгаа зөрүү гэж ойлголт гарч ирээд байгаа зүйл гэвэл өнгөрсөн оны 2 сард тэтгэвэр авагчдын доод хэмжээг 500 мянга болгосон. Мөн бүгдийг нь жигд 15 хувиар нэмэгдэхэд тэтгэвэр авч байгаа доод хэмжээний, мөн дунд хэмжээнд авч байгаа тэтгэвэр авагч нарын хооронд байсан зөрүү бараг арилж байгаа.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууна.

Д.Сарангэрэл: Далд эдийн засагтай хийж байгаа Засгийн газрын тэмцэл үр дүнгээ өгч өнөөдрийн энэ цалин, тэтгэвэр, халамж нэмэх ийм боломж үүссэн гэж үзэж байгаа.

Тэгээд 2024 онд энэ тэмцэл бас нэлээн үр дүнгээ өгөх байх. Энэ үед бид одонтой ээжийн мөнгөний асуудлыг эргэж харах ёстой.

Хоёрдугаарт, энэ **“Цалинтай ээж”** хөтөлбөрийг иргэд, эмэгтэйчүүд нэлээн шүүмжилж байна.

Тухайн үед 50 мянган төгрөг буюу цалинтай ээж хөтөлбөр үүргээ гүйцэтгэсэн. Тэгэхэд юмны үнэ харьцангуй гайгүй. Бас үнийн хөөргөдөл өнөөдрийн хэмжээнд очоогүй байсан үе.

Одоо бол арга байхгүй энэ мөнгөнд нэг памперсны ч үнэ хүрэхгүй байна. Ялангуяа нэмэгдэл тэжээл хэрэглэж байгаа хүүхэдтэй ээжид нөлөөгөө үзүүлэхгүй байна гэдэг ийм асуудал байгаа.

Тэгээд 2024 оны төсөвт би энэ **“Цалинтай ээж”** хөтөлбөр болон **“Одонтой ээж”**-үүдийн асуудал дээр Засгийг газар анхаараарай гэдэг ийм саналыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ чинь одоо харь гаргаас ирсэн хүмүүс энд цуглачихсан юм шиг л юм яриад байх юм. Аан. Гэнэтхэн л хөрсөн дээрээ буучихсан юм уу, яасан юм. Сонгууль дөхөж байгаа юм уу. Ингээд баахан.

Үгүй ээ. Энэ 8 жил нүүрс нь байдгаараа л байсан, бүх юм байдгаараа л байсан шүү дээ. Тэгээд өмнө нь сэргээгээд ийм сайхан болгочихгүй яасан юм бэ? Тэр хулгайтайгаа тэнцээд байгаа юм ерөөсөө алга байна шүү дээ.

Тэр хүүхдийн мөнгө нөгөө 9 хувьд нь буцааж өгнө гээд байна. Тэрийгээ хүүтэй нь өгөөрэй. Хөөе. Тийм. Нэг сараас өдий хүртэл зовоож зовоочоод эргээд яахдаа тэр уучлалаа гуйгаад хүүтэй нь өгөөрэй.

Тэгээд асуудалд та нар яаж ингэж хандаж чадаад байна. Хүссэн хүүхдэд нь өгнө ч гэх шиг. Үгүй ээ, үгүй. Тэр авахгүй гэж хүссэн хүүхдэд нь битгий өг л дөө. Би нэг ч хүүхэд гарахгүй болов уу гэж бодож байна.

Асуудалд та нар яаж ханддаг вэ гэдгийг нь үүнээс эхлээд л мэдэгдэж байгаа байхгүй юу. Нэг.

Ер нь анги дүүргэлт, энэ тэр бол маш хүнд байгаа шүү дээ. Монгол Улс бол.

Тэр хүүхдийн нэг ангид сурч байгаа 50, 60-уулаа сурч байна. Бараг л хүүхдийн засан хүмүүжүүлэх юу шиг л байж байгаа шүү дээ. Тэнд ямар юмны сургалт байх вэ дээ.

Тэгээд сүүлийн хэдэн жил энэ хүүхдийн цэцэрлэг, сургуулиудыг барьсан гээд байгаа. Хамгийн муу материалаар хамгийн муу барилгууд босгосон байна лээ шүү дээ. Та нар. Одоо тэрийгээ очиж үзэж хар. Хоёр, гуравхан жилийн өмнө барьсан барилгууд бүгдээрээ дээрээсээ эхлээд нураад унаж байна лээ.

Гэтэл бусад улс орнуудад яадаг вэ. Хамгийн найдвартай, хамгийн сайн материалаар, хамгийн чанартай барилгыг хүүхдэд зориулж барьдаг.

Өнөөдөр хар л даа. Энэ Улаанбаатар хот. Баахан сайд нар тавьчихсан. Тэр төр нь төрийн хэмнэлтийн хууль орон нутагт л үйлчилж

байгаа шүү дээ. Энд тэр дэд сайдууд, энэ янз бүрийн дарга нар тарган цатгалан хэвээрээ л явж байгаа шүү дээ.

Тэр хөдөө орон нутагт ард түмэнд төрийн үйлчилгээ бүрэн очиж хүрч чадахаа байсан шүү дээ. Төрийн хэмнэлтийн хууль гэдгээрээ.

Тэгээд хулгай зэлгийтэй тэмцээд байна гэнэ. Гэнэтхэн л нэг сэрсэн юм шиг, харь гаригаас баахан улсууд ирчихсэн юм шиг л байх юм.

Нэг их тэмцээд гийгүүлээд байгаа юм ерөөсөө байхгүй. Том том хулгайч нар чинь тэр чигээрээ л байж байгаа. Ямар ч сэргэлт байхгүй байгаа. Яг юу сэргэчихсэн юм.

Хил, гааль чинь байдгаараа л байгаа. Тэгэхэд тэр хулгай нь иргэдийн шүүмжлэл ихэснэгүүт бага ч гэсэн багасаад өнөөдөр 28 сая тонн нүүрс гарчхаж байна шүү дээ.

Өмнө энэ их хулгай, энэ их зөрүү хаана байдаг байсан бэ? 8 жил энэ хулгай чинь явагдсан байна шүү дээ. Одоо аргагүй эрхэнд сонгууль дөхөж байгаа болохоор эрх биш нэг жоохон жоохон юм гялтайлгаад. Тэгээд ханшинд идэгдсэн энэ мөнгөө тараагаад иймэрхүү маягаар л очих гэж байна гэж би ойлгоод байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал манай хүүхдүүдийн тэр сурч байгаа боломж нөхцөл юун XXI зуун бэ. XXI зуунд Африкийн улс орнууд ч ийм байхаа больчихсон шүү дээ. Ийм нөхцөлд байгаа.

Тэгээд энэ дээр бие биеийгээ магтаад л, ингээд л нэг сайхан болж байгаа юм шиг энэ дээрээ яриад байгаа боловч ард түмний амьдрал шал өөр байна. Хэцүү байна. Хөгжлийн

бэрхшээлтэй иргэд дээр анхаарч байгаа юм ерөөсөө алга. Тэр сургууль энэ тэр дээр нь яваад очоорой.

Хуучин манай Санжаасүрэнгийн Оюун гэдэг гишүүн байсан. Байнга анхаарал тавьдаг байсан. Одоо тэгж анхаарал тавиад үүний төлөө яваад байгаа юм ерөөсөө алга байна. Ийм л байгаа шүү дээ. Амьдрал дээр бол.

Тэгэхээр нөхөд минь саяын наад алдаатай бодлогуудаа зас. Зүгээр нэг уриа лоозон, хурал цуглаан л их хийж байна. Тэгээд бие биеийгээ их л магтаж байна. Хүмүүсийн амьдрал бахь байдгаараа байна.

Нөгөө Улаанбаатар чинь түгжрэлтэй, хөрсний бохирдол ихтэй.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ?

Гишүүд асуулт хариултад хүндэтгэлтэй хандана шүү. Олонх, цөөнх гэж байхгүй. Асуултад хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Цөөнхөд хүндэтгэлтэй хандаж байх хэрэгтэй.

Асуултад хариулья. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Д.Ганбат гишүүний хэлсэн саналд хариулт өгье.

Тодотголыг ер нь дэмжиж байгаа юм байна гэж ойлголоо. Сүүлийн жилүүдэд хийгдсэн ялангуяа уул уурхайн салбарт байсан маш томоохон далд эдийн засаг, хуримтлагдсан энэ их зүйлийг ил болгож өнөөдөр ийм боломж гарч ирж байгааг тодорхойлж хэллээ гэж би ингэж ойлголоо.

Та хэтэрхий их тэгж улс төржүүлээд яах вэ. Энэ боломж хэзээ

нэгэн цагт гарч ирэх л байсан. Энэ бүх зүйл хэзээ нэгэн цагт ил болох л байсан. Харин тэр боломжийг ард түмэнд, олон нийтэд бид бүхий л боломжоор, бүхий л бодлогоороо жигд хүртээмжтэй байдлаар ийм бодлогын зохицуулалт хийх л ёстой. Тэр цаг хугацаа нь өнөөдөр байгаа юм.

Үүнийг хойшлуулах ямар ч эрх бидэнд байхгүй. Цаг хугацаа ч биднийг хүлээхгүй.

Хүмүүс инфляцтай холбож ярьж байгаа. Яах аргагүй онолын дагуу тэгж ярих нь аргагүй л дээ. Гэхдээ энэ инфляцыг нам доор болтол 8 хувь, 6 хувь болтол хүлээж байгаад цалинг нэмнэ гэдэг тийм боломж, тийм сонголт өнөөдөр байхгүй. Тэр болтол энэ олон нийт чинь хүлээж чадахгүй. Энэ төрийн албан хаагч нар маань бүгд гараад явна. Бүгд Солонгос яваад өгнө.

Тийм учраас энэ арга хэмжээнүүдийг бид өнөөдөр цаг алдалгүй авч байгаа юм. Ингээд 7 сарын 01-нээс цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө, мөн нийслэлийнхээ түгжрэлийг ч бид орхисонгүй. Эдгээр зүйлээр бид энэ удаагийн тодотголоо хийж байгаа.

Тодотгол гэдгийг дахин сануулж хэлье. Бүх зүйлийг бид шийдэж чадахгүй. Тодотгол өөрөө хязгаарлагдмал.

Тийм учраас энэ удаа тулгамдсан, орхигдсон, мөн боломж гарч ирж байгаа учраас зайлшгүй анхаарч үзэх ёстой ийм зүйлүүдээ бид хийж амжуулж байна гэж бодож байгаа. Хүүхдийн мөнгө ч ялгаагүй.

Ер нь 100 хувь олгогдож байгаатай ерөөсөө огт ялгаагүй. Зөвхөн хүүхдийн мөнгийг хүүхдийн бусад бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, хүүхдийн төлөө фондоор дамжуулж арай өөр

хэлбэрээр хүүхдүүд дээр очиж болох юм гэсэн ийм сонголтыг хийх тэр боломжийг олгож байгаа зүйл.

Өмнөхөөсөө хамаагүй дэвшилттэй ингэж орж ирж байгаа гэж ойлгоорой. Д.Ганбат гишүүн ээ. Өөр боловсролын салбарын талаар асуух шиг болсон.

Санал хэлэх шиг болсон.

Г.Занданшатар:
Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Д.Ганбат гишүүнд баярлалаа. Манай Д.Ганбат гишүүн маань боловсролын багц хуулиуд дээр бас нэлээн санаа тавьж, сэтгэл тавьж ажиллаж байгаа.

Тэгээд тэр тусмаа өнөөдөр бас яг хөндөгдсөн, нөгөө загатнасан газар маажна гэдэг шиг хөндөгдсөн гурван ээлжийн сургууль, тэр тусмаа нэг ангид 50-иас 60 хүүхэдтэй суралцаж байгаа анги, танхим, бүлгүүдийн асуудлуудыг хөндөж харж тавьж байгаад би бас туйлын их баярлаж байгаа.

Тэгэхээр бид өнгөрсөн 20 жилийн турш ерөөсөө гол гол асуудлуудаа ерөөсөө шийдэж чадахгүй явсаар байгаад л өнөөдөр энэ нийгмийн тэгш бус байдал тартагтаа хүрчхэж байгаа байхгүй юу.

Түүний нэг амьд жишээ бол цэцэрлэгийн хүртээмжийн асуудал байсан. Өнгөрсөн жил бид Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийг газар бодитой түүхэн шийдвэр гаргаж 200 тэрбумын санхүүжилт шийдэж өгсөн учраас бид олон жилийн, аль ч Засгийн газрын үед шийдэж явж чаддаггүй ийм сугалааны цэцэрлэгийн тогтолцоог бид халсан.

Энэ маш том дэвшил болсон гэж ойлгож байгаа. Одоо бид нарын анхаарах зүйл бол гурван ээлжийн сургууль.

Улаанбаатар хотод гурван ээлжийн 17 сургууль байгаа юм. Судалгаагаар.

Тэгээд нэг ангидаа 50-иас дээш хүүхэдтэй сурч байгаа, 60-иас дээш хүүхэдтэй сурч байгаа бүлгүүд 170 орчим ийм бүлэг байна гэсэн бид нарын нэг судалгаа байна.

Тэгэхээр бид энэ жил 9 сарын 01-нээс өмнө ямар ч байсан одоо нөгөө том сургуулиуд барьж үүнийг шийдэж чадахгүй учраас ерөнхийдөө сургуулийн хэв шинж, бүлгийн хэв шинжүүдийг нь бас өөрчилж энэ гурван ээлжийн сургуулийг буюу нэг ангид 45 хүүхдээс дээш суралцуулахгүй байх энэ шийдлүүдийг бид гаргаж ажиллаж байна. Д.Ганбат гишүүн ээ. Ажиллаж байна.

Энэ дээр бид маш олон шийдлүүд гаргаж байгаа.

Тэгэхээр 2024 оны улсын төсөв орж ирэхэд Эдийн засаг, хөгжлийн сайдтай яриад улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ цаашдаа гурван ээлжид орох эрсдэлтэй улсын хэмжээнд 41 сургууль байгаа юм. 17 дээр нэмэх нь дахиад ингээд сургуулиа нэмэхээр 41 сургууль байгаа юм.

Тэгэхээр энэ 41 сургуулиудын санхүүжилтийн төсвийн эх үүсвэрүүдийн асуудлыг шийдвэрлэх чиглэл рүү бодлогын шийдвэр гаргая. Энэ хүрээндээ 2024 оныхоо төсвийн төсөөлөл, төсвийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Угаасаа миний асуултад хариулж чаддаг ч үгүй юм. Би тэрийг мэдэж байна. Гэхдээ яах вэ би хэлж байаас.

Хүүхдийн мөнгө би хүүтэй нь өгчих гэж байна шүү дээ. Уучлал гуйгаад. Тийм. 1 сараас одоо хүртэл 6 сар өгөөгүй байна. Тэрнийхээ уучлалыг гуйгаад өгчих гэж байна.

Тэгээд хүүхдэд зориулсан юмнууд чинь яагаад ингээд чанаргүй байдаг юм бэ? Тэр хоол унд нь чанаргүй, тэр байшин барилга нь чанаргүй, 50, 60-аар нь чихдэг. Энэ чинь одоо ямар хорих лагерь юм уу. Болохгүй шүү дээ. Та нар.

Тэгсэн мөртлөө одоо энэ хугацаанд хэчнээн их мөнгө орж ирэх байсан. Тэр нүүрсний хулгайч нартайгаа хайрлахынхаа оронд тэмц л дээ. Хоёрын хооронд ганц нэг Их Хурлын гишүүдийг аваачиж шидчихээд л, ард нь том хулгайч нар нь дандаа үлдээд байгаа шүү дээ. Ийм л байгаа шүү дээ. Амьдрал дээр.

Энэ мэнийгээ болиоч ээ. Энэ улс орон сүүлийн ганцхан жил ингэж байгаад л ард түмнээ улны болгочоод. Та нарын нэр хүнд чинь улны болчихсон. Ингээд сэргээчихнэ гэж бодоод байгаа бол эндүүрэл шүү дээ.

Сэтгэлээсээ ажилла л даа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Д.Ганбат гишүүн. Баагаагийн Баттөмөр гишүүн

Б.Баттөмөр: Энэ төсвийн хуулийг дагаж орж ирж байгаа төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа худалдаж авах энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бид дэмжиж явж байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн гарц гэхээр шинжлэх ухаанаа дэмжиж, шинжлэх ухаандаа хөрөнгө оруулж ажиллах ёстой байгаа юм л даа. Тэгээд сая сайдын үгэнд хэлж байгаа юм.

Тэр 90 оны түвшнээс өнөөдөр ухарчихсан байгаа шүү. 6400, 6500 орчим эрдэм шинжилгээний ажилтантай байсан бол өнөөдөр 1400 болоод одоо энэ чинь хэд юм, 4 дахин буурчихсан.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувийн хэмжээ нь 0.01 болж багассан. Ийм л байдалтай болчихсон байгаа юм.

Тэгээд энэ шинжлэх ухааны байгууллагуудын төрийн өмчтэй компаниудын зарласан тендерт орж чадахгүй болсон. Тэр барьцаа хөрөнгийг байрлуулах данс нь төсвийнхөө хуулиар бас хаалттай байдаг. Болохгүй болчихсон гэдэг ийм юм яригддаг.

Энэ аж ахуйн нэгжүүд нь гэрчилгээн дээрээ эрдэм шинжилгээний байгууллага, эрдэм шинжилгээний ажил эрхэлнэ гэсэн ийм юм бичүүлж аваад янз бүрийн тендерт ороод тэгээд ялаад, тэгээд шинжлэх ухааны байгууллагад аваачиж өгч тэд нараар хийлгэдэг. Өөрөөр хэлбэл эрдэм шинжилгээний ажлууд дээр хүртэл ченжүүд бий болчихсон. Тухайлбал, Эрдэнэтийн нэг зарласан тендерт 300 сая төгрөгийн ажлыг нэг хувийн компани аваад шинжлэх ухааны байгууллагад очоод 100 саяар хийлгэж байх жишээтэй. Ийм л юм болчихсон байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр эрдэм шинжилгээний байгууллагуудаа дэмжих ёстой. Тухайлбал, энд хэд хэдэн жишээ. Одоо Биокомбинат гэхэд л бидний ярьдаг малын өвчний, шүлхий энэ тэр гээд вакцинуудыг хийчихсэн байдаг. Тендерт

орж болдоггүй. Тендерт орохоороо зэрэг янз бүрийн тэмдэглэгээтэй гадна дотнын вакцинууд ялагддаг.

Энэ дотооддоо хийчихсэн юмаа яагаад дэмжиж болдоггүй юм бэ?

Дараагийн жишээ юу гэхээр Эрдэнэт үйлдвэрийн хаягдал усны баяжуулалтын процесст нөлөөлж байгаа бохирдуулагчийг тодорхойлох, усыг цэвэрлэх технологи боловсронгуй болгох тендер зарласан байгаа юм.

Энэ тендерт ороод манай Шинжлэх ухааны академийн Химийн технологийн хүрээлэн ганцаараа ордог. Өөр хийх, ордог газар байдаггүй. Гурван удаа ороод гурвууланд нь тендер хүчингүй. Үгүй ээ, яагаад энэ төрийн өмчтэй шинжлэх ухааны байгууллагуудынхаа хийж байгаа бүтээлийг яагаад худалдаж авч болдоггүй байгаа юм бэ?

Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс угаах үйлдвэрийн технологийн туршилтын 3 ордын нүүрс дээр технологийн туршилт хийх тендер бас зарлагдсан байгаа юм.

Тэгээд нөгөө шинжлэх ухааны байгууллагууд нь орох гэхээр зэрэг барьцаа тавих данс байхгүй. Гэх мэтээр ингээд энэ шинжлэх ухааныхаа байгууллагуудаа нэг хорлож байгаа ч юм шиг ийм л ажиллагаа яваад байна л даа. Тийм.

Тэгээд үүнийг сая Монгол Улсын Ерөнхий сайд Шинжлэх ухааны академийн шинжлэх ухааны ажилтнуудтай уулзахдаа энэ ажил дээр бид ахиц өөрчлөлт гаргая гээд амлаад явсан байгаа.

Тэгээд Засгийн газрын хурлаар ороод дэмжигдээд тэгээд төсвийн тодотголын энэ юунд ороод ирсэн байдаг. Тэгтэл өчигдөр Төсвийн байнгын хороон дээр энэ дэмжигдээгүй байгаа.

Тэгээд яагаад дэмжигдээгүй юм бол. Би Г.Тэмүүлэн даргаас нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, сайдаас асууя. Энэ юу болж байна? Яагаад дэмжигдэхгүй байгаа юм.

Шинжлэх ухаанаа ер нь цаашдаа яах юм бэ? Бид чинь ингээд яваад байх юм уу?

Би гишүүддээ хэлэхэд юу гэхээр энэ Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй байгаа энэ саналыг дэмжихгүй байдлаар шинжлэх ухаандаа оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эндээ тавих анхаарлыг нэмэгдүүлэх ийм шаардлага байна. Энд нэг их тийм том ажил байхгүй шүү дээ.

Манай шинжлэх ухааны байгууллагуудын хийчихсэн тэр туршилт, тэр патенттай тэр ажлуудыг л ажил болгоё л гэсэн ийм ажил явж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ дээр анхаарч өгье. Хоёр сайд.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Б.Баттөмөр гишүүнтэй санал нэг байна.

Тэгээд Монгол Улсын Засгийг газар олон жил шинжлэх ухааны салбарт үүссэн, угжирсан, тендерийн хуулийн халхавч дотор шинжлэх ухааныхаа

салбарын хөгжих, дэвших зүйлийг боомилсон ийм эрх зүйн тогтолцоог шинэчлээд оруулаад ирье ээ л гэдэг ийм хуулийг л өргөн барьсан. Ийм хуулийг.

Тэгэхээр тооцоо, судалгаагаар үзэхээр төрөөс өгч байгаа Шинжлэх ухаан, технологийн санг санхүүжүүлж байгаа зардал жилийн 10-аас 12-хон тэрбум төгрөг байгаа байхгүй юу.

Тэгээд бид чинь нэг судалгаан дээр дөнгөж 15 саяас 20 сая төгрөгийн санхүүжилт өгчхөөд тэгээд суурь судалгаа хий, үр дүн гарга, инновац хий гэж хэлээд сууж байгаа улс шүү дээ.

Тэгэхээр яагаад ч нэг судалгааг 15-аас 20 сая төгрөгөөр санхүүжүүлчхээд үр дүн хүсдэг, үр дүн шаарддаг ийм төр засаг гээд би байхгүй л болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ тогтолцоог өөрчилье. Тэгээд ерөнхийдөө нэг судалгаа хийж үзэхэд төрийн өмчит компаниуд, энэ төрийн байгууллагууд судалгаа, шинжилгээн дээр 100 орчим тэрбум төгрөг зардаг юм билээ шүү дээ. Жилд. Даруй нөгөө Шинжлэх ухаан, технологийн сангийн мөнгөнөөс чинь бараг 6, 7 дахин их мөнгийг тендерийн хуулиар зарцуулдаг. Гэтэл өөрийнх нь дотоодын шинжилгээ, дотоодын шинжлэх ухааны байгууллага, хүрээлэнгүүд дээр энэ бүх суурь судалгаанууд нь хийгдчихсэн. Патент нь байгаа, инновац болчихсон.

Тэгээд түүрүүн Б.Баттөмөр гишүүн ярьж байна шүү дээ. Зөвхөн нэгхэн жишээ гэхэд угаасаа тэр Химийн хүрээлэнгээс өөр хийж чадах тэр судалгаа шинжилгээ тэр Эрдэнэт үйлдвэр дээр зарлагдахад хэн ч орохгүй. Хэн ч ордоггүй. Угаасаа өөр компани хийж чадахгүй учраас гаднын ч орохгүй,

дотнынхон ч орохгүй. Тэгээд Химийн хүрээлэн нь орох гэхээр өөрөө орж чаддаггүй. Ийм чөдөр тушаа болгоод хаячихсан.

Тэгэхээр энэ тогтолцоог л бид жаахан энэ цоожийг нь мулталъя гэдэг нэг ийм шинэчлэл хийх гэж л одоо энэ хуулийг өргөн барьсан байгаа юм. Гэхдээ би Төсвийн байнгын хороон дээр яах вэ, Төсвийн байнгын хорооныхон шинэ батлагдаж соёрхон батлагдах гэж байгаа тендерийн хуулиудтай бас нийцлийг нь хангах ёстой юм байна гэд зүйлийг тойрч ярьсан юм болов уу л гэж бодсон шүү дээ.

Одоо энэ чинь яг төсөв дагасан хууль дээр дэмжих дэмжихгүйн тухай санал өгдөггүй. Хэлэлцэх эсэхийг нь бид хэлэлцээд сууж байгаа.

Одоо тэгэхээр яг эндээс илүү нөгөө тендерийн хороо, тендерийн шинэ хуулийн ажлын хэсэг ахалж ажилласан манай Ц.Сандаг-Очир гишүүн маань энэ зүйл дээр бас шинэ гаргалгаанууд гаргаж байгаа.

Г.Тэмүүлэн гишүүн маань бас шинэ санаачилгууд гаргаж байгаа.

Тэгээд одоо энэ дээрээ ингээд бид энэ хэлэлцүүлгийн үеэр засаад залруулаад явчих ийм бололцоонууд нь байгаа болов уу гэж бодож байгаа.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд тодруулья. 1 минут.

Б.Жавхлан: Тийм. Л.Энх-Амгалан сайдын асуулт дээр нэмж хэлье.

Сайд аа, та тэгэхдээ жоохон буруу өнцгөөс яриад байна шүү. Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулиар төсвийн хууль дээрээ чөдөр

түшээ болчихсон ч гэдэг юм уу, тийм өнцөг энд байхгүй шүү дээ.

Төсвийн хууль яалаа гэж. Наадах чинь төсвийн хууль өөрийнхөө энэ төсвийнхөө бодлогыг хамгаалаад үүнийхээ төлөө л явж байгаа асуудал.

Өмнө нь та ямар замбараагүй байсныг мэдээд мэдэхгүй байна уу, эсвэл ерөөсөө мэдэхгүй байна уу.

Энэ нэг хэсэг төрийн байгууллагууд бие биеийнхээ тендерт ордог тийм замбараагүй үе байсан.

Тийм учраас энэ чинь бүр зах хязгаараа алдсан үе ч байсан юм билээ л дээ.

Тийм учраас ингээд эргээд арилжааны банкнууд дээр данс нээж болохгүй, тендер юмнууд дээр бас хязгаартай байх ёстой. Төсвөөр баталгаа гаргаж болохгүй байх зарчмуудыг нэлээн хэдэн жилийн өмнө хийсэн юм байна лээ.

Одоо харин шинжлэх ухааны болон бусад салбарууд. Ганц шинжлэх ухаан дээр ч биш, бусад салбарууд дээр ч тэр өөрсдийнхөө дотоод үйл ажиллагаа, дотоод нөөцөөрөө нэмэлт орлого олж болох. Тэрийгээ эргээд төрийн албан хаагч нарын болон байгууллагын үндсэн чиг үүрэгт нэмэр болох нийгмийн талын асуудлуудыг нь шийдэж болох. Өөрөөр хэлбэл төсөв дээрээс ачааллаа бас жоохон хөнгөлөөд өөрөө өөрийгөө тэтгээд авч явах боломжуудыг нь тавьж өгөх гэж байгаа болохоос биш чөдөрлөчихсөнийг нь нэг чөдрийг нь авч тавих гэж байгаа асуудал ерөөсөө огт биш шүү.

Өчигдөр Ц.Сандаг-Очир гишүүн бас зөв л өнцгөөс хэлсэн. Хувийн хэвшлийнхэнтэй ийм өрсөлдөөн хийж болохгүй ээ гэж.

Тийм учраас тэр өрсөлдөөн биш. Энэ чинь зөвхөн яг патенттай хэсэг дээр нь. Тэгээд яг нарийн чиглэлийн өөр тийм байгууллагууд хийж чадахгүй тийм зүйлүүд дээр нь л ийм боломжуудыг нээж өгч байгаа юм гэж үүнийгээ аягүй тодорхой гаргаж хэлэх хэрэгтэй байхгүй юу.

Тэгэхгүй ингээд нэг юмыг хийж өгөх гэж байна гээд болж байгаа юмнуудыгаа бүгдийг нь ингэж харлуулж явуулж болохгүй.

Танайхаас оруулж ирсэн томьёоллыг чинь бид дэмжээд энэ тодотголоо дагуулаад л өргөн барьсан. Салбар нь өөрсдөө энэ заалтуудаа хамгаалаад, дэмжүүлээд явах нь бас салбар салбарын өөрсдийнх нь л ажил шүү дээ. Тийм.

Г.Занданшатар: Тендерийн хууль дээр шинжлэх ухаан, патенттай холбоотой асуудлуудыг бас хялбаршуулсан журмаар шууд гэрээ байгуулах нөхцөлүүд байсан л даа.

Үүгээр хэтэрхий их задгайруулчихвал ахиад энэ сангууд шиг юм болж болзошгүй учраас бас хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд үүнийгээ нарийвчилж зохицуулахгүй бол деталь нуугддаг учраас.

Жамбын Батсуурь гишүүн. Алга байна. Хаслаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би гурван тодорхой зүйл хэлье.

Нэгдүгээрт, энэ удаагийн төсвийн тодотгол ер нь урьд хожид энэ Их Хуралд болж байгаагүй л ийм тодотгол болж байна л даа.

Өмнө нь төсөв тасарсан, орлого байхгүй болсон, хүндрэлтэй ийм нөхцөлд төсвийн тодотгол хийдэг байсан бол энэ удаа төсвийн орлого давж биелсэн ийм сайхан нөхцөлд төсвийн тодотгол хийж байгаа.

Энэ эдийн засгийн боломжийг ялангуяа ахмад настнуудынхаа тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүү ялгаа ялгааг арилгах. Нөгөө талынх нь нэг том шийдэж байгаа, цогцоор нь шийдэж байгаа асуудал бол төрийн албан хаагчдын цалингийн ялгааг ойртуулах.

Их ялгамжтай байдлыг тогтоочихсон шүү дээ. Энд үе үеийн парламентын гишүүдийн бидний буруутай үйл ажиллагаа байна. Манай нөхдүүд нэг салбарын цалин, нийгмийн хамгаалалттай холбоотой асуудлыг, нэг салбарын хууль оруулж ирэхээрээ тухайн салбарын цалин, нийгмийн хамгаалалтын асуудлыг чирч оруулж ирээд л. Ингээд шийдэж явсаар байгаад бүр холион бантан болгоод тавьчихсан.

Тийм учраас үүнийг засаж залруулах ийм чиглэлийг Их Хурлын зүгээс, Засгийн газрын зүгээс нэгдсэн бодлогоор гаргаж. Цаашид хэн нэгэн Их Хурлын гишүүн салбарын хуулийг санаачилж оруулж ирж энэ бодлогыг эвддэг байдлыг зогсоохоор тогтож байгаа нь их зөв.

Үүнтэй уялдуулаад цалингийн тэр хэт ялгаатай байдлыг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч өгч байгаад үнэхээр баяртай, талархалтай байгаа. Ялангуяа манай биеийн тамирын салбарынхныг бүр орхичихсон. Олон жил ингээд орхичихсон.

Яг үнэндээ хийж байгаа, гүйцэтгэж байгаа ажил, үүргийн хувьд

төрийн албаны бусад салбараас ялгагдах юм байхгүй л ажиллаж байгаа. Бүр тэр байтугай хагас, бүтэн сайнгүй амралтгүй ажилладаг улсууд чинь биеийн тамирын салбарынхан, соёл, урлагийн салбарын хүмүүс шүү дээ. Энэ ажил, мэргэжлийн онцлог гэж байна.

Тэгэхээр энэ салбарынхны цалинг бас нэг жишигт ойртуулж нэмэгдүүлж байгаа явдалд би талархаж байгаа гэдгээ зориуд тэмдэглэж хэлье.

Энд тэнд Байнгын хороо, янз бүрийн юунаас яригдаж байхад бусад салбарынхан янз бүрийн хэл үг гараад байна. Ингээд Засгаас оруулж ирсэн бодлогыг эвдэх гээд байна, унагах гээд байна гэсэн нэг ийм юм яриад байгаа. Арай ч нэг тийм муухай юм хийгдэхгүй байлгүй дээ гэж би бодож байгаа шүү.

Энэ хөрөөний ир шиг болчихсон цалингийн тогтолцоо юмыг нэг жаахан ойртуулаад жишиг болгохгүй бол болохгүй ээ гэж.

Дараагийн нэг хэлэх гээд байгаа юм бол энэ төрийн хэмнэлтийн хууль их чухал хууль, бодлого баталсан. Хэрэгжилтийг нь хангаж байгаа.

Тэгэхээр Сангийн яам, Сангийн сайдыг энэ яг бодит тоон үр дүн, хэдий хэмжээний, хэчнээн зуун тэрбумын хэмнэлтийг хийв ээ гэдгийг олон нийтэд, нийгэмд сайн хэлж мэдээлж өгөөч ээ гэж би ингэж хэлэх гээд байгаа юм.

Олон жил бид ярьсан. Төрийн дээд түвшний даргалах бүрэлдэхүүний орон тоо, сандал суудал, унаа машин, энэ цалин хангамж, гадаадад нэгдүгээр зэрэглэлийн юугаар явдаг, өндөр үнэтэй буудал юу юу ч билээ. Одоо энэ хэрэглээтэй холбоотой. Энэ бол бүр замаа алдсан ийм зүйл байсан л даа. Өчнөөн

олон орлогчийг томилдог. Унаа машин унах шаардлагагүй албан тушаалтнуудыг унаажуулдаг гэх мэтчилнээр өчнөөн асуудал байсан. Үүнийг цэгцэлсэн нь зүйтэй.

Нөгөө талд нь орон нутагт дунд, анхан шатанд ажиллаж байгаа байгууллагуудын төсөв, зардал энэ хэмнэлтийн хуультай хэмнэгдсэнтэй холбоотой бас хүндрэл бэрхшээлтэй ийм юмнууд байна. Үүнийг яаж анхаарч байгаа вэ гэж.

Цаг багтахгүй болж байгаа учраас. Сүүлийнхийг нь энэ худалдан авах ажиллагаатай холбоотой хөдөө сум, суурин газруудад тэр худалдан авах ажиллагаатай холбоотой. Цаг нь дууслаа. Дараагийн нэг минут дээрээ би үүнийгээ асууя.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Б.Бат-Эрдэнэ сайдын асуултад хариулъя.

Төрийн хэмнэлтийн хууль цаг үеэ олсон, үр дүнгээ өгсөн сайн хууль болж чадсан.

Батлагдаад одоо яг нэг жил болж байна. Нэг жил болохдоо хоёр төсвийн жил дамжлаа. 2022 оны төсвийн жилд. Одоо сүүлийн хагаст гэсэн үг шүү дээ. Бараг 200-аад тэрбум төгрөг бодитойгоор хэмнэгдсэн.

Харин 2023 оны төсвийг бид төлөвлөхөд яг хэмнэлтийн хуулиа бариад үндсэндээ 1 их наяд төгрөгийн зардлыг хэмнэж чадсан.

Энэ маш бодитой эдийн засгийн үр өгөөжөө өгсөн ийм сайн хууль болж чадсан. Олон жил яригдсан юм билээ.

Тэгээд энэ Их Хурал үүнийг маш сайн дэмжиж, энэ төсвийн шинэчлэл, төсвийн реформыг урагшлуулахад маш сайн суурь тавьж өгсөн.

Тодруулж хэлбэл ингэж хэмнэж болдог юм байна гэдгийг харуулсан.

Ялангуяа төрийн дундаас дээд албан тушаалтнуудын. Одоо бид comfort zone гэж ярьдаг. Тансаг хэрэглээ гэх үү. Эсвэл хэмнэж болох урсгал зардлаас эхлээд хэрэглээний зардал бүх зүйл, бүх шатан дээр.

Дээрээс нь мөн төсвийн бас нэг томоохон бүрэлдэхүүн хэсэг болох хөрөнгө оруулалт дээр ч гэсэндээ маш сайн төлөвлөлттэй, зөвхөн яг хэрэгцээнд зориулагдсан.

Мөн олон жил болж сунжирч төсөв дээр эргээд дарамт болохгүй байх гээд.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтыг үүнийг нь зөвхөн улсын төсвөөс, үүнийг нь орон нутгийн төсвөөс, үүнийг ерөөсөө төсөв дээрээс хийж болохгүй шүү гэдгийг нь хүртэл маш нарийн зааж өгсөн.

Өөрөөр хэлбэл төсвийг маш хэмнэлттэйгээр төлөвлөхөд маш сайн ийм нэмэртэй хууль болж өгсөн.

Миний хариулт болсон байх. Тийм ээ.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Сумын худалдан авах ажиллагааны талаар гэсэн. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би энэ цагт багтаж амжаад асууж чадаагүй.

Одоо энэ дагаж орж ирж байгаа хуулиудтай холбоотой худалдан авах ажиллагаа. Төрийн худалдан авах хуультай холбоотой байгаа юм.

Тэгэхээр энэ бол хөдөө орон нутагт, ялангуяа сум, аймагт орон нутагтаа заавал тендер зарлахгүйгээр хийчхэж болохоор ийм ажил, үйлчилгээний юмнууд байна.

Үүнийг хөрөнгө санхүүгийн жаахан нэмэгдээд, тэнд нь шууд гэрээ хийгээд ингээд гүйцэтгүүлээд байх тийм бололцоо байх уу? Энэ талаар иргэд их ярьж байгаа. Одоо Батширээт сумын иргэн н.Алтанхуяг гээд хүн байж байна. Хувийн модны цех, үйлдвэртэй. Зөндөө сайхан юм хийж байх юм. Энэ мэтчилэнгээр.

Энэ ер нь худалдан авах ажиллагаатай холбоотой юмыг цэгцлэхгүй бол ингээд л сум орон нутгаар. Манай Өмнөдэлгэр суманд нэг сайхан Соёлын төв бариад авсан. Тэрийг гүйцэтгэгч компани гэж үгүй ээ мөн хөглүүлсэн байна.

Наашаагаа Цэнхэрмандал сумын Соёлын төв гэхэд бас ялгаа байхгүй. Ингээд цаана нь нийгмээр яриад байгаа тэр Баянхутагийн дотуур байрны барилга гэж нэг юм.../минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Хэдүүлээ хэмнэлтийн хууль ярьж байгаа. Тэгээд нөгөө талдаа ингээд шууд

худалдан авалт яриад явахаар зөрчилдөөд байгаа юм.

Тэгэхээр яах вэ, худалдан авах ажиллагааг шуудыг бол аль болох бид хязгаарлах л хэрэгтэй байгаа юм.

Энэ явж ирсэн учраас энэ рүүгээ бас ингээд явах гээд байдаг нэг ийм төлөв явчхаад байгаа юм. Яах вэ, үнэхээр тусгай зориулалтын, тусгай шаардлага хангасан, эсвэл цаг хугацааны хувьд үнэхээр давчуу болсон, нэн шаардлагатай, эсвэл шууд Их Хурал дээр шийдэж болох ч юм уу ийм зохицуулалтуудыг байж болох юм гэж Төрийн худалдан авах ажиллагааны хуулийн шинэчилсэн найруулгад бид оруулж өгсөн байгаа.

Энэ талаар ажлын хэсгээс нэмж хариулна биз.

Яах вэ, одоо бол 20 сая төгрөг дотор төсвийн ерөнхийлөн захирагч нар шууд худалдан авах нь нээлттэй байгаа. Шинэчилсэн найруулгад оруулж байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Хоёр асуулт байна.

Нэгдүгээрт, “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан агентлагийн даргыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр толгойлуулъя” гэсэн Засгийн газрын бодлого байгаа юм шиг байна.

Энэ ч утгаараа агентлагийн даргад тавигдаж байгаа шаардлагыг буюу төрийн албанд 8 жил ажилласан байх. Тэр дундаа удирдах албан тушаалд ажилласан байх гэдэг шаардлагыг нь

хангахад бэрхшээлтэй байгаа учраас энэ шаардлагыг багасгаж байгаа юм байна.

Энэ зарчмыг нь би дэмжиж байгаа юм.

Тэгэхдээ байна шүү дээ. Үүнийгээ хийхдээ Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулаад, төрийн албаны бүх удирдах албан тушаалд тавигддаг нөгөө шаардлагыг хоёр дахин багасгаад оруулаад ирж байгаа зарчим нь буруу байна.

Одоо энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульдаа л өөрчлөлт оруулаад л, яг тэр тухайн агентлагийнхаа даргад тавих шаардлагаа л багасгачих л даа.

Түүнээс биш энэ чинь бүх “Монгол төрийн удирдах албан тушаалд тавигдаж байгаа шаардлагыг нэг агентлагийн дарга тавих гэж бүхэлд нь бууруулж байгаа зарчмыг би болохгүй байна” гэж үзэж байна.

Яагаад гэхээр “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэдэг ойлголт чинь их өргөн болчихсон. “Б”, “Ц” вирустэй байх, түр зуурт группт орох гээд энэ чинь их өргөн хүрээтэй болчихсон шүү дээ. Гэмтлийн зэргээсээ хамаараад.

Тэр байтугай нэг аймгийн, нэг сумын хүн амын тал нь тахир дутуугийн худлаа дүгнэлт гаргуулж групп авч байгаа асуудал гарсан шүү дээ.

Тэгэхээр энэ чинь нөгөө худлаа дүгнэлт гаргадаг, худлаа даатгалын сангаас тэтгэмж авдаг, худлаа групп тогтоодог ийм юмаа би цэгцэлж чадаагүй байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ.

Тэгээд худлаа эмнэлгийн тодорхойлолт аваад л агентлагийн дарга, Төрийн нарийн, өндөр албан тушаалд.

Тавигдах шаардлагад хүрээгүй нөхдүүд нэг эмнэлгийн анкет, эмчийн бичиг аваад л. Тэгээд шаардлага хангаагүй, ажилласан жил нь хүрэхгүй баахан хүмүүс томилогддог цонх болчих вий дээ.

Тэгээд энэ чинь бас өвчин зовлонтой. Би өөр утгаар ярьж байгаа юм. Энд удирдах ажил хийх гэж байгаа хүн чинь эрүүл саруул хүн хийнэ шүү дээ. Ачаалал даах чадвар байхгүй юу энэ чинь.

Энэ логикийг нь би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. **Ачаалал даах чадвар, толгой нь эрүүл саруул байх ёстой шүү дээ. Мэдрэл муутай биш.**

Эсвэл энэ төрийг одоо ер нь юу гэж бодоод байгаа юм.

Хоёр дахь асуулт нь, Хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудал эрхэлсэн агентлагийг “залуучууд” гэдгийг нь гаргаад, “Хүүхэд, гэр бүл хамгааллын агентлаг” болгож байгаа юм байна.

Залуучуудыг нь болохоор “Залуучуудын хөгжлийн төв” болгочхож байгаа юм байна.

Тэгээд энэ нэг агентлагийг дахиад хоёр хуваагаад явж байгаагийн утга ёс яг юу байгаа юм бол. Сонгуулийн жил үндсэндээ нэг жил л дутуу байна шүү дээ.

Тэгээд нэг жилийн дутуу байж байхад чинь бүтцийн өөрчлөлт хийгээд л, дахиад л хаяг усыг нь солиод л, хүмүүсийг нь салгаад л, хоёр дарга болгоод л. Энэ ямар бодлого зорилгоор ганц сонгууль болох гэж байхад чинь

дахиад бүтцийн өөрчлөлтийг энэ байгууллага дээр хийх гээд байгаа юм бол?

Ер нь “Залуучуудын хөгжлийн төв” гэхээсээ илүү “Ахмадуудын хөгжлийн төв” шаардлагатай болчихсон юм билээ.

Сая Хүний эрхийн комиссын тайлан илтгэлийг бид хэлэлцсэн. Хамгийн сэтгэл санааны асуудалд орж ганцаардаж байгаа, хоорондоо асуудлаа ярилцах дутагдаж байгаа асуудал бол энэ ахмадууд дээр маань бий болчихсон юм билээ.

Г.Занданшатар: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа хариулна.

Х.Булгантуяа: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь яах вэ бид илүү их оролцоог хангасан улс болъё, илүү их оролцоог хангасан нийгэм болъё гэх юм бол төр өөрөө үүнийг манлайлахгүй болохгүй байгаа юм.

Одоо нийтдээ манай төрийн албанд улс даяараа 100 гаруй мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ч гэсэн манай төрийн албанд 4800 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг. Үүнээс 87 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа. Төрийн захиргааны албан тушаалд өнөөдөр удирдах албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 0.5 хувь нь л байгаа.

Ингээд бид хэдийгээр манай яам Төрийн албаны зөвлөлтэй хамтраад шалгалт өгөх болзол, журамд энэ хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг нь өөрчлүүлээ. Шалгалт авах байрыг нь

хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах гээд эдгээр зүйлүүд дээр нь ажиллаж байгаа ч гэсэн үнэнийг хэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн албаны энэ өндөр босгыг даваад, дээрээс нь нэмээд өндөр босгоос дээшлээгээ хөгжин дэвшихэд, энэ мерит зарчмаар ахихад их амаргүй өндөр шалгууртай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд битгий хэл одоо сумдад, орон нутагт гээд тэгж байхад шалгуурыг нь хангах төрийн албан хаагч олдохгүй байна гээд манай дээр төрийн албаны олон салбаруудад албан тушаалууд нь өнөөдөр хоосон байж байгаа.

2022 онд гэж байхад төрийн албаны ерөнхий шалгалтад хөгжлийн бэрхшээлтэй 3 хүн л оролцсон. 3 хүн л оролцсон.

Тэгэхээр ийм байгаад байгаа учраас бид төр өөрөө ийм хатуу шалгуурыг тавьчхаад, ажлын байрууд нь ч гэсэн хүртээмжтэй биш байчхаад, тэгснээ хувийн хэвшлийг болохоороо хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулсангүй гээд торгоод байна гэдэг бол бас их учир дутагдалтай юм.

Тэгээд оролцоог хангасан нийгмийг бий болгоё гэдэг утгаараа улс өөрөө, төр засаг өөрсдөө энэ дээр манлайлья гэж энэ удаагийн хуульд өнөөдөр өөрчлөлт оруулж орж ирж байгаа.

Мэдээж таны хэлж байгаагаар бүр энэ үүрэг хариуцлагыг хүлээх эрүүл мэндийн хувьд ч байдаг юм уу, ийм боломжгүй байх юм бол түүн дээр нь Төрийн албаны тухай хуулиараа дүгнэлтүүд нь гараад явах байх гэж бодож байна.

Ийм ч учраас бид бас хөгжлийн бэрхшээлтэй. Ганцхан энэ агентлагт зориулагдаж гаргасан шийдвэр биш шүү. Манай Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албаны шалгуур маань бас нэлээдгүй өндөр.

Тэгэхээр энэ дээр зүгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ахин дэвших боломжийг нь хоёр дахин хөнгөн болгож өгье л гэдэг ийм нэгдүгээр шалгуур үзүүлэлтүүд орж ирж байгаа юм. Энд нь манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлаг маань ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн удирдаасай гэж би ч хувь хүнийхээ хувьд үзэж байна. Монгол Улсын ерөнхий сайд ч гэсэн оролцоог хангасан нийгмийг бий болгохын төлөө төр засаг үүнээс эхэлье гэдгийг бас тавьж байгаа юм.

Хоёр дахь нь, **“Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн агентлаг”** гэж байсан. Үүн дээр хоёр, гурван асуудал үүсээд байгаа юм.

Нэгдүгээрт, манай эмэгтэйчүүд, ахмадуудын маань хувьд тэгвэл хэрвээ ингэж сегментлэж байгаа юм бол бид нарт яах юм бэ гэдэг асуудал.

Өнөөдөр эмэгтэйчүүд, ахмадууд руу хүрч ажиллахад бодлогоо манай яам гаргаад, төрийн бус байгууллагуудаар дамжуулж үйлчилгээгээ иргэдэд, сегментэд хүрч очиж ажиллахыг хийж байгаа.

Яг үүнтэй адилхан залуучууд руу бид бас хүрч ажиллаж болох юм. Залуучууд руу чиглэсэн хууль маань өнөөдөр батлагдаад энэ агентлагаар дамжуулж нэлээдгүй ажлуудыг бид хийсэн.

Тэгэхдээ цаашдаа үүнийг хэд хэдэн байдлаар хийж болох юм байна. Энэ төвүүд гэдэг нь Б.Энхбаяр гишүүн ээ. Нөгөө аймаг, орон нутгуудад хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор энэ агентлагийн хэлтсүүдээр дамжуулаад Залуучуудын төвүүд гэж байгуулагдсан юм.

Зарим нь манай Гэр бүл хүүхэд хөгжлийн газрын нэг өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа. Зарим нь өөрийн гэсэн байртай байгаа.

Үүнийг аймаг, орон нутагт, аймгийн Засаг дарга, дүүргийн Засаг дарга, Залуучуудын хөгжлийн орон нутаг дахь зөвлөлийнх нь даргаар ажилладаг. Эсвэл орон нутаг өөрөө энэ бүтцийг аваад үргэлжлүүлээд авч явж болох юм.

Бид агентлагаараа дамжуулаад энэ хуулийнхаа хүрээнд ямар ч байсан эхлэлийг нь бас гайгүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Цалин тэтгэвэр нэмэх асуудал.

Яах вэ, иргэдийн дунд хүлээлт их байх шиг байна.

Тэгэхдээ бодит орлогын өсөлт байж чадах уу, үгүй юу гэдэг л асуудал байгаа.

Тэгээд Эдийн засгийн байнгын хороон дээр энэ талаар асуусан л даа. Тэгэхдээ чуулган дээр бас дахиад асуучихмаар санагдаад байна.

Нэгдүгээрт, өнөөдөр инфляц 11.3 хувьтай байгаа. Өндөр байхгүй юу. Өндөр. Дахиад зах зээл рүү ингээд сүүлийн 6 сарын хугацаанд бид 1.8 их

наяд төгрөг хийх гээд байна. Үр дүнд нь инфляц өснө.

Тэгэхээр үр дүнд нь иргэдийн бодит орлого маань өсөх үү, үгүй юу гэдэг дээр асуултын тэмдэг гарч ирж байгаа юм. Яг хэдэн хувиар өсөх юм бэ гээд.

Тэгэхээр үүнийгээ дагалдуулаад ямар бодлогын арга хэрэгсэл хэрэглэх юм бэ? Мөнгөний бодлогын орон зай чинь улам ингээд хумигдаад байгаа. Тэгэхээр тэнд ганцхан л арга хэмжээ байгаа. Тэр нь юу вэ гэхээр бодлогын хүүгээ л өсгөх.

Бодлогын хүүгээ өсгөх юм бол бизнесийн сектор чинь дахиад шахагдаад л явчихна.

Тэгэхээр яг энэ дээр яг ямар арга хэмжээ авах юм бэ? Нэг.

Хоёрдугаарт нь, нүүрсний экспорт энэ жил ингээд өссөн болохоор, төсөөлөл өөдрөг байгаа болохоор бид эх үүсвэртэй болчихлоо гэж тайлбарлаад байх шиг байна. Тийм.

Гэтэл яагаад өнөөдөр ийм байгаа вэ гэхээр бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Америкийн Нэгдсэн Улс, Хятадын худалдааны асуудалд хүндрэлтэй хэвээрээ байгаа. Австрали нүүрсээ нийлүүлэхгүй байгаа. 100-аас 120 сая тонн нүүрс нийлүүлэхгүй байгаа болохоор бид нарт орон зай гарч ирчхээд байгаа.

Гэхдээ энэ байнга үргэлжлэхгүй шүү дээ. Австрали нийлүүлээд эхлэх юм бол яах билээ. Цаашаа ирэх жил, дараа жил, 4 жил, 5 жил, дунд, хугацаандаа урт хугацаандаа.

Өнөөдөр бид зардлынхаа тэлэлтийг хийчхээд дараа нь орлогоо

алдчихсан тохиолдолд энэ чинь эргээд л дарамт болж ирнэ шүү дээ.

Тэгээд энэ дээрээ төсөөллөө юу гэж харж байгаа юм бэ? Орлогын төсөөлөл. Ялангуяа нүүрсний салбар дахь орлогын төсөөллөө яаж харж байгаа юм?

Хятад чинь 300 саяын л хэрэглээтэй. Тооны. Тэгээд үүнээс 50 сая дээр нь л явдаг байсан. Гэтэл одоо юу болж байна гээд гэхээр бид нарын зах зээлийг чинь Оросууд эзэлчихсэн. Тэгээд өрсөлдөөн үүсээд байгаа шүү дээ.

Тэгээд мөнгөө яаж цаашаа олох юм бэ гэдэг. Энэ дээр нэг бодитой төсөөллөө хуваалцаач ээ.

Дараагийн нэг зүйл нь тэтгэврийн асуудал байна. Нийгмийн даатгалын сан чинь өөрөө 4 их наядын том, дээрээс нь алдагдалтай, цаашаагаа ийм алдагдалтай явах юм бол дийлэхгүй. Ачааллаа.

Ингээд шүүмжлэхээр зөрүүлээд сошиалаар Т.Доржханд гишүүн, ХҮН намынхаа тухайлбал энэ тэтгэврийг буулга гэж шаардлага тавьж байна. Ахмадуудаасаа мөнгө хасдаг ямар өөдгүй хүмүүс вэ гэсэн байдлаар зориуд ингээд мушгин гуйвуулаад байгаа юм.

Эсрэгээрээ үүнийг цогц байдлаар реформоо зоригтой хийгээд, тэтгэврийнхээ реформыг хийе. Хуримтлалынхаа тогтолцоо руу, хагас хуримтлалын тогтолцоо руу яаралтай одоо хий. Түүнд чинь мөнгө хэрэгтэй юм байна. Үүнийгээ одоогоос шийдээд явчихъя. Хуримтлуулаад явъя л гэдэг ийм агуулгаар бид яриад байгаа шүү дээ.

Гэтэл өнөөдрийн энэ арга хэмжээ маань дахиад л ийм нэг параметрийн өөрчлөлт байдлаар орж ирээд, тэгээд нөгөө тэтгэврийн зөрүүг нөхөх байдлаар

явахаар нөгөө үндсэн суурь зовлон маань хойшоо шидэгдээд л байна.

Тэгээд цаашаа шидэгдээд байхаар бид нөгөө суурь өөрчлөлтүүдээ хэзээ яаж хийх юм бэ? Ийм байдлаараа боломжгүй шүү дээ. Ахиад л тэтгэврийн реформ чинь хойшоогоо шидэгдээд л яваад байх юм бол, тэгээд мөнгө байхгүй байх юм бол энэ нэг том реформууд чинь, эдийн засгийн реформууд чинь хийгдэх боломжгүй болно.

Тэгэхээр үүнийгээ яаж харж байгаа юм бэ гэдэг дээр бас нэг асуулт авчихмаар байна.

Тэгээд ер нь Монгол Улс эдийн засаг чинь борцлогдчихсон байгаа шүү дээ. 11, 12, 13 тэрбум доллар дээр 10 жил гацчихсан. Гацаатай. Экспорт нь савлагаатай.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Санал хэлсэн үү? 3 асуулт тавьсан байна. Хариулъя.

Х.Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Т.Доржханд гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа үнэн. Инфляц, барааны үнэ гээд иргэдийн амьжиргаанд үнэхээр хүнд тусаж байна.

Бид тэгээд бас энэ цаг үед инфляц буурахыг хүлээж байж цалин, тэтгэврээ нэмнэ гэхээр яг иргэдийн амьдрал, амьжиргаа үнэнийг хэлэхэд үүнийг хүлээж чадахгүй болчхоод байгаа юм. Манай төрийн албан хаагчдын цалин доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс арай жоохон өндөр. Ажилтай мөртлөө ядуу болчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнтэй уялдуулаад бид эдийн засгийн боломж бололцоо гарсан эхний боломжийг ашиглаад энэ удаа бид төрийн албан хаагчдынхаа цалинг, хүүхдийн мөнгийг өнгөрсөн жил 2023 оны төсвийг өргөн барихад эдийн засаг маш хүнд, хил хэзээ нээгдэх нь ч тодорхойгүй байсан цаг үед бас нэг хүүхдийн мөнгийг 9 хувь хасаад энд ороод ирчихсэн байсан. Энэ бүгдийг нөхөж олгоод, нэмж олгох.

Дээрээс нь нэмээд тэтгэврийн бас энэ зөрүүг арилгаад тэтгэврийг 10 хувиар бас хамтад нь нэмэх ийм арга хэмжээнүүдийг зэрэг авч орж ирж байгаа юм.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн маань хувьд таны санаа зовж байгаа зөв.

Улсын Их Хуралд нийгмийн даатгалын багц хуулийг өргөн барьчихсан байгаа. Засгийг газар.

П.Анужин гишүүн Нийгмийн бодлогын байнгын хорооны даргын хувьд ахлаад ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Одоо энэ хаврын чуулганаар бид энэ нийгмийн даатгалын багц хуулиа батлуулна гэж үзэж байгаа.

Нийгмийн даатгалын багц хуулийг батлуулахад урьтал болгож, бэлтгэл ажлыг хангаж бас энэ тэтгэврийн зөрүүг арилгахгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Тэгэхгүй бол ахмадуудын маань хувьд. Одоо нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүсийн хувьд ч гэсэн аягүй шударга биш байгаа байхгүй юу.

Илүү олон жил ажилласан, илүү их нийгмийн даатгал шимтгэл төлсөн мөртлөө 20 жилийн өмнө өнөөдөр тэтгэвэрт гарснаасаа болоод хохирч

үлдээд. Адил төстэй ажил хийгээд, адилхан нөхцөлд ажил хийгээд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хүнтэйгээ харьцуулах юм бол 2 жилийн өмнө тэтгэвэрт гарсан хүнээс хамаагүй бага тэтгэвэр аваад байхад л ахмадууд маань энэ шударга бус байна гэж яриад байгаа юм.

Тэгэхээр бид нэгэнт шударга нийгмийг бий болгоно гэж байгаа бол хамгийн эхнээсээ энэ тэтгэврийн зөрүүг арилгахаасаа хамтдаа л эхлэх ёстой.

Тэгээд энэ удаагийн тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээг бид хийхгүй бол энэ бол 5, 6 жилийн өмнө бид 100 тэрбум төгрөгөөр бүтэн жил тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээг авч болохоор байсан.

Одоо бид бараг 200 тэрбум төгрөгөөр хагас жилд тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээг авч байна.

Гэхдээ үүнийг нэг удаа хийчих юм бол ирэх жилээс авхуулаад бид хоёр юмыг тэгэхдээ хийх ёстой юм билээ.

Нэгдүгээрт, итгэлцүүрээ бид жил болгон батлаад явах хэрэгтэй. Тэгэх юм бол энэ. Тэгэхдээ шинээр тэтгэвэрт гарч байгаа хүмүүст л хэрэглэгдэнэ.

Хоёрдугаарт, тэтгэврээ бид инфляцтай жил болгон уялдуулж нэмэх ёстой. Ингэх юм бол ингэж том дүнтэйгээр тэтгэврийн зөрүү арилгах арга хэмжээ бид авах шаардлагагүй болоод нийгмийн даатгалын багц хууль маань батлагдахад энэ суурь зарчим нь хангагдчихсан, хууль батлагдсан даруйдаа амжилттай хэрэгжих боломж нь үүгээр бий болж байгаа.

Тэгээд Т.Доржханд дарга, манай ХҮН намынхан нийгмийн даатгалын багц

хуулийг маш их дэмжиж хамтран ажиллаж байгаа. Энэ бол ерөөсөө төсвийн шинэчлэлийн бас их том реформын нэг юм билээ.

Тэгэхгүй нийгмийн даатгалын сан нь алдагдалтай байгаад байхаар төсвөөсөө нөхсөөр байгаад л үнэнийг хэлэхэд нэг хармаанаасаа нөгөө хармааруугаа нөхсөөр байгаад энэ төсвийн алдагдал, өр зээлийн хэмжээ буурахааргүй нөхцөл байдалд хүрчхээд байгаа юм.

Тэгээд үнийн өсөлттэй холбоотойгоор Сангийн яамныхан мэдээлэл өгөх үү. М.Санжаадорж дарга мэдээлэл өгөх үү. Үнийн өсөлттэй холбоотойгоор. Нүүрсний төлөвлөлт гэсэн. Тийм. Орлогын төлөв байдлын талаар гэсэн.

Ж.Ганбат дарга хариулах уу?

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. М.Санжаадорж дарга. 84 дүгээр микрофоныг өгье. Ажлын хэсгийн.

М.Санжаадорж: Яг одоо хэлэлцэгдэж байгаа, дагаж байгаа хуультай холбоотойгоор яг ийм зохицуулалтын асуудал ч юм уу, хөндөгдсөн заалт байхгүй.

Гэхдээ түрүүний асуусан асуултад хариулахад жишээ нь, нүүрсний экспортын хэмжээ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэг жилийн хэрэглээ 3.5 тэрбум тонн нүүрс байдаг. Үүнээс яг кокс нь 600 орчим сая тонн нүүрсний хэрэглээтэй байдаг.

Гадаадаас авдаг хэмжээ нь 70-аас 100 сая тонн орчмыг авдаг.

Гишүүний хэлсэнчлэн Австралитай харилцаа тааруу байгаатай

холбоотойгоор Индонез болон Монголын зах зээлийн хувьд боломж маш өндрөөр гарч ирчхээд байгаа.

Манайх тэгэхдээ нийт гаргаж байгаа нүүрсний маань 50-иас 60 хувь нь л кокс байдаг. Үлдсэн нь эрчим хүчний нүүрс. Сул коксжиход бас гардаг.

Тэгэхээр бид нарын гаргаж байгаа юу гэдэг юм, 30 сая тонны коксжих нүүрс зах зээлдээ таарсан нүүрс гэж бид найдаж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нөгөө талдаа инфляцын анхны үүсэл юу вэ гэхээр олон улсад өрнөсөн гадаадаас импортлогдож орж ирсэн ханшийн нөлөөлөлтэй хамт орж ирсэн энэ инфляцын нөлөөлөл байгаа.

Тэгэхээр бид экспортоо л аль болох сайн хийж байж, зорилтоо өндөр тавьж байж, тэр зорилтоо хангахын төлөө Засгийн газрынх нь түвшинд бүхэлдээ ажиллаж байж, валютын урсгалаа нэмэгдүүлж байж л инфляцын асуудлаас бид гарч ирэх боломжтой гэж бид харж байгаа.

Засгийн газраас дэвшүүлээд, Улсын Их Хурлаар эцэслэн баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын асуудал байгаа. Үүн дээр яг аж үйлдвэрийн сэргэлт, боомтын сэргэлт, нөгөө талдаа бас мөн төрийн албаны сэргэлтийн асуудлууд хамт орж ирсэн байгаа.

Энэ асуудлынхаа хүрээнд төсвийн тодотгол дээр асуудлуудаа дэвшүүлээд, тэгээд энэ хэмжээнд бид орлогоо олно. Санхүүжилтээ энэ хэмжээгээр санхүүжүүлж чадна гэсэн итгэл үнэмшилтэйгээр тооцоон дээрээ суурилсан тооцоолол дээрээ үндэслээд оруулж ирсэн байгаа.

Тэгээд дагаж байгаа зүйлүүд дээр бас үүнтэй холбоотой зохицуулалтууд орж ирсэн байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Т.Доржханд гишүүн тодруулж асууя.

Т.Доржханд: 2023 оны инфляцын зорилт чинь өөрөө 8 хувь байгаа шүү дээ.

Тэгээд 8 хувь дээрээ та нар барьж чадах юм уу? Энэ дээр нэг тодруулчихмаар байх юм.

Тэгээд хоёрдугаарт төсвийн орлого чинь экспортоосоо хамаараад байна шүү дээ. Тийм ээ. Экспорт чинь савлаад байна шүү дээ. Нөгөө талд чинь эдийн засгийг тэлдэг арга хэрэгсэл чинь юу вэ гээд тэгэхээр гаднын хөрөнгө оруулалт. Энэ чинь тэг дээр байгаад байна шүү дээ. Яагаад вэ гээд гэхээр энэ чинь ханш чинь өөрөө унаад хэлбэлзээд байхаар хэн ийшээ хөрөнгө оруулах билээ дээ.

Тэгэхээр макро тогтвортой байдлаа хийгээд, ханшаа ингээд тогтворжуулж чадах юм бол тэр урсгал чинь нэгдэх гээд байна. Гэтэл өнөөдрийн энэ арга хэмжээнүүд чинь ханшинд чинь нөлөөлөх гээд байна шүү дээ. Төлбөрийн баланс дээр чинь дарамт өгөх. Яг энэ дээр та нар дотроо яаж ярьсан юм бэ?

Гуравт нь юу байна гээд гэхээр бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Гурав дахь эх үүсвэр бол гаднаас оруулж ирэх зээл, бондын эх үүсвэр. Гэтэл энэ чинь өрийн таазандаа тулчхаад энэ эх үүсвэр чинь цоожтой байгаад байдаг.

Тэгэхээр зөвхөн экспортыг баримжаалж явж байгаад нөгөө хоёр дахь урсгалаа хаачих вий дээ. Энэ дээр яг өөр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Т.Доржханд гишүүний асуултад хариулъя. Сангийн яам хариулах уу? Хэн бэ? Ж.Ганбат. М.Санжаадорж уу? 84 үү? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаарай.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Т.Доржханд гишүүний асуултад хариулъя.

Төсвийн хүрээний мэдэгдлийг сая үүний өмнөх юун дээр баталчихсан. Энэ дээр хэрэглээний үнийн өсөлтийн түвшинг 10 хувь байхаар нэмэгдүүлээд орчихсон байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл бид одоо яг хэрэглээ талдаа ингээд 1.5 хэн их наядын зарцуулалт нэмчхэж байна гэсэн үг.

Манай яамны хийсэн тооцоогоор импорт талдаа 200 орчим сая долларын нөлөөлөл бид энэ дээр ачаалал ирэх юм байна гэдэг тооцоо хийсэн байгаа.

Нөгөө талдаа мэдээж хэрэг бид хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор эдийн засгийн тэлэлт бас тодорхой хэмжээнд явагдах юм байна гэж бид тооцож байгаа.

Энэ хэмжээгээрээ бас нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, мөн НӨАТ-ын орлого нэмэгдэхээр байна гэж бид харж байгаа.

Ер нь эдийн засгийн бүтэц талаас нь харахаар бид илүү их номинал тоогоос нь яриад байхаас гадна нөгөө талдаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя. 1 минут.

Т.Доржханд: ХҮН намын эдийн засагчид “Монголын эдийн засгийн клуб” гээд “тинк танк” ажиллуулдаг. Тэр нь 1200, 1300 эдийн засагчид байдаг юм. Монголбанкныхан ч их байдаг юм.

Бид нарын зүгээс энэ цалин тэтгэврийг нэмэх асуудлыг бид шүүмжилж байгаа юм огт биш. Нэмж болно. Гагцхүү бодит орлого нь өсөх үү гэдэг л асуудал байгаа.

Өөрөөр хэлэхэд инфляцыг хөөрөгдөөд явчих юм бол, мөнгөний бодлогын арга, хэрэгслийг ашиглахгүй юм бол, тэлэлт хийгээд явчих юм бол энэ чинь үр дүнгүй болчихно.

Дахиад юмны үнийг чинь хөөрөгдчихнө, бодит орлого нь буурчихна.

Тэгэхээр энэ дээрээ манай Сангийн яам, Хөгжлийн яам, Монголбанктайгаа сууж байгаад арга хэрэгсэлээ гаргаж ирээд дахиад энд тогтоолоор хийхгүй болохгүй.

Хоёрдугаарт, бид нөгөө хуримтлалын тогтолцоо руу орно гээд тэтгэврийн санг маш олон хүмүүст хүлээлт үүсгэчихсэн шүү дээ. Хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэнэ гээд. Тийм биз дээ. Залуучууд. Одоо ийшээгээ бүгдээрээ ярьж байгаад зоригтой орох хэрэгтэй. Том реформ руугаа орох хэрэгтэй. Попдох.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Т.Доржханд гишүүний тодруулгад хариулъя. Хэн хариулах вэ? М.Санжаадорж дарга. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын

дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр инфляцын түвшин бид 8 байгааг 10 хувь дээр зорилтот түвшингөө аваачна гээд 2 пунктээр нэмээд сая батлуулчихсан байгаа.

Нөгөө талдаа яах вэ, бид тооцооллыг улсын төсөв талын зарлага талаа бид дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулахаар дунджаар 25 хувь байдаг. Энэ түвшиндээ байгаа юм. Өөрөөр хэлбэл дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулж байгаа хэмжээгээр бид мөнгөний нийлүүлэлт гайгүй. Цэвэр мөнгөний нийлүүлэлт талдаа мэдээж хэрэг нэмэгдэнэ.

Инфляц 2 хувиар нэмэгдэж байгаа тооцоолол дээр бас юу орж ирж байна гэхээр түрүүний миний хэлдэг 200 сая долларын бид импортын талдаа дарамт ирж магадгүй гэсэн тооцоолол байгаа юм.

Мэдээж хэрэг таны зөвлөсний үүний дагуу бид хэд Монголбанкныхантайгаа энэ талаар ярилцаж байгаа.

Нөгөө талдаа мэдээж хэрэг зөвхөн төсвийн бодлого талтайгаа хийж байгаа боловч нөгөө талдаа мөнгөний бодлого талдаа бид юу хийх вэ гэдэг дээр бас ярилцаад явж байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу? Х.Булгантуяа сайд нэмж хариулья.

Х.Булгантуяа: Хуримтлалын сангийн хуулийг манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бас бичиж байгаа, боловсруулж байгаа. Олон улсын зөвлөхүүд оролцоод.

Байгалийн баялгийн сантайгаа уялдаж, Сангийн тухай хуультайгаа бас

уялдаж орж ирэх ёстой байгаа. Иргэдэд ер нь байгалийн баялгаас нь хүртэх, энэ хууль эрх зүйн орчныг нь боловсруулах, нийгмийн даатгалын сандаа төлсөн шимтгэлээсээ, байгалийн баялгаасаа орж ирж байгаа ногдол ашиг, орлогоосоо иргэд, олон нийт ипотек бүтээгдэхүүний зээлд хамрагдахад хүртэл урьдчилгаа төлбөрт нь ашигладаг байх нь хууль эрх зүйн орчиг бид боловсруулж байна.

Ирэх намар Улсын Их Хуралд өргөн барьчих болов уу гэж харж байна.

Л.Мөнхбаатар: Одоо Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр 2023 оны улсын төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай л асуудал. Бидний ярьж тогтсоноор төсвийн тодотгол гэж ярьдаг.

Үүнийг дагуулж зарим хуулиудад өөрчлөлт оруулах тухай асуудал орж ирсэн. Мэдээж энэ удаагийн төсвийн тодотгол эдийн засгаа сэргээх, баялгийнхаа борлуулалт, тээвэрлэлт энэ бүхий л үйл ажиллагааг ил тод болгож, үр өгөөжийг дээшлүүлэх, төсвөө эрүүлжүүлэх, хариуцлага сахилгыг дээшлүүлэх гээд энэ цогц арга хэмжээний үр дүнд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд нааштай үр дүнгүүд гарч, төсөвт төвлөрөх орлого тодорхой хэмжээгээр давж биелэх ийм бололцоо бүрдсэнтэй холбогдуулж иргэдийн амьдрал ахуйг дэмжих, тодорхой цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжүүдийн ялгаатай байдлыг арилгах, нэмэгдүүлэх ийм л арга хэмжээг л авч хэрэгжүүлж байгаа ийм зүйл.

2023 оны төсөвтөө бид энэ баялаг бүтээгчдээ дэмжих, татварын бааз сууриа

өргөтгөх чиглэлээр тодорхой хөрөнгүүд тусгасан.

Тэр 229 тэрбум төгрөг. Түүний цаана 1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй, бас боломжит хугацаатай зээлийн асуудлыг шийдсэн гээд олон зүйлүүдийг тодорхой үе шаттай бодлоготойгоор авч хэрэгжүүлээд яваад байгаа. Энэ бол би зохих үр дүнгээ өгнө гэж ойлгож байгаа юм.

Тэгээд тодорхой бий болсон үр дүнгийн тодорхой хэсгийг иргэдийн аж амьдрал, цалин, тэтгэвэр, тэтгэмжийнхээ асуудал руу чиглүүлэх ёстой гэсэн нэгдсэн байр суурь дээрээс энэхүү төсвийн тодотголыг хийж байгаа.

Дагуулаад орж ирж байгаа хуулиуд дээр бас ярих зүйлүүд байгаа. Бид Төрийн албаны тухай хуульдаа өөрчлөлт оруулж байна. Энэ дотор бас хэд хэдэн заалтыг эргэж харж анзаармаар зүйлүүд байгаад байна. Яах аргагүй төрийн алба гэдэг тогтвортой, мэргэшсэн, шатлан дэвших замаар явдаг ийм алба. Энэ том албаныхаа үзэл баримтлалыг тодотголоор дагуулаад өөрчилчхөж бас боломгүй байна.

Тийм учраас тэр үндэсний ажиллах хүчний тоонд эзлэх хувийн жин гэдгийг зүгээр бас дуугарчихдаг зүйл биш ээ. Бид ер нь төрийн албаныхаа бүтэц, чиг үүрэг, ямар чиг үүргүүдээ бусдаар гүйцэтгүүлж болох юм. Одоо байгаагаасаа ямыг нь либералчилж болох юм гэдэг нэлээн том судалгаа, дүгнэлт дээр тулгуурлаж үзэл баримтлал их тодорхой болж байж яригдах ёстой зүйл гэж. Нэг.

Хоёрдугаарт, нэмэгдэл цалингийн асуудал бас хамаагүй ярьчихдаг зүйл биш ээ. Үндсэн цалин нэмэгдэл, цалин хоёр

хоорондоо бас зохистой харьцаатай явдаг зүйл.

Дээр нь бид энэ үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу явж байгаа.

Тийм учраас цалингийн сан дотор үндсэн цалин хийгээд тэр гүйцэтгэл, үр дүнгээр авч болох цалингийн орон зайнууд хоорондоо ямар баланстай явах ёстой юм бэ энэ тэр гэдэг энэ зүйлүүдээ нэлээн нарийн тооцож үзэж, түүн дээрээ тулгуурлаж байж сая энэ хувь хэмжээ юмнууд яригдаж гарч ирэх ёстой.

Тийм учраас би тэр үндэсний ажиллах хүчинд эзлэх хувийн жин, нэмэгдэл цалингийн хувь энэ тэр гэсэн энэ заалтуудыг ер нь ямар тооцоо, судалгаанд оруулж ирэв? Энэ удаагийн энэ орж ирсэн асуудлаа татаад авчихвал яасан юм бэ?

Нэлээн ул суурьтай судалж байж оруулж ирвэл яасан юм гэсэн ийм саналтай, ийм асуулттай байна.

Хоёр дахь зүйл. Төрийн хэмнэлтийн хууль үр дүнгээ өгч байгаа. Гэхдээ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Ж.Батжаргал гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Ч.Дондогмаа: Засгийг газрын Хэрэг эрхлэх газар Ч.Дондогмаа. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Төрийн албан хаагчийн тоог хязгаарлахтай холбоотой асуудлаар хариулъя.

Төрийн албан хаагчийн тоог хязгаарлах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлаар Засгийг газрын Хэрэг эрхлэх газар дээр ажлын хэсгүүд байгуулагдаад, судалгаа хийгдээд, бас үе шаттайгаар хийгдэх ажлууд зохион байгуулагдаад явж байгаа.

Төрийн албан хаагчийн тооны талаар судалгаа хийсэн. Энэ тодотголыг дагуулж оруулж ирсэн хуулиар ерөнхийдөө нийт ажиллах хүчний тоонд эзлэх хувь нь 15 хувиас ихгүй байна гэж оруулж ирээд энэ зохицуулалтаа 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлж мөрдөхөөр байгаа.

Тэгэхээр одоо шууд энэ үйл ажиллагаа хийгдэхгүй. Үе шаттай хийгдсэний үндсэн дээр энэ 15 хувь дээр байна гэсэн асуудал 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжинэ.

Л.Мөнхбаатар: Болсон уу? Хэн хариулах вэ? Нэмж хариулах нь хэн юм? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулья.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулья.

Тийм. Гишүүний хэлж байгаатай бид яг санал нэг байна.

Тооцоо судалгааны хувьд үндсэн цалингаас нь нэмэгдлийн хэмжээг хэрхэн тооцох вэ? Ялангуяа нэмэгдэл дотроо тогтмол нэмэгдлүүдийн хэмжээг хэрхэн тооцох вэ? Харин хувьсаж нэмэгдэж, хасагддаг буюу үр дүн, бүтээмжид суурилсан нэмэгдлийг хэрхэн тооцох вэ гэдэг асуудал их чухал асуудал болчихоод байгаа.

Ер нь олон улсад үүнийг “**clean wage**”_[цэвэр цалин]” бодлого гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл үндсэн цалингаа илүү их том болгодог. Тогтмол нэмэгдлүүдээ үндсэн цалиндаа шингээгээд гэсэн үг.

Тэгэхээр одоо юу гэдэг юм, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга байхын тулд докторын зэрэгтэй байх ёстой, мэргэшсэн нягтлан байх ёстой, ажилласан жил нь тэд байх ёстой гэх юм бол үүнийгээ үндсэн шалгууртаа орчхож байгаа учраас үндсэн цалиндаа орох ёстой.

Түүнээс биш тус тусдаа нэмэгдлүүд өгдөг биш ийм байдлаар яваад.

Харин нэмэгдлийн хэмжээ нь илүү тийм гүйцэтгэлд суурилсан, бүтээмжид суурилсан, тухайн хүнийг албан тушаалтныг үнэлэх. Нөгөө талдаа мөн давхар байгууллагыг нь үнэлэхэд ашигласан тэр үнэлгээнийхээ хэмжээнд нь суурилж явах ёстой гэж хэлэх гээд байгаа юм.

Одоогийн Төрийн албаны тухай хууль дээр ямар нэгэн байдлаар нэмэгдлийг хязгаарласан хувь хэмжээ байхгүй байгаа.

Энэ нь Сангийн яамны хувьд ямар бэрхшээл үүсгэж байна гэхээр салбар болгоны хуулиар салбарууд өөрсдийнх нь салбарын хуулийг хэлэлцүүлэхдээ тус тусдаа нэмэгдлүүдийг салбарын хуулиуд дээр оруулчихдаг.

Эдгээр нэмэгдлүүдийг нь тооцоод үзэхээр зарим албан хаагчдын хувьд маш өндөр нэмэгдэл, 100 хувиас ч илүү өндөр нэмэгдэл одоо авч байгаа тийм албан хаагч нар гарч ирээд байгаа.

Нөгөө талдаа бид үндсэн цалин талаа нэмэгдүүлж байгаа тохиолдолд тодорхой хэмжээнд бас нэмэгдлийнхээ хэмжээг хязгаарлахгүй бол цалингийн сангаа тавьж туух магадлал аягүй их өндөр байна гэж бид хараад байгаа юм.

Тийм учраас энэ хязгаарлалтын асуудлыг одоогийн хууль дээр байхгүй учраас эхний ээлжид 100 хувь гэдгээр зохицуулалтыг нь оруулж ирье ээ гэдэг зүйл оруулж ирсэн байгаа.

Дараагийн ээлжид бид Төрийн албаны тухай хууль дээр энэ хуулиараа ер нь нэмэгдлүүдээ зохицуулна гэдэг зохицуулалтаа оруулж ирчхээд энэ дээр хугацаагаа авчхаж байгаа юм.

Хугацаагаа авчхад 2024 оны төсвийг бид хийхдээ бусад салбарын хуулиудын нэмэгдлүүдийг салбарын хуулиудаас нь илүү их Төрийн албаны хууль руугаа шингээсэн байдлаар оруулж ирэх бэлтгэл ажлаа хангах байдлаар энэ нэмэгдлийн хэмжээг хязгаарлаж оруулж ирж байгаа гэж ойлгож болно.

Яг хоёр жилийн өмнө хийсэн судалгаагаар үндсэн цалин, нэмэгдлийн харьцаа үндсэн цалингаасаа 67 орчим хувь байсан. Төрийн албан хаагчдын хувьд дунджаар. Зарим нь 67-гоосоо ч бага байгаа, их байгаа. Тэгэхдээ дундаж нь 67 гэсэн тооцоо байсан.

Тийм учраас бид 100 хувиас ямар ч байсан хэтрүүлэхгүй байж байгаад энэ хүрээндээ Төрийн албаны хууль руугаа энэ цалин нэмэгдлийн үндсэн бодлогоо шингээе гэсэн зорилгоор үүнийг оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одоо эрхэм гишүүн Гочоогийн Ганболд асуултаа асууя.

Г.Ганболд: Төсвийн тодотгол л яриад байх шиг байх юм. Би энэ төсвийн тодотголыг дагаж орж ирсэн энэ 7 хуулийн хэлэлцэх хэсгийг л хэлэлцэж байна гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хуулиуд дотор би эхлээд энэ Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой.

Төрийн хэмнэлтийн хууль үр дүнгээ өгсөн гэж сая Сангийн сайд хэлж байна. Үүнийг үнэхээр хамгийн сайн хэрэгжиж байгаа газар бол орон нутагт байна.

Нэг талаасаа орон нутгийн төрийн байгууллагуудад нэлээн том дарамт болж байна. Орон нутагт баахан том газар нутагтай аймаг, сумуудад унаагүй дарга нар л байна даа.

Энэ агуулгаараа хөндөгдсөн заалт учраас аймгийн Засаг дарга нарын энэ орлогчдыг, энэ сумдын иргэдийн Хурлын дарга нарын унааны асуудлыг хуулийн заалтаар шийдээд өгчих боломж байхгүй юм уу?

Бид нарын албан тушаалын автомашин, албан хэрэгцээний автомашин гэдэг юмнуудаа жаахан зааглаад. Тэр хүмүүсийн чинь автомашин албан тушаалынх биш шүү дээ. Энэ чинь албан хэрэгцээний автомашин.

Тэрийг нь энэ хуулиараа зөвшөөрөөд өгчих боломж байхгүй юм уу гэж асуух гээд байгаа юм.

Хоёрдугаарт нь, Худалдан авахын хуультай холбоотой.

Энэ заалтаар зөвхөн Засгийг газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны тодорхой чиглэлээр судалгаа, эрдэм

шинжилгээний худалдан авалт хийхэд энэ хууль үйлчлэхгүй гэж байна л даа.

Тэгэхээр энэ дээр тусгай журам гарах юм уу? Эсвэл ерөөсөө ийм чиглэлийн үйл ажиллагааг шууд худалдан авалтаар явна гэж ингэж ойлгох уу? Энэ дээр нэг хариулт авмаар байна.

Тэгээд яах вэ, энэ дээр хөндөгдөөгүй ч гэсэн би Сангийн яамныхнаас одоо энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд орон нутгуудад явж байхад жижиг худалдан авалтууд, тэр дундаа орон нутгийн иргэдийн оролцоон дээр тулгуурласан 20 сая төгрөгийг шууд гэрээгээр орон нутгийн иргэдээр гүйцэтгүүлдэг энэ ажлын төсөвт өртгийг жаахан нэмэгдүүлээд 50, 60 сая төгрөг болгох ийм боломж байгаа юу?

Ингэхгүй бол орон нутагт 30 сая төгрөгийн тендер зарлах гэж зураг төсөв, тусгай зөвшөөрөл гээд. Тэгээд НӨАТ, магадлашгүй ажил, энэ тэрэ гэсээр байгаад яг нөгөө барилга дээр нь наалдаж байгаа нь 10 гаруйхан сая төгрөг. Үүнээс болж орон нутагт энэ Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлууд чанаргүй болж байгаа зүйлүүд их байгаа юм.

Тэгээд энэ дээр шинэчилсэн найруулга дээр бас анхаараач ээ гэж хэлэх гээд байгаа юм.

Дараагийн нэг асуудал. Энэ хууль дээр 5 сарын 31-нээс өмнө худалдан авалт хийгдээгүй бол төсөв нь татагддаг нэг ийм заалт байгаа юм. Үүнтэй холбоотой тендерийн хуулийн дагуу чинь заргалддаг, зарим нэг байгууллагууд нь шүүхэддэгээс болоод орон нутагт иргэд төсөв татагдах зүйлүүд байгаа учраас энэ цаг хугацааг бас нэг эргэж харах ийм

боломж байгаа юу гэдгийг бас асуух гээд байгаа юм би.

Дараагийн асуудал нь, энэ Харилцаа холбооны хууль дээр энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9, 10 гэснийг хасах гэсэн нэг заалт байна л даа.

Тэгэхээр би Цахим хөгжил, харилцаа холбооны яам бол би Дэд бүтцийн яам гэж ойлгодог юм. Энэ агуулгаараа хөдөө орон нутгийн алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох, хиймэл дагуулыг хөөргөх гээд Н.Учрал сайд бас нэлээн зүйлүүд ярьж байна л даа.

Энэ Харилцаа холбооны хуульд өөрчлөлт орсноор яг ямар өөрчлөлтүүд орох гэж байгаа юм бэ. Тусгай зөвшөөрөлгүй болох гэж байгаа юм уу, зөвшөөрөлтэй болох гэж байгаа юм уу гэдгийг би асуух гээд байгаа юм.

Сая Ж.Батжаргал гишүүний асууж байгаа Төрийн албаны хууль байна л даа. Энэ бол нээрээ бас одоо яг хэлж байгаа шиг ойлгомжгүй байгаа юм.

Яг өнөөдрийн байдлаар “үндэсний нийт ажиллах хүчин” гэдэг нь яг Монгол Улсын хэмжээнд яг хэд байгаа юм бэ?

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Ж.Ганбат хариулья. 82 дугаар микрофоныг өгье.

Ж.Ганбат: Г.Ганболд гишүүний асуултад хариулья.

Бид энэ төсөв дагуулдуулан хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн хууль дээр Засгийн газраас тээврийн хэрэгслийн асуудал дээр хүүхдийн байгууллага, мөн багийн дарга нарын тээврийн хэрэгсэл ашиглах эрхийг нь

нээж өгсөн байдлаар энэ зохицуулалтын хүнд тусгаж өгсөн.

Харин сумын Засаг даргын орлогч, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын асуудлыг энэ дээр хөндөж оруулж ирээгүй байгаа.

Дараагийнх нь тэр 5 сарын 31-нээс өмнө худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй бол хэмнэлтэд тооцогдож татагдах асуудлыг энэ мөрдөх заалтыг нь бид хоёр жилээр хойшлуулахаар тусгаж оруулж ирсэн байгаа.

Шалтгаан нь бид Төрийн хэмнэлтийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан.

Энэ заалтыг бид 2025 оны 01 сарын 01 гээд тусгахаар хойшлуулж оруулж ирсэн. Шалтгаан нь **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын үйл ажиллагааны зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд худалдан авах ажиллагаанд оролцогчдын оролцоог нарийн мэргэжил шаардлагатай байгаа баримт бичгийг боловсруулах гээд төслүүдийн бэлтгэлийг хангахтай холбоотойгоор энэ заалтыг хоёр жилээр хойшлуулъя гэдэг ийм байдлаар хуулийн төсөлд тусгаж оруулж ирсэн байгаа.

Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийг үндэслэ, зураг төсвийг хийлгэх, бэлэн байдлыг хангахад зориулсан 40 тэрбум төгрөгийн 25.3 тэрбум төгрөгийг 63.3 хувь нь гэрээ байгуулаагүй байгааг хэмнэлтэд тооцсоноос ирэх онуудад шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд бэлэн байдал хангагдахгүй байх гэдэг ийм нөхцөл байдал үүсээд байгаа учраас бид энэ 2025 оны 01 сарын 01 гэдэг байдлаар энэ 5 сарын 31-ний хугацааг хоёр жилээр

хойшлуулахаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу? Хэн нэмж хариулах юм? Ням-Осорын Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тодотголын үеэр Харилцаа холбооны хуульд бас тодорхой өөрчлөлт оруулахаар орж ирсэн.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бид яг одоогийн байдлаар 330 сум, багуудаас 1226 багт ямар нэг байдлаар интернэтийн үйлчилгээг хүргэсэн.

Цаашдаа хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр яг энэ багуудад энэ интернэтийн үйлчилгээ хүргээч ээ гэдэг хүсэлтүүдийг тавиад ингээд дэд бүтэц байгуулаад явахаар цаашдаа хүн амын төвлөрөл багатай ийм багуудаар интернэтийн үйлчилгээ хүргэхэд хувийн хэвшлийн зүгээс маш хүндрэлтэй болж байгаа.

Яагаад гэхээр мэдээж урсгал зардлаа цаашдаа авч явах, цаашлаад тэр дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыгаа шийдэх. Хэдийгээр өөрсдийнхөө тэр татварын дараах ашгийн 3 хувиасаа төвлөрүүлээд байгаа үүргийн сангаар санхүүжилт хийгээд явж байгаа ч гэсэн эдгээр нь өөрөө тогтвортой үйл ажиллагааг хангахад маш их бэрхшээлтэй болж байна.

Тэгээд бас нөгөө цахим шилжилт эрчимтэй өрнөж байгаа энэ үед интернэтийн хүртээмжийг сайжруулахгүйгээр, харилцаа холбооны салбарынхаа энэ хатуу дэд бүтцийг сайжруулахгүйгээ бүр бид цаашаа энэ

цахимжилтыг эрчимжүүлнэ гэдэг маш их бэрхшээлтэй.

Интернэтийн хүртээмж сайжирсан гэж ярьдаг боловч манайх шиг өргөн уудам газар нутгийн гуравны нэгд л интернэтийн үйлчилгээ хүрсэн. Гуравны нэг.

Тэгэхээр цаашдаа малчдадаа энэ өргөн уудам газар нутагтай улсад энэ алслагдсан багуудаар, сумуудаар интернэтийн хүртээмжийг сайжруулахаас гадна одоо тэр хурдыг нь сайжруулах ажлуудыг хийх зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Тэгээд цаашдаа бид шилэн кабель татаад интернэтийн дэд бүтэц сайжруулна гэдэг бол ер нь боломжгүй болж эхэлж байгаа. Үүргийн сан үүргээ биелүүлсэн.

Компани, аж ахуйн нэгжүүд ч гэсэн боломжтой бүх багуудаараа л интернэтээ хүргэчихсэн.

Одоо цаашлаад шинэ дэд бүтцийг эрэлхийлэхээс өөр гарц байхгүй.

Тийм учраас өнөөдөр энэ нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх хэд хэдэн компаниуд дэлхий дахинд гарчихлаа л даа.

Нам орбитын хиймэл дагуул нөгөө дэлхийн гадаргатай хамгийн ойрхон байрладаг. 550км орчим. Сансрын хиймэл дагуул бараг 36 километрт байрлаж байгаа шүү дээ.

Гэтэл 550-д байрлаж байгаа хиймэл дагуулаас интернэтийн үйлчилгээ авна гэдэг заавал тийм нэг станц байгуулаад дамжихгүйгээр хэрэглэгч тэр хиймэл дагуул руу яг бидний энгийнээр мэддэг төхөөрөмж, нөгөө DDish-ийн

төхөөрөмж шиг ийм төхөөрөмжөө аваад л шууд сансраас интернэт авах бололцоог бүрдүүлэх шинэ технологийг нэвтрүүлсэн шийдлүүд.

Одоо энэ **OneWeb** компани, **STARLINK** гээд олон компаниуд үйлдвэрлээд амжилттай өрнүүлж байна.

Тэдгээрээс мэдээж тэргүүлж байгаа энэ **SpaceX**, **STARLINK** компанийн үйлчилгээг манай улсад нэвтрүүлэх чиглэлээр хэд хэдэн удаа тухайн компани хүсэлт гаргаж байсан юм билээ.

Тэгээд бид энэ удаагийнхаа хуульд сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ авах гэсэн зөвшөөрлийг нэг компани дээр нь олгох буюу зөвхөн сансрын хиймэл дагуулын үйлчилгээ эрхэлж байгаа компаниудад тухайн компанид нь интернэтийн үйлчилгээ хүргэх эрхийг нь, сүлжээ байгуулах эрхийг нь аль алиныг нь өгөх бололцоо хуулиар нээж өгье.

Энэ зөвхөн сансрын хиймэл дагуул дээр гэдэг ийм зорилтыг дэвшүүлээд Засгийн газраас энэ хуулийг өргөн мэдүүлсэн.

Тэгээд **SpaceX**-ийн Элон Маск Ерөнхий сайдтай бас албан уулзалт хийгээд энэ хүсэлтээ илэрхийлсэн.

Тэгэхээр зөвхөн энэ бол тэр **STARLINK**-т олгох гээд байгаа биш нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх аль ч байгууллагад бид зөвшөөрлийг нь өгөх хуулийг л нээж байгаа юм.

Үүний хүрээнд 7 сарын 05-наас 07-ны үед **SpaceX**-ээс төлөөлөгч нар ирнэ. Ингээд зөвшөөрлөө аваад энэ бололцоо бүрэн нээгдэнэ.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя.

Г.Ганболд: Ж.Ганбат дарга аа, би сумдын Засаг даргын орлогч гэж яриагүй л дээ. Аймагт ганцхан аймгийн Засаг даргын орлогчийн унаа. Тэгээд сумдын иргэдийн хурлын дарга.

Би наадхыг чинь хөндөгдсөн заалт гэж ойлгоод байгаа шүү дээ. Яагаад гэхээр зэрэг наад жагсаалт дээр чинь нэг ёсондоо хүүхэд хамгааллын машиныг нэмье гэж байна шүү дээ.

Тэгэхээр чинь наад заалт чинь өөрөө би хөндөгдсөн заалт гэж ойлгоод байх юм.

Тэгэхээр наадах дээр чинь л би нэмж оруулах тухай асуудал яриад байгаа шүү дээ. Тийм.

Энэ асуудлыг яг нэмж оруулаад бид энэ хөндөгдсөн заалт гэж ойлгоод хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явах юм бол Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад явъя л гэсэн бодолтой байна л даа.

Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулах юм уу, Хэрэг эрхлэх нь хариулах юм уу. Түрүүн би нэг асуулт асуусан шүү дээ. Төрийн албаны хууль дээр одоо яг ажиллах хүчний тоо нь яг хэд байгаа юм? Өнөөдрийн байдлаар.

Тэнд өнөөдрийн төрийн албан хаагчдыг харьцуулбал хэдэн хувьтай байгаа учраас 15 хувьд нэм.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Г.Ганболд гишүүний асуулт дээр би бас нэмээд нэг зүйл асуугаад орхиё. Сангийн яамнаас.

Энэ хэмнэлтийн хуулиар хөндөгдөж байгаа заалт байгаа. Орон нутагт албан хэрэгцээнд унаж байгаа автомашины асуудал байгаа. Энэ дээр яах вэ, сумын Засаг дарга, иргэдийн Хурлын асуудал яригдаж байна.

Энэ дээр нэмээд сумдын сургуулиудад автомашин шаардлагатай байдаг. Сумын төвөөсөө 200, 300 километр алслагдсан байна. Тэр бартаатай, хүнд нөхцөлтэй газар өвөл явдаг. Энэ хүмүүс олимпиад гэдэг юм уу, сургалт байна, тэмцээн уралдаан гээд явна. Мөн өвөл сумдад хүүхдүүдээ хүргэж өгдөг. Сургуулийн захиргаанаасаа зохион байгуулж хүргэж өгдөг ажлууд байдаг. Эдгээрт зайлшгүй автомашинууд бас хэрэгтэй байдаг юм. Фургон автомашин.

Эдгээрийг авах гэхээр хэмнэлтийн хуульд хөндөгдөж ороогүй байна гээд хязгаарлалтад ороод байдаг. Энэ асуудал энэ хуулиар шийдэгдэж байгаа юу гэдгийг бас нэмээд асуучихъя.

Ингээд Г.Ганболд гишүүний асуултад хэн хариулах вэ? М.Санжаадорж дарга хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Автомашинтай холбоотой заалт хөндөгдөж орж ирсэн.

Тэгэхдээ Засгийн газрын түвшинд бодлогоор зөвхөн хүүхдийн тусгай автомашин, хүүхдийн хүүхэд тээвэрлэхэд зориулсан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд зориулсан, хүүхэд суухад зориулсан тусгай сандалтай, хэрэгсэлтэй энэ автомашиныг зөвшөөрөх.

Мөн дээрээс нь багийн хэмжээнд төрийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд автомашин зайлшгүй шаардлагатай байна гэж үзсэний хүрээнд энэ хоёр агуулгаар л бодлогоор оруулж ирсэн.

Заалтын хувьд хөндөгдсөн. Байнгын хороон дээр мэдээж хэрэг гишүүний хувиар саналаа гаргаад явахад энэ хөндөгдсөн заалт учраас боломжтой болчхож байгаа юм.

Ерөнхийдөө хүүхэд хамгааллын үйлчилгээ гэдэг дотроо сургуулийн автомашины асуудал бас тусгай оноглогдсон асуудлууд нь ороод явчих боломжтой болов уу гэж би бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ойлголоо. Нэмж хариулъя. 81 дүгээр микрофон уу? 83 дугаар микрофон хариулъя.

Тийм байна. Протокол тэмдэглэгдлээ. М.Санжаадорж даргын үг.

Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

Ч.Дондогмаа: Г.Ганболд гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Төрийн албан хаагчийн тоог хязгаарлахдаа Үндэсний статистикийн хорооны 2022 оны жилийн эцсийн мэдээллээс авсан. Манай улсын ажиллах хүчний нийт тоо нь 1 сая 265 мянга 200 гэж үздэг юм байна.

Энэ ажиллах хүчний тооныхоо 15 хувьтай тэнцэх хэмжээний төрийн албан хаагч ажиллах нь зүйтэй гэсэн олон улсын ийм жишиг тоо байдаг юм байна. Одоо яг 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчийн тоо

ажиллах хүчний тооны 17.8 хувийг эзэлж байсан.

Энэ оны 4 сарын байдлаар 18 хувьд хүрсэн байгаа. Тэгээд энэ тоог 15 хувьд хүргэх арга хэмжээг 2026 он хүртэл үе шаттай хэрэгжүүлье гэсэн зохицуулалт оруулж ирсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Ганболд: Харин тэгэхээр чинь наад заалт чинь өөрөө жоохон ойлгомжгүй юм биш үү.

Одоо ажиллах хүчний тоо харьцуулаад. За больё больё. Хүмүүс орж ирээд.

Л.Мөнхбаатар: Болсон уу?

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Өлзийт сумын сургуулийн 1982 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Энэ сургуулийн энэ төгсөгчдийн ангийн багшаар манай Адьяасүрэн гишүүний ээж Самбуугийн Амгалан мөн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Та бүгдэд ажил, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

А.Адьяасүрэн гишүүний маань ээж Самбуугийн Амгалан гуай 35 жил багшилсан ийм сурган хүмүүжүүлэгч багш хүн байгаа. Ингээд танд бас Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн

өмнөөс аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Төсвийн тодотголыг дэмжиж байгаа. Бас баяртай байгаа.

Өнгөрсөн хугацаанд төрийн албан хаагчидтай уулзахад, ахмадуудтай уулзахад төрийн албаны цалин цагааны асуудал, тэтгэврийн асуудал, тэтгэвэр дотроо зөрүүний асуудал олон жил яригдсан. Энэ хүндрэлтэй зүйлүүд бас ингээд нэг шийдэгдэж байгаад их баяртай байгаа юм.

Ер нь 2020-2022 он бол КОВИД-ын жил. 2022 оны 10 сараас эхлээд энэ болохгүй бүтэхгүй зүйлтэй тэмцсэн Засгийн газрын тэмцлийн үр дүн өнөөдөр 6 сарын дараа гарч, төсөв анх удаа 2, 3 их наядаар давж байгаа.

Тэгээд үүгээрээ өнөөдөр асуудлаа шийдэж байгаа нь туйлын зөв. Сонгуульд зориулж цалин, тэтгэврийг шийдэж байгаа, эсвэл энд тэндхийн өр шир тавьсан байдалтай биш, харин зөв шийдвэр гаргаж явсны үр дүн.

Улсын Их Хурал бас энэ дээр бодлогын зөв дэмжлэгүүдийг үзүүлж ажилласан гэж бодож байгаа гэдгээ хэлье.

Надад гурван асуулт байгаа юм. Бидний өнөөдрийн ярьж байгаа төсвийн тодотголын энэ бололцоог магадгүй Улсын Их Хурлаар баталсан энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль гэж хуулийн хэрэгжилт явснаараа өнөөдөр ийм нөхцөл байдал үүсэж байгаа гэж ойлгож байгаа. Ингэж танилцуулагдаж байгаа.

Биржийн хууль дээр хоёр асуулт байгаа юм. Өнөөдөр нүүрсний тээврийн асуудлыг гацсан гацаагүй гээд л сошиалаар янз янзын л зүйлүүд яригдаад байгаа. Үнэхээр Монгол Улсаас экспортолж байгаа нүүрсний урсгал өнөөдөр яг ямар байдалтай байгаа юм бэ гэж. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 7 сарын 01-нээс энэ хууль бүрэн утгаараа хэрэгжиж эхэлнэ. Хууль хэрэгжээд эхлэхээр ганц нүүрс биш Монгол Улсаас гарч байгаа бусад уул уурхайн бүтээгдэхүүн, баялгийг биржээр худалдаалах асуудлууд бас давхар яригдаж байгаа.

Тэгэхээр үүний бэлтгэл ажил ер нь ямархуу түвшинд хангагдаж байгаа вэ? Биржийн хууль амьдрал дээрээ ер нь хэр нийцэж байгаа вэ гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрт. Цалин, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой энэ удаагийн нэмэгдэл цалингийн зөрүү, тэтгэврийн зөрүүг арилгасан маш том суурь шинэчлэл хийгдэж байгаа.

Мөн удахгүй цалинг 2023 ондоо дахин нэмнэ. Нэмэхдээ бүгдийг жигд нэмнэ гэсэн ийм зүйлүүд бас яригдсан.

Тэгэхээр дараагийн цалингийн нэмэгдлийн асуудал дээр ер нь энэ 2023 ондоо төлөвлөж байгаа зүйл байгаа юу. Энэ удаагийн төсвийн тодотголд тэр нэмэгдлүүд бас орж ирж байгаа юу гэсэн нэг ийм зүйлийг асууя гэж бодож байна.

Гурав дахь асуулт. Төсвийн тодотголыг дагаж орж ирж байгаа 7 хууль. Тэр дундаа хэмнэлтийн хууль байгаа. Хэмнэлтийн хуулийг агуулгын хувьд дэмжиж байгаа. 1 их наяд төгрөгийн хэмнэлтийг Монгол Улсын төсөвт үзүүлж байна гэдэг өөрөө асар их тоо.

Хэмнэлтийн хууль дээр зарим нэг зүйл, заалтуудыг улс орны эдийн засаг нааштай болж байгаа дээр жоохон сулруулах ийм зохицуулалтуудыг хийе гэсэн ийм зүйлүүд яригдаж байгаа.

Энэ дотор хоёр, гурван зүйл байгаа.

Жишээ нь, хэмнэлтийн хуулийн 6.5 дээр зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гээд заахаар аймгийн эрүүл мэндийн газруудын үйл ажиллагаа бас болохгүй байна гээд Ж.Чинбүрэн гишүүн нэлээн сайн ярьдаг. Орон нутагт ажиллаж байхад ч гэсэн энэ асуудлууд бас яригдаад байдаг.

Төрийн албан хаагчдын гол бас нэг ярьж байгаа зүйл бол энэ төрийн албыг, төрийн үйлчилгээг ард, иргэдэд хүргэх тэр хяналт тавих тэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд энэ унаа машин, шатахууны зардал, томилолтын асуудлууд маш ихээр танагдчихсан.

Тэгэхээр цаашид явахад хэцүү болоод байна гэж байгаа юм. Гэтэл хэмнэлтийн хууль дээр өргөн барьчихсан энэ зүйл дээр саяын миний хэлдэг томилолттой холбоотой 15.1.5 гэсэн заалт хөндөгдөөгүй гэдэг агуулгаараа бас явахгүй. Энэ удаагийн төсвийн тодотгол.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Ажлын хэсэг хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Биржийн хууль батлагдсан байгаа. Тодотголтой холбоотойгоор хамт өргөн бариагүй.

Гэхдээ ер нь Биржийн хуультай холбоотойгоор урьдчилсан байдлаар хэрэгжүүлэхийн өмнө 8 журам батлагдах ёстой байгаа. Үүнээс 6 журмын төслийг нь ер нь яамдаас санал аваад явж байгаа. Ингээд Засгийг газраараа батлагдах ийм асуудлууд байгаа.

Мөн Хөрөнгийн бирж маань өөрөө бас бэлтгэлээ хангахын тулд батлуулах ёстой дүрэм, журмууд байгаа. Үүнийгээ батлуулаад явж байгаа.

Тэгэхээр 7 сарын 01-нд хууль маань хэрэгжээд явахад энэ зүйлүүд ингээд нэлээн бэлтгэл хангагдаж байгаа гэсэн үг.

Мөн Засгийн газраас биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр, төрлийг Уул уурхайн биржийн тухай хуулийн 5.4-д заасны дагуу мөн тогтоосон байгаа. Эхний ээлжинд хайлуур жонш, төмөр, нүүрс гэсэн бүтээгдэхүүнүүдийг биржээр зарагдах асуудлууд тавигдсан. Ярьж байгаа.

Одоо Биржийн хууль яг бүрэн хүчин төгөлдөр 7 сарын 01-нээс мөрдөхөөс өмнө ч гэсэн биржээр нүүрсээ арилжаалаад эхэлсэн байгаа. Засгийн газрын хувьд.

Өнөөдөр 6 сарын 15-ны байдлаар 25 сая тонн нүүрс гарчхаад байгаа. Биржээр худалдаалагдаад явах, түүхий эдээ зах зээлийн үнээр борлуулах боломж маш сайн мөрдөж байна гэдэг нь харагдаад байгаа тийм асуудал байна.

Хоёрдугаар асуудлын хувьд, эрүүл мэндийн автомашины асуудлыг Засгийн газраас яг хэмнэлтийн хууль дээр

эмнэлгийн гэдэг асуудлаар одоогийн хууль дээр байгааг бид хөндөхөөр оруулж ирээгүй.

Тэгэхдээ заалт нь өөрөө хөндөгдсөн заалт байгаа учраас энэ асуудал дээр гишүүд Их Хурлын бүрэн эрхийнхээ хүрээндээ Байнгын хороон дээр энэ хэлэлцэгдээд явах ийм асуудал байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одоо Б.Саранчимэг гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана.

Нийтдээ 9 санал хураалт байгаа. Гишүүд танхимд байраа эзэлье. Одоо Батсүхийн Саранчимэг гишүүн асуултаа асууя.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулаад дагалдах хуульд Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар орж ирж байна.

Тэгэхээр технологийн хөгжил нийгмийн хэрэгцээ, цаг үеэ дагаад зайлшгүй өөрчлөлт хийгдэх ёстой хууль гэж үзэж байгаа юм.

Тэгээд Монгол шиг ийм том газар нутагтай, нягтарш сийрэг, цөөн хүн амтай улс оронд иргэдийг харилцаа холбоогоор тогтвортой хангах, ялангуяа гамшиг эрсдэлийн үед найдвартай хангах нь төрийн хэрэг.

Ер нь одоогийн нөхцөл байдалд олон суурин, олон сумууд ингээд ямар ч сүлжээгүй, интернэтгүй байгаа.

Тэгэхээр хамгийн сүүлд гэхэд би Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт

бригадад гэхэд хөөцөлдөж байж сүлжээтэй болгосон байх жишээтэй.

Тэгэхээр нэг хүн араас нь явах биш, төр бодлогоороо байхгүй байгаа, сүлжээгүй байгаа сумуудыг сүлжээтэй болгох, интернэттэй болгох тал дээр Харилцаа холбоо, цахим хөгжлийн яам ямар бодлого барьж байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар нам орбитын хиймэл дагуул, үйлчилгээг дэмжих хэрэгтэй байгаа. Энэ дээр ямар бодлого барьж байна вэ?

Сүүлийн үеийн өндөр технологийн хэрэглээг нутагшуулах, одоо энэ **Starlink, Oneweb, Telstra** гээд л. Цаашлаад үндэсний харилцаа холбооны хиймэл дагуулыг үйлдвэрлэж, хөөргөх бодлогыг яаж хэрэгжүүлэхээр явж байгаа вэ гэсэн нэг ийм асуулт.

Дараагийн асуулт. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зардлаар алслагдсан сумдын ард иргэдийг холбоожуулах зорилготой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Тэгэхээр энэ сангийн үйл ажиллагаа, зориулалт хэвээрээ байгаа юу? Энэ 100-аас 200 хүнтэй багийн иргэдийг холбоожуулахад багагүй зардал гарч цаашдаа алдагдалтай ажиллахаар харагдаад байгаа.

Тэгэхээр үүнийг ер нь цаашдаа яая гэсэн бодлоготой байгаа вэ? Тэгээд малчдад энэ интернэтийг хүргэх, мэдээлэл хүргэх хамгийн чухал байгаа алслагдсан аймаг, сумдад холбоо муутай байгаа газруудыг ямар бодлогоор барьж, цаашдаа ямар үйл ажиллагаандаа хэрэгжүүлбэ гэж бодож байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна. Н.Учрал сайдаас асууя.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Та хоёр чинь асуулт хариултаа түрүүн ярьчихсан биз дээ. Дараа нь тодруулчих.

Н.Учрал: Төсөв дагалдуулаад түрүүн би тайлбарласан.

Харилцаа холбооны хуульд өөрчлөлт орж байгаа. Бид Зөвшөөрлийн хуулийг батлан гаргасан. Зөвшөөрлийн хууль дээр тодорхой ямар зөвшөөрлүүд байх вэ гээд. Одоо жишээ нь бараг 360 зөвшөөрөл болоод зөвшөөрлийн тоо багассан.

Тэгэхээр нэгэнт Зөвшөөрлийн хуулиар салбар болгоны асуудлуудыг зохицуулж байгаа учраас салбарын сайдууд дахиад нэг бодлого, чиглэл гаргаж ирээд байх шаардлагагүй учраас миний хувьд сайдаар томилогдоод тэр бодлогын чиглэлийг цуцлаад, Зөвшөөрлийнхөө хуулийн дагуу ямар ч гаднын компани өөрсдөө хүсэлтээ гаргаад Харилцаа, холбооны зохицуулах хороонд хүсэлтээ гаргаад үйл ажиллагаа явуулах нь нээлттэй гэдэг байр сууриа тодорхой илэрхийлсэн.

Энэ ч утгаараа гаднын нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагууд Монголд компаниа байгуулаад өөрсдөө зөвшөөрөл авах хүсэлтээ Харилцаа, холбооны зохицуулах хороонд гаргаад ирсэн.

Гэсэн хэдий ч тухайн байгууллагууд нэгэнт Монголд тийм бие даасан станц байгуулаад интернэтийн үйлчилгээ эрхлэх болоод сүлжээ байгуулах тусгай зөвшөөрлөө нэг компани дээр аваад үйл ажиллагаа явуулъя гэж хүсдэг ч заавал хуулиараа

буюу Харилцаа холбооны хуулиар заавал хоёр компани байгуулж энэ хүсэлтээ гаргах ёстой гэдэг ийм шалгуур тавьчихаад байдаг байсан.

Тэгээд сая Ерөнхий сайд Элон Масктай уулзсан уулзалтынхаа үеэр бид нэгэнт Монголд Та бүхнээс станц байгуулахыг шаардахгүй учраас үүнийг нь нээж өгье.

Үүний хүрээнд манайх шиг өргөн уудам газар нутагтай улс оронд малчдад интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахад нь улс орон болгон өөр өөрийн бодлогын дэмжлэг үзүүлдэгтэй адилхан бид ч гэсэн ийм бодлогын дэмжлэг үзүүлье гэдгээ илэрхийлсэн.

Үүнтэй холбогдуулаад Засгийг газар дээр ярилцсаны дагуу хуульд өөрчлөлт оруулж байгаа.

Ингээд Зөвшөөрлийн хуулийн 9.10 дахь заалтыг хассанаараа тэр **Starlink** байна уу, тэр **OneWeb** байна уу, аль ч компани Монголд сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх, зөвшөөрлөө зохицуулах хороонд хүссэнээрээ нэг компанийн нэр дээр Монголд үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.

Үүний хүрээнд яг бидний мэддэгээр тэр DDish-ийн антенн шиг нэг ийм төхөөрөмжөө аваад л интернэтийг хаана ч хэрэглэх бололцоо нэмэгдвэл түүнийг дагаад харилцаа холбоо, олон суваг дамжуулах үйлчилгээ мэдээж дагаад орж ирнэ.

Тэгээд энэ утгаараа ялангуяа аялал жуулчлалын салбар, уул уурхайн салбар, хөдөө аж ахуйн салбар, алслагдсан боомтуудаар, багуудаар, гамшгийн үе дэх онцгой байдлын үед дуут дохиолол гээд

маш олон чиглэлээр энэ хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэх үйлчилгээ орж ирснээрээ маш том давуу талууд үүснэ бид харж байгаа.

Тэгэхээр шинэ дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хуулийн дагасан өөрчлөлт оруулж ирж байна.

Ингээд 7 дугаар сард тус компаниуд Монголд орж ирэх үүд хаалга нь нээгдээд эхнээсээ зөвшөөрлөө хүсээд эхэлж байгаа.

Мэдээж дотоодын зах зээлээ хамгаалах бодлогыг бид бас барьж байгаа учраас дотооддоо үйлчилгээ явуулж байгаа компаниудыгаа бас бодлогоор дэмжих, тэр арилжааны шинж чанартай үйлчилгээ явуулахыг нь нээж өгч байгаа.

Зүгээр сансрын хиймэл дагуул дээр л зөвхөн энэ 9.10 дахь заалтыг Харилцаа холбооны хуулиас хасаж, тэр нам орбитын хиймэл дагуул үйлчилгээ эрхэлж байгаа компаниудыг дэмжье гэсэн бодлогоор Төсвийн хуулийг дагалдуулаад энэ хуулийн өөрчлөлт орж ирж байна.

Г.Занданшатар: Одоо санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглая. Б.Саранчимэг гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр төсвийн тодотголоор хүүхдийн мөнгийг 100 хувь олгохоор шийдэж байгаа. Тэгээд нөхөн олгож байгаа. Аваагүй байсан хүүхдүүдэд

Тэгэхээр ер нь Хүүхдийн санд зарим мөнгийг хүсэлтийнх нь дагуу төвлөрүүлье гээд салбарын сайд ярьж байсан.

Тэгэхээр “Хүүхдийн төлөө сан” ер нь ямархуу байдалтай байгаа вэ? Цаашдаа “Хүүхдийн төлөө сан”-г яаж хөгжүүлэе гэж бодож байгаа вэ?

Монгол Улсын Ерөнхий сайд хүүхдийн хамгаалал дээр маш их манлайлж ажиллаж байгаа.

Тэгээд хүүхдийн хамгааллын талаар илүү ямар шинэ бодлого барьж байгаа вэ гэсэн асуултыг асууя.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулна.

Х.Булгантуяа: Хүүхдийн төлөө сангийн мэдээлэл “shilen.gov.mn” дээр ил тод болсон.

Энэ дээр 11 орчим тэрбум төгрөг төвлөрсөн. Сангийн мөнгийг бараг огт зарцуулалт хийгээгүй. 1 тэрбум орчим төгрөгөөр зарим олон улсын тив, дэлхийн соёл, урлаг, спортын тэмцээнд хүүхдийг шагнах гэх мэтчилэн 1 тэрбум орчим төгрөг хүрэхгүй санхүүжилтийн шийдвэрийг нь гаргаж санхүүжилт нь хийгдсэн. Бусад 10 гаруй тэрбум төгрөг нь энэ сан дээр байгаа.

Сангаас хүүхдийн төлөө томоохон бүтээн байгуулалт, томоохон зөв хөрөнгө оруулалтыг хийх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Үүнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан хүүхдийн төрийн бус байгууллагуудад орсон. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр шийдвэр гаргаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Энд бас нэлээдгүй хандив хүмүүс өгсөн. Та бүхэн энэ сайт руу ороод харах юм бол “Хүүхдийн төлөө фонд”-оос манай урлагийнхан тоглолт хийгээд

иргэд, олон нийт хандив өгөөд бараг 2.1 тэрбум төгрөгийн хандив орж ирсэн.

Ингээд бусад авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын дугаараас гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулъя.

Х.Булгантуяа: Тэгээд иргэд, олон нийтээс фондын сангийн мөнгийг бусад сан шигээ зарцуулчихсан юм биш үү гэж санаа зовоод асуултууд нэлээдгүй ирж байгаа. Та бүхэн энэ сайт руу орж хараарай.

Тэгээд энд хандив өгсөн бүх хүмүүстээ баярлалаа гэж хүүхдүүдийнхээ өмнөөс хэлмээр байна.

Улаанбаатар хотын хүүхдийн төрийн бус байгууллагуудаас гэхэд 1.6 тэрбум төгрөг, Туушин боловсролын сангаас гэхэд 10 сая төгрөг гээд хандивуудыг нэлээдгүй өгсөн.

Энэ нь иргэдээс, дээрээс нь нэмээд салбарынхнаас өгч байгаа. Улаанбаатар гэр бүл хүүхдийн байгууллагаас 1.5 сая төгрөг гэх мэтчилэн хандивууд өгсний үр дүнд өнөөдөр 11 тэрбум төгрөг энэ сан дээр бүрдсэн юм.

Мөн төсвийн тодотголыг дагуулаад хүүхэд хамгааллын байгууллагын унааг хэмнэлтийн хуулиар хасчихсан байсныг бас нэмж тавьж байгаа. Хүүхэд хамгааллын кэйс дээр очоод ажиллах гэхээр унаа тэрэггүй болчихоод байсан.

Мөн эмэгтэй гишүүдээс санал гаргаад, Ерөнхий сайд бас дэмжээд 2024 онд хүүхэд хамгааллын төсвийг хоёр дахин нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байгаа.

Үүнийг 2024 оны төсвийн санал дээр оруулаад тусгаад явж байгаа.

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Д.Тогтохсүрэн дарга хурал үймүүлэхээ больё. С.Чинзориг сайд суудалдаа суу. Б.Пүрэвдорж гишүүн суудалдаа суу. Санал хураалт явуулъя.

Ингээд санал хураалт явууллаа. Гишүүд асуулт асууж хариулт авч дууссан. Одоо ингээд Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын төсвийн тухай хуулийг дагалдуулж өргөн барьсан Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

55 гишүүн санал хураалтад оролцож, 36 гишүүн дэмжиж, 65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

65.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. /алх цохив/

69.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. /алх цохив/

Б.Бейсен гишүүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжихгүй байна уу? Тэгвэл кнопоо ажиллуул.

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явууль. /алх цохив/

39 гишүүн дэмжиж, 70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ 6 дугаар хууль дээр олон гишүүд санал гаргасан учраас Ц.Сандаг-Очир гишүүн ч гэсэн санал хэлсэн.

Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгөөд Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч.

Хураагаад. Тэгээд дотроо тэр хүрээ хязгаарыг нь тогтоож бас хэтэрхий ингээд задгайлаад тавьчихгүй. Шинжлэх ухаан, технологийн ололт, инновацыг дэмжихэд чиглүүлж, нарийсгаж тодотгож ингээд анхны хэлэлцүүлгийг хий гэсэн ийм зарчим, горимын саналууд яригдсан гэдгийг анхааруулаад санал хураалт явууль.

Байнгын хорооны хэлэлцэх боломжгүй гэсэн санал дэмжигдсэнгүй.

Ингэснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр боллоо.

Тэгэхдээ Ц.Сандаг-Очир нарын Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргаж байгаа саналыг харгалзан үзэх нь зүйтэй. Яагаад гэвэл бас ингээд салбар.

Ер нь цаашдаа Засгийн газар нэг юм анхаармаар байгаа юм.

Төсвийн хууль илүү процессын хууль. Түрүүн Ж.Батжаргал гишүүн ч хэлээд байна лээ.

Үүнийг дагалдуулаад органик том хуулиуд дээр өөрчлөлт оруулаад, үзэл баримтлалыг нь, Төрийн албаны тухай хууль ч байдаг юм уу нэг жилийн төсвийн процессын тухай хуулийг дагалдуулж энэ органик том өөрчлөлт хийгээд байдаг бол энэ хууль зүйн техникийн хувьд ч гэсэн тэр, тогтолцооны хувьд ч гэсэн бас их.

Тэгээд л нөгөө нэг том НӨАТ-ын системээ алдагдуулах гээд л, эсвэл төрийн албаны тогтолцоогоо алдагдуулах гээд л, эсвэл худалдан авах ажиллагаагаа өөрчлөөд байдаг бол бас энэ хууль зүйн тогтворгүй байдлыг бий болгодог

эрсдэлтэй гэдгийг анхаарах нь зүйтэй шүү.

7.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

67.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Дараагийн асуудал.

Дөрөв. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

“Агаарын хөлгийн хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн батална.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.

Гишүүд байж байгаарай. Энэ шууд санал хураалттай нийт гишүүдийн олонхоор 39 гишүүнээр батална.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс нь Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцод 1971 онд нэгдэн орсон.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн хууль бус үйлдлүүд дэлхий даяар нэмэгдэж байгаатай холбогдуулан “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцын нэмэлт протоколыг баталж орхигдуулсан зарим шаардлагатай зохицуулалтуудыг нэмж тусгасан.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол” нь 2018 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд одоогоор нийт 35 улс гарын үсэг зурж, 21 улс соёрхон баталж, 21 улс нэгдэн ороод байна.

Энэхүү протоколд ашиглалтад байгаа агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хяналт тогтоох үйлдэл, оролдлого, оролцооны хэлбэр, хүлээлгэх хариуцлага, гэмт үйлдлийн хамрах хүрээ, харьяалал, ялын байдал, төрийн байгууллагаас авах арга хэмжээ, улс орнуудын хамтын ажиллагааны зохион байгуулалт зэргийг илүү нарийвчлан тодорхойлсон.

Монгол Улс нь Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын оролцогч улсын хувьд агаарын тээврийн салбарын хурдацтай өсөлттэй уялдуулан иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор энэхүү протоколыг соёрхон батлах шаардлага үүсээд байна.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй.

Харин хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт өөрчлөлт оруулах шаардлагатай.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Төсвийн байнгын хороо хуралдана. Төсвийн хэлэлцүүлэг явуулна. Ганзоригийн Тэмүүлэн дарга.

“Жанжин Д.Сүхбаатар” танхимд Төсвийн байнгын хорооны гишүүд хуралдана шүү.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус Байнгын хороонд Хууль зүйн байнгын хорооноос “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76.4-д заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтээ ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Баян-Өлгий аймгийн нисэх буудлын аэродромын өргөтгөлийн ажлын санхүүжилт шийдвэрлэгдсэн хэдий ч яагаад барилгын ажлыг эхлэхгүй байгаа

талаар ажлын хэсгээс асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаас “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.14.3-д заасныг үндэслэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх, хэлэлцүүлэхийг шийдвэрлэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар Монголын Эмэгтэйчүүдийн холбооны Баянзүрх дэх салбар зөвлөлийн гишүүд

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт эхчүүд, эмэгтэйчүүд Та бүхэндээ хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Эмэгтэйчүүд маань их идэвхтэй байж, бие биеийгээ дэмжиж, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэцгээгээрэй.

Ингээд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Чимэддоржийн Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Пүрэвжавын Ганболд Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлээ.

Дараагийн асуудалд оръё.

Тав. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улсын хувьд тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудит, хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр, сургалтад хамрагдах, хурал чуулганд оролцох зэргээр олон улсын иргэний нисэхийн үйл хэрэгт оролцож байна.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн аюул занал, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, илүү үр дүнтэй арга хэмжээ авахад чиглэсэн эрх зүйн хэв хэмжээг бэхжүүлэх зорилгоор “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-ыг баталсан.

Тус конвенц нь 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд одоогоор 34 улс гарын үсэг зурж, 23 улс

соёрхон баталж, 19 улс нэгдэн ороод байна.

Энэхүү конвенц олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд дурдаагүй орхигдуулсан зохицуулалтууд, түүнчлэн гэмт хэрэгт тооцох үйлдэл, ялын байдал, гэмт хэргийн оролцогчид, хэргийн харьяалал, гэмт этгээдийг шилжүүлэх, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан тусгасан бөгөөд Монгол Улсын 1972 оны нэгдэн орсон “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” Монералийн конвенц, түүний нэмэлт протоколуудаас давуу хүчин чадалтай юм.

Агаарын тээврийг либералчилж, нислэгийн тоо, нислэгийн чиглэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа энэ үед манай улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт түвшинг олон улсын шинэчилсэн найруулсаар байгаа стандарт шаардлагад нийцүүлэх, энэ төрлийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцыг соёрхон баталснаар иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин, эрх зүйн тогтолцоог сайжруулахад дэмжлэг болох бөгөөд улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй.

Энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт тооцох үйлдлүүдийг тодорхой заасан бол 3 дугаар зүйл, 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хүнд ял оногдуулахаар тусгасан.

Иймд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа болно.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Батгөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Батгөмөр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тус Байнгын хороо Хууль зүйн байнгын хорооноос “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй

тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76.4-т заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн талаарх санал, дүгнэлт ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.14.3-д заасныг үндэслэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр эрхлэх асуудалд нь хамрах Байнгын хороонд шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийн тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн албан хаагчид болон Баянцагаан сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт ахмадууд болон Шүүхийн шинжилгээний албаны ажилтан Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд, “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд тус тус шилжүүлээ.

Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Завсарлага. 14.00 цагт.

Одоо Төсвийн байнгын хорооны хуралд гишүүд ороорой. Хурал давхцаж болохгүй. 14.00 цагаас.

З А В С А Р Л А Г А

Г.Занданшатар: Төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, төсвийн хэлэлцүүлгүүд Төсвийн байнгын хороо дуусаагүй байгаа учраас түр хойшлууллаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 15-ны өдрийн үдээс хойших чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хууль, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай энэ хуулиуд Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа учраас түр хойшлууллаа.

Одоо ингээд сонгуулийн тухай хуулийн асуудал хэлэлцэнэ.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд

/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд даргад үг өгнө.

Ингээд сая Улсын Их Хурал дахь Эмэгтэйчүүдийн лобби бүлгийн саналыг Улсын Их Хурлын гишүүд, Төрийн байгуулалтын байнгын хороо, намын бүлгүүдийн дарга нартай зөвшилцөөд Улсын Их Хурлын тухай хуулийн 3.4-д заасан Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ гэсэн Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцүүлэн Улсын Их Хурал дахь Эмэгтэйчүүдийн бүлэг, Эмэгтэйчүүдийг дэмжих лобби бүлгийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороонд холбогдох санал дэвшүүлэхээр намын бүлгийн дарга нартай Эмэгтэйчүүдийн бүлгийн дарга, гишүүдтэй хэлэлцэн тохирсон болно.

Энэ талаар манай Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Нямаагийн Энхболд дарга. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд.

Н.Энхболд: Баярлалаа. Дарга аа.

Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад энэ Сонгуулийн хуулийн дагалдаж орж ирсэн хуулиудын эцсийн хэлэлцүүлгийг хийсэн. Ийшээ шийдвэрээ гаргачихсан байгаа.

Тэгэхдээ сая Их Хурлын дарга хэлсэн. Ер нь бас цөөнхөө дахиад нэг сонсох шаардлага байна. Тал талаас нь ярья. Бусад олон хүчин зүйлүүдтэйгээ уялдуулж бас дахиад нэг ярья гэсэн ийм бодолтой байна. Ойлголцолд хүрч байгаа гэж бодож байна.

Тэгээд хэдийгээр эцсийн хэлэлцүүлэг хийчихсэн байгаа ч ер нь бол эцсийн хэлэлцүүлэг хийчихсэн асуудлыг дахиад өөр дэгээр хэлэлцэхэд амаргүй байдаг.

Тэгэхдээ чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйл гэж байгаа.

Тэр 5 дугаар зүйл дээр хуралдааны дэгээр зохицуулаагүй аливаа асуудлыг хэрэв хэлэлцэнэ гэвэл, тэгвэл тухайн асуудлыг хэлэлцэх энэ дэгийг нь тэгээд хуулиар зохицуулах боломж байхгүй байгаа бол Төрийн байгуулалтын байнгын хороо санаачлаад ийм дэгээр

хэлэлцье гэсэн саналыг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж болно.

Нэгдсэн хуралдаан олонхын саналаар тэр дэгийг нь дэмжвэл тэр дэгийн дагуу одоо асуудлыг эцсийн хэлэлцүүлгээ гүйцээж хийгээд оруулж ирэх ийм боломж байгаа.

Тэгэхдээ ийм дэгийг зөвхөн яг тухайн ярьж байгаа асуудлыг л ярьж шийдвэрлэхэд хэрэглэж байх тухай ийм дэгийн заалт байна. Өөр одоо үүнийг цааш нь халиулаад юм болгон дээр нийтлэг хэрэглээд байх боломж байхгүй.

Тэгэхээр биднийг эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа энэ үйл явцаа үргэлжлүүлээд дэгийн тухай санал оруулаад ирэх боломжийг хангаж өгнө үү гэж Их Хурлын даргаас хүсэж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо дахиж хуралдана.

Энэ бол мэдээж Монгол Улсын “Алсын Хараа-2050” хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой Хөгжлийн Зорилт”-уудын 5 дахь зорилт болох 2030 онд бид Тогтвортой хөгжлийн зорилт Жендэрийн тэгш байдлыг хангах зорилт дэвшүүлсэн.

Энэ хүрээндээ Сонгуулийн хууль дахь саналыг бас харгалзан үзээд ирж яваа цагийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн 2028 оноо бид угтан харах тийм шийдэл гарах ёстой.

Охид, бүсгүйчүүдээ дэмжих, ирээдүйн чиг хандлагыг ч гэсэн тодорхойлох ёстой.

Үүнтэй нийцүүлэн намын бүлгүүдийн удирдлагууд, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга санал гаргаад, эмэгтэйчүүдийн бүлэгтэй хэлэлцээд бас тодорхой саналыг дахин хэлэлцэх шаардлага үүссэн учраас.

Тэгээд энэ асуудал нь дэгээр зохицуулаагүй учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар явуулах 5.1-ийн хуулийн дагуу шийдвэрлэлээ. /алх цохив/

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо одоо хуралдана.

Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа учраас.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо одоо хуралдаж, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд “Их эзэн Чингис хаан” танхимд уу?

“Эзэн Чингис хаан” танхимд Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдчихъя.

Угаасаа Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа учраас ирц хүрэхгүй. Ингээд саналууд бас унах магадлалтай байна. Олон гишүүд байхгүй.

Төсвийн байнгын хороо бас олон санал хураалттай байна. 4 цаг хүртэл үргэлжилнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Гочоогийн Ганболд гишүүн, Г.Мөнхцэцэг гишүүн, Д.Сарангэрэл гишүүн, Ж.Сүхбаатар гишүүн. Шууд Төрийн байгуулалтын байнгын хороо руу орчих.

Чуулган түр завсарлалаа. /алх цохив/

З А В С А Р Л А Г А

Зургаа.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль,

Улсын Их Хурлын тогтоолын төслүүд

*/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ **(үргэлжлэл)***

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүд чуулганы хуралдаанаа үргэлжлүүлбэ. Сая Төсвийн байнгын хороо хуралдаж тарсан. Саналын томъёолол боловсруулагдаж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо бас хуралдсан.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулаагүй асуудлуудыг хэрхэн зохицуулах талаар гарсан санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 6 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийн тухай асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийн 10 дахь

зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 53.4 дэх заалтыг Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дахин хэлэлцүүлж томъёолох шаардлага үүссэн бөгөөд тус асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцсэнийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийн тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Уншчих.

Н.Энхболд: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэг.

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 10 дахь зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 53.4 дэх саналыг Байнгын

хорооны эцсийн хэлэлцүүлгээр дахин хэлэлцүүлнэ.

2. Уг асуудлыг хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг баримтална гэсэн ийм дэгийг танилцуулж байна.

Хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Та бүхэнд дэмжвэл Байнгын хороо хуралдаад саяын асуудлуудаа дахиж үргэлжлүүлж хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах учиртай юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүнд баярлалаа.

Одоо Нямаагийн Энхболд гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулаад, тэгээд энэ дэгээр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана.

Тэгээд дараа нь төсвийн асуудлаа хэлэлцэнэ.

Өнөөдөр олон асуудалтай байгаа. 14 асуудалтай байгаа. Одоо 6 дугаар асуудал.

Цаг сунгаж хуралдана гэдгийг анхааруулья.

14 асуудлаас 6. Асуулт, хариулт явчихсан юм. Та байхгүй байсан юм.

Санал хураалт явуулья. Асуулт, хариулт нь дуусчихсан. Санал хураалт.

Үүнийг чинь дараа нь яг санал хураалт нь явна. Одоо зүгээр дэгээ л зохиож, ахиж хуралдах л. Төрийн байгуулалтын байнгын хороо энэ дэгээрээ ахиж хуралдах санал. Тийм. Харин тийм зохицуулаагүй асуудлыг дэгээр өөрөө санал гаргаад, түүнийг санал хураагаад шийднэ гэсэн ийм дэгтэй. Болно. Дэг дээрээ байгаа юм.

Санал хураалт явуулья. Гишүүд анхааралтай байгаарай. /алх цохив/

Энэ санал хураалтыг дэмжээрэй. О.Цогтгэрэл гишүүн ээ. Дэмжээрэй дэмжээрэй. Дэгийг нь баталж байна. Байнгын хорооны гаргасан саналыг.

56.6 хувийн саналаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналыг дэмжлээ.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж болно.

Одоо дараагийн асуудалдаа орно.

Долоо. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь

танилцуулна. Ж.Батсуурь гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 7 хууль, Монгол Улсын Их Хурлын 2 тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар дээрх хууль Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжсэн тул хуралдаан даргалагчаас уг асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу дахин боловсруулж санал

хураалгахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жамбын Батсуурь гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Сархадын Зулпхар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батаагийн Батцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Бодлого, төлөвлөлтийн

газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимидсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баасансүрэнгийн Алимаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Нарантуяагийн Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сандагийн Тунгалагтамир, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Басангийн Батжаргал, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Буянбадрахын Жавзанжаргал нар нэгдсэн хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр төсвийн талаар хэд хэдэн асуулт асуух гэсэн юм. Ялангуяа 2022 оны 4 сарын 15-нд батлагдсан Их Хурлын тогтоол байгаа. Энэ талаар асууя.

Сая иргэдтэйгээ уулзахад зурагтаар улс төрчид эдийн засаг өсөж байна, нүүрс их гарч байна, доллар их орж ирж байна гээд сайхан зүйл их ярих юм гэж байна. Манай иргэд.

Гэхдээ ард иргэдийн хөргөгч хоосон байна, гэдэс хоосон байна, өр зээлдээ баригдаж байна гэж ярьж байгаа юм.

Тэгэхээр би Засгийн газраас мах, гурилын үнийг тогтворжуулна гэсэн хууль гараад хөнгөлөлттэй дэмжлэг, зээл үзүүлээд байхад яагаад ингэж их үнэ өсөөд байгаа юм бэ гэдгийг асуух гэсэн юм.

Тэгээд энэ хэр үр дүнтэй болсон юм бэ? Үүргээ хэрхэн гүйцэтгэсэн талаар аудитын дүгнэлт гарсан уу?

Үнийн өсөлтийг хязгаарлахад нийт хэдий хэмжээний зээл, дэмжлэг үзүүлсэн бэ? Түүхий нефтийн үнэ 40 гаруй хувиар буураад байхад шатахууны үнэ яагаад нэг ч төгрөг буухгүй байна гээд иргэд асуусан. Үүнийг бас би асуучихъя.

Тэгээд 2022 оны 4 сарын 15-нд батлагдсан хуулийн хэрэгжилтийн тайлан гарсан уу?

Хоёрдугаар чухал асуудал би энэ Үндэсний статистикийн хорооны мэдээллийг авсан юм.

Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт ерөөсөө маш хурдацтай буурч байна.

2000 мянган онд 60.9 байсан бол одоо 2022 онд 48 хувь руу ингээд буучихсан.

Тэгэхээр би сая мэдээлэл авч үзлээ л дээ. Тэгэхээр эмэгтэйчүүдийг бид нар заавал яагаад дэмжих ёстой юм бэ гээд л гадуур яриад байх юм. Гэтэл эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 618-хан сая төгрөг төсөвлөсөн байгаа юм.

Тэгэхээр чинь яаж энэ эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт чинь нэмэгдэх юм бэ.

Хоёрт, эмэгтэй бизнест олгосон ЖДҮ-гийн зээл гэсэн чинь 9.7 тэрбум төгрөг. Энэ чинь одоо арай бас доромжилж байгаа шүү. 9.7 тэрбум төгрөг чинь нэг авлигачийн гэрээслэл гарч байгаа шүү дээ.

Тэгэхээр Хөгжлийн банкн дээр эрэгтэй улс төрчид чинь 100 тэрбумаар нь, 50, 60 тэрбумаар нь аваад байхад эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон зээл чинь ерөөсөө 9.7-хон тэрбум байна л даа. Би өнгөрсөн оныхыг яриад байгаа юм.

Тэгэхээр энэ 2023, 2024 онд ер нь эмэгтэй бизнес эрхлэгчдээ дэмжих ЖДҮ-д та нар хэдэн төгрөг тавьсан юм бэ гэсэн ийм хоёр асуултыг асууя.

Хамаг сангуудаа тоночхоод тэгээд энэ ЖДҮ сан дээр яагаад ер нь юм тавихаа больчихсон юм бэ? Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан дээр чинь л гол зээл байж бид ажил эрхлэлтээ дэмжинэ.

Тэгээд ер нь 90 оны нэг эзэнгүй айл шиг болчихсон байна шүү. Сая би бас дүүргээрээ нэлээн явлаа.

Хүүхдүүд нь бүгд гадагшаа гараад ажил хийнэ гээд явчихдаг. Эмч нар, багш нар, сувилагч гээд ажил хийх хүн

олдохоо байсан. Бүгд гадагшаа гарч ажиллана.

Дээрээс нь агаарын бохирдол, хөрсний бохирдол гээд ер нь гэр бүлээрээ гадаадад гарч амьдаръя гэдэг болж.

Тэгэхээр цалин бид хэчнээн нэмээд үнийн өсөлтийг чинь бид хязгаарлаж чадахгүй байна л даа.

Тэгэхээр энэ дээр Засгийн газар ямар ажил хийх юм бэ? Тодотголоор энэ асуудлууд чинь ер нь засагдаж байгаа юу гэдэг гол асуултыг л асуух гэсэн юм.

Л.Мөнхбаатар: С.Одонтуяа даргын асуултад хэн хариулах уу? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Нэмэлтээр ажлын хэсэг хариулж болно.

Б.Жавхлан: С.Одонтуяа гишүүний зарим асуултуудад нь хариулъя.

Х.Болорчулуун сайд ирээд багцаа талаар яривал зүгээр байх юм. Жижиг, дунд үйлдвэрлэл дээр 2019 оноос хойш татвар төлөгчдийн мөнгөнөөс, төсвийн мөнгөнөөс дахиж зузаатгал хийгдээгүй. Одоогоор хуримтлагдаад байгаа өмнө нь Жижиг, дунд үйлдвэрийн санг төсвөөс зузаатгасан, нэгэнт эргэлтийн хөрөнгө бий болсон учраас эргэн төлөлтөөсөө дараагийн зээлдэгч нартаа зээлээ олгоод яв гэдэг ийм чиглэл гараад. Түүнээс хойш төсвөөс ерөөсөө огт санхүүжилт хийгдээгүй байгаа.

Нас, хүйс, шашин шүтлэг, юу байдаг юм тийм байдлаар ангилж зээл олгодоггүй болов уу л гэж бодож байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд төдийг, эрэгтэйд нь төдийг гэж тийм ангилал байхгүй байх.

Үүнийг уг нь Х.Болорчулуун сайд илүү дэлгэрэнгүй хариулах хэрэгтэй байна.

Үнийн өсөлтийн хувьд ийм байгаа юм. Өнөөдөр цалин нэмсэн ч үнийн өсөлтийн дарамт ирнэ. 12 сард цалин нэмсэн ч үнийн өсөлтийн дарамт ирнэ. Хойтон өдийд цалин нэмсэн ч үнийн өсөлтийн дарамт ирнэ.

Харин хойшлуулбал ард иргэд хүлээж чадахгүй.

Тийм учраас одоо боломж гарч байгаа хамгийн энэ цаг мөчид бид цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө энэ төсвийн урсгал зардлаараа дамжуулан өрхийн орлогыг бодитойгоор дэмжиж байгаа ийм тодотгол юм.

Харин Засгийн газар ч тэр, Монголбанк ч тэр төсвийн зардлаар дамжиж мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх. Үүнээс болж инфляцад дарамт ирэх сөрөг дарамтуудыг арилгахаар, саармагжуулахаар хоёр бодлого уялдаж явах ёстой.

Мөнгөний бодлого мэдээж хатуу төлөвтэй үргэлжилнэ. Төсвийн зүгээс ч тэр эдийн засгийн болон захиргааны арга хэмжээнүүдийг аль альныг нь аваад явна.

Өнөөдөр Төсвийн байнгын хороон дээр төсвийн тодотголыг дагаж Их Хурлын тогтоол гаргаж үнийн өсөлт, инфляцад нөлөөлөх нөлөөллийг саармагжуулах тал дээр Засгийн газарт үүрэг өгөх юм байна гэж ойлгосон байгаа. Тийм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: С.Одонтуяа дарга тодруулж асууя.

С.Одонтуяа: Би цалин, тэтгэвэр нэмэхийг дэмжиж байгаа.

Угаасаа цалин, тэтгэвэр нэмэхгүй бол одоо энэ авч байгаа цалин, тэтгэвэр чинь хаанаа ч хүрэхгүй байгаа шүү дээ. Би үүнийг дэмжиж байгаа.

Миний асуусан асуулт бол Улсын Их Хурал энэ тогтоол гаргаад үнийг хязгаарлая, гурилынх, одоо махных, сүүнийх ч гэдэг юм уу. Энэ тогтоол гаргаад байхад энэ тогтоолын чинь хэрэгжилт нь хэр үр дүнгээ өгсөн юм бэ? Яагаад юмны чинь үнэ ингээд өсөөд байгаа юм бэ гэдгийг би Засгийн газраас асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Х.Болорчулуун сайд байхгүй бол Сангийн яамныхан юм уу, өөр хүмүүс үүнийгээ хариул.

Үр дүн гарсан юм уу гэж л би асуугаад байна шүү дээ.

Энэ чинь 2022 оны 4 сард батлагдсан тогтоол байхгүй юу. Тэгэхээр одоо ингээд бараг жил болчихсон байхад энэ хэр үр дүнтэй байсан бэ? Энэ дээрээ аудит хийж үзсэн юм уу гээд байна шүү дээ.

Түүнээс би цалин, тэтгэвэр нэмэхийг дэмжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулья. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: С.Одонтуяа гишүүний асуултад манай яаманд хамааралтай эсэхийг нь би хариулья.

2022 оны 4 сарын 15 чинь энэ тогтоол биш хууль шүү дээ. Хууль байхгүй юу. Зарим нэр төрлийн стратегийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг саармагжуулах тухай Засгийн газарт эрх олгосон ийм хууль байгаа юм.

Энэ дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яамны хариуцсан ажил бол энэ нефтийн бүтээгдэхүүнүүдийн зарим нэр төрлийн шүү. Ялангуяа 92 болон дизель түлшүүд дээр үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, саармагжуулах ийм арга хэмжээг ав.

Энэ дээр Засгийн газрын баталгаа хэрэглэж болно гэсэн зөвшөөрөл өгсөн юм.

Энэ хууль маань 2022 оны 12 сарын 31-нд дууссан. Өөрөөр хэлбэл хагас жил ажиллах ийм хууль байсан байгаа юм.

Манай хоёр яам хариуцсан ажлаа амжилттай сайн хийсэн. Өнгөрсөн жилийн сүүлийн хагаст 92 дээр ялангуяа үнийн өсөлт гараагүй.

Засгийн газар, Сангийн яам анх удаа Засгийн газрын баталгааг тухайлан компаниуд дээр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Б.Жавхлан сайд гүйцээгээд хариулъя. 1 минут.

Б.Жавхлан: Төв банк, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, шатахуун импортлогч компаниуд дөрвөлсөн гэрээ хийгээд, хөнгөлөлттэй зээл өгөөд, баталгаа гаргаад. Тэр зээл нь харин банкуудаас гарсан. Банкны эх үүсвэрүүдээс.

Ингэж гараад импортлогч компаниуд дээр хямдралтай эх үүсвэр очоод нөөцөө амжилттай татаад, мөн үнэ дээрээ хязгаарлалтыг Засгийн газраас тавьж байгааг хүлээн зөвшөөрөөд, ингээд тодорхой түвшинд. Би буруу хэлээгүй бол 3200 түвшинд заасан хугацаандаа амжилттай тогтвортой барьсан байгаа.

Бусад хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн болон хүнсний чиглэлийн гурил, махан дээр чиглэлийн яам нь хариулбал илүү оновчтой болов уу.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? Хүмүүс байгаа билүү? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамныхан холбогдох мэдээллийг С.Одонтуяа даргад өгье.

Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Энэ удаагийн төсвийн тодотголыг тоймлоод харахаар цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмж байгаа.

Үүнийг мэдээж ард иргэд талархан хүлээж авч таарна. Ер нь энэ процессын цаана яг одоо юу болж байна вэ? Дүр төрхийг нь харах юм бол 1.8 их наяд гэдэг нь түр зуурын орлого дээр тулгуурласан нэг ийм мөнгөн тооцооллыг эрсдэл бүхий байдлаар тасралтгүй жил бүхэн байдлаар гарах зардал нөгөө талд нь ингээд нэмэгдэж байгаа юм.

Үүний цаана дахиад л наанаа төр төсвийн томролт гэдэг зүйл л яг үүний цаана яваад байгаа юм.

Нөгөө юу гэж байдаг юм гэнэ лээ. Эрүүл мэндийн салбарт нэг ийм пар паркинсоны өвчин гээд. Үүнийг нийгмийн салбарт бас адилхан үйлчилдэг гэсэн утгатай.

Тэр нь төрийн алба гэдэг дандаа өөрийгөө томруулах шинжтэй байдаг. Өөртөө ажил бодож зохиож олдог, өөртөө орон тоо нэмж байдаг. Яг л том дүр зургаар нь харах юм бол яг тэр Паркинсоны өвчин гэдэг зүйл Паркинсоны хууль гэдэг зүйл энд үйлчлээд л байна л даа.

Ард иргэд хүсэж байна. Хэрэгцээ шаардлагатай байгаа. Тэгээд эцсийн дүндээ Монголын төр томроод л, төсвийг нь нийт улсын эдийн засагт эзлэх хувь хэмжээ улам л томроод л байгаа.

Тэгэхээр үүний цаана 1.8 их наяд гэдэг чинь бага мөнгө биш ээ. Мэдээж цалин, тэтгэвэр, тэтгэмж дээр асуудал байгаа. Тэгэхдээ үүнийг орж ирэхдээ тодорхой хэмжээг нь засгаас бариад байсан, уриа лоозон болгоод байсан **“Халамжаас хөдөлмөрт шилжинэ”** гэдэг бодлого руугаа тодорхой хэмжээний энэ зүйл маань шилжихгүй яасан юм бэ? Тодорхой хэмжээнийх нь эндээ тавигдаж.

Хэдийгээр бүхэл бүтэн жилийн төсөв, тодотгол ч гэсэн түр зуур үнийн өсөлтөөс дагаж орж ирж байгаа тодорхой хэмжээний орлогыг шууд төрийн оролцоотой хувааж хэрэглэнэ хэдүүлээ, ирээдүйд бүр илүү сайхнаар тооцож байгаад хуваагаад хэрэглэхийг гэдэг энэ логик өөрөө болохгүй л байгаад байгаа байхгүй юу.

Зөвхөн үнийн өсөлтөөс орж ирсэн түр зуурын орлогыг зүгээр хуваагаад хэрэглэхийг.

Үүнийг чинь дагаад төрийн томролт гээд олон зүйл чинь л үүний цаана яваад байна шүү дээ.

Тэгэхээр тодорхой хэсэг, хэмжээг энэ дээр тэр “халамжаас хөдөлмөрт” гэдэг бодлого руугаа яагаад тавиагүй юм бол? Энэ “халамжаас халамжид”, “халамжаас илүү их халамжид” гэдэг уриа лоозон болоод хувирчихлаа шүү дээ. Яг энэ одлогын өөрчлөлт. Одоо бид нарын хэлэлцэж байгаа энэ 1.8 их наяд чинь.

1.8 их наяд чинь харьцуулаад хэлэх юм бол Монгол Улсын нийт төсвийн зарлагын бараг 10-аад хувьтай тэнцүү зүйлийг зөвхөн тодотголоор бэлэн мөнгөөр, том дүнгээрээ халамжид л шилжүүлчихье л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр яагаад нэг “халамжаас хөдөлмөрт” гэдэг дээрээ бодлогын асуудал оруулж ирээгүй юм бол.

Энэ чинь өөрөө ингээд бид нарыг буруу зүгт хөтлөөд байна шүү дээ.

Төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хэмжээ чинь бараг 40 хувь руу дөхөж байгаа байх. Бодвол. Ямар нэгэн бууралт байхгүй. Буцаж өсөж байгаа.

Тэгэхээр бодлогын сонголт дээрээ бас нэг тайлбар хэлж өгөөч ээ л гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Увс аймгийн Бөхмөрөн сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийнхээ ажил амьдралд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. /алга ташив/

О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Х.Булгантуяа сайд юм уу? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: О.Цогтгэрэл гишүүний асуултыг. Уучлаарай. Сайн ойлгосонгүй.

Ер нь дэмжээд байгаа юм байна. Тэгээд үнийн өсөлт байгаад байгаа юм

байна. Альныг нь сонгосон бэ гээд асуугаад байх шиг байх юм.

Тэгэхээр одоо би цалингаа нэмээд хэрэггүй байсан юм аа л гээд байх шиг байна. Тийм үү?

Би дахиад хэлье. Сүүлийн 3 жил бид энэ КОВИД, дайн гээд энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжээ олигтой нэмж чадаагүй юм. Үнэхээр энэ боломж гараагүй.

Сүүлийн жил гаруйн хугацаанд уул уурхай дагасан том далд эдийн засаг дээр нэлээдгүй ноцолдлоо. Нэлээн л юм боллоо. Нийгмээрээ л юм боллоо.

Тэгээд ингээд харахад далайн түвшнээс дөнгөж орой нь л цухуйж байх шиг байгаа юм. Цаашаа өшөө ч гүн рүү нь оролдох боломжууд байгаа. Тэр хэрээр энэ боломжууд нэмэгдэнэ гэж харж байгаа.

Ингээд боломж гарч ирж байгаа эхний энэ цаг хугацаан дээр цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөөр дамжуулж хамгийн их орхигдчихоод байгаа хүн амынхаа өрхийн орлогыг дэмжиж байгаа юм.

Цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгө гээд.

Энэ удаа энэ бол тодотгол. Тодотголоор бид бүх асуудлыг шийдэж чадахгүй. Бүх асуудлыг шийдэж чадахгүй. Тулгамдсан, орхигдсон энэ асуудлуудаа шийдэж байгаа.

2024 оны төсөв ороод ирэхээр мэдээж таны саяын хэлсэн “Халамжаас хөдөлмөрт” гэдэг суурь бодлогоо үргэлжлүүлнэ. Түүн дээр илүү их тодорхой ярих боломжууд гарах байх.

Харин энэ удаагийн боломжоо өрхийн орлогоо дэмжихэд бид зориулж байгаа юм.

Өнөөдөр нэмсэн ч инфляц хөдөлнө, хойтон нэмсэн ч инфляц хөдөлнө. Хойтонг харин ард түмэн дахиад нэг жил хүлээж чадахгүй.

Тийм учраас л өнөөдөр энэ арга хэмжээг авч байгаа юм.

Тэгээд та хэд маань дэмжинэ байх гэж найдаж байна.

Л.Мөнхбаатар: Одоо эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуултаа асууя.

Д.Ганбат: Б.Жавхланг Сангийн сайд байхад цалин нэмэгдэхгүй, тэтгэвэр нэмэгдэхгүй л гээд байсан. Харин нэмж байх шив дээ. Тийм.

Яах вэ, үүний цаана олон асуудлууд байна. Танайхан л хоорондоо л тэгж яриад байсан юм шүү.

Тэгээд муу л болгон манайханд битгий овоолоод байгаарай.

Асуудлууд байна. Энэ өр, авлага чинь юу болж байна аа? Ер нь та нар цалингаа нэмэхдээ тэр инфляцтай уялдуулаад нэмж байхад яадаг юм бэ? Тэр тэтгэврийг тэгшитгэж нэмдэг нь зөв үү, үгүй юу?

Тэр өөрийнхөө хуримтлуулсан сангаасаа л цалинжаад л явж байх ёстой ийм л систем шүү дээ. Үүнийг та нар шал өөр болгоод хаячихсан. Тэгээд эндээ ороогдоод л ингээд явж байгаа.

Нөгөө талаар 7, 8 жил нүүрсний хулгай, энэ янз бүрийн хулгай гаарсан шүү дээ. Одоо л тэгээд нэг тэмцэх гэж

байгаа дүр эсгээд л яваад байх юм. Тэгээд тэмцэж чадах юм уу, үгүй юм уу?

Хэрвээ үүнтэйгээ эртхэн тэмцээд явсан бол энэ ард түмний чинь цалин, тэтгэвэр, энэ амьдрал ахуй чинь хоёр, гурав дахин өндөр байх боломж байлаа шүү дээ. Тэр боломжийг байхгүй болгочихсон.

Японы хэвлэл мэдээлэл бол манай хэвлэл мэдээлэлтэй адилхан худалдагдсан хэвлэл мэдээлэл биш л дээ.

Тэгээд түүгээр гарч байна. Хамгийн өрийн хавханд орох эхний 5, 6 улсын нэг нь Монгол Улс гээд зарлаж байна. Энэ нь ч би ортой байх гэж үзэж байна. Хятадтай хийгээд байгаа своп хэлцэл ямар байна вэ? Энэ өсөөд байгаа юу, багасаад байгаа юу?

Өнөөдөр 5, 6 жилийн өмнөхийг бодвол манай Монгол Улсын нийт өр 15, 16 тэрбумаас 33 тэрбум болчихлоо. Үүнээс нэг доллар, нэг цент ч төлөгдөөгүй. Сүүлийн 8 жилд. Миний ойлгож байгаагаар. Ер нь ч тийм байгаа гэж мэдэж байна.

Ард хормойгоо аваад л урд хормойгоо нөхөөд л зээлийг зээлээр дараад л явуулж байгаа. Энэ асуудал чинь цаашдаа яах юм бэ?

Тэр тусмаа Засгийн газрын өр та хэдийг олонх болоход бараг зуугаад жил 4 тэрбум долларын л өртэй байсан. Одоо 8 болчихсон байгаа. Үүнээс ч илүү болчихсон байгаа болов уу гэж би бодож байна.

Энэ одоо яагаад ямар учиртай юм бэ? Энэ мэтчилэнгийн өр, авлагаа одоо яах юм?

Нөгөө талаар та нар буруу замаар явж байна. Энэ хувийн хэвшлүүд цаашдаа яаж хөдлөх юм? Өнөөдөр төрийн оролцоо чинь 34, 35 хувьтай байна. Зарлагаа ч нэмчихсэн, орлогоо ч нэмчихсэн. Төсөв чинь.

Нийт Монгол Улсын эдийн засгийн 35, 40 хувийг зүгээр л төсөв дээр нь байна. Үүнээс гадна Монгол Улсын төрийн өмчтэй компани гээд та нарын яриад байдаг тэр компаниудыг нэмэх юм бол бараг 50, 60 хувь нь. Тэндээс ямар ч ашиг орлого байдаггүй. Алдагдалтай юм байдаг.

Тэгээд төрийн албан хаагчдын тоо чинь 200, 300 мянга. Энэ компанид ажиллаж байгаа хүмүүстэйгээ нийлээд. Ийм л байдалтай байгаа. Үндсээрээ буруу юмыг Та нар ингээд л энэ чигээрээ явсаар байгаад л энэ 7, 8 жилийг өнгөрлөө, үрлээ. Энэ бол Монголын ард түмний хувьд алдагдсан он жилүүд болчихоод байгаа байхгүй юу. Алдагдсан он жилүүд. Ийм л байгаа.

Яах вэ, та нар тэр Пи Ар энэ тэр, тэр худалдан авсан хэвлэл мэдээллийг тэгээд л хаалтын гэрээгээр зохицуулаад байж болж байгаа.

Энэ ард иргэд чинь өөрсдөө дайжиж байна шүү дээ. Монгол Улсаас. Залуучууд дайжиж байна. Амьдрах аргагүй болж байна. Тэгээд аргагүйн эрхэнд нэг жоохон жоохон нэг дусал шиг юм нэмж байна шүү дээ.

Тэгээд үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд яваад байсан. Хар л даа. Өнөөдөр 26 мянгын үнэтэй мах идэж байна шүү дээ. Монгол Улс.

Л.Мөнхбаатар: Д.Ганбат гишүүний асуултад хэн хариулах вэ? Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя. Тийм. Өдөр асуусан асуултаа давтаж асуулаа. Би давтаад л хариулъя.

Хэдүүлээ цугтаа сүүлийн гурван жилийг биднээс шалтгаалахгүй дэлхий нийтийн цар тахал, энэ дайн тулааныг хамтдаа өнгөрүүлж байгаа шүү.

Би энэ цаг хугацааг улс төржүүлэхгүй байгаа. Урагшаагаа мөн өр, зээлтэй холбоотой асуудлыг бас л улс төржүүлэхгүй л байгаа.

Гадаад өр, зээл дээр Ардчилсан намын өр, Монгол Ардын Намын тавьсан өр гэж байдаггүй. Монгол Улсын Засгийн газрын өр л гэж байдаг.

Үүнийг бид ялгалгүй нуруун дээрээ үүрээд, зохицуулалт хийхийг нь хийгээд, төлөхийг нь төлөөд явж байгаа.

Ноднин өдийд Монгол Улс гадаад өрийн дарамтаасаа болж дампуурлын ирмэгт байсан. Тэрийг битгий мартаарай. Тэр өр хэзээнээс эхэлсэн бэ гэдгийг бас битгий мартаарай.

Харин тэрийг бид зохицуулалт хийсэн. Зохицуулалт хийсэн байгаа. Амжилттай зохицуулалт хийсэн байгаа.

Энэ нүүрстэй холбоотой олон жил боломж алдсан гэдгийг Та хэллээ. Та маш зөв сайхан онош тавилаа. Үнэн.

Арав гаруй жил маш их боломж байсныг бид алдсан байна. Арав гаруй жил төмөр замаар бид экспортлож болох байсан тэр боломжийг бас алдсан байгаа.

Ингээд нэг юм, энэ олон түгжээ ноднингоос нэг үзүүрээсээ бага зэрэг тайлагдаад, зөвхөн үзүүрээсээ гарч

ирэхэд ийм боломж бидэнд бий болж байгаа шүү.

Үүнийг хамгийн эхний цаг хугацаан дээр нь хэдүүлээ энд кноп дарж ард олон нийтдээ хүүхдийн мөнгөөр, цалин, тэтгэвэр, тэтгэмжээр өрхийн орлогыг нь хамтдаа дэмжих гэж байна.

Таныг ч гэсэн дэмжинэ байх гэж би найдаж байна. Своп хэлэлцээр Төв банкнаас авсан мэдээллээр сунгаж байгаа юм байна лээ.

Үүнийг сунгахаас өөр аргагүй л дээ. Тэгээд ойрын хугацаанд ямар ч байсан нэг тийм төлбөрийн тэнцэл гадаад валютын нөөц дээр нэг их айхтар дарамт ирэхгүй болов уу гэж бодож байна.

Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээр харин тантай би сая 100 хувь санал нийлж байна.

Үүнийг харин бүтцийн өөрчлөлт хийх, цаашид IPO гаргах, эсвэл татан буулгах, бүтцийн өөрчлөлт хийх, засаглалыг нь сайжруулах гээд хөтөлбөр гаргаад Засгийн газар ажиллаад явж байгаа. Хугацаа нь болохоор тайлан тавья.

Засгийн газрын өр 8 тэрбум доллар байгаа. Үүнээс бид ялангуяа бондын өрийг амжилттай буулгаад явж байгаа.

Хүүг нь бууруулаад, хэмжээг нь бууруулаад. Ноднингоос хойш нийтдээ бид нар 600 гаруй сая доллароор бондын өрийг амжилттай буулгасан. 2.9 тэрбум доллар байх байсныг одоо 2.2 тэрбум доллар болгож амжилттай бууруулсан байгаа шүү. Тийм.

Энэ дээр бид маш амжилттай явж байгаа.

Гадна талдаа бид Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр нь хадгалж чадлаа. Энэ жил дефолт болох байсныг ямар ч байсан энэ жил, хойтон жил ямар ч эрсдэлгүй болгож чадсан.

Хөгжлийн банкнаас хамааралтай мөн Засгийн газрын дефолтыг бас хамгаалж чадсан. Ийм амжилттай болж байгаа зүйлүүд байгаа шүү. Д.Ганбат гишүүн. Тийм.

Болохгүй байгаа зүйлүүд байгаа байгаа. Одоо энэ инфляц сүүлийн жилүүдэд өндөр байна. Гаднаас их шалтгаалж байна. Бид өөрсдөөсөө шалтгаалах зүйлүүдээ бас чамгүй хийгээд л явж байгаа.

Ялангуяа валютын өсөлтөөс хамааралтай инфляцын нөлөөллийг бид амжилттай бууруулж барьж чадаж байгаа. Үүнийгээ цаашаагаа бид амжилттай үргэлжлүүлнэ.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулна. 1 минут.

Д.Ганбат: Би тов тодорхой асуултууд асуугаад байгаа юм л даа. Та нар 8 жил, 10 жилийн хугацаанд нэг цент төлөв үү л гэж байгаа юм. Өрдөө. Тэрийг асуусан.

Өглөө асуухдаа та нар хариулаагүй. Тэр хүүхдийн мөнгийг та нар тэгээд л мэдэн будилж байгаа юм шиг ялгаварлаж өгчхөөд л, одоо болохоор буцаагаад тэр мөнгөө өгөхдөө хүүтэй нь өг гэж байгаа.

Нөгөө талаар мөнгөө авахгүй гэж хүсэлт гаргасан хүнд нь л битгий өг. Тийм хүн ховорхон гарна. Битгий тэр юмыг эсрэгээр нь бодож бай. Заавал та нар гуйж байгаа юм шиг хүсэлт гаргах

энэ тэр ямар хэрэгтэй юм. Бүх мэдээлэл та нарт байгаа. Тэр өгдгөөрөө л өг. Хүсэлт гаргасанд нь өгнө. Өө.., яая яаж байгаа юм. Боль мэдэв үү.

Хүсэлт гаргаад авахгүй гэсэнд нь битгий өг. Тэгж та нар сэтгэх ёстой байхгүй юу. Юмыг дандаа нөгөө талаас нь харах юм. Ард түмэндээ яаж хүндрэл учруулах вэ, яаж гай зовлон бий болгох вэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Д.Ганбат гишүүн асуултад хариулъя. Та анхааралтай сонсоорой. Түрүүхэн би хэлсэн шүү.

2021-ээс 2023 онд нийтдээ бид 5.9 их наяд төгрөгийн өр төлбөрийг гадаад дотоодод төлсөн байна. Үүнийг өрийн зохицуулалттайгаа нийлүүлэх юм бол 10.8 их наяд төгрөгийн өрийн зохицуулалтыг бид амжилттай хийгээд өнөөдөр Монгол Улс гадаад зах зээл дээр ямар нэг өрийн дефолтын эрсдэл байхгүй, амжилттай зээлжих зэрэглэлээ хамгаалаад явж байна.

Үүнийг сүүлийн хоёр жил Засгийн газар амжилттай хийсэн сайн ажлуудын маань нэг шүү. Үүнийг та сайн бичээд аваарай. Харин.

Хүүхдийн мөнгөн дээр харин яг таны хэлснээр л явж байгаа шүү дээ. Ер нь.

Та ноднин л хэлээд байсан. Яг таны хэлснээр явж байгаа. Одоо бид боломж гарч ирж байгаа учраас төсөв дээрээ ямар ч байсан 100 хувь тавьчихсан байгаа. Эндээс хүүхдийн мөнгө авах шаардлагагүй байна. Үүнийг хүүхдүүдийнхээ сайн сайхны төлөө хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтад нь

хүүхдийн төлөө фондоор ч юм уу дамжуулж хийе гэсэн ийм сонголтыг л өгч байгаа.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тэгэхээр Д.Ганбат гишүүн ээ, таны хэлсэнтэй нийлж байгаа биз дээ.

Би авах шаардлага байхгүй. Харин авсныгаа би ийш нь хандивлая гэж байгаа сонголт л байгаа. Бусад нь шууд хариулсан хариулаагүй хүүхдүүд дээрээ бүгд дээр нь очно гэсэн үг.

Харин тэр дүнг хараарай. 1.5 их наядаас ганцхан хувь хандив явахад нэг сургууль 15 тэрбум, 2 хувь явахад 30 тэрбум. 2 том сургууль. Энд ийм их боломжууд байгаа учраас бас ийм сонголтыг ард иргэддээ тэр хэсэгт бас өгөх ёстой. Энэ нь шударга ёсонд нийцнэ гэж бодож байгаа. Тийм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 26 саналын томьёолол байгаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “энэ хуульд

заасан журмаар” гэсний өмнө “энэ хуулийн 9.2-т нийцүүлэн” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Бейсен гишүүн дэмжсэн юм байна

2.Үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөлтийн аргуудад шилжиж байгаатай холбогдуулан судалгаа тооцооллыг нарийвчлан судалж, төслийн үзэл баримтлалыг тодорхой болгох үүднээс төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 16 дугаар зүйлийн 16.4, мөн зүйлийн 3 дахь заалтын 57 дугаар зүйлийн 57.18 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.1, 78.3 дахь хэсгүүдийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

63.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт тусгагдсан асуудлыг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган зохицуулахаар төслөөс хасаж, мөн заалтын 78.2 дахь хэсгийг төслийн 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийг 2025 оны 01

дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

74.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Найруулгын санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.7 дахь хэсгийн “түүний хэмжээ” гэснийг “албан тушаалын цалингийн хэмжээ” гэж, 3 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж тус тус өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлээс “зүйл,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 17.2 дахь хэсгийн “6, 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй” гэснийг “6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “6.2 дахь хэсгийн “сум” гэсний дараа “баг,” гэж” гэснийг “6.2 дахь хэсгийн “Аймаг,

нийслэл,” гэсний дараа “сум,” гэж, “сум,” гэсний дараа “баг,” гэж” гэж өөрчлөх.

Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат. Санал хураалт. /алх цохив/

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 4 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас” гэснийг,” хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

Төрийн хэмнэлтийн хуулиар форум гээд бүх хувцас хассан байсныг сэргээж оруулж байгаа юм. Энэ амьдралд бас болохгүй байгаа юм. Зам дээр дайруулбал яана. Тийм. Эрүүл мэндийн сайд засаг дээр ярихгүй. Багийн эмчийн унааг энд ярьдаг.

60.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1. Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.6 дахь заалтын “орон нутгийн салбар, нэгжийг нэгдсэн удирдлагаар хангаж ажлын уялдааг сайжруулах,” гэснийг “энэ хуулийн 20.1-д заасан төвийн үйл ажиллагааны салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах,” гэж өөрчлөн “, ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлэх” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

72.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.7 дахь заалтын “аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, салбарууд дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийг” гэснийг “аймаг, нийслэл, сум, дүүргийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.8 дахь заалтын “, олон улсын байгууллагын” гэснийг хасаж, “төрийн бус” гэсний дараа “байгууллага” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.10 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг аймаг, дүүрэг, сум дахь Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан хүргэх, энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог” гэснийг “аймаг, сум, дүүрэг дэх төвийн хэрэгжүүлэх энэ хуулийн 20.2-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Асуулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно.

Санал хураалт явуулья. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

62.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйл буюу 19.1.11 дэх заалтын “Энэ хуульд заасан чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоог” гэснийг “энэ хуулийн 19.1-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

Би Г.Тэмүүлэн, Н.Учрал гишүүн хоёрыг Залуучуудын холбооны дарга нар байсан учраас тэгээд л зөв л юм хийж байгаа байх гэж бодоод л дэмжээд.

6.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.2 дахь заалтын “гарах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх” гэснийг “гаргахтай холбоотой саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх,” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхдээ энэ төсвийн хуультай яг ямар холбоотойг нь л ойлгохгүй байгаа юм.

7.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.5.гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тулгамдсан бэрхшээлийг даван туулах талаар залуучуудад сургалт явуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

73.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай асуудал орж байна.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “үйлчилгээ болон энэ хуульд заасан” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

34 гишүүн дэмжиж, 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар зүйл буюу 20.4 дэх хэсгийн “төвийг” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. /алх цохив/

“Төвийг” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэсэн юм байна. Шигтгэсэн хувилбар нь юу байна? Ням-Осорын Учрал гишүүн үг хэлнэ.

Н.Учрал: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэдэн онд билээ, 2017 онд батлуулсан.

Тэгээд ажлын хэсгийг нь ахалж батлуулсан. Тэгээд Г.Тэмүүлэн гишүүн бид хоёр энэ хуулийг тухайн үед санаачилж ингэж батлуулсан.

Тэгээд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиар Залуучуудын хөгжлийг дэмжих төв гэдэг ийм ойлголт орж ирсэн юм.

Дээрээс нь Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүдтэй болсон. Залуучуудын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг байгуулсан. Ингээд Залуучуудын хөгжлийг дэмжих сан гэдэг ойлголт бас энэ хуулиар орж ирсэн ч тусгай сангийн хуульд өөрчлөлт ороогүй учраас энэ сан байгуулагдаагүй.

Тэгээд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиараа энэ төсөвтөө дагуулж орж ирж байгаа хуулиар залуучуудын асуудлыг тэр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх л ийм агуулга орж ирж байгаа юм байна.

Тэгээд Засгийн газраас өргөн мэдүүлснээр. Тэгээд сая одоо энэ хэлэлцүүлгийн үеэр “залуучуудын асуудлыг эрхэлсэн иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ” гэдэг нэг ийм үг орж ирлээ.

Тэгээд одоо яг дахиад нэг асуудал үүсэж байгаа юм. Ямар асуудал үүсэж

байгаа вэ гэхээр мэргэжлийн холбооны хуулийг би 2019 онд санаачлаад Их Хурал дээр хэлэлцэх эсэхээ дэмжээд ингээд нэг ажлын хэсэг байгуулаад Б.Баттөмөр гишүүн ахлаад одоо ингээд байж байна.

Тэгээд ерөөсөө мэргэжлийн холбоо гэж юуг ойлгохыг бид ерөөсөө шийдэж чадаагүй байхгүй юу. Өнөөдрийг хүртэл.

Тэгээд сүүлд тэр холбоо Сангийн эрх зүйн байдлын хууль орж ирсэн. Дахиад бас шийдэгдээгүй.

Тэгээд одоо ямар байдал үүсэх вэ гэхээр залуучуудын асуудлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ гэхээр одоо энэ төсвийн хууль дээр дагасан залуучуудын хууль дээр залуучуудын асуудлыг эрхэлсэн иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ гэхээр залуучуудын асуудлыг эрхэлж байгаа маш олон төрийн бус байгууллага байгаа.

Бүгдээрээ залуучуудын асуудлыг эрхэлдэг иргэний нийгмийн байгууллагууд. Энэ олон байгууллагуудыг Х.Булгантуяа сайд хагалах юм байна. Ер нь цаашдаа.

Одоо Х.Булгантуяа сайдын л ажил болж хувирлаа. Яах вэ гэхээр маш олон залуучуудын байгууллага гарч ирээд бид ажлаа хийнэ гээд тань дээр ирнэ. Та тэгээд яаж ангилж ялгаж, ямар босго шаардлага тавьж шийдэхийг өөрийн ухаан л мэдэх л ийм л ажил боллоо л доо, тэгээд.

Залуучуудын маш олон иргэний нийгмийн байгууллага байгаа шүү. Тэгээд тэр олон байгууллагаас алинд нь өгөх вэ гэдгийг та шийднэ. Эсвэл сайхан хуваарилаад өгөх юм уу, хуваагаад өгөх юм уу.

Уг нь мэргэжлийн холбооныхоо хуулийг гаргачихсан бол залуучуудын асуудлыг эрхэлдэг мэргэжлийн холбоо байгуулагдчих ёстой байхгүй юу.

Тэгээд тэр байгууллагад нь шилжүүлээд л, тэр мэргэжлийн холбооны ард олон сонирхлын бүлэгтэй төрийн бус байгууллагууд ажлаа хийгээд л явчихгүй болохоор ингээд салбарын сайд дээр энэ бүх ачаа ирчихдэг.

Тэгээд одоо өнөөдөр энэ төсвийн хуулиар чинь Г.Тэмүүлэн гишүүний. Г.Тэмүүлэн гишүүн бол их зөв юм бас гаргаж ирсэн юм байна.

Яагаад гэхээр **“залуучуудын асуудал эрхэлсэн иргэний нийгмийн байгууллага”** гээд ерөнхий байдлаар нээж өгч байна шүү дээ.

Тэгэхээр Г.Тэмүүлэн гишүүн бид хоёрын ажилласан энэ залуучуудын хуулийг амьтай байлгахуй эсэх асуудлыг Х.Булгантуяа сайд хагалах нь.

Тэгээд ингээд залуучуудын асуудлыг хэн хариуцах вэ гэдэг том ажил эхэлнэ. Энэ хуулийн ард. Одоо бол төрийн захиргааны байгууллага чинь хийгээд байгаа шүү дээ. Төрийн захиргааны байгууллага чинь.

Тэгээд тэр төрийн захиргааны байгууллага чинь байхгүй болоод төрийн бус руу шилжүүлэх гээд байна шүү дээ. Төрийн бус байгууллага гэдэг байсан чинь одоо өөрчлөгдөөд **“залуучуудын асуудлыг эрхэлсэн иргэний нийгмийн байгууллагад шилжүүлнэ”** гэхээр залуучуудын асуудлыг эрхэлдэг иргэний нийгмийн байгууллага маш их шүү дээ. Тэгээд цаашдаа ер нь яг юу болохыг би хэлж мэдэхгүй байна.

Тийм учраас мэргэжлийн холбооныхоо хуулийг л гаргахгүй бол энэ цаашдаа явахааргүй боллоо. Их л бас зовж зүдэрч байгуул.../минут дуусав/

Г.Занданшатар: Саналыг дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Сая дэмжсэн.

Тэгээд сайд нар Засгийн газар дээрээ сайн ярьж орж иржээ. Энэ хуулийн агуулга нь өөр байна л даа.

Х.Булгантуяа гишүүн дэмжиж үг хэлнэ гэсэн үү?

Х.Булгантуяа: Энэ хуулийн 4.1.5 дээр залуучуудын иргэний нийгмийн байгууллага гэж залуучуудын оролцоотой, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагыг гэж энэ хуулийнх нь томъёолол дээр нь оруулж өгсөн юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газраас, манай яамнаас ч гэсэндээ энэ чиг үүргийг нь хуулийнх нь дагуу нэр томъёог нь бичиж оруулж ирсэн юм.

Нэгдүгээрт, манай эмэгтэйчүүд, ахмадын гэхэд жишээлбэл яг хариуцсан улсын, төр засгийн агентлаг бас байхгүй.

Тэгэхдээ бид үүнийг бас л ингээд л төрийн бус байгууллагуудаар, иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээлээд гүйцэтгүүлээд бас явж байгаа.

Энэ хууль маш үр дүнгээ өгсөн. Үүний үр дүнд нэлээдгүй олон аймгуудад. Зарим нь Гэр бүл, хүүхэд хөгжлийн газар дээр нэг өрөө, зарим нь тусгайлсан залуучуудын хөгжлийн төвтэй болсон.

Үүнийг хуулийнхаа дагуу аймаг, орон нутгийн Засаг дарга нар тухайн

орон нутгийнхаа хорооных нь даргаар ажилладаг. Орон нутаг ч гэсэн үүнийг аваад явах нь зүйтэй юм байна гэж байгаа юм.

Сая хүүхдийн байгууллагын үе үеийн төлөөлөлтэй уулзахад хоёр жилийн дараа хүүхдийн байгууллага Монгол Улсын хүүхдийн үндэсний байгууллага 100 жилийнхээ ойг тэмдэглэх гэж байгаа.

Тэгээд энэ хоёр өөр сегментийг нэг байгууллага дотор байгаад. Дээрээс нь нэмээд үнэнийг хэлэхэд энэ байгууллага дотроо бас удирдлага, зохион байгуулалтын хувьд их асуудалтай. Үүсгэн байгуулагдсанаасаа хойш дарга цэрэг нь бараг 6 удаа солигдсон.

Тэгэхээр үүнийг залуучуудын асуудал хүүхдийн асуудлаас их ондоо юм. Тэгэхээр яг л хүүхдийн байгууллагыг нь тэр чигээр нь хүүхдийн байгууллагаар нь явуулж өгөөч ээ гээд. Харин хүүхдийн хамгааллын төсвийг нь 2024 онд хоёр дахин нэмье гэдэг шийдвэр гарсан.

Хүүхэд хамгааллын хуулийг бид бас удахгүй өргөн барих гэж байна.

Залуучуудынхыг харин бид бодох ёстой юм нь Монголын залуучуудын холбоо гээд бараг 4 давхар байртай, хотын төвд яам, Тамгын газар шиг том байртай байгууллага байгаа.

Энэ байгууллагынхаа эрх зүйг бид харин сайжруулаад ийм түүхтэй, том байртай ийм төрийн бус байгууллагуудаараа харин залуучуудынхаа асуудлыг.../алх цохив/

Г.Занданшатар: Сайд нар бие биеэсээ асууж дууслаа.

Энэ заалт чинь төвийн үйл ажиллагааны зардлыг гэж л заалт байгаа шүү дээ. Яг үүнтэй шууд холбоод. “Төв” гэснийг “төвийн үйл ажиллагааны зардлыг” гэж байгаа юм. Төвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэснийг л төвийн үйл ажиллагааны зардлыг гэж тодруулж байгаа юм билээ. Ийм санал хураалт байгаа. Санал хураалт явуулъя.

Ер нь Г.Тэмүүлэн гишүүний гаргаж байгаа санал зөв байгаа юм. Х.Булгантуяа сайд аа, Н.Учрал сайд аа, Г.Тэмүүлэн гишүүнийх.

Хэтэрхий ерөнхий мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоогоор гүйцэтгүүлнэ гээд заачихсан байсныг залуучуудын байгууллага гэж тодотгож өгч нарийвчилж байгаа л агуулгатай юм билээ. Бас л нэгийг бодсон юм шиг байгаа юм. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Тэгээд сумынхыг итгэмжлэх шаардлагатай болж байгаа юм билээ. Уг нь аймаг, сум, нийслэл, дүүрэг, сумын түвшинд гэж байгаа юм.

63.5 хувийн саналаар.

10. Найруулгын санал.

Төслийн 2 дугаар зүйл буюу 20.2.3 дахь заалтын “сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн” гэснийг “сонирхлын бүлгийн” гэж, 20.2.7 дахь заалтын “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 20.3 дахь хэсгийн “, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор” гэснийг “залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 52 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж, 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.5 дахь хэсгийн “хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах” гэснийг “хуулийн 23.2-т заасан” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль зүйн техникийн хувьд зөв тодорхойлсон байна. Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж байхгүй шүү дээ. Байгалиасаа байна уу, аваар ослоор ч байна уу. Хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж шинэ нэр томьёо гаргаж ирснийг зассан байна.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.6 дахь хэсгийн “томилсон тохиолдолд байгууллага дэд даргатай байна.” гэсний дараа “Энэ тохиолдолд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг хамаарахгүй.” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт.

63.5 хувийн саналаар санал дэмжиж байна.

Төрийн хэмнэлтийн хууль чинь түр хууль уу, бүтэн хууль уу?

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 40.7 дахь хэсгийн “заасан байгууллагын” гэснийг “заасны дагуу томилогдсон” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3.15 дахь хэсгийн “судалгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээхтэй холбоотой” гэснийг “шинжлэх ухааны суурь, хавсарга, технологи, хөгжүүлэлтийн туршилт судалгаа болон инновац судалгааны” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн, Хавдисламын Баделхан, Хүрэлбаатарын Булгантуяа, Лхагвын Мөнхбаатар, Бөхчулууны Пүрэвдорж. Санал хураалт. /алх цохив/

72.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан өдрөөс” гэснийг “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар санал хураалт явуулья.

1.Төслийн 1 дэх заалтын “тогтоолын 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 2.4, 2.5 дахь дэд заалт” гэснийг “тогтоолд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт, мөн тогтоолын 2 дахь заалтад 4 дэх дэд заалт тус тус” гэж, мөн заалтын 4 дэх дэд заалтыг 3 дахь заалт болгон тус заалтын “нөхөн олгох,” гэснийг “нөхөн олгосугай.” гэж, 5 дахь дэд заалтыг 4 дэх дэд заалт болгон өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтын “Мөн тогтоолын” гэснийг “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын” гэж өөрчлөн, төсөлд “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчилсүгэй.” гэсэн агуулга бүхий 3 дахь заалт нэмж, төслийн 3 дахь заалтын дугаарыг “4” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

73.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн тогтоох хэсгийн “хэсэгт заасныг” гэснийг “хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

71.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулья.

Нэг. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтын “хүүхдэд” гэснийг “хүүхэд бүрд” гэж өөрчлөн, “хүүхдийн эцэг эх, асран

хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтэд үндэслэсэн” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

57.7 хувийн саналаар байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Г.Тэмүүлэн дарга Төсвийн байнгын хороо хуралдана шүү дээ. Өнөөдөр. Үүний дараа. Тийм ээ.

Хоёрдугаар хэлэлцүүлгийнхээ дараа энэ хэлэлцүүлгүүдээ хийнэ.

Найм.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Одоо Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлтсийн эмнэлгийг явуулна.

Төслүүдийг хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын байнгын хороод Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, гаргасан санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлснийг тус Байнгын хороо хуралдаанаараа нэгтгэн хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн тодотголын төслийг хэлэлцэхэд хуралдаанд оролцсон зарим гишүүдээс Монгол Улсын 2023 оны төсвийн дүнд нөлөөлөхгүй хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний нэр, байршлыг өөрчлөх, төсвийн ерөнхийлөн захирагч

хооронд шилжүүлэхтэй холбоотой санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямрал 2013-2015 оны түүхий эдийн шокийн нөлөөллөөс бүрэн гүйцэд ангижраагүй байхад 2020 онд цар тахал тархаж дэлхий нийтээрээ, тэр тусмаа манай улсын нийгэм, эдийн засагт бас хүнд цохилт ирсэн.

Мөн Оросын Холбооны Улс, Украины хооронд болж буй дайн тулаан, улаан буудай, бордоо, түлш, шатахуун, эрчим хүчний бүтээгдэхүүний үнэ ханш өссөн.

Энэ бүхэн Та бидний уруудсан бизнес, унасан цалингаа өсгөх, өссөн инфляц, буцалсан үнийн өсөлтийг буулгах томоохон сорилттой нүүр тулгуулж байна.

Гэвч Монголын Засгийн газрын төсөв, мөнгөний бодлого ямар хэмжээнд байгааг илүүц олон үггүйгээр үнийн өсөлт, төгрөгийн ханшийн сулралаас бид бүгд бас харж болно.

Инфляц гурав дахь жилдээ хоёр оронтой тоонд үргэлжилж, өрхийн бодит орлого буурлаа.

Монгол Улс дунд, дундаж давхаргагүй Африк, Латин Америкийн буурай орнуудын эгнээ рүү эрчимтэйгээр алхаж байна.

Манай улсын бүтээмж удааширч, уул уурхайгаас улам бүүр хараат болж нийгэмд тэгш бус байдал гаарч, халамжийн улс орон боллоо.

Гэтэл өнөөдрийг хүртэл эрх баригчид инфляц, инфляц өсөж, иргэдийн цалин орлого, тэтгэвэр үнэгүйдэж, мөн шалтгааныг оношилж чадаагүй байгаа нь өргөн барьсан тодотголоос бас тодорхой харагдаж байна.

Инфляц төрийн үл үзэгдэх татвар юм.

Төрийн буруу бодлогын үр дүн инфляцаар бас хэмжигддэг.

Өнгөрсөн жилүүдэд хурдтай тэлсэн төсвийн хажуугаар тооцоо судалгаагүй 15 их наядын хоёр ч хөтөлбөр хэрэгжсэн. Өнөөг хүртэл тайлан тавигдсангүй.

КОВИД-ын үед иргэдийн эрүүл мэнд, улсынхаа эдийн засгийг хамгаал

гэж донор орнууд, олон улсын санхүүгийн байгууллагууд 1 тэрбум ам.доллар буюу бараг 3 их наяд төгрөгийн тусламж, хөнгөлөлттэй зээлүүд өгсөн.

Эрдэнэт үйлдвэр 1 их наяд төгрөг, Оюу Толгой компани Арбитрын шүүхийн барьцааны 1.2 их наяд төгрөгөө хандивласан.

Аж ахуйн нэгжүүд ч зүгээр суугаагүй. Өөрөөр хэлбэл манай Засгийн газар дэлхийн бусад улсуудтай харьцуулахад хангалттай хэмжээний хөрөнгө КОВИД-той тэмцэхэд зарцуулсан ч үр дүн нь үлэмж хангалтгүй байгааг албан статистик, иргэдийн амьжиргаа харуулсаар байна.

Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт 2016 онд 11 их наяд байсан бол өнөөдөр 30 их наяд болж бэлэн мөнгөний хэмжээ өсжээ.

Гэтэл сүүлийн 10 гаруй жилд манай дотоодын нийт бүтээгдэхүүн Монгол төгрөгөөр өссөн дүнтэй харагдаж байгаа ч америк доллароор 13, 14, 15 тэрбум долларын хэмжээнд л сүүлийн 10 гаруй жил л эргэлдлээ.

Их наядын хөтөлбөрүүдийн үр дүн хангалтгүй байсныг олон зуун аж ахуйн нэгж хаалгаа барьж аж ажил орлогогүй ядуусын эгнээ өргөжсөнөөс харж болно.

Ид ажиллах насны залуучууд гадаад руу бөөн бөөнөөрөө тэмүүлж, Монгол Улсын 3 хүн тутмын 2 нь орлого багатай, ажилгүй ангилал руу. Ийм дэндүү харамсан үзүүлэлт рүү улам ойртож байна.

Өнгөрсөн хоёр жилд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ асар хурдтай өсөж, эдийн засаг хүндэрсэн

шалтгааныг эрх баригчид зөвхөн цар тахлаас болсон, улс орон бүхэн ийм хүнд байгаа мэтээр ойлгуулахыг бас хичээж байна.

Инфляц өрхийн орлогоос 14 их наяд төгрөгийг хумсалсан гэж Монголбанкны удирдлага Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороон дээр мэдэгдсэн.

Инфляц 14 их наядыг хумсалсан шүү гэж.

Энэхүү алдаагаа засахаар төсвийн орлого, зарлагыг тус бүр 1.8 их наядар өсгөх төсвийн бодлого өргөн барьсан нь ардаа урхаг ихтэй бодлогын томоохон алдааны эхлэлийг тавьж магадгүй байгааг бид бүгд анхааруулж байна.

2023 оны төсөв анх халамжаас хөдөлмөрт гэсэн хачин гоё уриа лоозонтойгоор өргөн баригдаж батлагдсан.

Гэвч өдөр өнгөрч цаг явахын хэрээр өнөө хөдөлмөрт шилжих, бизнесийг дэмжих уриа маань сонсогдохоо больж, халамж, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх, өргөтгөх санаачилгуудад бүрэн дарагдаж байна.

Халамжаас хөдөлмөрт шилжинэ гэсэн бодлогоо Монгол Улсын Засгийн газар хаана гээчхэв.

Бүтээмжийг урамшуулах, бизнесийг дэмжих бодит санал санаачилгуудыг ярихаа болиод удлаа.

Уул уурхайгаас бусад бизнесийнхнийг дэмжих, тэр бүү хэл тэдний асуудлыг анхааран сонсдог нь ч орхигдлоо.

Үр дүнд нь халамж хавтгайрч, ажилгүйдэл нэмэгдэж, залуус гадагшаагаа дүрвэсээр.

Хүүхдийн мөнгийг зорилтот өрхүүдэд олгоно. Энэ халамж гэж Засгийн газраас зарласан. Гэвч жил хагасын дараа хүүхдийн мөнгийг хавтгайд нь олгох нь зөв юм байна гэж дүгнэснээ энэхүү тодотголоор харуулж байна.

Одоо Та бүхэн хүүхдийн мөнгө гэдэг чинь халамжийн бодлого юм уу, хүн амаа өсгөх, байгалийн баялгаас иргэддээ ирээдүйдээ тэгш хүртээж буй бодлого юм уу гэдэг тодорхой хариултаа өгөх цаг болжээ.

Хэрэв халамж юм бол одоогийнх шиг халамжийн сангаасаа олгох юм бол Монголын бүх хүүхэд халамж авах, хүртэх нөхцөлд аж төрөн суугаа гэсэн үг үү.

Монгол Улс бүгдээрээ халамжид хамрагдахаар ийм нөхцөл байдалд орлоо гэсэн үг үү.

2023 оны эхний 6 сарын байдлаар 25 сая тонн нүүрс өндөр үнээр экспортолж төлөвлөгөө давж биелсэн.

Энэ байдлаараа энэ жилийг 50 сая тонн нүүрс экспортолно гэж үзжээ. Засгийн газраас.

Тийм гүйцэтгэл гардаг тун сайн юм.

Өнөөдөр Хятадын боомтууд дээр нэг тонн нүүрс 108 ам.доллаароор зарагдаж байна. Ойрын хугацаанд 85 болж магадгүй гэж байна.

Бид бүгд 110-аас доошгүй доллароор бүтэн жилжингээ зарчихна гэж энэ төсвийн тодотголд тусгаж байгаа.

Хятад Улс ойролцоогоор 70-аас 80 сая тонн коксжих нүүрс импортоор авдаг. Тэд мөн өнгөрсөн 4 сарын 01-нээс коксжих нүүрсэндээ 3 хувийн импортын татвар авч эхэлсэн. Мөн Австралийн нүүрсэнд тавьсан хориггоо цуцалж сулруулжээ. Мөн Оросын Холбооны Улс, Индонез зэрэг улс коксжих нүүрсийг асар ихээр нийлүүлэх төлөвлөгөө гарган идэвхтэйгээр ажиллаж байна.

Тэгэхээр энэ бүхэн Монгол Улсын коксжих нүүрсний борлуулалт саарах магадлал өндөртэйг бид бүгдэд харуулж байна.

Төсвийн орлого их наядаар давж өссөн нь тодотгол хийх нэг шалтгаан болохыг Засгийн газар тодотгосон.

Харамсалтай нь энэ бодит өсөлт биш үнийн өсөлтийг дагаж инфляц хэмээх татвар нэмэгдэж ирсэн нь бас ийм үзэгдэл үүний цаана байгаа.

Өөрөөр хэлбэл импортоор оруулж ирдэг хүнс, валютын ханшаас шалтгаалан үнэ нэмэгдэхэд НӨАТ болон бусад татварын хэмжээ өсөж, татварын хөөс үүссэн гэдгийг энд бас хэлэхгүй байна.

Төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийг нэмснээр цар тахлын хүндийг арай ядан туулсан олон мянган хувийн хэвшлийнхэн дахин цалингаа нэмэхийн тулд үнэ өсгөх, эсвэл хаалгаа барих гэдэг хоёр сонголтыг сонгох хүндхэн сонголтын шийдвэртэй нүүр тулж байна.

Цалин, тэтгэвэр, тэтгэмж сар бүр тогтмол гарах зардал. Харин түүхий эдийн ханш тогтмол өндөр байдаггүй.

Нүүрсний үнэ унавал гаднаас зээл авч төсвийн алдагдлаа нөхөхөөс өөр арга байхгүй.

Гэтэл Засгийн газрын өрийн тааз бас тулчихсан байдаг. Валютын ханш чангарвал гадаадын хөрөнгө оруулалт ч буурна. Ийнхүү инфляц нэмэгдэж Монгол төгрөгийн ханш сулрах энэ чөтгөрийн тойрог руу гулсан орох эрсдэл төсвийн тодотголын цаана байгааг бас хэлэх ёстой.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс цалин, тэтгэвэр нэмэхийг огтхон ч эсэргүүцээгүй.

Харин Засгийн газрын бодлого ихээхэн эрсдэл дагуулж байгааг анхааруулж байна.

Засгийн газар гоё сайхан уриа лоозонгоор хөөцөлдөхөөс илүү төсөв, мөнгөний бодлогоо зөв удирдах, буруу шийдвэрүүдээ засаж залруулах, хямралд цөхөрсөн аж ахуйн нэгжүүдээ дэмжих, гадаад өрийн хэмжээгээ багасгах, үнэ тогтвортой барих тэр тогтворжуулах тооцоо, судалгаатай бодит ажлуудаа үргэлжлүүлэн хийх ажлууд шаардагдаж байгааг Ардчилсан намын бүлгээс анхааруулан сануулж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил,

харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ч.Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Макро, эдийн засгийн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нарантуяагийн Баярмаа тус яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сандагийн Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Басангийн Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Дугаржавын Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Буянбадрахын Жавзанжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга.

Энэ чинь протоколд тэмдэглэгдэх ёстой.

Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад гишүүд бэлдэнэ. Дэгээр хоёр дахь хэлэлцүүлэг дээр тухайн санал дээрээ л санал хэлж болно.

Төсвийн хууль хэлэлцдэг дэгээрээ явна шүү дээ.

Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт болно.

Санал тус бүрээр дэмжсэн, дэмжээгүй үг хэлж, ярьж болно. Дэг нь ийм юм. Та ч уг нь дэг овоо сайн мэддэг байсан бөлгөө.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн.

Материал Засгийн газрын сайд нарт өгөөгүй. Бусдад нь тарчихсан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “6 дугаар зүйл” гэснийг “6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Нэг дэх саналтай холбогдуулж Б.Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 2016 оны 2 дугаар улиралд мөнгөний нийлүүлэлт ойролцоогоор 11 их наяд төгрөг байсан.

Тэгээд өнөөдөр 30 их наяд төгрөг болчихсон байгаа.

Тэгээд энэ их зах зээл рүү оруулсан мөнгө өнөөдөр үнийн хөөрөгдлийг шууд бий болгож байгаа юм. Тэгээд өнөөдрийн энэ оруулж ирж байгаа төсвийн тодотгол дээр үнэ нэмээд байгаа. Үнэ нэмэгдэж байгаа учраас цалин, тэтгэвэр нэмж байгаа юм л гэж яриад байгаа юм.

Тэгэхээр төрийн төсөв, мөнгөний бодлого зөв байна уу, буруу байна уу гэдгийг ямар асуудлаар хэмждэг вэ гэхээр үнийн өсөлт ямар байгаа юм, тэгээд төгрөгийн ханш хэр зэрэг суларч байгаа юм гэдгээр л дүгнэдэг байхгүй юу.

Тэгээд өнгөрсөн хугацаанд төгрөгийн ханш суларсан, үнийн өсөлт болсон тэр бүх зүйлийг КОВИД руу чихдэг. КОВИД болохгүй учраас л ингээд байна гэдэг.

Гэтэл дэлхий даяар л КОВИД гарсан шүү дээ. Дэлхий даяар л КОВИД гарсан. КОВИД-той мөртлөө өнөөдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улс 1 хувийн инфляцтай байна. Дайнтай мөртлөө Орос 3 хувийн инфляцтай байна. Япон 0.2 хувийн инфляцтай байж байна. Африкийн орнууд бүр дефляц руу ороод явж байна шүү дээ.

Тэгээд энэ КОВИД руу юмаа чихдэгээ болих хэрэгтэй байхгүй юу даа.

Тэгээд л Ардчилсан нам руу бас чихнэ.

Одоо ингээд та нар ерөөсөө эдийн засгийг солонгоруулах тал дээр ерөөсөө юу ч хийхгүй байна.

Гурван жилийн өмнө уул уурхайгаас олж байсан орлого 3 их наяд төгрөг байсан. Өнөөдөр энэ төсвийн тодотголоор 6 их наяд төгрөг болгоод. Ерөөсөө зөвхөн уул уурхайгаас хамааралтай ийм орон болгож хувиргаад л.

Тэгээд тэндээсээ нэг жоохон орлого олонгуут нь ингээд л бүх юмыг цалин, тэтгэвэр лүү нэмээд тэгээд зах зээл рүү оруулаад. Түүнээсээ үүдээд инфляц бий болоод байгааг.

Ерөөсөө түүнийгээ удирдаж ерөөсөө чадахгүй.

Та нарын төсөв, мөнгөний бодлого чинь гол нь л үнийн өсөлтийг хазаарлан барихад л чиглэгдсэн байх ёстой шүү дээ.

Гэтэл тэр тал дээр ерөөсөө арга хэмжээ ерөөсөө авахгүй байгаа юм. Тэгээд бүх буруу юмыг ерөөсөө ингээд л нэг тийм. Өөрсдөө ямар ч буруугүй юм шиг асуудалд ханддаг зүйлээ ер нь хэзээ болих юм бэ.

Одоо орж ирж байгаа, төсвийн тодотгол хийж байгаа үндсэн шалтгаан нүүрснээс орж ирж байгаа орлого 54 хувиар өссөн. Дээрээс нь инфляцын татвар буюу барааны үнийн өсөлтөөс орж ирж байгаа татвар 34 хувь нэмэгдсэнээс шалтгаалж л энэ төсвийн тодотголыг хийж байгаа шүү дээ.

Хувийн хэвшлүүд сайжраад, түүнээсээ болоод төсвийн тодотголыг хийж байгаа юм ерөөсөө байхгүй байгаа.

Тэгээд Д.Ганбат гишүүн юм асуухаар яагаад ингээд дээрэлхээд байдаг юм бэ. Зөв л юм ярьж байна лээ шүү дээ.

Нэг тийм, та нарын олон жил төр бариад, эрх бариад яваад, бүр дарга байсан энэ зан чанар чинь янз янзын асуулт хариулт дээр муухай илрэх юм.

Ер нь ард түмэн та нарын нэг хэмжээнд нь барих цаг болохоосоо, бүр болдгоосоо бүр хугацаа нь хэтрээд өнгөрчихсөн байна шүү. Аан.

Энэ сайд нар нь хашхираад үг хэлүүлэхгүй юм байна. Болилоо.

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт 6 дугаар зүйлийг 6.1 бодлоготой ямар ч холбоогүй л санал хэллээ.

Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

51.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр хавсралтаар” гэснийг “энэ хуулийн хавсралтаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

68.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Манай С.Амарсайхан сайд ирсэн байна.

Төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлнэ.

Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье.

6 дугаар сарын 13-нд Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан Ишбалын Сайнбуян, Зулын Цэвээн нарын 8 дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайханд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Ээжид нь бас давхар баярын мэнд хүргэе. Зулын Цэвээн гуайд.

Одоо дараагийн санал хураалтыг явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага болох Шадар сайдын ажлын албаны урсгал төсвийн гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, шалгах зардлын ангилал дахь хөрөнгийн эх үүсвэрээс 1,600.0 сая төгрөгийг Онцгой байдлын ерөнхий газрын багаж, техник, хэрэгслийн зардалд 1,000.0 сая төгрөг, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны зардал 600.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр шилжүүлэх.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир.

Сайнбуянгийн Амарсайхан Шадар сайд, Улсын Их Хурлын гишүүн.

Ашиг сонирхлын зөрчилтэй боловч төрсөн өдөр нь учраас үг өглөө.

С.Амарсайхан: Тийм. Салбартаа шийдүүлээд авчихъя даа.

Энэ гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг арилгахтай холбоотой Шадар сайдын багц дээр гэж 2023 оны төсөв дээр туссан 1.6 тэрбум төгрөгийг Хэрэг эрхлэх дээр тавьчихсан байсан юм.

Тэгээд үүнийг Онцгой байдлын ерөнхий газар луу шилжүүлж, энэ зуны үер, бороо ус, болзошгүй гамшгийн эрсдэлд зайлшгүй зарцуулах асуудлыг тэр мэргэжлийн байгууллагууд нь шилжүүлбэ гэж ийм санал гаргасан юм.

Тийм учраас энэ Байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжихгүй байх дээр санал хураалгаж өгөөч ээ гэсэн санал гаргаж байгаа юм.

Их Хурлын дарга аа. Тийм.

Г.Занданшатар: Санал хураалт.

Санал хураалтад 51 гишүүн оролцож, 22 гишүүн дэмжиж, 29 гишүүн татгалзаж, Цэндийн Сандаг-Очир гишүүний санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй гэсэн үг.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын “Х. 1.1.260.Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Мөрөн сум, Титэм сургууль/, төсөвт өртөг 9, 673.3 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 340.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Ш.1.24.Багийн хөгжлийг дэмжих

хөтөлбөр /Хөвсгөл, Ховд/ төсөвт өртөг 3,611.3 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 2,711.3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүн 340.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, уг төсөл, арга хэмжээний эдийн засгийн ангилалд “тоног төхөөрөмж” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Баттогтохын Чойжилсүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт.

Одоо бол болно. Одоо ингээд Байнгын хорооны саналаа дэмжицгээнэ.

Түрүүчийнх төсөвт өртөг нэмэгдүүлээгүй. Энэ дотроо гүйж байсан. Энэ чинь төсөвт өртгийг хасаж, нэмээд энэ ТЭЗҮ-гээс нь хасаад.

Түрүүчийнх онцгой байдлын шаардлага гээд ингээд хүмүүс нэмсэн байж магадгүй.

Тэгээд энэ Засгийн газар дээрээ яагаад яриагүй юм тэгвэл. Санал хураалт явуулъя. Ямар ч байсан. Санал хураалтаар л ярь.

Байнгын хорооныхоо саналыг дэмжээд явъя л гэж байгаа юм байна. Ц.Сандаг-Очир гишүүн дараа нь саналаа татчих байлгүй дээ. Өмнөх саналыг.

Санал хураалт. /алх цохив/

Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмаа дагавал Ц.Сандаг-Очир гишүүн саналаа татчихвал болж байна.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “ХШ.3.3.Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Баянхонгор, Булган,

Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “Хөвсгөл” гэснийг “Говь-Алтай” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан.

Байнгын хорооны саналаа дэмжихгүй бол энэ Хөвсгөлийн гишүүдээс нь асуугаагүй.

Санал хураалт. /алх цохив/

Дэмжих юм байна. Хөвсгөлийн гишүүдийн. Энэ бол төсөв задалж байгаа л юм байна гэж ойлголоо.

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын “IX.1.112.Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийн “өргөн чөлөөний” гэсний дараа “болон төв гудамжнуудын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа.

Энэ үг нэмж болохгүй. С.Одонтуяа гишүүн татчих аа. Санал хураалт. /алх цохив/

Та нар тэр нэгдүгээр санал хураалт дээрээ хэлэхгүй юү. Энэ чинь ингээд Засгийн газрын байр суурь л гэж Шадар сайд хэлэхээр ойлгоно шүү дээ.

Цэндийн Сандаг-Очир гишүүн санал гаргаад л, гишүүд дэмжээд л. Тэр үедээ хэлэхгүй. Тэгээд санал хураалт өнгөрсөн хойно нь. Тэр чинь дэмжсэн, дэмжээгүй үгийг тэр үед нь л хэлж байх хэрэгтэй.

62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын “X.1.1.65.Сургуулийн барилга, 720 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2019-2023, төсөвт өртөг 7,593.9 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,086.3 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн төсөвт өртөг “7,593.9 сая төгрөг” гэснийг “10,246.9 сая төгрөг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Эхнийхээ асуудлыг тэр Төсвийн байнгын хороон дээр ахиж яриад. Танхимын зарчмаар шийдэхгүй.

Сая гэнэдүүлсэн байсан юм. Тайлбар байхгүй л дээ. Одоо санал хураалт явуулаад дуусчихсан. Одоо сайд нар Засгийн газар дээрээ ярь. Тийм.

Сая ингээд Засгийн газрын санал юм шиг ойлгогдоод л, гэнэтийн, онцгой байдлын юм гээд оруулчихлаа шүү дээ. Хэрвээ зарчимгүй байсан юм бол энэ саналаа нэг бол тат, нэг бол дахиж

горимын саналаар дахиж санал хураалт явуулъя.

Сайд нар танхимын зарчмаар ажиллах ёстой шүү. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Татахгүй бол би Ч.Хүрэлбаатар гишүүнд үг өгөөд горимын саналаар дахиж санал хураалт явуулна.

Засаг дээрээ ярих ёстой байхгүй юу. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн горимын санал хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: Үгүй үгүй. Энэ зарчимгүй юм болоод байгаа учраас үг авч байгаа юм.

Энэ төсвийн тодотгол дээр зөвхөн цалин, хүүхдийн мөнгө, тэтгэврийг оруулж ирж байгаа.

Улаанбаатар хотын түгжрэл гээд тус тусдаа салангид байгаа замыг холбож дуусгаж Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах чиглэлийн хөрөнгө оруулалтыг нийслэл дээр тавигдсан ийм л төсвийн хөрөнгө оруулалт.

Гэтэл одоо Улсын Их Хурлын гишүүд маань энэ дээр бүгдээрээ тэвчээртэй байж, бүгдэд нь тойрог, тойрог дээр нь асуудал байгаад байхад Засгийн газрын хоёр гишүүний хоорондын төсөв, мөнгө шилжүүлэх тухай асуудал гаргаад тэр санал нь Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй.

Энэ дээр дэмжигдчихэж байна.

Би энэ дээр юу гэж хэлэх гэж байгаа юм бэ гэхээр Засгийн газрын гишүүд маань хариуцлагатай байх хэрэгтэй. Гишүүдээ хүндэтгэх хэрэгтэй. Гишүүд маань орж ирсэн бүх саналыг

бүгдэд нь хүндэтгэлтэй хандаад янз бүрийн санал гаргаагүй. Гаргасан цөөхөн саналыг бүгдийг нь унагаасан.

Тэгэхээр энэ саналыг Ц.Сандаг-Очир гишүүн татаад авчих. С.Амарсайхан сайд та татуул, нэг бол. Үгүй бол би горимын санал гаргаж байна.

Ц.Сандаг-Очир гишүүний санал дээр дахин санал хураалт явуулж өг. Хэдүүлээ зарчим баривал барьсан шиг бариад явъя. Барихгүй бол Улсын Их Хурлын чинь нэр хүнд хаа сайгүй унадаг, Засгийн газрын сайд нарын ч гэсэн нэр хүнд унана шүү дээ.

Хэдүүлээ зарчим барьж байгаа бол барьсан шиг бариад дуустал явах хэрэгтэй. Зарчимгүй явъя гэж байгаа бол зарчимгүй байдгаараа байя. Тэгээд ард түмнээр дүнгээ тавиулъя.

Тэгэхээр би энэ дээр зарчмаа барья.

Тийм учраас саналаа татах хэрэгтэй. С.Амарсайхан сайд. Энд тэндхийн сайд нарын төсөв дээр илүү мөнгө байгаа юм бол зүгээр хас, зардлаа бууруулъя.

Нэг сайд дээр нь илүү мөнгө байгаад нөгөө сайд нь авах гэж байгаа юм бол тийм юм хэрэггүй. Зүгээр тэр мөнгийг нь хасчих. Б.Жавхлан сайд аа. Санал гаргаад.

Г.Занданшатар: Энэ зарчмын асуудал бөгөөд. Сая санал хураалт дээр онцгой байдал, онцгой нөхцөл байдал үүссэн гэсэн агуулгаар. Тэгээд бусад сайд нар хэлээгүй учраас үүнийг ингээд дэмжигдээд явчихсан гэж ойлгож байна.

Ингээд Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд

нарын байр суурь ийм байгаа учраас Засгийн газарт танхимын зарчмаар ажиллах ёстой.

Нэн ялангуяа төсөв дээр танхимын зарчим баримтлах ёстой.

Бүх гишүүд яг ийм зарчим баримталж байгаа учраас одоо хоёр Шадар сайд энд Их Хурлын танхимд мэтгэлцэхгүй ээ, ярихгүй ээ.

Цэндийн Сандаг-Очир гишүүн татаад авчих. Би ингээд татаад авсанд тооцлоо. Зарчмаа барья. Тэгэх үү? Үг байхгүй.

Одоо горимын саналаар. Цэндийн Сандаг-Очир гишүүн. Үг өгвөл Ц.Сандаг-Очир гишүүн л өгнө. Та энд санал гаргаагүй юм чинь. Түүрүүн үг хэлчихсэн. Одоо болсон.

Цэндийн Сандаг-Очир гишүүн. Нөхцөл байдлыг харгалзан үзээд та энэ саналдаа.

Ц.Сандаг-Очир: Надад Шадар сайдын ажлын албанаас Хэрэг эрхлэх газар дээр анхнаасаа буруу тавигдчихсан байна гэж ойлгуулсан.

Тэгээд энэ зардал бол ямар нэг төсөв дээр зардал нэмэгдэхгүй. Байгалийн аливаа гамшиг, эрсдэл, ослоос урьдчилан сэргийлэх энэ чиглэлийн зардал.

Тэгээд Хэрэг эрхлэх газраас гарч болохгүй байна. Чиг үүрэг нь болохоор Онцгой байдлын ерөнхий газар дээр байж байж гарах ёстой.

Тэгээд Хэрэг эрхлэх газар дээрээс гарч болохгүй болчхоод байна.

Тийм учраас энэ зардал юм нь гарч болохгүй байгаа учраас ангиллыг нь хооронд нь зохицуулалт хийх л байгаа юм гэж ойлгуулж надаар санал гаргуулсан шүү дээ.

Энэ чинь өчигдөр л гэхэд баруун аймгуудын зарим сумаар байгалийн гамшиг, үер ус гараад л яваа юм билээ шүү.

Тэгээд түүнд шаардлагатай хөрөнгө оруулалт юмнуудыг нь яах юм. Цаашдаа юу гарахыг яаж мэдэх юм.

Г.Занданшатар: Ингээд Ц.Сандаг-Очир гишүүний ойлголт зөрүүтэй байсан учраас саналаа буцааж татаж авлаа гэж ойлголоо. Тийм ээ.

Эцсийн хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хороон дээр үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Саналыг татаж авсан гэж ойлголоо.

Яг ийм тодорхой асуудлууд байгаа бол Засгийн газар танхимын зарчмаар саналаа нэгтгэ.

Энд сайд нар хоорондоо хэрэлдээд баймааргүй байна. Сайд нар хариуцлагатай баймаар байна. Анхнаасаа оруулж ирэхдээ.

Энд Их Хурлын танхимыг сайд нарын маргааны танхим болгохгүй.

Энэ асуудлыг татаж авсанд тооцлоо. Буруу ойлголцол болсон байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр үүнийгээ янзал.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр

Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд

/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ (үргэлжлэл)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023 оны 4 сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд

өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед санал хурааж дэмжигдсэн нэгтгэсэн төслийн талаарх зарим зарчмын зөрүүтэй саналын томъёолол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдсөн эсэх, хэрхэн нийцүүлэх, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийг дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай шийдвэрийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газар 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлснийг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн, Хууль тогтоох хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 14, 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 6 санал, 42 дугаар зүйлийн 2.2.2-т заасны дагуу гаргасан хууль зүйн дүгнэлттэй холбоотой боловсруулсан 3 саналаар санал хураасан бол хуулийн нэгтгэсэн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагагүй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул мөн зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан 3 саналаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 42 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж, 41 дүгээр зүйлийн зарим

хэсгийг хасах, өөрчлөх, бэхэн тэмдэглэгээ хийхтэй холбогдсон зарим зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан 66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг хасах, нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзах, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байх, цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байх, нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчдээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглох зэрэг нийт 13 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийн талаарх 10 дахь зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон төслийн 1 дүгээр зүйлийн 30 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгээр Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дахин хэлэлцүүлж томъёолох шаардлагатай гэж үзсэн бөгөөд тус асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан дэгийн дагуу Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй 2 саналын томъёоллыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь, Ц.Мөнх-Оргил нар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ш.Адъяаа гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдийн Адъяаа гишүүнээр тасаллаа.

18.00 цаг өнгөрсөн учраас чуулганыг сонгож хуралдуулья гэсэн саналтай байна. Гишүүд дэмжих үү?

Ингээд олонхын саналаар сунгалаа. /алх цохив/

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн дэмжиж байгаа юм байна. Тогмидын Доржханд гишүүн.

Одоо тэгээд алд бие минь алжаавал алжаатугай, ахуй төр минь бүү алдартугай гээд энд бичээстэй байна шүү. Энэ дээр.

Одоо ингээд асуултаа асууцгаая. Х.Булгантуяа гишүүнээр тасаллаа. Одоо болно. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн. Х.Булгантуяа, Б.Жаргалмаа гишүүн хоёр түрүүн гар өргөсөн. Одоо ингээд бие биеийгээ дагаад юу яагаад байхгүй.

Төсвийн байнгын хороо одоо хуралдана. “Б” танхимд.

Д.Өнөрболор: Дарга аа, минутаа эхнээсээ авъя.

Г.Занданшатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнийг эхнээс нь эхлүүлъя.

Д.Өнөрболор: Миний хувьд удаа дараа Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлт, улс төрийн намын тухай болон сонгуулийн энэ хууль гурвуулаа багцлагдаж орж ирж байж л үндсэн энэ улс төрийн суурь тогтолцоо шинэчлэгдэнэ. Улс орны цаашдын хөгжилд ч гэсэн ач холбогдлоо өгнө гэдгийг удаа дараа одоо илэрхийлээд байгаа.

Тэгээд энэ Улс төрийн намын тухай хууль ер нь яг ямар шатдаа яваа юм бэ? Ер нь хэзээ хэлэлцүүлэгт бэлэн болох юм бэ гэж асууя.

Монгол Улсын иргэн энэ төрийн үйл хэрэгт төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулж шууд оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Ардчиллын үнэт зүйл бол сонгууль гэж.

Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийг түүхэн өөрчлөлт гэж нэрлэж байгаагаа үнэхээр амилуулах эсэх нь яг энэ сонгуулийн хуулийн өөрчлөлтөөр л шийдэгдэх ёстой.

Гэтэл Сонгуулийн хуулийн одоо орж ирж байгаа энэ төслөөр харах юм бол голдуу зохион байгуулалттай холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийг ер нь голдуу энэ агуулгаар оруулж ирсэн байна. Зохицуулах байдлаар.

Тэгэхээр нөгөө л тэгш бус байдал, энэ авилга, хээл хахууль, мөнгөнөөс хамааралтай сонгууль гээд тийм ээ, энэ байдал засагдахааргүй ингэж ойлгогдохоор ийм нөхцөл байдалтай байна.

Тэгээд энэ хуулиар нэр дэвшигчдэд тавигдах шалгуур. Тэр дундаа энэ жагсаалтыг эрэмбэлэхэд нам, эвсэлд тавигдах шаардлага, энэ жагсаалт нээлттэй байх ёстой. Энэ жагсаалтад ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэшсэн ур чадвартай төлөөлөгч сонгох боломжийг ард иргэдэд олгох ёс ёстой гэж бодож байна.

Тэгэхээр энэ болгон сонгуулийн хуулийн бодит хэмжүүр байх ёстой. Одоо ялангуяа манай намын дарга нар нийгмийн шударга бустай тэмцэж байна. Ард түмний мэдэх эрхийг хүндэтгэж байна. Ийм зам гаргаж байгаа яг энэ цаг үед нэр дэвшигч бүр нээлттэй шүүгдэх ёстой. Нийгэмд бүр анхнаасаа нээлттэй байхаар хуульчлах ёстой гэж үзэж байна.

Ер нь эрх мэдэлтэй, мөнгөтэй, мөн олон дам шалтгаанаар нэр муутай, ёс зүйгүй, ард түмнийг төлөөлөх эрхгүйо ийм төлөөлөл намуудаас дэмжигдээд Улсын Их Хуралд орж ирэх нь гэдэг сонгогч түмэн, ард олны сэрэмжлэлийг, ард түмний итгэл үнэмшлийн дархлааг бид өнөөдөр хангаж өгөх үүрэгтэй гэж үзэж байна.

Тийм учраас өнөөдөр ард түмэн, төрийн хоорондох итгэлцэл нэлээн ан цав үүсчихсэн байж байгаа энэ тохиолдолд ард түмэн хэнд итгэх вэ гэдэг асуулт бодомжид анхнаасаа нээлттэй хандаж, тэдний төлөөллийг хянах, шинжих. Тийм ээ. Сонгох, батлах энэ бүх эрхэд нь халдалгүйгээр нэн нээлттэй бодлогыг яг энэ шинэчлэлийн түүхийн яг энэ гараан дээр тод үзүүлэх хэрэгтэй байна.

Оюун дүгнэлтээ хийх энэ өндөр боломжийг энэ хуулиар бид нар хангах ёстой байна гэж үзэж байна.

Тэгээд энэ нээлттэй ийм итгэлцлийн алхмуудыг хийснээр өнөөдөр төр, ард иргэдийн итгэлцэл сэргэх бас нэг гол алхмын нэг хэсэг болно.

Тийм учраас ард иргэд ч ийм хүлээлттэй байгаа. Энэ зохицуулалтыг ч гэсэн ард иргэд шаардаж байгаа.

Тийм учраас дарга нар энэ тал дээр ойлгох нь чухал байна. Тэгэхээр ажлын хэсгийнхэн маань энэ асуудлыг яг хуульчлах тал дээр нь анхаарлаа хандуулаач ээ гэдэг ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ.

Бадарчийн Жаргалмаа гишүүн нэмэх гэсэн. Карт чинь сугалаастай байгаад байна. Картаа гүйцээчих. П.Анужин гишүүн хоёрыг нэмье.

Бадарчийн Жаргалмаа гишүүн юу яагаад байна шүү. Картаа сугалчхаад кноп дарахгүй байгаад байх юм. Тэгэхээр кноп чинь орохгүй байгаа юм. П.Анужин гишүүнийх ч гэсэн. П.Анужин гишүүнийх нэмэгдсэн. Бадарчийн Жаргалмаа, П.Анужин гишүүн хоёрыг нэмсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн хариулна.

Улс төрийн намын тухай хуультай яаж уялдаж байгаа вэ?

Н.Энхболд: Улс төрийн намын тухай хууль Ерөнхийлөгч өргөн мэдүүлчихсэн байгаа. Анхны хэлэлцүүлгээ хийчихсэн. Ажлын хэсэг томилогдчихсон ажиллаж байгаа. Ахлагчаар нь Д.Тогтохсүрэн гишүүн ажиллаж байгаа.

Бидний ярьснаар ер нь ажлын хэсэг өнөөдөр ингээд Сонгуулийн хууль ерөнхийдөө эцэслэгдчихвэл. Д.Тогтохсүрэн дарга бид хоёр ярьсан.

Маргаашаас ажлын хэсэг хуралдана. Магадгүй хагас сайн, бүтэн сайнд ярьж магадгүй.

Нэг дэх өдөр ажлын хэсгээс гарсан анхны саналуудыг бас улс төрийн намуудын хүрээнд хэлэлцүүлье гэж бодож бэлдээд байгаа.

Тэгээд дахиж ажлын хэсэг хуралдаад Байнгын хороонд оруулна. Ингээд хоёр шаттайгаар хэлэлцээд явна.

Байнгын хороодоос гаргасан хуралдааны цаглавараар ер нь энэ хаврын чуулганаараа Улс төрийн намын хуулиа батална гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа.

Сонгуулийн хууль яаж гарахаас Улс төрийн намын тухай хуулийг хэлэлцэх үед анхаарах зүйлүүд нь бас давхар гарах ёстой. Тэгээд сонгуулийн хууль, намын хууль, тэн дотроо санхүүжилттэй холбоотой асуудал Үндсэн хуулийн өөрчлөлт гурав нийлээд ингэж багцаараа ажиллаж байж үр дүн нь гарна гэсэн таны байр суурьтай нэг байр суурьтай байна.

Тийм учраас аль болохоор хоорондоо уялдаа холбоо сайтай Үндсэн хуульд орсон өөрчлөлтийнхөө тавьсан зорилгыг биелүүлэх хэмжээнд энэ асуудлууд яригдана. Яригдаж яваа гэж ойлгож байгаа.

Ер нь Улс төрийн намын хууль дээр таны яриад байгаа зүйл ихэнх нь орно.

Түрүүн асуусан. Ер нь анхнаасаа нэрээ дэвшүүлэхдээ яах ёстой юм. Сонгуулийн хуульд орсон зүйл юу байна гэсэн утгаар асуусан гэж бодлоо.

Бид намууд нэрээ дэвшүүлэхдээ ийм ийм зарчмуудыг баримтална гэж түрүүчийн хэлэлцүүлгээр оруулсан. Гишүүд яриад санал хуваагдаж байсан. Яг үнэнийг хэлэхэд.

Нэг хэсэг нь үүнийг сонгуулийн хуульд оруулах хэрэг байна уу, үгүй юу. Намынхаа хуулиар явбал яасан юм гээд. Нөгөө хэсэг нь байх ёстой гээд.

Тэгээд бид ямар ч байсан ярьж байгаад ер нь хуулиудыг хэлэлцэж байх үед хүмүүсийн гар гаргаж байсан санал үнэхээр бүх л хуульдаа энэ намуудад зөв хүмүүсээ дэмжүүлэх шаардлага, шалгууруудыг нь зааж өгч байх ёстой. Ялангуяа сонгуулийн хуульд байхад илүүдэхгүй гэсэн саналууд их гарчихсан байсан учраас.

Сая анхны хэлэлцүүлгийн дараа ажлын хэсэг дээрээ Байнгын хороогоор хэлэлцээд шууд баримтална гэхээр бас тодорхойгүй зүйлүүд их том тунхагийн чанартай юмнууд орчхоод байх юм.

Тэгэхээр гол зүйлүүдээ намуудын тухай хуулиар хийнэ.

Ер нь харгалзах ёстой гэдгийг нь зааж өгье гээд одоо санал хураах томъёолол дотор “харгалзана” гээд үгээр гарчихсан явж байгаа. Тийм.

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүний хэлж байгаа тэр Үндсэн хуулийн 19.3-д орсон намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, ардчилсан зарчимд нийцсэн дотоод зохион байгуулалт, дотоод ардчилалтай байна гэж байгаа юм.

Хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэсэн. Үүнийг баримталж ажиллаарай л гэж хэлж байгаа юм байна.

Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийгээд үүнийхээ дагуу Сонгуулийн хуулийг бид ярилцаж байна гэж ойлгож байгаа.

Гэтэл энэ Сонгуулийн хуулиараа та нар юу болгоод байна аа? Тэр дэгийн хууль байхгүй ч гэнэ үү. Хууль нь байхгүй юмыг та нар тэгээд л өөрсдөө тэнд хутгаад л. Энэ Төрийн байгуулалтын байнгын хороо, тэр ажлын хэсэг чинь ямар хачин заваан юм хийгээд байна.

Тэгээд бүх юмыг хуульчилж байна гээд. Заавал Монгол Ардын нам л ялах ёстой юм шиг тийм сонгуулийн хуулийг хийгээд байх юм. Боль л доо тэрийгээ.

Одоо нөхөн сонгууль хэзээ явагдах юм? Тэр Архангай аймаг дээр нэг төлөөлөл нь байхгүй л байгаа шүү дээ. Нэлээн хэдэн сар болчихлоо. Одоо аягүй бол жил дутуу гээд л тэр нөхөн сонгуулиа хийхгүй явах юм байгаа биз.

Үүнийг би Сонгуулийн ерөнхий хорооноос асууя.

Нөгөө талаар жилээс жилд сонгогчдын тоо багасаж байгаа. 2008 оны 7 сарын 01-нд сонгуульд үр дүнд нь дургүйцлээ илэрхийлсэн иргэд жагсаж байсан.

Тэгээд дараа нь юу гэсэн гэхээр сонгуульд оролцоогүй иргэд энэ үймээнийг гаргасан байна гээд л. Тийм зүйл яриад л өнгөрсөн.

Тэгэхээр жилээс жилд багасаад байгаа энэ сонгогчдынхоо ирцийг яах юм бэ? Энэ талаар сонгогчдоо оролцуулах. Энэ чинь төр засагтаа итгэхээ байчихсан, сонгуулийг нь үнэн зөв гаргана гэдэгт найдахгүй ийм болохоор сонгогчид оролцохгүй байгаа шүү дээ.

Анх 1992 онд Ардчилсан нам ялдаг ийм үед 80, 90 хувьтай сонгуульд ордог байсан. Одоо хамгийн сүүлд 60 байна уу. Нөхөн сонгууль 50 хүрэхгүй ирцтэй орсон шүү дээ. Ийм л байгаа.

Үүнийг дээшлүүлэх талаар ямар арга хэмжээ авч байгаа вэ? Үүнийг асууя.

Дараа нь, эмэгтэйчүүдээр та нар их тоглож байна. Нэг 40 хувь, нэг 50 хувь, нэг 30 хувь гээд л.

Заавал та нарт таалагдсан шийдвэр гаргах ёстой юм уу? Улсын Их Хурал. Гаргахгүй болохоор буцаагаад л.

Энэ Н.Энхболд дарга, Н.Энхболд гуай одоо тэнд юу ч найруулаад байдаг юм. Тэгээд энэ хүний нэрийг үгүй мөн их ашиглаж байна даа. Тэгээд ийм хутгасан, заваарсан юм ахиад л оруулж ирээд л байдаг.

Заавал та нар ялах ёстой юм уу?

Тэр нам болгон өөр өөрөө. Заавал Монгол Ардын нам шиг адилхан байх албагүй. Та нар баахан дагуул намтай болохын тулд танай Монгол Ардын нам чинь бас бусад улсын дагуул болж байгаа. Тэр тал руу аягүй эрсдэлтэй байгаа. Тийм юм руу энэ сонгуулийн хууль чинь явуулах нь. Энэ намын хууль чинь. Та нарын энэ байдлаараа бол.

5 жил, 10 жилийн цаадхаа хар гэдгийг бас анхааруулмаар байна.

Нөгөө талаар намын жагсаалтыг хийхэд Та нарын нэр хүнд байхгүй болчихжээ. Монгол Ардын намд жагсаад байхаар эрэгтэй хүн ч байхгүй болчихсон юм шиг байна.

Тэгээд морь унасан толгойгүй хүн шиг хэдэн эмэгтэй хүмүүсийг оруулж ирээд л тэгээд үелээд явах юм гэнэ. Энэ чинь одоо юу вэ? Одоо нэг эрэгтэй, нэг эмэгтэй гэх юм уу.

Зарим газар хоёр эмэгтэй яваад нэг эрэгтэй явъя л даа. Тэгж хуульчил л даа. Та нар.

Дэлхийн хаана ч байхгүй юмыг хуульчлаад шахаад байх юм.

Тэгээд энэ Засгийн газар нь үлгэр жишээ үзүүл л дээ. Одоо баахан Засгийн газрын хэрүүл энэ Улсын Их Хурал дээр орж ирдэг болсон. Аль нь Их Хурал юм, аль нь Засгийн газар юм. Мэдэгдэхээ байчихсан.

Одоо энэ хэлтэй амтай байгаа, хариуцлагагүй олон танхимын биш ажилладаг гишүүдээ солиод 50 хувийг нь эмэгтэй сайд болго л доо. Тэрүүгээрээ харуул л даа. Боломж нь та нарт байна шүү дээ. Үзүүл тэрийгээ.

Тэгэхгүй тэгээд поп поп юм яриад л яваад байдаг. Тэгээд амьдрал дээр тэр нь ерөөсөө үр дүн байхгүй. Явж явж баахан цаг хугацаа үрж үрж байгаад л эргээд л эсрэг ийм хууль болгодог.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн хариулъя. Байнгын хороо.

Н.Энхболд: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Дэг зөрчсөн юм байхгүй ээ, Д.Ганбат гишүүн ээ.

Ер нь амьдрал баян болохоор аливаа асуудлыг хэлэлцэж байх явцад бас тодорхой хэмжээгээр зохицуулагдаагүй зүйлүүд гарч ирдэг. Тэрийг ч ер нь дэгийн тухай хуулийг анх боловсруулж батлахдаа, өчнөөн олон жил мөрдөж ирэхдээ харж үзээд яг хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудал гараад ирвэл яаж хэлэлцэж байх вэ гэдэг ийм зүйлийг дэгийн тухай хуульд оруулчихсан байж байгаа. 5 дугаар зүйл дээр нь байгаа.

Тэгээд өнөөдөр яагаад энэ асуудал дэгийг дахиж хөндөж ярих хэрэг болов гэхээр яг хоёрдугаар хэлэлцүүлгээр яриад, Байнгын хороон дээр санал хураахдаа Их Хурлын чуулганаар

анхдугаар хэлэлцүүлгээр хэлэлцсэн зүйлүүдийнхээ дагуу хураагаад Байнгын хороо үндсэндээ саналаа хураагаад шийдвэрээ гаргаад танилцуулахын өмнө дахиад нөхцөл байдал үүссэн учраас үүнийг яаж хэлэлцэх вэ гэдэг асуудлыг яриад.

Тэгээд яг энэ тохиолдолд ингэж ингэж зохицуулсан тусгайлан заасан зүйл, заалт байхгүй байгаа юм.

Тэгэхээр дэгийн тухай хуулийнхаа 5 дугаар зүйлийг бариад. Өөрөөр хэлбэл хуулийнхаа дотор байгаа заалтыг ашиглаад Улсын Их Хуралд Байнгын хорооноос саналаа оруулаад Улсын Их Хурал дэмжээд, дэмжсэн тэр чигээр нь хэлэлцээд оруулж болдог энэ хуулийн заалт энэ дагуу явж байгаа.

Энэ дээр хууль зөрчсөн зүйл байхгүй.

Ганцхан Ардын намыг ялуулах гээд энэ хуулийг хийгээд байгаа юм биш ээ. Энэ анхнаасаа Ардын намын 4 гишүүн, Ардчилсан намын 2 гишүүн, түүний дотор та өөрөө ороод хийсэн ийм хоёр хуулийн хуулийн төслийг Их Хурал ярьж байгаад нэгтгээд хэлэлцээд аль альнаас нь орсон зүйлүүд нь үндсэндээ олон зүйл давхцаж байсан. Тэрийгээ найруулж нэгтгээд аль аль хуулиасаа орох ёстой зүйлүүд вэ гэсэн юмыг ингээд хамтруулаад яг хамт хэлэлцээд л явж байгаа ийм хууль.

Тэгэхээр үүнийг зөвхөн Ардын нам ялах гээд өөртөө зориулаад хийгээд байгаа хууль гэж ойлгож болохгүй.

Бид нарын хоёр талаасаа барьсан хоёр хууль хамтраад гарч байгаа хууль шүү гэдгийг хэлье.

Ирцтэй холбоотой асуудал гарч байна. Янз бүр л байдаг юм. Улс орон болгон.

Хамгийн ардчиллын үлгэр жишээ болж явдаг улсууд хүртэл ерөөсөө ХХ зуун, ХХI зууны сүүлийн үеийн хандлага юм уу гэж бодмоор. Ирц нь ингээд буураад байдаг маягтай олон жишээнүүд байдаг.

Зарим газар заавал оролцох ёстой. Орохгүй бол мөнгө төлдөг хүртэл ийм зохицуулалттай газрууд бий. Тэгэхдээ манайд ийм зохицуулалт байхгүй. Бид явж ирсэн практикаараа явж байгаа.

50 хувь хүрэхгүй бол харин сонгууль хүчингүй болдог тогтолцоо сүүлийн олон сонгуулиудаар мөрдөгдөж ирсэн. Та бас үүнийг мэдэж байгаа.

Эмэгтэйчүүдийн квотын асуудлыг ч гэсэн энэ ч ганцхан Ардын нам л ялах гээд л, нэг бууруулаад л, нэг ихэсгээд л, дахиж бууруулаад л яваад байгаа асуудал биш ээ.

Хууль санаачлагчид. Тухайлбал, бидний санаачилсан хууль дээр өмнөх хуулиудаар нэр дэвшигчдийн 20 хүртэл хувь нь нэг хүйсийн төлөөлөл байх ийм заалттай. Тэр дагуу бид сонгуулиа явуулж ирсэн.

Бид өргөн мэдүүлэхтээ 30 гэж болгосон. 10 хувиар. Бас 4 жилийн хугацаан дотор томоохон өөрчлөлт.

Дахиад ярьж байгаад Байнгын хороон дээр 40 болсон. Эргээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн.

Нямаагийн Энхболд гишүүн гүйцээгээд хариулчихъя. Тэгээд дараа нь тодруулах юм байна. Тийм ээ.

Н.Энхболд: Нөхөн сонгууль явах тухай асуудал одоохондоо Их Хурал дээр яригдаагүй байна.

Энэ Сонгуулийн хууль яаж батлагдсан. Түүнтэй бас тодорхой хэмжээгээр уялдах ёстой. Тийм учраас ингээд өнөөдөр хууль батлагдчихвал тэрний дараа яригдах зүйл байх гэж ингэж бодож байгаа. Энэ Сонгуулийн ерөнхий хорооны шийдээд байх ч асуудал биш. Улсын Их Хурал өөрөө шийдэх ёстой байгаа юм.

Квотын хувьд би сая хэлсэн. Үелээд явна гэдгээр яах вэ, Д.Ганбат гишүүн байр сууриа илэрхийллээ гэж бодлоо. Болно л доо. Хоёр эмэгтэй, нэг эрэгтэй, хоёр эмэгтэй гэж болно. Бидний өргөсөн хууль дээр нэг нэгээр нь явъя гэсэн. Урьд нь байгаагүй хэмжээгээр жагсаалтад эмэгтэйчүүдийнхээ тоог нэмэгдүүлэх ийм үүднээс л бид нар нэг нэгээр гэж явъя гэсэн эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хийсэн заалт байгаа.

Улс оронд янз бүр л байдаг байх. Бид дэвшилт л гэж үзэж байгаа. Тийм.

Г.Занданшатар: Сонгуулийн ерөнхий хороо. П.Дэлгэрнаран дарга. 83 байна уу?

П.Дэлгэрнаран: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нөхөн сонгууль явуулах болон орон гарсан суудлыг нөхөх тухай харилцааг энэ 77 дугаар зүйлээр зааж зохицуулсан байдаг.

Тэгээд Ж.Мөнхбат гишүүний орон гарсантай холбогдуулаад бид энэ суудлыг нөхөх болон нөхөн сонгууль явуулах тухай мэдээллээ Төрийн байгуулалтын байнгын хороо болон Улсын Их Хуралд хугацаанд нь хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулна.

Д.Ганбат: Би ер нь яах вэ аль болохоор л эмэгтэйчүүдийг энэ улс төрийн шийдвэр гаргах энэ юманд аль болохоор сайн оролцоосой л гэж боддог хүний нэг л дээ.

Тэгэхээр миний ойлгож байгаагаар О.Цогтгэрэл гишүүн бид хоёрын өргөн барьсан хуульд 40 гэж байгаа.

Танайх чинь Засгийн газар нь 50 гээд байгаа юм байна гэж ойлгосон. Та нар чинь 30 гээд байгаа юм уу? Хуучин 20 байсан. Яг одоо ямар юман дээр ямар шийдвэр гаргачхаад ирсэн юм бэ? Саяын Төрийн байгуулалтын байнгын хороо, энэ ажлын хэсэг чинь.

Тэгээд ямар шат дунд яаж байгаад ийм болчхов?

Г.Занданшатар: Ажлын хэсэг. Хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулна.

Н.Энхболд: 50, 50 гэсэн хувилбар хаанаас ч орж ирээгүй. Д.Ганбат дарга аа.

Аль ч өргөсөн хуулийн төсөлд 50, 50 гэсэн юм байхгүй. 4 гишүүний өргөн барьсан дээр 30 хүртэл. 30-аас доошгүй гэж байгаа. Түрүүчийнхийг хэлсэн. Түрүүчийн сонгуулиуд 20-иос доошгүй байсан. 30-аас доошгүй болгосон.

О.Цогтгэрэл гишүүн та хоёрын өргөсөн дээр 40 гэж байсан.

Зүгээр тэр жагсаалтад орох гишүүдээ ингээд сөөлжлөөд явна гэдэг 50, 50 гэсэн үг л дээ. Тэр хэвээрээ байж байгаа.

Түүнээс нийт дэвшигчдийн 50-иас доошгүй хувь гэсэн заалт, санал байхгүй. Орж ирээгүй. Ажлын хэсэг дээр ч тийм юм яригдаагүй. Байнгын хороон дээр ч яригдаагүй.

Одоо хамгийн сүүлийн хувилбараар оруулж ирж байгаа саналын томъёоллыг ингээд удахгүй уншаад танилцуулна.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа.

Өнөөдөр Их Хурлаар хэлэлцэж байгаа Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг маш олон охид, хөвгүүд залуучууд, Монголын нийгэм тэр чигээрээ, тэр байтугай саяхан болсон Жендэрийн тэгш байдлын олон улсын чуулган хуралдсан.

Олон улсын байгууллагууд, дэлхий нийт анхааралтай ажиглаж байгаа гэж бодож байна.

Монгол Ардын намын хувьд 100-аад жилийн өмнө Монгол Ардын намын Төв хорооны аппаратад эмэгтэйчүүдийн тасгийг байгуулж Азидаа анх удаа улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн, ардчилсан, социал демократ үзэл баримтлалтай ийм нам байгаа.

Шинэ зууныг авч явж байгаа намын удирдлагууд, намын залуучууд, намын гишүүд ч гэсэн **“Алсын хараа-**

2050” хөгжлийн үзэл баримтлалдаа хүний хөгжлийг гол төвөө болгож, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хүний эрхийг дээдлэх энэ асуудалд бусад улс төрийн хүчнүүдээ манлайлан ажиллаж байгаа гэж харж байгаа.

Өнөөдөр нийгэмд яригдаад байгаа, ялангуяа эмэгтэй гишүүд квотоо нэмэх гэж байна, эмэгтэй гишүүд дараагийн сонгуулиа хийх гэж үүнийг ярьж байна гэдэг асуудлыг би хариуцлагатайгаар өнөөдөр үгүйсгэж байна.

Өнөөдөр энд байгаа эмэгтэй гишүүдийн, өнөөдөр сайд хийж байгаа юм уу, улстөрд байгаа эмэгтэйчүүдийн асуудал ерөөсөө огт биш юм.

Жилийн дараа өнөөдрийн Улсын Их Хурал, Засгийн газар дүнгээ тавиулна. Гишүүд сонгогчдодоо дүнгээ тавиулна. Дараа жилийн сонгуульд нэр дэвших үү, үгүй юу гэдгийг нам өөрөө шийднэ. Нэр дэвшигчдээ тодорхойлно.

Тэгэхээр өнөөдрийн ярьж байгаа энэ асуудал сүүлийн 30 жилийн хөгжилд бид үнэлгээ, дүгнэлт хийгээд эрчүүд давамгайлсан хөгжлийн 30 жилд, ардчиллын 30 жилд бид нийгэм, хүний эрх, эрүүл мэнд, боловсрол, ялангуяа хүний хөгжлийн асуудлуудыг орхиж ирсэн нь жендэрийн тэгш байдал хангагдаагүйтэй холбоотой гэж нэгдүгээрт үзэж байгаа юм.

Хоёрдугаарт, өнөөдрийн гаргаж байгаа жендэрийн эрх тэгш байдал, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжүүлэх гээд оролцоог нь нэмэгдүүлэх гээд байгаа энэ асуудал нь ирээдүйн охид, хөвгүүд, залуучуудын хүйсээр ялгаварлагдахгүй байх, улс орныхоо төлөө ажиллах тэр нийгмийн суурь нь илүү эерэг сайн болох, ийм ялгаварлалгүй, хүйсийн ялгаварлалгүй

ийм улс орныг авч явахад залуучууд маань орж ирэх, ирээдүйн залуучууддаа үндэс суурийг бэлдэж байгаа хөгжил дэвшлийн асуудал юм гэдгийг хэлье.

Тэгээд ер нь сайн яваа эрэгтэйчүүдийн ард дандаа илүү сайн чадвартай эмэгтэйчүүд байдаг.

Өнөөдөр эрх эрхэм Их Хурлын гишүүд Та бүхэндээ хэлэхэд та нарыг маань ч гэсэн өнөөдөр энэ хүчтэй эр хүн болоход ухаалаг ээжийн тэр ухаан нөлөөлсөн гэдэгт эргэлзэхгүй байна.

Эцэст нь Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар даргын хэлсэн энэ ирж яваа цагийг бид нар зогсоох ямар ч арга байхгүй.

Тийм учраас бид 30, 40 гэж ярихаасаа илүү ямар нэгэн байдлаар Үндсэн хуульд заасан, бидний тунхагласан хүйсийн ялгаварлалгүй эрх тэгш хөгжих боломжийг Та бүхэн маань дэмжиж цааш нь авч яваач гэдэг хүсэлтийг Монголын мянга мянган залуучууд, эмэгтэйчүүдийнхээ өмнөөс илэрхийлэн хэлж байна.

Маш их баярлалаа.

Г.Занданшатар: Б.Баярсайхан гишүүн үг хэллээ. Одоо Баагаагийн Батгөмөр гишүүн.

Б.Батгөмөр: Ингээд сонгуулийн хууль батлагдах тал руугаа орж байна.

Тэгээд энэ сонгуулийн хуулийг яагаад сонгуулийн жил, дөрвөн жил тутамд хийдэг вэ гэхээр Үндсэн хууль шиг яагаад ингээд олон удаа хэрэглэгддэг байж болох уу гэхээр зэрэг тухайн тухайн сонгууль яаж явагдав, ямар алдаа байв, ямар дутагдал байв. Тэгээд бүрдсэн парламент маань яаж ажиллав. Дараагийн

юун дээр анхаарах ёстой юм. Энэ зүйлийг л хийх гэж л дөрвөн жил тутамд сонгуулийн хуулийг л ярьж байгаа юм л даа.

Тэгээд энэ удаагийн сонгууль олон намын саналуудыг авсан, маш их олон удаа ярилцлага хийсэн. Урд урдаасаа илүү ололттой болж байгаа байх чинь гэж ойлгож байгаа юм.

Сая манай гишүүдийн ярьж байгаа тэр улс төрийн намуудынхаа хуультай, улс төрийн намын хуультай маш нягт явах ёстой.

Надад нэг ажиглагддаг зүйл юу вэ гэхээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд манай улс төрийн намууд маш их олон улс төрчдийг бэлдсэн байна. Энэ олон улс төрч дундаас төрийн зүтгэлтнүүд гарах ёстой байгаа юм.

Тэгээд энэ төрийн зүтгэлтнүүд ер нь их бага гарсан юм болов уу гэж надад бодогддог юм. Дандаа улс төрчид гардаг. Яах вэ, янз бүрийн улсууд байна.

Тэгээд нөгөө “хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ” гэж үг байдаг. Боломжоос илүү зүйл амладаг. Эдийн засгаа улс төржүүлдэг. Түүнээс болоод эдийн засгийн харилцаа алдагддаг.

Манай өнөөдрийн эдийн засгийн хөгжлийн мухардал үүнтэй холбоотой байгаа.

Тийм учраас үүнийг бид бодох ёстой юм гэж надад ойлгогддог.

Гаднынхан сүүлийн үед бас оролцож байна л даа. Танай сонгууль ийм байх ёстой, пропорционал байх ёстой гээд.

Сингапурын Ерөнхий сайд Ли Куаны нэг хэлсэн үг байдаг шүү дээ. Англи, Франц Улс колони байсан орнууддаа Үндсэн хуулийг нь, сонгуулийн хуулийг нь, хөгжлийн хуулийг нь баталж өгсөн байдаг гэж. Бэлдэж өгсөн байдаг.

Яг тэр замаар яваад хөгжчихсөн улс байдаггүй.

Сингапур Улс яагаад хөгжлийн манлайд хүрсэн гэхээр бид өөрсдийнхөө толгойгоор явсан юм гэж.

Гаднынхны ярьж зөвлөж байгаагаасаа бид авах ёстой юм бий, хаях ч юм бий.

Тийм учраас монгол толгойгоороо гол гол энэ сонгуулийн хууль, хөгжлийн хууль, төсөв, одоо ямар юм байдаг юм бүх юмыг л монгол толгойгоороо л хийж байвал илүү үр дүнтэй болно гэж ойлгож байгаа юм.

Энэ намуудын төлөвшлийн асуудал их чухал. Өнөөдөр парламент гурван суудалтай гурван нам байна. Цаад талд нь 40 нам бүртгэлтэй, 36 үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа юм. Яг өнөөдөр төлөвшсөн тэр баруун, зүүнийхээ үзэл баримтлалаар ялгарч байгаа ийм намууд хэд байна гэхээр байхгүй.

Тийм учраас улс төрийн намын хуулийн шинэчлэл их ач холбогдолтой.

Дараагийн асуудал юу гэхээр сонгуулийн хууль эрэгтэйдээ биш, эмэгтэйдээ биш, эмч багш нартаа биш. Ер нь энэ танхимд, энэ суудалд дандаа манлайлагч нар орж ирэх ёстой.

Төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байгаа хүн дандаа

манлайлагч байх ёстой. Бид манлайлагч болж чадаж байна уу, үгүй юу гээд ингээд үзэхээр бас учир дутагдалтай л байгаа юм.

Энд нэг хэлэх ёстой зүйл сонгогчдын боловсролын асуудал.

Сонгогчид хэр зэрэг зөв сонголт хийнэ тэр хэмжээгээр сайн парламент бүрдэнэ.

Тийм учраас манай Сонгуулийн хороо, Монголын төрөөс энэ үлдэж байгаа нэг жилийн хугацаанд маш сайн сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр, зөв сонголт хийхэд нь туслах ёстой.

Энэ ажил хаягдаад яваад байгаа юм шиг надад санагдаж байгаа юм. Энэ дээрээ анхааръя. Тэгээд ингээд хууль батлагдаад мөрдөгдөнө гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Өнөөдөр уг нь би яриагаа “Ичээч Монголын улс төрчид өө” гэж хэлэх ёстой байсан.

Харин ичих сэтгэлтэй юм байна бас ч гэж. Ард иргэдийнхээ зовлон зүдгүүр, хүсэл сонирхлыг бас сонсдог, ойлгодог учраас 40 хувь гэж оруулж ирж байгаа юм байна. Талархаж байна.

Тэгэхдээ харин яагаад 4 жил хүлээгээрэй гэж байгаа юм бол?

Та нарын авдраас нэг хувьдаа байгаа мөнгөн аягыг чинь бид гуйгаагүй шүү дээ. Монголын төрд эмэгтэйчүүдийн дуу хоолой хамтдаа байгаачээ л гэж байгаа шүү дээ.

Эрчүүдийг бүгдийг нь хөөгөөд гарга гэж хэлээгүй. Бид салаа замын уулзвар дээр байгаа.

Өнгөрсөн 30 жил бид эрчүүд давамгайлсан улс төрөөр явсан. Одоо нөгөө салаа зам нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа шийдвэр гаргаад явъя л гэдэг салаа зам руу орж байгаа.

Салаа замын уулзвар дээр ирвэл явж үзээгүйгээрээ яваарай гэж нэг үг байдаг юм даа.

Тэгэхээр Эзэн Чингис хааны маань хөрөг зураг энд заларсан байна. Энэ танхимд. Чингис хаан монгол ээжээс төрсөн. Төрийн шийдвэрийг гаргахдаа насан туршдаа ээжтэйгээ зөвлөлдсөн. Эмэгтэй хүмүүстэй зөвлөлдсөн. Түүний буруу гэж байхгүй.

Тэгээд яагаад 4 жил хүлээ гэж байгаа юм. Миний асуулт бол 2028 он гэж янаглахаа болиод 2024 оноос байж болох уу л гэж би асууж байгаа юм. Яагаад.

Яагаад хүлээлгэж байгаа юм? Эмэгтэйчүүд бэлэн биш гэж байгаа юм уу? Тэгээд бид бэлэн юм уу? Монголын эрчүүд бэлэн юм уу?

Өнөөдөр Германы ард түмэн А.Меркельд итгэхдээ бэлэн гэж итгэсэн. Боломж өгсөн. М.Тэтчерт Англичууд боломж өгсөн.

Монгол эрчүүд өнөөдөр монгол эмэгтэйчүүдийг яг герман эмэгтэйчүүд шиг сайн авч явж чадаж байгаа юу? Үгүй. Тэдэнд боломж, итгэлийг өгье. Өнөөдрөөс эхлээд. Яагаад өгөхгүй байгаа юм бэ гэдэг миний асуулт.

Хоёрдугаарт, эмэгтэй гишүүд одоо өнөөдөр ингээд л орж ирэхэд л

Б.Жаргалмаа гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр үнэхээр дуу хоолойгоо гаргадаг. Одоо Б.Баярсайхан гишүүн байна. Хүүхдийн хүчирхийлэл. Олон асуудал дээр. Би бүгдийг нь хэлж чадна.

Бидний ойлгодоггүй, бидний мэдэрдэггүй зүйлүүдийг ярьдаг шүү дээ. Хамтдаа улс орноо авч явъя л гэдгийг би хэлж байгаа.

Эрчүүдийг зайлуулья гээгүй. Харин эрчүүд өнөөдөр нэг зүйл байна. Надгүйгээр энэ төр яана аа, бидэнгүйгээр яана аа, энэ хэдэн хүүхнүүд ороод ирвэл ер нь яаж баллах бол гээд бодоод байх шиг байна.

Би ч гэсэн Үйлдвэрчинд байхдаа бас тэгж боддог байсан. Үгүй ээ, энэ Үйлдвэрчин чинь одоо надгүйгээр амаараа шороо үмхэнэ дээ. Үгүй ээ, энэ одоо тэнцэхгүй байх аа. Яана аа. Энэ одоо мөхөндөө. Яана аа.

Хүн тэгж бодоод эхлэх юм бол сэтгэл зүйн өвчин тусаж байна гэсэн үг шүү. Шууд ажлаа өгөх ёстой болж байна гэсэн санаа. Энэ үнэн. Надгүйгээр энэ төр яана гэж бодож л байгаа бол сэтгэл зүйн өвчин тусчихсан байна гэсэн үг.

Тэгэхээр “aristocracy” гэдэг юм л даа. Платоний онол дээр. Элит. Би шилдэг, би онцгой, би энэ төрийг удирдана гэдэг энэ аристократ үзлээсээ салаад бид “democracy” буюу ардчилал, төлөөллийн ардчилал.

Нийгмийн 51.3 хувийг төлөөлж байгаа хүмүүст 40 хувийн дэвших боломж өгье өө л гэж өнөөдөр ярьж байгаа шүү дээ.

Өнөөдөр 1.8 сая эмэгтэйчүүд Монголд хөдөлмөр хийж байна. Хувийн

хэвшлийн 53.2 хувь нь эмэгтэйчүүдийн нуруун дээр явж байна. Тэр зовлон өнөөдөр энэ чуулганд орж ирэх ёстой байна.

Сант Маралын судалгаан дээр гарсан байна. Ер нь эмэгтэйчүүд гэртээ хүүхдээ хараад ингээд гэртээ байх нь зөв. Эрчүүд улс төр хийх нь зөв өө. Энэ санаа бодол зөв үү гэсэн асуулт асуусан байна. 94 хувь нь зөвшөөрөхгүй гэсэн байна.

Монголын ард түмэн өнөөдөр эрэгтэй, эмэгтэй ижил тэгш Монголын улс төр, шийдвэр гаргалтад оролцоод.../минут дуусав/

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хороон дарга Нямаагийн Энхболд хариулна.

Н.Энхболд: Нэгдүгээрт, үүнийг хүн болгон ойлгож байгаа байх.

Энд “эмэгтэйчүүдийг” гэсэн үг байхгүй байгаа. Аливаа “хүйсийн төлөөлөл” гэсэн үг байгаа. Нэгд.

Хоёрт, ер нь хэд хүртэл дэвшүүлж болох нь намуудад боломжууд байгаа гэдгийг хэлэх байна.

Гуравдугаарт, аливаа хууль үзэл бодлын зөрүү, зөвшилцөл, үүний үндсэн дээр л гардаг.

Бид хоёр удаа хэлэлцээд энэ асуудлыг нэг удаа цааш нь, нэг удаа нааш нь болгоод ингээд Их Хурлаараа бүхэлдээ хэлэлцээд л яг өнөөдрийн түвшинд хүрээд дахиж ярьж байгаад дундын хувилбар ийм юм байна гэсэн ерөнхий ойлголцолд ажлын хэсэг, Байнгын хорооны хэмжээнд хүрээд саналаа оруулж байгаа.

Одоо яаж шийдэх нь Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцож байгаа нийт гишүүдийн эрхийн асуудал гэж хэлмээр байна.

Тэгэхээр би ажлын хэсгийн 9 хүн, Байнгын хорооны 19 хүн, Улсын Их Хурлын 74, 75 гишүүн хүн болгон дотроо юу гэж бодож одоо хүртэлх шийдвэр гаргаж өгснийг бүгдийнх нь өмнө хариулж мэдэхгүй байна.

Хурал удирдах үүргийнхээ дагуу олонхынхоо саналыг дагаад 31 болоод, 41 болоод ингэж явж байгаад л одоогийн түвшинд ирсэн гэдгээ л хэлье дээ. С.Ганбаатар гишүүн маань.

Тэгээд ингээд л орхиё доо. Одоо өөр юу нэмэх вэ.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Эмэгтэй хүмүүст таалагдах гээд ярьж байна гэж зарим хүмүүс бодох вий дээ. Үгүй ээ.

Улс оронд өнөөдөр яг ийм л арга зам чухал байгаа. Бид 30 жил яваад ирсэн замаараа эдийн засгаа, улс орноо дампууруулсан гэж муу ёрын үг хэлээд яах вэ. Маш муу авч явж байгаа.

Одоо бид дараагийн өөр альтернатив боломж байна уу л гэдгийг ярилцаж байгаа шүү.

Яг өнөөдөр Н.Энхболд даргад буруу байхгүй. Н.Энхболд дарга тэрийг чинь хурал зохион байгуулж байгаа л төдий хүн. Би ямар нэгэн хүнийг буруутгамааргүй байна.

Харин нийт гишүүд та нар маань энэ дээр анхаараад өгөөч ээ. Бан Ги Мун хүртэл хүрч ирээд гуйлаа шүү дээ. Үгүй

ээ, нээрээ бид шараа болж байна даа чааваас.

Жентелмен гэдэг бол өөртөө итгэлтэй байхын нэр шүү дээ. Эрэгтэй улс төрчид жоохон өөртөө итгэлтэй баймаар байна.

Тэгээд миний хэлэх гэж байгаа гол санаа бол эрх баригчид минь ээ, Социал демократ нам гэдэг бол социал гэж нийгмийн ардчилсан нам шүү дээ. Нийгмийн чинь 51.3 хувь нь энэ шийдвэр гаргах түвшинд хүчтэй орж ирье гэдгийг бид зүрх сэтгэлээрээ дэмжих ёстой.../минут дуусав/

Г.Занданшатар: Сайн хэллээ. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: 1992 оноос хойш 8 сонгууль хийсэн. Одоо 9 дэх сонгуулийнхаа тоглоомын дүрмээ баталж, одоо батлагдах гэж байх шиг байна.

Өнгөрсөн түүхийг. Та хэд жоохон чимээгүй байж байгаач.

Өнгөрсөн түүхийг хараад байхад эрх баригчид дараагийнхаа сонгуульд ялах хуулийг л голдуу хүч түрж хийдэг. Нөхцөл байдлыг Монголын ард түмэн байнга харж мэдэрч байгаа.

Өнгөрсөн 8 сонгуульд Ардчилсан нам үндсэндээ ялж үзээгүй. 2 удаа л олонх болж байсан. Бусад одоо 6 сонгууль буюу 24 жилд нь Ардын нам ялж, 70 суудал, 65 суудал, 62 суудлуудыг авч байсан.

Өнөөгийн Монголын нөхцөл байдал өмнөх сонгуулиудын хуулийг баталж байсан тэр үр дагавар л, үр нөлөөлөл өнөөдөр харагдаж байна гэж ойлгож байгаа юм.

Тэгээд эрх баригчид сүүлийн үед хэлсэн, ярьснаа мэдэхгүй их орон гаран, заримдаа бүр гаран гаран ч болчихсон юм уу, яасан юм.

Одоо эмэгтэйчүүдийн асуудал, бусад асуудал дээр ер нь нэлээн л будиллаа.

Биднийг нэг юм хэлэхээр, цөөнхийг юм хэлэнгүүт дэг дэг гээд орилчихдог. Тэгээд өөрсдийнхөө зүйлийг хийе гэхээр дэгийг дуртай нөхцөлдөө, дуртай гарцаа гаргаж ирээд хийчихдэг.

Үнэхээр дэг өөрчлөөд хийж байгаа юм уу гээд Байнгын хороон дээр Б.Пүрэвдорж гишүүн бид хоёр бас алдаагаа засаж байгаа юм уу гээд санал гаргангуут үүнийг дэг өөрчилж хийхгүй ээ гэсэн байр сууриас ханддаг.

Энэ удаагийн сонгуулийн хуулийг өөрчлөхдөө Үндсэн хуулийг өөрчлөх замаар, Үндсэн хуулийн цэцийг бүр төрийн эргэлтийн шинжтэй үйл ажиллагаанууд хийгдэж байж хийж байна.

Тэгэхээр энэ сонгуулийн хуулийг уг нь нэлээд ард нийтээр яг Үндсэн хууль шиг хэлэлцүүлэгдэх л ёстой байсан гэж ойлгож байгаа.

Сая ерөнхийдөө багцлаад явчхаж байна л даа. Парламентад суудаггүй жижиг намуудыг шилний цаанаас чихэр долоолгож байна. Хувийг нь багасгах замаар, жагсаалт өгөх замаар. Нөгөөдүүл нь юу нь ч амархан хууртдаг юм.

Эвсэл нөхцөл байдлуудыг харилцан адилгүйгээр хүч түрэн оруулж ирж байх жишээний ч байдаг юм уу.

Дээр нь үеийн үед ярьдаг авлига, хээл хахууль, төрийн завхрал, авлигал төрийн сонгуулийн хулгай байдаг. Мөнгө.

Нүүрсний хулгайн мөнгө, Хөгжлийн банкны хулгайн мөнгө, ЖДҮ-гийн хулгайн мөнгө энэ 2024 оны сонгуулиар нүүрээ хувиргаж орж ирэх нь байна гэж л харагдаж байгаа.

Яагаад вэ гэхээр Ардчилсан намын ажлын хэсэг дээр өгсөн эд мөнгө тараах, мөнгө тараах асуудлыг бүх түвшинд, бүх хугацаанд хориглоё гэсэн заалт дэмжигдсэнгүй.

Үүнийг оруулахаас юунд нь харшраад байдаг юм. Сайд, дарга нар төсөв дээр суусан мөнгөөр далимдуулж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүмүүсийн толгойг эргүүлдэг. Хүчтэй нь хүчгүйгээ барьж иддэг ийм нөхцөлүүдийг бүрэн шийдүүлж чадсангүй.

Энэ нь юу гэж харагдаад байна вэ гэхээр эрх баригч нар дараагийнхаа ялах тоглоомын дүрмийг хүч түрж барьж байгаа.

Бид 11-хэн. Бид цөөхүүлхнээ. Мэдэж байна. Тэгэхдээ ажлын хэсэг дээр байгаа намын ажлын хэсгээс өгсөн саналууд бүрэн тусахгүй байгаад сэтгэл дундуур байгаа.

Өнөөдөр жагсаалтад орж байгаа эмэгтэй нь 50, 50 болж байдаг. Тойрогт байгаа нь яахаараа 30 хувь байдаг юм. Логикийн зөрчилтэй л байхгүй юу. Жагсаалтад оруулбал одоо тэр зебра гэж яриад байна. Эрэгтэй, эмэгтэй, эрэгтэй, эмэгтэй. 50, 50. Тойрог руу яахаараа 30 хувь.

Тэгээд хэрвээ сонгуульд оролцвол бүгдээрээ заавал 39-өөс доошгүйг дэвшүүлнэ.

Энэ чинь юу гэж байна гэсэн үг юм. Стандарт тогтоож өгөөд байна шүү дээ.

Ийм л зүйлийг хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Үг хэллээ Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Ганц хоёр зүйл ярих гэсэн юм. Тодруулах зүйл ч байгаа.

Үндсэн хуулийн холимог тогтолцоо ороод. Энэ бол өөрөө тийм маш чухал өөрчлөлт гэж нийгэм даяараа л үзэж байгаа. Үүнийг хэрэгжихийн амин чухал зүйл нь сонгуулийн хууль дотор бас явж байгаа.

Тэгэхээр одоо анхнаасаа ярилцах ганц хоёр зүйл нь ер нь тойргийн гишүүн жагсаалтын гишүүн хоёрын ялгаа гэдэг зүйл ер нь аль ч хуулиуд дээр яригдахгүй явчхаад байгаа л даа.

Үүн дээр хэрвээ хууль эрх зүйн хамгаалалтын хувьд ч юм уу, ер нь ялгаа байхгүй гэдгийг яаж нотолж байгаа билээ. Жишээ нь, жагсаалтын гишүүн гэдэг бол үндсэндээ намын квотоор орж байгаа л гишүүн.

Би зүгээр тодорхой нэг жишээ асууя л даа.

Намын төлөөллийн байгууллага нь тухайн гишүүнд хариуцлага, сахилга тооцоод намын гишүүнээс хасчихлаа. Тэгвэл тэр гишүүн дээр бүрэн эрхийн асуудал үүсэх үү? Жишээ нь.

Гэх мэтийн яг энэ хоёрын хооронд өөр ямар зүйл гарч болох билээ. Эдгээр дээр бид тодорхой тийм хууль эрх зүйн хариултауд, хамгаалалтууд, тодорхой байдлууд, ойлгомжтой байдлууд байгаа байгаа билүү? Гэх зүйлс цаана нь гарах байх.

Хоёрдугаарт нь, Үндсэн хуулийн үг, өгүүлбэр дээр олныг сонгоно гэхчхэн. Тэр ч бас тухайн нөхцөл байдалдаа зөв шийдэл байх гэж бодож байгаа.

Гэтэл энэ чинь түрүүн асуултад гарч байна лээ. Явсаар байгаад олныг гэдэг чинь сонгуульд хэдэн хувь нь ордог билээ. Дахиад магадгүй оролцсон иргэдийн 20 гаруй хувиар сонгогддог. Тэр нь ирц нь бага байдаг. Ингээд үзвэл ард иргэдийн маш бага хувиар сонгогдох нөхцөл байдал ер нь цааш цаашдаа улам үүсэх гээд байгаа юм.

Гэтэл энэ ардчилал чинь өөрөө олонхын зарчмын үүний цаана явж байдаг.

Тэгэхээр сонгуулийн ирц гэдэг зүйл дээр бид ямарваа нэгэн тийм хөшүүргүүд хууль эрх зүйн хувьд ашиглах боломж бололцоонуудыг. Энэ хуулиуд дээр бас яригдаагүй л дээ. Ер нь цаашдаа энэ үр дагавар гарч болох юм. Жишээ нь, зарим улс оронд нэгэнт төрөөс халамж, үйлчилгээ авч байгаа бол төрөө байгуулахдаа оролцох ёстой гэдэг зарчим үйлчилдэг юм байна. Та оролцох ёстой. Оролцчихоод саналаа өгөхгүй байж болно.

Магадгүй энэ тохиолдолд оролцоогүй иргэд халамжаас хасагддаг ч юм уу. Янз бүрийн хөшүүргүүд бусад улс орнууд ашигладаг.

Тэгэхээр бид ирцийг нь өөрөө бас асуудал дагуулж. Магадгүй нийт иргэдийнхээ 10-хан хувийн саналаар сонгогдсон гишүүн гараад ирэх магадлал. Оролцсон гишүүдийн 20 хувиар, нийт иргэдийнхээ 10-хан хувийн саналаар гараад ирэх магадлал ч үүний цаана ингээд үүсээд л байна л даа.

Тэгэхээр эдгээр дээр ер нь ямарваа нэгэн тийм хууль зүйн хувьд бид нар яригдсан, хэлэгдсэн. Эдгээр дээр энэ гарч үүсэж болзошгүй нөхцөл байдлаас хамгаалсан зүйлс ер нь яригдаж байгаа билүү? Хуульд тусаж байгаа билүү? Энэ бүгд дээр нэг мэдээлэл өгөөч.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн хариулт өгнө.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Ж.Батсуурь гишүүн, О.Цогтгэрэл гишүүн нарын асуултад хариулъя.

Хоёр төсөл өргөн баригдсан. Нэг нь, О.Цогтгэрэл нарын гишүүд. Нэг нь, Н.Энхболд нарын гишүүдийн.

Бид ажлын хэсэг дээр Ж.Батсуурь гишүүн өөрөө сууж байсан, Н.Ганибал гишүүн, Ц.Туваан гишүүн нар байсан.

Бид Ардчилсан намын тавьсан бүх саналыг авсан. Бүх саналыг авсан. Сая Ж.Батсуурь гишүүн бараг санал аваагүй юм шиг. Нэг нам дангаараа хууль хийчихсэн юм шиг ингэж ярьж болохгүй гэдгийг би хэлмээр байгаа юм.

100 хувь авсан. Сүүлд нь манай С.Одонтуяа гишүүн, Н.Ганибал гишүүн, Ц.Туваан гишүүн нар бүх санал өгөөд, аваад дууслаа гэж бүгдээрээ бараг чекэлсэн.

Тийм учраас би тавьсан саналуудыг бүрэн авсан гэдгийг зориуд хэлье гэж бодож байгаа юм.

Хэд хэдэн асуудал байна.

Нэгдүгээрт, тэр жагсаалтаар нэр дэвшиж байгаа гишүүдийн хувьд цаашдаа нөгөө эргүүлэн татахтай холбоотой асуудлыг Улсын Их Хурлын хууль болон намын хуулиар энд тусгаж өгөх юм билээ. Ямар одоо хэлбэрээр татах вэ. Тэр жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүнийг. Дараагийн хүн нь ямар хэлбэрээр орох вэ гэдгийг Улсын Их Хурлын хууль болон Улс төрийн намын тухай хуулиар зохицуулах юм билээ гэдгийг би хэлье гэж бодож байна.

Одоо мөрдөж байгаа сонгуулийн хуулиар нийт сонгогчдын болон тухайн тойргийн сонгогчдын 50 ба 50 хувь дээрх нэг нь ирж байж сонгууль хүчин төгөлдөр болдог болдог.

Тийм учраас тухайн тойргийн сонгогчдын 50 ба түүнээс дээш хувь нь оролцсон тохиолдолд сонгуулийг хүчинтэй гэж байгаа.

Тийм учраас 10, 20 хувь нь оролцох боломжгүй. Заавал 50 хувь оролцох ёстой байгаа юм.

Нөгөө талаар хамгийн олон санал гэж байгаа юм. Бид ерөөсөө олныг төлөөлөх гэдгийг тухайн тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүс дотроосоо хамгийн олон санал авсан хүнийг л сонгож тооцно л гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл бусад сонгогчдоосоо илүү санал авсан хүнийг л сонгогдсонд тооцно гэдэг ийм л зарчим явж байгаа.

Тэр мөнгө тараахтай холбоотой асуудал дээр ийм зүйл байгаа юм. Яах вэ, нэг зүйл байгаа юм. Сонгуулийн энэ

хууль бол сонгуулийн харилцаа зохицуулсан хууль. Сонгуулийн жилийн 01 сарын 01-нээс сонгууль дуустах харилцаа зохицуулдаг ийм л хууль. Сонгуулийн бус үе дэх харилцааг энэ хуулиар зохицуулах боломжгүй байгаа юм.

Тийм учраас түрүүн Ж.Батсуурь гишүүний яриад байгаа 4 жилийн турш хаая гэдгийг энэ сонгуулийн хуулиар хаах ямар ч боломжгүй учраас ажлын хэсэг дээр энэ асуудлыг ярьж байгаад сонгуулийн хуульд тусгах, сонгуулийн хуулиар зохицуулах харилцаа биш ээ гэж үзсэн байгаа юм.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн алга байна. Хаслаа. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа.

Хууль санаачлагч бөгөөд ажлын хэсгийн гишүүний хувиар асуулт байхгүй. Тэгэхдээ нэг зүйлийг бас тодруулаад протоколд үлдээмээр байгаа юм.

Тэр нь юу вэ гэхээр сүүлийн хоёр долоо хоногийн хугацаанд эмэгтэйчүүдийн квотын асуудал нэлээд олон нийтийг хамарлаа.

30 хувь болсон, 40 хувь болсон, эргээд 30 хувь болсон. Тэгээд 2028 оноос 40 хувь гэдэг хувилбар ярьж байх шиг байна.

Тэгээд үүгээрээ яах вэ, энэ парламент бас амьд байна л даа. Бас нэг зүйлийг олзуурхаад байна.

Хоёрдугаарт, манай парламентад суугаа эмэгтэй гишүүд болон Улсын Их Хурлын суудалтай болон суудалгүй бусад намын эмэгтэйчүүд нам үл

харгалзаж нийлээд тэгээд санал бодлоо илэрхийлээд нийгэмд бас нөлөөллийн ажил хийж байгаа нь олзуурхаж байна. Сайн байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан.

Тэгээд харамсалтай нь энэ маань түрүүн тэмдэглэлд дурдагдаагүй юм байна. Үүнийгээ би зориуд тэмдэглэлд үлдээмээр байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр 30 хувь, 40 хувь гэж явсан. Тэгвэл 2024 оны сонгуульд 35 хувиас эхэлье гэдэг ийм санал гаргасан. Харамсалтай нь дэмжигдээгүй.

Тэгэхээр үүнийгээ хэлчихье.

Тэгээд хоёрдугаарт ХҮН намын хувьд бид угаасаа 50, 50 гэдэг хөтөлбөрийг 11 сарын 06-нд буюу өмнөх оны 2022 онд энэ бодлогоо гаргаад танилцуулчихсан. Энэ дээрээ бид хатуу байна.

Тийм болохоороо хэдийгээр хууль квот ингэж тогтоож байгаа ч гэлээ гэсэн улс төрийн институцийн хувьд, Улсын Их Хуралд суудалтай намын хувьд, намын даргын хувьд би энэ зарчим дээрээ хатуу байна гэдгээ энэ дээр мэдэгдчихмээр байна.

Тэгээд яагаад эмэгтэйчүүд хэрэгтэй юм бэ энэ парламентад. Мөн шийдвэр гаргах түвшинд гэдэг дээр хоёрхон л санаа хэлчихмээр байгаа юм.

Нэгдүгээрт нь юу байна гэхээр бид парламентын засаглалтай улс. Ардчиллаа бэхжүүлэхийн тулд парламентын засаглалаа бэхжүүлье. Үүний тулд Үндсэн хуулийн өөрчлөлт хийсэн.

Энэ бол намуудын бодлогын мэтгэлцээний талбар. Энэ агуулгаараа энд попууд биш, хувь хүмүүс биш, улс төрийн институцүүд орж ирээд бодлогоороо өрсөлдөөд мэтгэлцдэг байх ёстой.

Энд чинь хамгийн их багийн тоглолт хийдэг, институцийнхээ зарчимд хатуу байдаг, тууштай байдаг тэр бүлэг эмэгтэйчүүд.

Ийм болохоор энэ парламентын ардчилалд эмэгтэйчүүдийн байр суурь, парламентад орж ирэх тэр боломж бололцоог нь хангаж өгснөөрөө Монгол Улс хожих юм. Монголын ардчилал хожно гэдэгт бүрэн итгэлтэй байгаа.

Хоёрдугаарх нь, Монгол Улс маш их алдагдалтай төсөв баталдаг. Өртэй. Өр нь байнга өсөж явдаг. Цаашаа яаж зогсоохоо мэдэхээ больчихсон ийм улс шүү.

Энэ улсын энэ асуудлын гол нь юу байна гэхээр бид төсвийн шийдвэр гаргахдаа дандаа зардлаа тэлээд байдаг.

Энэ дээр бусад улсын парламентад шийдвэр гаргаж байгаа тэр нөлөөллүүдийг нь, тооцооллуудыг нь аваад үзэхээр судалгаанаас эмэгтэйчүүд учиргүй попроод, учиргүй их зардал өсгөөд байдаггүй юм билээ л дээ.

Тийм болохоор Монголын нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд энэ парламент дотор олон эмэгтэйчүүд орж ирснээрээ магадгүй бид төсвийн сахилга бат сайжирна гэдэг хувь хүний итгэл үнэмшил байна.

Ийм болохоор бид уг нь өнөөдрөөс л энэ квотынхоо асуудлыг шийдээд явах нь зүйтэй.

Тэгэхдээ цаашдаа аль болох л 50, 50 гэдэг тэр тоо руу улс төрийн намууд маань манлайлаад яваасай гэж хүсэж байгаа. Тэгээд үүнийг би бас зориуд протоколд үлдээе гэж бодлоо. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн алга байна.

Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Би бас үг хэлье. Асуулт байхгүй.

Би зарим нэгэн тоо болон сонгогчдынхоо үгсийг л дайх гэсэн юм.

Монгол Улсын нийт хүн амын нийт сонгогчдын 51 хувь нь эмэгтэйчүүд.

2020 оны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд саналаа өгсөн сонгогчдын 55.9 хувь нь, 2016 онд, 2021 онд Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгсөн сонгогчдын 54.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Өчигдөр Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хэлэлцсэн.

Энэ тайланд Монгол Улс эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг хорооны зөвлөмж, хэрэгжилт дээр ер нь ямар байдалтай ажилласан юм бэ, ямар зөвлөмжийг өгсөн юм, бид цаашид юу анхаарах ёстой юм бэ гэдэг ийм чиглэлийг өгснийг танилцуулсан.

Эмэгтэйчүүдийг үндэсний болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргах албан тушаалд эрэгтэй хүмүүстэй адил тэгш байдлаар томилох, сургалт, жендэрийн мэдрэмжтэй ажилд зуучлах,

түр зуурын тусгай арга хэмжээ авах зэрэг зорилт арга хэмжээг ав. Шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоотой байхын ач холбогдлын талаар нийгэмд сурталчлах үйл ажиллагааг идэвхтэй явууллаа гэдэг ийм зөвлөмжийг мөн өгсөн байна.

Сая Т.Доржханд гишүүн ч хэллээ. Үг хэлсэн гишүүд маань бүгдээрээ хэллээ.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа ард намын бүхий л төлөөлөл, тэр дундаа эмэгтэйчүүд нэгдэн Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн квотын асуудлыг бас эрчимтэйгээр ярилцаж, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн ажлыг идэвхтэй хийж байгаа.

Би өөрийн сонгогдсон 27 дугаар тойргоос ирсэн сонгогчдынхоо саналыг энд уламжилмаар байна.

Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар тойргийн сонгогч гэсэн байна. Ганхуягийн Энэбиш 27 дугаар тойргийн сонгогч Машбатын Өнөрчулуун, Шархүүгийн Галбадрах, Бүүвэйбаатарын Өлзийхүү, Шижирбаатар гээд энэ эмэгтэйчүүд бас саналаа хэлсэн байна.

Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээнээс Монголын Социал Демократ Монголын эмэгтэйчүүдийн холбооны бүхий л гишүүд, Нийгмийн ардчилал Монголын эмэгтэйчүүдийн холбоонд байсан, одоо байгаа эмэгтэйчүүд, ахмад парламентын эмэгтэй гишүүд бүгдээрээ энэ квотын асуудлыг дэмжиж үг хэлж, өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлээрэй гэдэг үүргийг бидэнд өгсөн учраас бид үг хэлж байгаа.

Өнөөдөр дэлхийн 140 гаруй улс орон улс төрийн намын тухай хуульдаа эмэгтэйчүүдийн квотыг тогтоож өгсөн

байдаг. Энэ бол дэлхийн жишиг гэдгийг бас онцгойлон хэлье.

Түүрэн бас Их Хурлын дарга хэлсэн үгэндээ Тогтвортой хөгжлийн зорилтын 5 дахь зорилтыг биелүүлэхийн тулд бид тодорхой хэмжээний алхам хийнэ гэдэгт бас итгэлтэй байна.

Эмэгтэйчүүд Монголын улс төрд орж ирснээрээ Монголын парламент. Би энэ **“Үндэсний гал голомт”** хөдөлгөөний тэргүүн Д.Мөнхөө гуайн хэлсэн үгийг онцолж хэлэх гэж байгаа юм.

“Эмэгтэйчүүд Монголын улс төрд орж ирснээрээ Монголын парламент Хүнийг хөгжлийн төвд тавьсан нийгмийн том хөтөлбөр бодлого, шийдвэр гаргах боломжийг нээж өгнө” хэмээн хэлсэн байгаа.

Би яагаад энэ хүмүүсийн хэлсэн үгийг дамжуулаад байна вэ гэвэл энэ парламентад сууж байгаа хэдэн эмэгтэйчүүд өөрсдийн эрхийн тухай яриагүй.

Монголын парламент энэ удаад ирээдүйн тухай, ирээдүйн хүний хөгжлийн тухай, охид, эмэгтэйчүүдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэр боломжийг нь нээж өгөх бүхий л боломжийг хангах энэ алхмыг зоригтойгоороо хийгээсэй гэдэг энэ хүсэлтийн дагуу хэлж байгаа.

Утсан дээр маш олон мессеж ирж байгаа. Би ганц мессежийг танилцуулъя. 86020570. Эмэгтэйчүүдийн 40 хувийн квот нэг нэг хувилбарыг дэмжиж өгнө үү. Иргэн Солонгоо гэсэн ийм мессежүүд маш ихээр ирж байгаа.

Ер нь Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүрэг, нэгдэн орсон

конвенц, энэ бүхнийхээ хэрэгжилтийг хангахын тулд, үүргээ биелүүлэхийн тулд энэ квотын асуудлыг дэмжинэ.

Намын эмэгтэйчүүд маш ихээр асууж байна. Яг 40 хувь уу, 40-өөс үү, 30-аас уу гэдэг асууж байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн 20-иос гэснийг, 40-өөс гэснийг нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 20-иос доошгүй гэснийг нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй гэж өөрчлөх санал Төрийн байгуулалтын байнгын хорооноос орж ирсэн байна.

Юутай ч бид ирээдүйнхээ төлөө.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа.

Дэлхийн бүх улс орнууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орнууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн “Тогтвортой хөгжил 2030” гэдэг зүйлийг баталсан. Г

Гол **concept**_[ойлголт] нь юу юм бэ гэхээр ерөөсөө л энэ хүйсийн тэнцвэртэй байдал хөгжлийн суурь юм гэдэг гол үзэл баримтлалыг баталсан. Тэнцвэртэй байдлыг хангах үүргийг дэлхийн бүх улс орнууд хүлээсэн байдаг юм. Үүрэг хүлээсэн байдаг гэсэн үг.

Өчигдөр Нийгмийн бодлогын байнгын хороогоор хуралдсан. Бид нэг асуудлын талаар ярьсан. Монгол Улсын ол олон улстай хийсэн олон талт гэрээ, хэлэлцээрүүдийн хэрэгжилтийн талаар, үр дүнгийн талаар бид нар ярилцсан.

Бид нар одоо бараг нэр сүрээс нь сонсоод л мэдэх мэдэхгүй маш олон олон талт гэрээ хэлэлцээрүүдийг байгуулдаг. Тэгэхдээ түүнийхээ үүргийг хүлээдэггүй, хэрэгжүүлэлтээ бид хангах боломжоо тооцдог уу гэвэл хэзээ ч үгүй. Хэзээ ч тийм зүйл байдаггүй.

Тэгэхээр энэ үүрэг аливаа улс орны өмнө, ялангуяа олон улсын тавцанд үүргээ хүлээхдээ хэрэгжүүлэх механизмаа ойлгодог байх хэрэгтэй. Олон улсын тавцанд амласан юм бол амлалтынхаа төлөө хичээдэг, зүтгэдэг байх хэрэгтэй. Улс орноороо. Энэ бол Монгол Улсын нэр төрийн асуудал.

Монгол Улс тэгэхдээ жендэрийн хувьд би бас харьцангуй дэвшилтэт үзэлтэй орон гэж боддог.

Тэгэхдээ статистик харвал хангалтгүй. Олон улсын дунджаас бид гол хавьд нь л явж байгаа. Монгол Улс 2011 онд Жендэрийн тэгш байдлын тухай хуулиа баталсан. Улсын Их Хурлаар.

Тэгээд энэ хууль маань бусад хуулиудын адил батлагдсан хэдий ч хэрэгжилтээрээ хангалтгүй байгаа.

Харин ч энэ удаа Улсын Их Хурлын дарга манлайлал үзүүлж Улсын Их Хурлаар баталсан юм бол тэр хуулиа хэрэгжүүлдэг байх хэрэгтэй. Бид өнөөдөр эмэгтэйчүүдийн асуудал яриагүй. Улсын Их Хурлаар батлагдсан хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэгдсэн ассамблей дээр хүлээсэн үүргийн талаар энэ жендэрийн асуудлыг тойрч ярьж байгаа юм.

Эмэгтэй хүн ярихаар эмэгтэй хүнийхээ тухай ярих гэж байна гэж өрөөсгөл ойлгож байгаа нь өнөөдөр жендэрийн тухай ойлголт хангалтгүй

байгаа нийгмийн маш одоо харанхуй гэж хэлмээр юм уу энэ л асуудал юм. Яагаад хүйсийн тэнцвэртэй байдал хөгжлийн гол тулгуур болдог юм бэ.

Ерөөсөө эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн зөв зохистой харилцаа нь хүний харилцаан дээр, гэр бүлийн харилцаан дээр, нийгмийн харилцаан дээр, улс төрийн харилцаан дээр өөрөө тогтвортой байж хөгжил өөрөө олон талт бодлогыг хангаж зөв явдаг л гэсэн ийм энгийн concept юм энэ өөрөө.

Бид эмэгтэй хүмүүсийн асуудлыг өнөөдөр ч гэсэн шинээр оруулж ирж байгаа төсөл дээр нь он ахиулаад гэдэг юм уу, хэрэгжих хугацааг нь хойшлуулаад л бас оруулж ирсэн байна. Энэ одоо яг яаа гэж өгч байгаа хугацаа юм оо? Надад бас нэг асуулт байна.

Ийм практик байдаг юм уу? Он, хугацаагаар ингэж дараалуулж өсгөх тухай ер нь яг ийм хуулийн практик байдаг юм уу гэдгийг би нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, үндэслэл нь юу юм оо?

Ер нь жендэрийн асуудал гэдэг бол хүйсийн тухай асуудал биш. Хэрвээ хүйсийн тухай эмэгтэйчүүдийн асуудал гэх юм бол ер нь Монгол орныг доройтуулсан.

Өнөөдрийг хүртэл энэ 30 жилд 600 орчим Их Хурлын гишүүн сонгогдсон бол 40 хүрэхгүй эмэгтэй Их Хурлын гишүүдээр сонгогдож байсан.

Тэгвэл авлигад идэгдсэн, улс орон зарсан, янз бүрийн сан цөлмөсөн ийм эмэгтэй хүн гэж байхгүй шүү дээ. Хэрвээ эмэгтэй хүний асуудал юм уу гэж үзвэл.

Гэхдээ би ахиад хэлье. Жендэр эмэгтэйчүүдийн асуудал биш. Энэ бол хүйсийн тэнцвэртэй байх тухай ийм л үндсэн асуудал юм гэдгийг би хэлье.

Тэгээд саяынхаа би асуултад хариу хариулт авъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга асуултад хариулья.

Н.Энхболд: П.Анужин гишүүний асуултад хариулья.

Улсын Их Хурлаас гарч байгаа гол бүтээгдэхүүн бол хууль, тогтоолууд байгаа.

Хуулиудад ч тэр, тогтоолуудад ч тэр, аливаа асуудлыг үе шаттайгаар шийдэх ямар нэгэн зорилт тавьсан бол түүнийгээ дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг бас тодорхой үе шаттайгаар тэрэндээ хүрч явах тухай зорилтуудыг хуулиар, тогтоолоор аль альнаар нь зохицуулж ирсэн ийм жишээнүүд байгаа.

Тухайлбал, хуулийн тухайд гэвэл Төсвийн татвар тогтвортой байдлын тухай хууль байна. Тийм ээ. Ирээдүй өв сангийн тухай хууль байна. Энэ хуулиудад тодорхой, одоо жишээ нь тэдэн он гэхэд төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан өрийн үлдэгдлийн хэмжээ тэдээс хэтэрч болохгүй гэсэн юм яг он оноор нь заачихсан ийм шалгуур үзүүлэлтүүдийг яг хуулиар хийчихсэн зүйлүүд байна.

Тогтоол гээд жишээ болгоод яривал бидний хамгийн ойрхон мэдэж байгаа жишээ 2030, 2050 оны зорилтууд байж байгаа. Энэ зорилтуудад. Тэгээд жендэртэй холбоотой бусад бүх л урт хугацааны хөтөлбөр зорилтууд дотор.

Тэр нь тогтоолоор батлагдсан ч бий, хуулиар зохицуулагдсан ч бий. Энэ дотор ингээд оныг нь заагаад тэдэн он гэхэд ийм түвшинд хүрнэ гэсэн ийм маш тодорхой заачихсан зүйл, заалтууд байгаа.

Тэгэхээр энэ манай практикт байдаг зүйл. Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэглэж ирсэн практик гэж ярина.

Ер нь Их Хурлаас гарч байгаа. Би түүрүүн хэлсэн. Гол бүтээгдэхүүн болох манай хууль, тогтоол юуны өмнө Үндсэн хуульд нийцсэн байх ёстой.

Бусад гарсан хууль тогтоомжтойгоо уялдсан байх ёстой. Үүнээс гол том шалгууруудаас бусдыг нь Улсын Их Хурал өөрийнхөө эрхийн хүрээнд шийдвэрүүдийг гаргаад явах ийм төрийн эрх барих дээд байгууллага гэсэн тодотголтой учраас нэгдүгээрт хууль зөрчөөгүй, хоёрт ийм практикууд байгаа. Энэ дагуу хийгдсэн гэдгийг л хэлэх байна.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн тодруулж асууна.

П.Анужин: Баярлалаа. Ямар ч байсан өнөөдөр дэвшилттэй юм ярьж байгаа.

Тэгээд би ахин Улсын Их Хурлын даргад талархаж байгаагаа илэрхийлье.

Нэгдүгээрх нь, хууль тогтоогч хуулийн хэрэгжилтийг хянах гол чиг үүргээ энэ удаа Улсын Их Хурлын дарга манлайлан гүйцэтгэсэн гэж би бодож байгаа. Нэгэнт жендэрийн хуулиа баталсан юм үүнийхээ хэрэгжилтийг хангах нь өөрийнх нь үүрэг талаасаа маш хариуцлагатай хандсан.

Хоёрдугаарт, дөнгөж саяхан болоод өнгөрсөн “Алтай дамнасан улсуудын жендэрийн тогтвортой хөгжил” гэдэг энэ том чуулган Монголчуудад жендэрийн тухай ойлголтыг маш өндрөөр тавьж ойлгуулсан маш том алхам байсан. Анхааралтай харсан бол.

Тэгэхээр соён гэгээрлийн ч үүргээ хийсэн, улс төрийнхөө манлайлал, Их Хурлын даргынхаа үүргийг энэ асуудал дээр амаргүй цаг үед энэ чухал шийдвэр дээр нөлөөлөлтэй ажилласанд талархаж байгаагаа дахин илэрхийлье.

Энэ бас түүх бичилцэж байгаа шүү. Та. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ер нь үг хэлсэн, асуулт асуусан нийт гишүүдийн дийлэнх олонх нь эмэгтэйчүүдийн оролцоог парламентад хангах талаар, жендэрийн эрх тэгш байдлын талаар дэвшилтэт үзэл санаа, прогрессив^[дэвшилтэт] санаачилга гаргаж ярилаа.

Тийм учраас энэ дээр би Улсын Их Хурал дахь намын бүлгүүдийн зөвшилцөл, тохиролцоо, ажлын хэсгийн нөр их ажлыг хүндэтгэхийн зэрэгцээ, ер нь ирж яваа цагийн эрэлт хэрэгцээ, шаардлага бол, дэлхий нийтийн чиг хандлага бол дэлхийн нийтийн амласан амлалт Тогтвортой хөгжлийн зорилтын 5 дахь зорилт жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэлхий нийтийн санаачилга болж байгаа.

Уламжлалт ёсоо бодсон ч гэсэн Өүлэн эхээс авхуулаад, Мандухай цэцэн хатныг хүртэл Монголын эмэгтэйчүүдийн төрт ёсонд гүйцэтгэж байсан үүрэг асар их.

Дэлхийн парламент яагаад үүнийг ирж яваа цаг гэж хэлж байгаа юм бэ гэхээр дэлхийд 1995 онд эмэгтэй парламентчид эзэлдэг хувь 11.5 хувь байсан бол одоо 26.5 хувь болсон юм билээ. 2030 онд 50 хувьд хүрэх зорилттой. 40 хувьд хүрч байгаа. 40 хувьд хүрнэ.

Тэгэхээр энэ бол ирж байгаа цагийн өнгө.

Хоёрдугаарт нь, хамгийн чухал юм нь дэлхий нийтийн технологийн IV хувьсгалын эрин үе. Хиймэл оюун ухаан, робот, технологийн дэвшил, хөгжил жендэрийн тэгш байдлыг шинээр харах, эрчүүдийн болон эмэгтэйчүүдийн давуу тал сул, тал өөрчлөгдөж байгаа ийм шинэ эрин үе гарч байна.

Илүү энэ технологийн хувьсгал зөөлөн ур чадварыг шаардаж байна.

Ийм ч учраас 40-өөс 160 сая эмэгтэй хүний ажлын нөхцөл байдал өөрчлөгдөж, шийдвэр гаргах түвшинд хүрнэ гэсэнд энэ технологийн хувьсгалын үр дүн ингэж нөлөөлнө гэсэн тийм чиг хандлагатай юм билээ. 40-өөс 160 сая хүн дэлхийн хэмжээнд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд гарч ирнэ гэсэн.

Энэ хэмжээгээрээ эмэгтэйчүүдийн зөөлөн ур чадвар, энэ бодлого хөтөлбөр, хууль тогтоох ажил үйлсэд оруулах хувь нэмэр өөрчлөгдөнө.

Ийм учраас дэлхий нийтийн ардчиллын үнэт зүйлийн үндсэн зарчим ч гэсэн тэгш эрхийн л тухай ойлголт, хүний эрхийн тухай ойлголт ч гэсэн тэгш эрхийн тухай ойлголт. Ийм учраас зарчмын хувьд ирж яваа цагийн өнгө гэж бид тодорхойлж байгаа юм.

Тийм учраас илүү прогрессив^[дэвшилтэт] байна гэдэг амаараа ярих биш дэвшилтэт үзэл санааг нь үйлдлээрээ бид харуулах ёстой.

Ийм учраас улс төрийн намуудын парламент суудалтай намуудын зөвшилцөл, тохиролцоо, шийдлийг хүндэтгэхийн зэрэгцээ өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим болох цөөнхийн саналыг хүндэтгэж, олон ургалч үзэл бодлыг уралдуулан олонхын саналаар шийдвэрлэнэ гэсэн зарчмын дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо харьцангуй дундын хувилбарыг гаргаж ирсэнд талархаж байна.

Зөвшилцөл, ойлголцолд хүрэхийн төлөө намын бүлгийн дарга нар, Төрийн байгуулалтын байнгын хороон дарга, хамгийн гол нь эмэгтэй парламентчдын ийм **“солидарность”** буюу **“эв санааны нэгдэл”** нийт нийгэмдээ нөлөөлж уриалж байгаа байдал эмэгтэйчүүдийн чадавхжилтыг **empowerment** буюу одоо улам чадавхижж байгаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтын 5 дугаар зорилт эмэгтэйчүүд чадавхижж байгааг харуулж байгаа тод жишээ гэж бодож байна.

Одоо хүйсийн тэгш байдлын асуудал зөвхөн эмэгтэйчүүдийг чадавхжуулах асуудал биш эрчүүдийг чадавхжуулах асуудал болж хувирсан гэдгийг бас онцлон тэмдэглэж хэлэх шаардлагатай байх.

Ийм учраас энэ дэвшилтэт үзэл санааны төлөө үгээ хэлж байгаа бүх гишүүддээ талархлаа илэрхийлье.

Одоо санал хураалтаа явуулна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтаа явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.10 дахь хэсэг болгох:

17/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Би өмнө нь яг энэ зүйл, заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөх санал дэвшүүлж байсан учраас үг авах цаг авч байгаа юм.

Энэ заалт ер нь өмнөхөөсөө нэн дордож орж ирж байна.

Гол зорилго нь ер нь анхны хэлэлцүүлэг дээрх агуулгаа сайжруулах, гүйцээн боловсруулах чиглэл өгсөн гэж ойлгож байгаа.

Тэгэхэд тэгш эрхийн зарчмыг хассан байна. Эндээс.

Тэгэхээр нам, эвслүүд нэр дэвшүүлэхдээ тэгш эрхийг хангахгүй юм байна гэж ойлгож болох юм уу? Н.Энхболд дарга аа.

Дээрээс нь “**нийгмийн бүлгийн төлөөлөл, оролцоог хангана**” гэж тодорхой байсныг “**харгалзана**” гэж өөрчилсөнийг ойлгохгүй байна. Гүйцээн боловсруулна гэж нийгмийн бүлгийн тэгш оролцоог гүйцэд халахыг хэлж байгаа юм уу?

Тэгэхээр сонгуулийн хууль бол Үндсэн хуулиар олгогдсон иргэний тэгш эрхийг баталгаатай хангах л асуудал байгаа.

Гол нь ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлыг хангах гэж байгаа юм бол тэр хангах зохицуулалтаа оруулж ирэх нь зүйтэй гэж би үзэж байна. Намуудын ёс зүйн хэм хэмжээ, удирдлагуудын, мөн нэр дэвшигчдийн ёс зүйн асуудал, мөнгөний сонгуулиас татгалздаг асуудал, улс төрийн намуудын одоо үнэт зүйл, улс орны хөгжлийн төлөөх бодлогоо дэвшүүлж, түүнийгээ хэрэгжүүлэх ёс зүйтэй, хариуцлагатай, ур чадвартай хүнийг нэр дэвшүүлэх нөхцөлийг хуульчлах агуулгаар гүйцээн боловсруулах чиглэл өгсөн гэж миний хувьд ойлгож байгаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас эхтэй жендэрийн үзэл санааг анхнаасаа манай намын дарга нар Л.Оюун-Эрдэнэ дарга, Д.Амарбаясгалан дарга нар дэмжсэн. Үзэл санааны хувьд анхнаасаа дэмжсэн.

Улс оронд тэгш эрхийн талаар хэвшсэн ойлголтыг сөрж эрэгтэй төвтэй засаглалын бүтцэд тэгш ижил ийм жишиг оруулж ирэхийг зорьж нийгэмд амлалт өгсөн. Энэ ач холбогдлыг өргөсөн.

Одоо би энэ байр сууриасаа ухрахгүй байх гэж найдаж байна.

Тэгш оролцоо гэж дэлхий даяараа ярьж байхад бид тэгш байдлыг хангах зарчим баримтлах хуулиас өнөөдөр хасаж байна. Бид ингэж ухарсаар л байх юм уу.

Хоёр жилийн өмнө парламент дахь эмэгтэйчүүдийн үзүүлэлтээрээ дэлхийд 129-д байсан бол өнөөдөр бид 134-д орж байна.

Тэгээд бидний эмэгтэйчүүд өнөөдөр цөөрснийх биш ээ. Дэлхийн улс орнууд оролцоогоо нэмэгдүүлж урагшилсаар л байна.

Азидаа бид өнөөдөр сүүл мушгиж байна. Монголын хүн амын 50 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа. Тэр дундаа дээд боловсрол эзэмшсэн чадвартай эмэгтэйчүүд 60 хувийг бүрдүүлж байгаа.

Гэтэл хүн амын 90 гаруй хувь нь муслим шашинтай Афганистан өнөөдөр 7-д орж байгаа. Энэ үзүүлэлтээр.

Тэгэхээр бид 27 орноос 21-д нь л орж байгаа ийм л үзүүлэлттэй бид сууж байгаа.

Гэтэл нийгэм, эдийн засагт өнөөдөр хуримтлагдсан маш олон асуудлуудыг шийдвэрлэхэд чадвартай, ёс зүйтэй, хариуцлагатай эмэгтэйчүүдийн оролцоо үгүйлэгдсээр байгаа.

Жендэрийн мэдрэмжтэй улс орнууд, тухайлах юм бол Франц Улсыг нэрлэж болж байна. Францын парламент өнөөдөр “**тэгш, ижил**” гэсэн хуулиа нэрлэж баталсан байдаг юм байна.

Тэгээд энэ бүх улс төрийн намууд нь эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчийн тоог ижил, тэгш байхаар. Хэрвээ хоёр хувь л алдагдахад улс төрийн намуудын санхүүжилтийг хасдаг ийм хатуу

хуультай байдаг юм байна. Энэ дээр манай дарга нар анхаарлаа хандуулаач ээ гэж би хүсэж байна.

Г.Занданшатар: Санал хураалт.
/алх цохив/

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтын 41.16 дахь хэсгийг хасаж, мөн заалтын 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.16 дахь хэсэг болгох:

“41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

76.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 26 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

4.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30.3 дахь хэсэг болгон 1 дүгээр зүйл нэмэх:

“4/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

82.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 42 дугаар зүйл болгох:

“5/42 дугаар зүйл

42 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

42.1.Тойрогт нэр дэвшигчдийн зурагтай хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбар тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

32 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсгийн “таваас” гэснийг “гурваас” гэж, мөн зүйлийн 11 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсгийн “нягтлах эрхтэй” гэснийг “болно” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсгийн “саналаа тэмдэглэсэн” гэснийг хасах.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2 дугаар зүйлийн 2 дахь заалт болгон шилжүүлэх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр дарга аа, сая Засгийн газраас өргөн баригдаж байгаа хөтөлбөрт чинь Засгийн газрын гишүүд Улсын Их Хурлын гишүүний эрхээ эдлэхгүй гэж зааж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр сайд нар үндсэндээ чуулган дээр үг хэлэхгүй болно гэсэн үг юм билээ. Ер нь энд хэрүүл хийгээд байх юм. Ерөөсөө тэрийг л баталчихъя.

8.Төслийн 3 дугаар зүйлийн “65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийн “бөгөөд” гэсний дараа “энэ хуульд заасны дагуу урьдчилан санал авсан битүүмжилсэн саналын хайрцаг,” гэж гэснийг, 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс”

гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “турваас” гэснийг “таваас” гэж,” гэж гэснийг, “41.6 дахь хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхийн аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, “61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “турваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг,” гэснийг, “30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг,” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг, 7 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн дугаарыг 20.15, 20.17 дахь хэсгийн дугаарыг 20.16 гэж,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

М.Үнэнбат дарга аа, энэ яг шигтгээд утгын өөрчлөлтүүдийг нь сайн гаргаарай.

Тэгэхгүй бол энэ хууль зүйн техникийн хувьд нэг таслал өөрчлөгдөхөд л бүтэн агуулга өөрчлөгддөг шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал байхаар юмнууд ингээд нэг санал хураалтаар хураагдчихаар сүүлд асуудал гарахгүй биз гэдгийг сайн нягталж үзээрэй.

9.Төслийн 3 дугаар зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “ухуулах” гэсний дараа “буюу зурагт” гэж, 41.2 дахь хэсгийн “эвслийн” гэсний дараа “тойрогт” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41.3 дахь хэсгийн “Ухуулах хуудас болон зурагт” гэсний “Зурагт” гэж, 41.11 дэх хэсгийн “нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг” гэснийг “зурагт самбарыг” гэж,” гэж, мөн зүйлийн “32.12” гэсний дараа “, 38.12” гэж, 5 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж, мөн зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “, ухуулах хуудас” гэснийг,” гэж, 6 дугаар зүйлийн “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.6.7 дахь заалт,” гэж тус тус нэмж, 6 дугаар зүйлийн “23.3.4” гэснийг “26.3.4” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 4 дүгээр зүйлийн ““20-оос гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй” гэснийг “нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй” гэж” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй гэдгээр.

Д.Өнөрболор: Байнгын хорооноос оруулж ирсэн энэ квоттой холбоотой заалт ухарсан гэж хэлэхгүй ч урагшилсан гэж бас харахгүй байна.

Миний хувьд нэг сөөм ч энэ байр сууриасаа, хуучин байр сууриасаа ухрахгүй бодолтой байгаа.

Үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа мэт боловчиг энэ сонгуулийн хууль байнга өөрчлөгддөг. Манай практикаар харах юм бол 2028 онд ч гэсэн энэ өөрчлөлт өөрчлөгдөхгүй байх гэсэн баталгаа алга байна.

Н.Энхболд даргаас асуумаар байна. Төрийн байгуулалтын байнгын хорооноос. Ийм баталгаа бий юу?

Энэ аргацаасан, дахин биднийг хуурлаа гэсэн иргэний нийгмийн байгууллагуудын эмэгтэйчүүдийн дуу хоолойг манай дарга нар анхаарлаа хандуулаач ээ.

Өнөөдөр олон арван жил тийм ээ, олон арван мянган мэдлэг боловсролтой, ур чадвартай эмэгтэйчүүдийн нүдийг

нээж энэ шийдэл чинь оюун санааг сэрээлээ шүү.

Улс төр дэх ер нь эмэгтэйчүүдийн энэ квотын асуудал өөрөө дэлхий дахинд маргаантай асуудал байдаг л даа.

Нэг талаасаа эмэгтэйчүүдийг эелдгээр ялгаварлаж, тэдний сул дорой мэт хандаж байгаа энэ хэлбэр гэж яригддаг. Гэхдээ нөгөө талаасаа ардчилал бас төгс систем биш боловчиг хүн төрөлхтөн өнөөдөр үүнээс илүү систем байж чадаагүй, чадахгүй тул дэлхий нийтээрээ ардчиллын замаар хөгжиж байгаа нь үнэнтэй адилхан улс төр дэх энэ эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд квотоос илүү арга зам байхгүй байгаа нь бас үнэн.

Тэгэхээр квот гэгч энэ хуулийн үзэл санаа нь 30 байна уу, 40 байна уу ер нь нэр дэвшүүлнэ гэсэн асуудал болохоос биш яг амьдрал дээр өнөөдөр улс төрийн намууд, удирдагч нарын энэ улс орноо хөгжүүлэхэд, удирдахад эмэгтэйчүүдийн оролцоог хангахад өөрсдөө анхаарч улс төрийн соёл гаргах ийм одоо юу гэдэг юм бэ дээ санаачилгатай байхыг хүсэх л юм бол бодит амьдрал дээр 40-өөс ч илүү байж болно, тэгш, ижил болгох ч асуудал нээлттэй гэж харагдаж байгаа.

Би Монгол Улсдаа хүчтэй эмэгтэй гэж өөртөө ч бас итгэлтэй байдаг.

Гэхдээ өнөөдөр эрэгтэй төвтэй засаглалын бүтэц дотор эмэгтэйчүүдийн үнэлэмж доогуур олон жил тогтсон байгаа хэвшмэл ойлголтын эсрэг, аль нэг эмэгтэй асуудалд орвол нийт эмэгтэйчүүдийг ялладаг нийгмийн хүлээн зөвшөөрч амжаагүй уур амьсгалын эсрэг, өнгөрсөн хугацааны шударга бус байдал, өчүүхэн эрх ашгаар том үнэт зүйлээ арилжаалсан хулгай дээрмийн бүлэглэл, энэ ёс зүйн уналтын эсрэг өнөөдөр улс

төрд хүчин мөхөстөх мэдрэмж бодитой төрж байна.

Тэгээд би өнөөдөр еврей биш учраас эс дуугарав ч байдаг юм уу, эсвэл би үйлдвэрчин биш учраас эс хөдлөв ч байдаг юм уу, одоо намайг авч яваагүй учраас би эс тэмцэв ч байдаг юм уу. Тийм ээ. Ийм жишээнүүдийг бид олонтоо ярьдаг.

Гэхдээ өнөөдөр ер нь аль ч улсад мөс зүсэх, шинэ жишиг тогтоох, түүхэн үүрэг гүйцэтгэх цаг хугацаа гэж байдаг.

Тэгэхээр өнөөдөр яг энэ түүхэн цаг хугацаа гэлтэй.

Тэгэхээр миний хувьд бусдад боломж олгогч, шинэ зам, мөр гаргагч ийм улс төрч байх нь миний бодлого зарчим гэж би боддог.

Тиймээс ирээдүйн дараагийн үе болох олон мянган чадварлаг, мэдлэг боловсролтой эмэгтэйчүүдийг өнөөдөр тэгш гараанаас өрсөлдөх боломж олгох, энэ замыг нь нээх түүхэн үүрэг тоогдож байна гэж хариуцлагатайгаар ойлгож байгаа.

Тэгэхээр хариуцлагатайгаар би энэ байр сууриасаа ухрахгүй байгаа юм.

Ер нь гарт байгаа боломжоо бусдад зориулахаас татгалзана гэдэг түүхийн өмнө хүлээх хариуцлага шүү дээ. Гарцаагүй ирж яваа цагийг дэмжигч байх уу, хаалт байх уу гэдэг Та бүгдийн өөрсдийн чинь л сонголт гэж би хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна.

Энэ ухралт биш ээ. Урагшилж ирж яваа цагаа угтсан, үүндээ бэлтгэхийг

шаардсан ийм дэвшил гэж би ойлгож байна.

Гэхдээ үүнийг өөрчлөгдөхгүй байхын баталгаа нь эмэгтэй гишүүдийн энэ хувь болох ёстой. Одоо энэ нэг нэгийн жагсаалтаар чинь доор хаяад 30 эмэгтэй гишүүн ирээдүйн баталгаа нь болж энэ заалт дээрээ зогсож байх ёстой.

Хоёрдугаарт нь, эмэгтэйчүүдийн лобби бүлгийн гишүүд, манай Ж.Сүхбаатар гишүүн ч юм уу, манай Д.Сарангэрэл гишүүн маш идэвхтэй тэмцсэн.

Энэ дагаж мөрдөх журмын тухай хууль хийгээд энэ заалтыг гуравны хоёроор өөрчлөхгүй энэ тэр гэсэн тийм түгжээ бас хийж байдаг туршлага бас бий. Энэ талаараа манай Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн их туршлагатай.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг чинь гаргасан хүмүүсийн нэг Б.Чимид гуай гуравны хоёр энэ тэр гээд бас цоожууд хийж байсан юм байна лээ шүү дээ.

Тэгээд ийм хамгаалалтаа харин өөрчлөгддөггүй байх.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн тогтолцоо, тогтвортой систем хийгээд, нэг жилийн өмнө өөрчлөхгүй болгоод нэлээн хаалтууд хийсэн. Үүнийгээ бэхжүүлэх л шаардлагатай.

Тийм учраас санал хураалт явуулна. Гишүүд санал хураалт. /алх цохив/

Дэмжинэ, дэмжинэ. Дэмжихгүй бол 20 болчихно шүү дээ.

65.2 хувийн саналаар.

11.Төслийн 6 дугаар зүйлийн “34.1.1 дэх заалт,” гэсний дараа “41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.12 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг” гэж нэмэх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Тэгэхдээ сая Д.Өнөрболор гишүүн бид хоёр, Б.Жаргалмаа гишүүн бидний санал дэмжсэн боловч эсрэг гарчихсан байна шүү дээ. Тэгж протоколд тэмдэглэе. Тэгээд ойлголоо шүү дээ.

М.Оюунчимэг гишүүн, Г.Мөнхцэцэг гишүүн, П.Анужин гишүүн.

Ахиад санал хураалт өгчих юм уу? Аан. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Парламентад сууж байгаа эрчүүддээ бас нэг зүйлийг анхааруулаад хэлье.

Мэдээж хэрэг энэ парламентад сууж байгаа 13 эмэгтэй бүгдээрээ жендэрийн асуудал дээр байр сууриа бүгд баттай, ноттойгоор илэрхийлж байсан.

Сая төхөөрөмж ажилласангүй. Дарга аа. Энэ саналыг хүчингүйд тооцоод дахин санал хураалгаж өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: Яах вэ, яах вэ. Энэ конценсусаар явах ёстой. Өмнөх санал биш, 10 дахь саналыг шүү дээ. Тийм ээ.

10 дахь саналыг хүчингүйд тооцох санал хураалт дахиж явуулъя.

Харин хүчингүйд тооцё гэсэн санал гаргаж байна. Ахиж санал хураалт. Ийм практиктай. Санал хураалт.

Бас унагааж болох байсан байж болно шүү дээ. Бадарчийн Жаргалмаа гишүүний санал хэмжигдсэнгүй.

Тэгэхдээ ер нь Бадарчийн Жаргалмаа гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Хүрэлбаатарын Булгантуяа, Мөнхөөгийн Оюунчимэг, Пүрэв-Очирын Анужин нарын гишүүд. Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын гишүүд дэмжсэнд тооцох.

Сая тэгэхдээ төхөөрөмж бас ажиллаагүй нь их сонин шүү. Минийх ч гэсэн ажиллаагүй.

Ингээд дэмжсэнд тооцож байгаа гэдгээ ингээд илэрхийлчихсэн гэж үзье. Протоколд тэмдэглэхээрэй. Дараагийн санал дээр үг хэлэх үү. Тийм ээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн.

Сонгуулийн хууль хэлэлцэж байгаа юм чинь ингээд бие биедээ хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Заавал ингээд давлагаалж явах албагүй шүү дээ энэ чинь. Ямар эмэгтэй диктатор байдаггүй гэж түрүүн хэлээд байсан шүү дээ. Түүн шиг энэ ардчилсан сонгуулийн зарчмыг ардчилалтай, олон ургалч үзлээр хэлэлцээд явахад ерөөсөө болохгүй юм байхгүй.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 30 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийн “дээд хэмжээнээс” гэснийг “хэмжээний дунджаас” гэж өөрчлөх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт явуулна.

Хэн үг хэлнэ гэсэн бэ? Үг байхгүй байна шүү. Хаалаа.

Санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Д.Тогтохсүрэн дарга аа, таны гаргасан санал шүү дээ.

84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ робот, машины эрин үе. Ирж яваа цаг, өөр өөр цаг үе ирж байгаа шүү.

13.Төсөл доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

84.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд орно. Сонгуулийн хуулийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудал. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Ес. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай”
(“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт)
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна.

Ч.Хүрэлбаатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг тус тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталсан.

Коронавируст халдвар, цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор тус хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удаашрах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүссэн тул шинэчлэн боловсруулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19.1.2 дахь заалтыг үндэслэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр буюу жилийн өмнө өргөн барьсан.

Ингээд хэлэлцэгдээгүй нэг жилийн хугацаа өнгөрсөн байна.

Тогтоолын төслийг өргөн барих үед үүссэн байсан цар тахлын нөхцөл байдал өөрчлөгдөж Өрийн удирдлагын тухай хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулиудад заасан шинээр зээлийг үүсгэхтэй холбоотой зохицуулалтууд өөрчлөгдсөн зэргээс хамааран уг тогтоолын төслийг шинэчлэх болсон анхны зорилго ач холбогдолгүй болоод байхыг анхаарч үзэхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн

байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт, коронавируст халдварын КОВИД-19-ийн цар тахалтай холбоотойгоор удаашрах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүссэн тул санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, санхүүжилтийн дүнг өөрчлөх, зарим төсөл, арга хэмжээний байршил, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь болон хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд зэргийг үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөлт оруулах зорилгоор тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед төсөл санаачлагчийн зүгээс тус төслийг өргөн барих үеийн цар тахлын нөхцөл байдал өөрчлөгдсөн, Өрийн удирдлагын тухай болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад заасан шинээр зээллэг үүсгэхтэй холбоотой зохицуулалтууд өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шинэчлэн батлах зорилго ач холбогдолгүй болсон талаар танилцуулгадаа дурдсан тул Улсын Их

Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлээгүй бөгөөд дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсгийг үндэслэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байхгүй.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Ч.Хүрэлбаатар сайд аа, энэ чинь ингээд хэлэлцэхгүй юм уу? Тийм ээ. Тэгвэл дэмжихгүй бол энэ чинь буцаад ирэх юм байна бас.

Үүнийг дэмжих ёстой. Байнгын хорооны томьёоллоор санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаас санал хураалт явуулъя. Энэ тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжинэ, дэмжинэ. Энэ хугацаа нь өнгөрчихсөн юм байна.

68.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулъя.

“Тогтоолын төсөл буцаах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Тогтоолын эцсийн найруулгыг буцаалаа. /алх цохив/
сонссонд тооцлоо. Тогтоолын төслийг

**Арав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан
авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалд оръё. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хурал хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж нэгдсэн хуралдаанд дараах байдлаар танилцуулж байна.

1.2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт нь хууль

тогтоомжийг нийцүүлэх хуваарийг 1 дүгээр хавсралтаар.

Хавсралтад дурдсан хугацаанд багтаан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулах ажлыг зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгах.

2.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгаж, уг арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар батлах.

3.Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт даалгах.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд

оруулж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хороо “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн

саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Энэ дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль их бүтээлч конструктивный болох л ийм шаардлагыг энд оруулж байгаа юм.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Санал хураалт. /алх цохив/

68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо энэ дотор яаж ингээд 126 багтах вэ гэдэг л юм хийх нь байна шүү дээ. Л.Мөнхбаатар даргатай ажлын хэсэг байгуулагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа. /алх цохив/

Арваннэг.Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны явцын тайлан

Дараагийн асуудалд орно. Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан

шалгах түр хорооны явцын тайланг сонсоно.

Хянан шалгах түр хорооны дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсад эмийн хяналт шалгалтыг сайжруулах, эсхүл хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаарх саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах Түр хороо байгуулагдаж 6 сарын хугацаанд ажиллаж, Түр хорооны ажиллах хугацаа дууссан болно.

Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Түр хорооны гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Д.Батлут, Э.Батшугар, Б.Бейсен, С.Ганбаатар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн, СОдонтуяа, Ц.Туваан нар ажиллалаа.

Хянан шалгах түр хорооны хуралдаанаар дотоодын болон импортын эмийн чанар, стандартын өнөөгийн байдал, эмийн хяналтын тогтолцоо, тулгамдаж байгаа асуудлуудын талаар холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг сонсож, Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын зохицуулалтын газрын эмийн шинжилгээний лаборатори, Монос эмийн үйлдвэрийн эм бэлдмэл, сорилтын лабораторийн нөхцөл байдалтай очиж танилцлаа.

Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмээр хангах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглээнд гаргах эмийг бүртгэхдээ эм үйлдвэрлэлийн зохистой дадал буюу Жи Эм Пи /good manufacturing practice

(GMP)/-гийн шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэгдсэн, идэвх найрлага, тун, тогтвортой байдал нь тогтоогдсон, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байх зэрэг үндсэн шаардлагыг тавьж байна.

Манай улсын эмийн бүртгэлд 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар нийт 4213 эм бүртгэлтэй байна.

Эдгээр эмийн 851 буюу 20.2 хувь нь үндэсний, 3362 буюу 79.8 хувь нь импортын эм байна.

Түүнчлэн нийт бүртгэлтэй эмийн 41 хувь нь эмийн хяналтын хатуу зохицуулалттай эрх бүхий байгууллагатай улс орноос, 59 хувь нь бусад орноос импортлогдож байна.

Манай улсад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын эм үйлдвэрлэлийн зохистой дадал Жи Эм Пи-гийн удирдамжид үндэслэн боловсруулсан эм үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага, стандартын дагуу өнөөгийн байдлаар эм үйлдвэрлэлийн зохистой дадлын батламж авсан 9 үйлдвэр байгаа нь нийт үйлдвэрийн 32 хувь юм.

Батламж аваагүй 17 эм, биологийн идэвхтэй бүтээгдэхүүний үйлдвэрт 2021-ээс 2022 онд хяналт, үнэлгээ хийхэд 2 үйлдвэр нь 80-аас 89 хувь, 4 нь 60-аас 79 хувь, 8 нь 40-өөс 59 хувь, 3 нь 20-оос 39 хувийн стандартын хэрэгжилттэй байна.

Монгол Улсын эмийн бүртгэлд үндэсний эмийн үйлдвэрийн 806 нэр төрлийн бүтээгдэхүүн бүртгэгдсэнээс 472 буюу 59 хувь нь Жи Эм Пи-тэй үйлдвэрт, 334 буюу 41 хувь нь Жи Эм Пи-гүй үйлдвэрт үйлдвэрлэгдсэн байна.

Манай улсын хувьд Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын

эм шинжлэх лаборатори нь эмийн чанарыг баталгаажуулах зорилгоор стандартын шаардлага хангаж байгаа эсэх шинжилгээг эмийн бүртгэлийн, хяналт шалгалтын, шинээр зохион бүтээсэн эмийн дээжид хийж байна.

Харин хяналт шинжилгээг эмийн зах зээлд гаргасны дараах тандалт судалгааны дээжид болон цагдаа, тагнуул, хил гаалийн байгууллагаас ирсэн хууль бус сэжиг, сэжигтэй, хуурамч эм илрүүлэх зорилгоор хийж байна.

Тус лаборатори нь жилд 2 мянга орчим дээжид шинжилгээ хийдэг бөгөөд дунджаар нийт шинжилгээний 31.6 хувь нь Үндэсний эмийн үйлдвэрийн, 68.4 хувийг импортын эмийн шинжилгээ эзэлж байна.

Иргэд эмийн үнэ, чанар, хүртээмжид эргэлзээ, шүүмжлэлтэй ханддаг. Уг асуудалд баталгаатай хариулт өгөх, дүгнэлт гарах, мэргэжлийн байгууллагын хүрэлцээ, технологийн чадамж дутмаг байна.

Өнгөрсөн хугацаанд эмийн хяналт тавих, хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, хэрэгжилт хяналт нь сул, түүнээс үүдсэн үр дүнг дүгнэх боломжгүй, тодорхойгүй байдал үүссэн хэвээр байна.

Эм зүйн салбарт эмийн бүртгэл, мэдээлэл, сунгалт, өөрчлөлт, экспорт, импортын лиценз олгох үйл ажиллагааны **licemed.mohs.mn**, эмнэлгийн тоног төхөөрөмжийн **heps.hdc.gov.mn**, эрүүл мэндийн байгууллагаас эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуур, эрт илрүүлгийн нөөцийн мэдээ авдаг **burtgel.gov.mn**, эмийн гаж нөлөөний мэдээллийг иргэд, эмнэлгийн мэргэжилтнээс хүлээн авдаг

E-reporting зэрэг программ хангамжийг ашиглаж байна.

Сүүлийн үед нийтийн мэдээлэл солилцооны **e-mongolia** систем эмийн бүртгэлийн зарим үйлчилгээг холбож Гаалийн ерөнхий газраас импортолсон эмийн тоо болон үнийн мэдээллийг авахын тулд **LiceMed** программд нэмэлт хөгжүүлэлтийг хийж Татварын ерөнхий газраас эмийн бар код, үнэ, тоо хэмжээний талаар мэдээлэл авах ажлыг зохион байгуулж байна.

Гэвч эмийн хяналт, зохицуулалтын нэгдсэн цахим тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах зохицуулахад хүндрэл учирч байна.

Одоо хэрэглэж байгаа системүүд болон технологи нь хэт хуучирсан, өндөр ачаалал авах боломжгүй, суурь технологийг хөгжүүлж зогссон, урсгал зардал өндөр, мэдээллүүд нь цэгцгүй, бүртгэлийн стандарт хангахгүй, мэдээллээ солилцож чадахгүй болсон байна.

Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэх программ хангамжид тавигдах үндсэн болон тусгай шаардлага, техникийн нөхцөл, мөрдөх стандарт, эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг боловсруулж Монгол Улсын Засгийн газраар батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Энэхүү журам батлагдан гарснаар эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж байгаа 30 гаруй программ хангамж,

мэдээллийн систем, мэдээллийн сангийн эх үүсвэр хоорондоо өгөгдлийг эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн платформоор дамжуулан нэг стандартаар солилцох, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, нууцлал, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байсан Цахим эрүүл мэнд төслийн эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформыг ажлын гүйцэтгэгч **“Тайхан Кабель солюшн”** компани гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй. Хийсэн ажил нь шаардлага хангаагүй. Гэрээний гүйцэтгэл хангалтгүй байгаа тухай Дэлхийн банкнаас хийлгэсэн олон улсын хөндлөнгийн аудитын дүгнэлт гарсны улмаас Монгол Улсын Засгийн газраас уг төслийг зогсоох шийдвэрийг 2023 оны 2 дугаар сард гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх хүрээнд эрүүл мэндийн салбарт цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад даалгасан.

Тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр олгодог тусгай зөвшөөрөл, вакцины гэрчилгээ, Эрүүл мэндийн даатгалын төлөлт, шинжилгээний хариу авах, эмнэлэгт цаг авах, цусны бүлгийн мэдээлэл зэрэг эрүүл мэндийн 18 үйлчилгээг цахим үйлчилгээний e-mongolia системд байршуулаад байна.

Мөн эмнэлэгт иргэнийг илгээх **“13А” маягтыг** цахимжуулах талаар 4 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанд танилцуулж, тэмдэгдэлээр өгсөн үүргийн дагуу цахим маягтыг төрийн үйлчилгээний e-mongolia системд Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар гарсан ажлын хэсгийн хүрээнд шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Түр хороо ажиллах явцдаа Улсын Их Хурлын тогтоолоор заасан тусгай шалгалтын сэдвийн хүрээ, хязгаарын дагуу хүний эмийн чанар, үйлдвэрлэлт, нийлүүлэлтийн чиглэлээр ажиллалаа.

Монгол Улсад бүртгэлтэй хуурамч болон стандарт бус эм бүртгэгдсэн талаарх нотлох баримт хангалтгүй учраас шинжээч, хянан шалгагч томилоогүй. Түүнчлэн дан ганц хүний эмийн чанар, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлыг шалган судлах бус эмийн үнийн асуудал, тээвэрлэлт, хадгалалтын асуудал, эмийн үнэ нь эмийн чанар стандартад нийцэж байгаа эсэх, зах зээл дээр худалдаалагдаж байгаа болон Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан, нөхцөлийн талаар дүгнэлт өгөх зэрэг асуудлыг зайлшгүй судлах шаардлага үүссэн.

Эмийн чанар, аюулгүй байдал нь зөвхөн тухайн эмийн түүхий эдийн цэвэршилт, сав, баглаа боодлоос гадна шинэ эмийг хөгжүүлэх, турших, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, эмийн үнэ, түүний зохистой хэрэглээ зэрэг олон хүчин зүйл, дадал, үйл ажиллагаанаас хамааралтай тул хяналт, зохицуулалтыг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг цогцоор нь хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эмийн чанар, аюулгүй байдлын зах зээлийн тандалт судалгааг эрчимжүүлэх, эм шинжлэх лабораторийг олон улсын түвшинд хүргэх, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах, бүртгэлийн нэгдсэн цахим тогтолцоог бүрдүүлэх, Эмийн зохицуулалтын байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж явцын тайланг Та бүхэнд танилцуулж байна.

Нэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг цогцоор хийхэд хууль эрх зүйн орчин дутагдалтай байгаа тул эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг цогцоор нь хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хоёр. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нөөц бүрдүүлэх нь эм ханган нийлүүлэх байгууллагуудаас бүрэн хамааралтай тул нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдлын үеийн зайлшгүй шаардлагатай болон өнчин эмийн улсын нөөцийн төвтэй болох асуудлыг судлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Гурав. Эмийн хяналт зохицуулалт нэгдсэн байдлаар цахим тогтолцоо бүрдээгүй байгаад ач холбогдол өгч анхаарч ажиллах.

Эмийн бүртгэлийг бүрэн цахимжуулж, иргэдэд тухайн эм хэзээ, аль улсаас, хэрхэн манай улсад ирсэн, хэзээ бүртгэгдсэн, бүртгэлийн хүчинтэй хугацаандаа байгаа эсэх, ямар найрлага, үйлчилгээтэй эм хэрэглэж байгаагаа болон бүртгэлгүй эмийн мэдээллийг

хянах боломж олгох гар утасны аппликэйшн нэвтрүүлэх.

Мөн эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангууд борлуулагдаж байгаа эмийн үнийн бодит мэдээллийг авч хяналт тавих, нөөцийг бодитой удирдах нөхцөлийг бүрдүүлэх.

Дөрөв. Эмийн чанарын хяналт хийх лавлагаа, лабораториуд, тоног төхөөрөмж, хүний нөөцийн дутагдалтай, эмийн зохицуулалтын байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах шаардлагатай тул эм, шинжлэх, лабораторийн тоног төхөөрөмжийг олон улсын түвшинд хүргэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх.

Тав. Зах зээлийн дараах эмийн чанар аюулгүй байдлын тандалт хийх, төсөв, санхүү, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны зардал хангалтгүй байгаа тул эмийн чанар, аюулгүй байдлын зах зээлийн тандалт судалгааг эрчимжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Зургаа. Хүний эмийн чанар, стандартыг шалгах явцад эмийн үнийн асуудлыг нарийвчлан судлах, зах зээл дээр худалдаалагдаж байгаа болон Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан, нөхцөлийн хяналт шалгалтыг цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын гишүүдээс уг асуудлаар Улсын Их Хурлын даргад Хянан шалгах түр хороо байгуулахаар тогтоолын төслийг өргөн барихаар төлөвлөж байгаа.

Иймд тус Хянан шалгах түр хороог татан буулгаж тусгай шалгалтын сэдвийн хүрээ, хязгаарыг нарийвчлан хүний эмийн зөвхөн чанар биш хүний эмийн чанар, үнэтэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулж Түр хорооны үйл ажиллагааг нэгтгэн явуулах саналтай байгааг Та бүхэнд дуулгая.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Их баярлалаа.

Танилцуулга, тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу. Б.Бейсен гишүүн байгаа юм уу?

Дараагийн түр хороог Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 22

гишүүн байх аа, 27 гишүүн санаачилсан байгаа.

Энэ дээр Б.Бейсен гишүүн оролцоод ажиллаарай.

Дараа нь шүүхийн тухай хууль, төсвийн тухай хууль гээд нэлээн олон хуулиуд байна.

Ингээд Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33.8-д заасны дагуу Улсын Их Хуралд санал, дүгнэлтээ танилцуулснаар татан буугдана гэж заасны дагуу Хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Монгол Улсын эмийн хянан шалгалтыг сайжруулах, эсхүл хянан шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох талаар саналыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо татан буугдсанд тооцлоо. /алх цохив/

Арванхоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд
/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын шүүх энэ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан

Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2023 оны 40 дүгээр тогтоолыг баталсан.

Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар болон холбогдох бусад албан тушаалтнуудад ажиллалаа.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.5, 82.2.7-д заасны дагуу ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа Монгол Улсын шүүхийн тухай хуульд иргэний давж заалдах эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах асуудал учир дутагдалтай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил өөрчлөн найруулж байгаа дэд заалтууд, тухайлбал анхан болон давж заалдах шатын гэсэн үгийг хассанаар хяналтын шатын шүүхийн хянан шийдвэрлэх хэргийн харьяаллыг өргөтгөж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат шүүхүүд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж ажиллаж байгаа эсэх талаар асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг үндэслэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах тухай горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч Ц.Цогт оролцож байгаа юм байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ширнэнбаньдийн Адьшаа гишүүнээр тасаллаа. Ингээд Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн асуудалтай холбогдуулж би өглөөний чуулган дээр байр суурь илэрхийлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллага хуулийнхаа хүрээнээс хальсан асуудал шийдээд байгаа гэж ойлгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэлт гаргаад, дахиад Үндсэн хуулийн зарим заалтыг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан.

Хууль дээдлэх зарчим алдагдаж байна. Тэгээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр Шүүхийн тухай хуулийн зарим заалт, иргэний хэрэг, эрүүгийн хэргийг шийдвэрлэх, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудыг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхэлж түдгэлзүүлсэн байгаа.

6 сарын дараа түдгэлзүүлсэн асуудлыг өнөөдөр бид Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэр гаргаж байна.

6 сарын хугацаанд ямар хийдэл гаргах гээд байна? Ямар хулгай хийх гээд байна? Ямар луйвар хийх гээд байна? Ямар хэргийг энэ хугацаанд Дээд шүүхээр хянуулах гээд байна гэдэг ийм хардалтыг би удаа дараа хэлж байна.

6 сарын дараа хууль түдгэлзүүлээд, тэгээд өнөөдөр Улсын Их Хуралд энэ хуульд өөрчлөлт оруулж байна.

Ийм зарчим байж болох уу? Хуулийн нэгдмэл ойлголт, хууль дээдлэх зарчим, шударга шүүхээр шүүлгэх асуудал ингэж байж болох уу? Улсын Их Хурлын дарга, удирдлагууд, Эрхэм гишүүд ээ.

Би Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Цогт шүүгчээс нэг асуудал асууя.

Монгол Улсын Дээд шүүх шүүх эрх мэдэл өнөөдөр Улсын Их Хурлын хууль тогтоох ажлын хэсэгт ордог чинь ямар учиртай юм бэ?

Яагаад өнөөдөр шүүх эрх мэдэл Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэгт орох ямар хууль зүйн үндэслэл байна аа?

Шүүхийн тухай хууль чинь шүүх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэл ажлын хэсэгт ордог анхны ийм тохиолдол гэж үзэж байна. Энэ талаар тайлбар авъя.

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр даргаас нэг асуулт асууя. Энэ 6 сарын дараа түдгэлзүүлсэн асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэх нь хууль дээдлэх зарчимд нийцэх үү? Яагаад өнөөдөр 6 сарын дараа түдгэлзүүлсэн асуудлыг өнөөдөр хэлэлцэж байгаа юм бэ?

Дээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчөөгүй гэж нэг шийдвэр гаргаад, зарим заалтыг түдгэлзүүлж байгаа нь энэ цэц гэдэг байгууллага хууль тогтоох эрх мэдэл, өөрийнхөө хуулийн хүрээнд хууль зөрчиж байхад Улсын Их Хурал яагаад энэ асуудлыг авч хэлэлцэхгүй байна.

Монгол Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд Монгол Улсын гадаад, дотоод бүх асуудлыг авч хэлэлцэнэ гэж байгаа шүү дээ.

Гэтэл өнөөдөр цэц хууль зөрчиж, салаа ойлголттой шийдвэр гаргаж 6 сарын хугацаанд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Батгөмөр Энхбаяр гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Ш.Адьяшаа гишүүний асуултад хариулъя.

Ш.Адьяшаа гишүүн өнөөдрийн чуулганы хуралдааны эхэнд энэ асуудлыг хөндөж ярьж байсан.

Үндсэн хуулийн цэц шүүхийн тухай хуулийн зарим заалт буюу Монгол Улсын Дээд шүүхийн харьяалан шийдэх гурван үндэслэлийн хоёр нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шударга шүүхээр шүүллгэх үндсэн эрхийн зөрчил болж байна гэдэг асуудлаар маргаан үүсгэж хянан шийдвэрлэсэн.

Ингэхдээ саяын хэлсэн Үндсэн хуульд заасантай нийцээгүй буюу хууль хийдлийг арилгах шаардлагатай гэдэг дүгнэлт гаргасан.

Ингэхдээ хууль тогтоох Улсын Их Хуралд бас хугацаа олгосон юм шиг байгаа юм.

Анх удаа ийм урт хугацаа буюу 2023 оны 12 сарын 15-ны өдрөөр энэ хийдлээ арилгахгүй бол саяын заалтууд түдгэлзэхээр дүгнэлтээ гаргасан.

Тэр ч утгаараа Ш.Адьяшаа гишүүн үнэхээр гайхаж цочирдож, бас хардаж сэрдэж, энэ ямар нэгэн юм хулгай хийх гээд байна гэдэг бас ийм мэргэжлийн хүний үнэрч шинж чанараараа хардаж асуугаад байгааг би их ойлгож байгаа юм.

Энэ дүгнэлтийг хүлээж авах эсэх асуудал дээр ч гэсэн Улсын Их Хурлын чуулганд бас энэ асуудал яригдсан. Зөрчөөгүй байна гэххэд нийцээгүй байна, хийдэлтэй байна, зас гэдэг. Тэгээд түдгэлзүүлдэг ийм дүгнэлт гаргаж байсан юм уу гэдэг асуудлыг олон гишүүд хөндөж ярьж байсан.

Нэгэнт Улсын Их Хурал хүлээж авсан тохиолдолд дэгийн тухай хуульд зааснаар Улсын Их Хурал ажлын 15

хоногийн дотор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуультай байгаа.

Яг энэ хуулийнхаа хугацаанд заасны дагуу Байнгын хороо хэлэлцэж энэ асуудлыг холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаа улс.

Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын Дээд шүүх Шүүхийн тухай хууль болон процессын хуулиудад албан ёсоор санал өгөх ийм чиг үүрэг хуульчлагдсан байгаа.

Үүнийхээ дагуу Улсын Дээд шүүх нийт шүүгчдийнхээ хуралдаанаар хэлэлцэж холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр саналаа ирүүлсэн.

Энэ асуудлыг мөн хууль тогтоох институтэд танилцуулах төлөөлөгчийг Ц.Цогт шүүгчийг томилсон байгаа юм. Дээд шүүх томилсон.

Тэр утгаараа энэ асуудал яригдаж байгаа.

Мэдээж энэ ямар нэг ийм юм хулгай хийчих гээд байгаа юм байхгүй. 12 сарын 05-наас өмнө ч юм уу, хойно нь ч юм уу хулгай хийчих гээд байна. Нэг л юм байгаад байх шиг байна гээд хардаад байх шиг байна.

Одоо угаасаа түдгэлзүүлсэн гээд байгаа шүүхийн хуулийн заалт чинь 12 сарын 15-наас хойш түдгэлзүүлнэ гэж байгаа учраас хууль зүйн хувьд хүчин төгөлдөр үйлчилж байгаа.

Бид Улсын Их Хурал, цэцийн дүгнэлтийг хүлээж аваад холбогдох өөрчлөлтийг хийгээд энэ нь ердийн горимоороо үйлчлээд явчих учраас энэ завсар хууль хийдлийн хугацааны ийм ямар нэгэн завсар гарахгүй.

Тийм учраас энэ холбогдох өөрчлөлт хийснээр хэн нэгэн этгээдэд аль нэгэн хэрэг кэйст давуу байдал олгох ийм нөхцөл байдал энэ цэцийн дүгнэлттэй холбоотойгоор үүсэхгүй гэдгийг би танд баталгаатайгаар хэлье. Өөр юу гэж хэлэх вэ.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн тодруулж асууна. Ц.Цогт шүүгч хариулахгүй билүү? Ц.Цогт шүүгч. 89.

Ц.Цогт: Монгол Улсын Их Хурал Улсын Дээд шүүхийн хоорондын харилцааг хуулиар зохицуулсан байдаг.

Ялангуяа Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 8.3 гэсэн заалтаар Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулж, шүүн таслах ажиллагааны процесстой холбоотой хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаараа хэлэлцэж саналаа Улсын Их Хуралд хүргүүлэх ийм хуультай.

2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Цэц шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 7.5.2 дэд заалтыг Үндсэн хуульд нийцээгүй гэдэг шийдвэр гарсны маргааш буюу 5 сарын 04-ний өдөр Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар энэ цэцийн дүгнэлттэй холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх, түүнд гарах асуудлын талаар хэлэлцээд ажлын хэсэг байгуулсан.

Өөрөөр хэлбэл энэ асуудлыг судалж, нэгэнт цэцийн дүгнэлт гарсан учраас Улсын Их Хурал ямар шийдвэр гаргахтай холбогдуулж хуулийг боловсронгуй болгох ийм ажлын хэсэг гаргасан.

Энэ ажлын хэсгийг би хариуцаж ажилласан байгаа. Гурван танхимаас шүүгч нар орсон.

Ингээд 2023 оны 6 сард сарын 06-ны өдрийн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны албан бичгээр энэ цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэх гэж байгаатай холбоотой саналаа ирүүл гэдэг ийм албан бичиг ирсэн.

Үүний дагуу нийт шүүгчдийн хуралдаан хуралдаад тодорхой санал боловсруулаад, тэгээд энэ саналыг Хууль зүйн байнгын хороонд юм уу, чуулганд танилцуулах шаардлагатай.

Манай гаргасан саналтай холбоотой асуулт Улсын Их Хурлын гишүүд асуувал түүнд нь тайлбар өгөх. Нэгэнт санал гаргасныхаа хувиар.

Тийм үүрэгтэйгээр Ерөнхий шүүгчийн итгэмжлэлээр энд чуулганы хуралдаанд оролцож байна.

Тэгээд ер нь Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоох байгууллага, шүүх эрх мэдэл адилхан.

Төрийн эрх мэдлийн нэг салбар гэдгийг ойлгож олон нийтэд ойлгогдох энэ үг хэлээ өөрсдөө сайн бодож ярина биз дээ.

Тэгээд бид сайн дураараа гэдэг юм уу, эсвэл аль нэг хүний ажлын туслах ч гэдэг юм уу тийм болж энд ирээгүй.

Хуульд заасан үүргийнхээ дагуу шүүхийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн төсөлд гаргасан саналаа асуулт байвал хариулах гээд ирсэн байна.

Г.Занданшатар:
Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Ойлголоо. Энэ дээд шүүгч өнөөдөр ингээд л Улсын Их Хурлын Байнгын хорооны ажлын хэсэгт ороод л, шүүх эрх мэдэл.

Ер нь тэгээд л цаашлаад бид байгууллагуудын хууль хэлэлцэхдээ ингээд л хүмүүсийг авч ирэх ийм жишгийг өнөөдөр тогтоож гэж ойлгож байна.

Ц.Цогц шүүгчээс дахиад нэг асуулт асууя.

Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх тухай хууль гэж 2016 онд баталсан. 46 зүйлтэй ийм хууль байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэж 2017 онд баталсан. Бас 46 зүйлтэй хууль байгаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль гэж 2002 онд батлагдсан. 20 бүлэг, 195 зүйлтэй ийм хууль байна.

Дээд шүүхийн тайлбар гаргахгүй л бол хууль хэрэглээний тухай тайлбарыг л үндэслэж Дээд шүүх хэрэг хэлэлцэнэ гэж Улсын Их Хурал батлаад байна. Энэ зөв юм уу, буруу юм уу?

Г.Занданшатар: 89. **Ц.Цогт** шүүгч хариулья.

Ц.Цогт: Ш.Адьяа гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр 2021 оны Шүүхийн тухай хуулийн дагуу Улсын Дээд шүүх тайлбар гаргах энэ арга зүй, процедур нь нэлээн тодорхой болсон.

Тэгэхдээ хамгийн гол нь хийсвэрээр урьдчилж тайлбар хийхгүй.

Яг практик дээр тухайн хуулийн хэрэглээтэй холбоотой асуудал үүсээд ирвэл тэр кэйс дээр нь судлаад хуулийг тайлбарладаг ийм арга зарчим руу орсон байгаа.

Энэ дагуу Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш Улсын Дээд шүүх эрүү, иргэн, захиргааны салбаруудад яг асуудалтай байгаа, проблемтой байгаа тэр хуулийн зүйл, заалтуудыг тайлбарлаж байгаа. Ээлж дараагаар.

Энэ бол бас тийм хялбар ажил биш байдаг. Нэлээн судалгаа хийж байж, түүнтэй холбогдох хэргүүдийг судалж байж тайлбарыг гаргадаг учраас нэлээн хугацаа шаарддаг. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа өнөөдрийн цэцийн дүгнэлттэй холбогдуулаад Улсын Дээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ер нь Улсын Их Хурлын тухай хуулийн 37.8-д зааснаар ажлын хэсэгт мэргэжлийн холбогдох хүмүүсийг оролцуулах асуудал нээлттэй зохицуулагдсан байдаг бөгөөд олон улсын практикт шүүгчид шүүн таслах үйл ажиллагаа, мөрдөн байцаах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар таслах эрхгүй оролцдог практик байдаг.

Тийм учраас хууль яг хэрэглээний гол субъектүүд учраас энэ бол нэг их хууль зөрчих асуудал байхгүй. Ажлын хэсэгт шүүгчид орж ажиллах явдал бол.

Гишүүд асуулт асууж, хариулт авч хариулт дууслаа. /алх цохив/

Байнгын хороо Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор саналт хураалт явуулъя.

Ер нь сая Баттөмөрийн Энхбаяр гишүүн баталгаа, энэ дээр янз бүрийн хар буруу санаа, янз бүрийн төлөвлөгөө байхгүй гэдгээ хэлсэн.

Тэр 12 сард гээд байгаа нь нэг хугацаа өгөх гэж. Нөгөө Шүүх байгуулах тухай хууль, бусад хуулиуд хэлэлцэхтэй уялдуулаад цэцийн шийдвэр бол тэр нийцээгүй гэж гарсан гэж үзэж байгаа.

Тэгээд үүний цаана нэг их тийм айхтар юм байгаа эсэхийг хэрвээ шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагуудад хандаж хянуулж болох байх.

Зүгээр ингээд яг үйл явдлын дараалал, хууль зүйн үндэслэлийн хувьд энд тэгж хардах, сэрдэх ямар нэгэн шалтгаан алга байна л гэж бодож байна.

Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэгт шүүхэд хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэгт шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Арвангурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд

/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудал орно. Монгол Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд түрүүчийнхтэй нэр, ажил албан тушаал нэг адил.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаагүй байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёолол, санал хураах шаардлагагүй байхгүй тул Монгол Улсын төсвийн 2023

оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Горимын санал гэж байхгүй. Санал хураалт байхгүй юм чинь горимын санал гэж байхгүй. Болжээ.

Арвандөрөв.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Дараагийн асуудал орно. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны

төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Төслийн эцсийн хувилбараар Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 20 их наяд 781.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.5 хувь, нийт зарлагыг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт

бүтээгдэхүүний 2.6 хувьтай тэнцүү байхаар тооцсон болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх тус Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцсэн төслийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг протоколд тэмдэглэхдээ нэг

адилаар тусгана. Бүгд ажил, албан тушаал, нэр, овог адилхан байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр дөнгөж саяхан бид бүхэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан.

Тэгэхээр энэ анхнаасаа 152 гишүүнтэй байхын эсрэг би байсан байгаа.

Ер нь хэтэрхий их тоогоор Их Хурлын гишүүдийг нэмэх нь буруу гэж үзэж, тодорхой эсэргүүцэл илэрхийлж байсан.

Тэгээд нэгэнт Их Хурлын гишүүдийн олонх нь энэ асуудлыг шийдвэрлэхээр шийдсэн учраас, ялангуяа гишүүдийн тоог нэмэх, жагсаалтад оруулах, ялангуяа сонгуультай холбоотой асуудлыг шийдвэрлэж байгаа тул сонгогчдын саналыг зөв тоолох асуудлыг шийдвэрлэж авах нь хамгийн чухал асуудал байсан юм.

Тэгэхээр шударга сайхан сонгууль болгож болно. Ямар ч хэлбэрээр сонгууль явуулж болно. Гагцхүү тэрийг зөв тоолох нь хамгийн чухал асуудал байгаа юм.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хэт олон гишүүн батлахын эсрэг байсан тэр зүйл дээр, ялангуяа сонгуулийн санал тоолох машиныг шинээр худалдаж авах, түүний программ хангамжийг төсөвт суулгах.

Мөн түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хурууны хээ болон нүүр

таних хэрэгслийг шинээр худалдаж авах, түүний программ хангамжийг тавих шаардлагуудыг тавьсан байгаа.

Тэгээд энэ шаардлагыг Төрийн байгуулалтын байнгын хороон дээр тавьсны дагуу Улсын Их Хурлын дарга болон Монгол Улсын Ерөнхий сайд орж ирж энэ асуудлаар Засгийн газарт тодорхой чиглэл өгч, Тэгээд энэ асуудлыг Сангийн сайд энэ улсын төсөв дээрээ тавьж оруулж ирсэн нь маш зөв зүйтэй зүйл болсон гэдгийг хэлье.

Өнөөдрийн өнөөдрийн тодотголоор ерөөсөө цалин, тэтгэвэр нэмж байгаа, хүүхдийн мөнгийг 100 болгож байгаа. Дээрээс нь шинээр хоёрхон хөрөнгө оруулалт тавьж байгаа.

Тэр нь Сонгуулийн ерөнхий хорооны хөрөнгө оруулалт дээр сонгогчдын саналыг тоолох машин болон программ хангамж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хурууны хээ болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэж байгаа.

Тийм учраас сөрөг хүчнийхээ саналыг хүлээж авч бас тодорхой

хэмжээнд сонгуулийг шударга явуулах энэ асуудал дээр санаачилга гаргасан эрх баригчдад бас талархлаа илэрхийлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулна. Дараа нь нэг тогтоолын асуудал байгаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Үүнтэй холбогдуулаад боловсруулсан тогтоолын төслийг хэлэлцэнэ. Энэ дээр санал хураалттай. Гишүүд байж байгаарай.

**Арвантав. “Хууль баталсантай холбогдуулан
авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн асуудалд оръё. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооноос боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга

хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотгол хийхтэй уялдуулан үнийн өсөлтөөс сэргийлэх, инфляцыг тогтворжуулах, бууруулах чиглэлээр төлбөрийн тэнцлийг сайжруулах, инфляцыг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогын тохиргоог тухай бүр авч хэрэгжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн хангалтыг харгалзан татварын уян хатан бодлого боловсруулж хэрэгжүүлэх, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг зохицуулж байгаа холбогдох хууль тогтоомжийг Төрийн албаны тухай хуулийн 4.7 дахь хэсэгтэй нийцүүлэн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө өөрчлөх саналыг боловсруулж, шийдвэрлүүлэх асуудлыг тус тус Засгийн газарт даалгахаар Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлэх үеэр Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Г.Тэмүүлэн гишүүн ээ, наадхаа наашаа өгчих.

Санал хураалт байхгүй гэдгийг цохон тэмдэглэхийн ялдамд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Аль дээр нь чиглэл өгөх билээ. Чиглэл өгүүлэх юмаа аваад ир.

Гишүүд асуулт, хариулт байхгүй.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлнэ.

Тэгэхдээ ажлын хэсгийн саналыг үндэслээд тогтоолын төслийн 5 дугаар заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Мөн 2 дугаар заалтыг тодорхой болгох, төлбөрийн тэнцлийг сайжруулахын тулд авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлох.

Хамгийн гол нь үнийн өсөлтөөс сэргийлэх, инфляцыг зорилт түвшинд тогтворжуулахын тулд гол нэрийн бараа, бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний инфляцыг тогтворжуулах талаар арга хэмжээ авахыг чиглэл өгөх.

Инфляцын 11.3 хувь байгаа бараг дийлэнх нь махны үнэ байгаа шүү дээ. Тийм ээ.

Үүнтэй холбогдох арга хэмжээ авахыг тодорхой чиглэл болгох нь зүйтэй гэсэн чиглэлийг өгч байна.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэнтэй холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Ер нь үүнийгээ нөгөө мөнгөний бодлоготой уялдуулж. Мөнгөний бодлогод бодлогын хүүг 4 нэгжээр нэмэгдүүлэх шаардлага, валютын ханшид болон инфляцад мөнгөний нийлүүлэлтэд үзүүлж байгаа асуудалтай мөнгөний бодлогыг уялдуулах шаардлага гарна.

Энэ заалтаа бас ийшээ юундаа оруулах шаардлагатай болж байгаа. Төсөв, мөнгөний бодлогын тохируулга

хийнэ гэдгээ тодорхой болгох шаардлагатай болох байх.

Ер нь валютын ханш нэлээн буурч 110 төгрөгөөр буурсан.

Валютын нөөц 3 тэрбум 850.0 сая долларт хүрээд байгаа.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банктай байгуулсан свопын гэрээг ахиад 3 жилээр сунгах зарчмын тохиролцоонд хүрсэн. Техникийн ажлын хэсэг ажиллаж байгаа.

Зах зээлийн хүлээлт их нааштай байгаа гэдгийг бас тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Үүний өмнө нэг зарлах юм байна. Төсвийн байнгын хороо одоо хуралдана.

Энэ тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх асуудлаар Төсвийн байнгын хороо хуралдана.

Чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 7 цаг 47 минут үргэлжилж, 20 цаг 41 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД